

Хүүхдийн хэсэг 4

Мормоны Ном
8–11 нас

Хүүхдийн хэсэг 4

Мормоны Ном

Наймаас арван нэгэн насны хүүхдүүдэд
заахад зориулав.

© 2002 by Intellectual Reserve, Inc.
Бүх эрхийг эдэлнэ
Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв
Англи эхийн зөвшөөрөл: 9/96
Орчуулгын зөвшөөрөл: 6/97
Primary 4: Book of Mormon-ын орчуулга
Mongolian

Агуулга

Хичээлийн Дугаар ба Гарчиг	Хуудас
Багш нарт зориулсан тусламж	v
1 Мормоны Ном Бол Хайрт Тэнгэрлэг Эцэгээс Ирсэн Бэлэг Юм	1
2 Нифай Бошиглогч Эцгээ Дагасан	5
3 Гуулин Ялтсуудыг Олж Авсан нь	9
4 Амьдралын Мод	13
5 Лихай ба Түүний Гэр Бүл Цөлд Удирдагдсан нь	17
6 Тэнгэрлэг Эцэг Нифайд Усан Онгоц Барихыг Тушаасан	20
7 Далайг Гаталсан нь	23
8 Шерим Бошиглогч Иаковтай Маргасан нь	26
9 Инос Залбирсан нь	29
10 Бэнжамин Хаан Ард Түмэндээ Заасан нь	33
11 Абинадай ба Ноа Хаан	36
12 Алма Мормоны Усанд Усаар Батсан нь	41
13 Лимхай Хааны Хүмүүс ба Алмагийн Хүмүүс	47
14 Бага Алма ба Мозаягийн Хөвгүүд Нүглээ Наманчилсан нь	50
15 Алма, Амюлек нарын Аммонайхад Хийсэн Номлол	53
16 Алма, Амюлек Хоёр Шоронд	57
17 Агуу Үйлчлэгч Аммон	61
18 Лэмонай Хааны Эцэг Хөрвүүлэгдсэн нь	64
19 Антай-Нифай Лихай	69
20 Антай-Христ Корихор	72
21 Зорамчууд ба Рамеумптом	76
22 Алма Итгэлийн Тухай Заасан	79
23 Алма Хиламан, Шиблон Нарын Хөвгүүддээ Зөвлөсөн нь	84
24 Алма Кориантон Хүүдээ Зөвлөсөн нь	89
25 Ахмад Моронай Зерахэмнаг Ялсан нь	93
26 Ахмад Моронай ба Эрх Чөлөөний Далбаа	98
27 Хиламан ба Хоёр Мянган Дайчин	103
28 Нифай, Лихай Хоёр Шоронд	107
29 Нифайн Бошиглол	110

30	Нифай Агуу Их Хүч Чадлыг Хүлээн Авсан	114
31	Лэмэны Сэмүэл	118
32	Есүс Христийн Мэндэлсний Америк дахь Тэмдгүүд	121
33	Аврагч Нифайчууд Дээр Ирсэн нь	125
34	Есүс Христ Нифайчуудад Ивээлүүдийн Тухай Заасан нь	128
35	Есүс Христ Өвчтөнийг Эдгэрүүлж, Хүүхдүүдийг Адисласан нь	134
36	Есүс Христ Нифайчуудад Ариун Ёслол Өгсөн нь	137
37	Есүс Христ Нифайчуудад Залбирхыг Заасан нь	140
38	Нифайчуудын Дундах Амар Амгалан Байдал	143
39	Мормон Нифайчуудын Мөхлийг Гэрчилсэн	147
40	Жарэдчууд Амлагдсан Газар луу Хөтлөгдсөн нь	150
41	Жарэдчууд Бошиглогчдыг Эсэргүүцсэн нь	153
42	Моронай ба Түүний Бичээсүүд	157
43	Моронай Есүс Христэд Итгэх Итгэлийг Заасан нь	161
44	Моронай ба Мормоны Номын Амлалт	166
45	Мормоны Ном бол Есүс Христийн Дахин Амилалтын Гэрч Мөн (Улаан Өндөгний Баяр)	170
46	Мормоны Ном: Есүс Христийн Өөр Нэгэн Гэрээ (Зул Сарын Баяр)	173
47	Пристийн Зэрэгтнүүд Бидний Амьдралыг Адисладаг (Пристийн Зэрэгтнийг Бэлтгэх Хичээл)	177

Багш Нарт Зориулсан Тусламж

Аврагч “Хэн боловч эдгээр тушаалуудаас хамгийн өчүүхнийг нь ч үл тоомсорлож, бусдад тийн сургавал тэнгэрийн хаанчлалд хамгийн өчүүхэн нэгэн гэгдэх болно. Харин хэн боловч тэдгээрийг сахьж, сургавал тэнгэрийн хаанчлалд агуу нэгэн гэгдэх болно” (Матай 5:19) гэж хэлснээрээ зарлигуудыг сургаж, дуулгавартай байхын чухлыг заасан. Та нарт хүүхдүүдэд хэрхэн усан баталгааныхаа гэрээг дагаж, мөн үйлчлэх вэ гэдгийг сурахад нь туслах нандин итгэл өгөгдсөн. Охин бүр залуу эмэгтэй болох хийгээд хөвгүүн бүр пристийн зэрэг хүлээн авч, залуу эрэгтэй болохдоо бэлтгэж байгаагийнх нь хувьд та нар тэдний амьдралд чухал нөлөө үзүүлж чадна.

1831 онд Сүм байгуулагдсаны дараахан, Аврагч багш нарт тэр үед байсан цорын ганц судрууд болох Ариун Библи болон Мормоны Номон дахь миний сайн мэдээний зарчмуудыг заах болно (С ба Г 42:12-ыг үз) гэж хэлжээ. Өнөөдөр багш нар хүүхдүүдэд Бурхан болон түүний Хүү Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлэхэд нь туслах Сургаал ба Гэрээ, Агуу Их Үнэт Сувд зэрэг бүх жишиг бүтээлүүдээс нандин үнэнүүдийг заах үүрэг хариуцлагатай юм.

Сургалт

1 сарын 1-ний өдөр наймаас арван нэгэн насны бүх хүүхдүүд Хүүхдийн Хэсэг 4, 5, 6 ба 7 гэсэн гарын авлагаас заалгадаг. Энэ насны бүлгийн бүх хүүхдүүд жил бүр зөвхөн нэг сургалтын дамжааг дүүргэсэн байна. Сургалтын дамжаа бүр нь судрын онцгой номон дээр: Хүүхдийн Хэсэг 4 нь Мормоны Номон дээр, Хүүхдийн Хэсэг 5 нь Сургаал ба Гэрээн дээр, Хүүхдийн Хэсэг 6 нь Хуучин Гэрээн дээр, Хүүхдийн Хэсэг 7 нь Шинэ Гэрээн дээр үндэслэсэн байна. Дөрвөн жилийн хугацаа өнгөрөхөд хүүхэд болгон жишиг бүтээл бүрийг судалсан байна.

Орон нутгийн хэрэгцээ болон наймаас арван нэгэн настай хүүхдүүдийн тооноос хамаарч ангиуд нь салангад насны бүлгүүд, холимог насны бүлгүүд юмуу охид хөвгүүдээрээ тусдаа ангигарч зохион байгуулагдаж болно. Хэдийгээр анги тань эмхлэгдсэн ч гэсэн та хүүхэд бүр хангалттай анхаарал халамж хүлээн авч байгаа эсэхийг анхаарч байх хэрэгтэй.

Хүүхдүүд арван хоёр нас хүрээд Залуу Эмэгтэйчүүд болон Аароны Пристийн Зэргийн ангид оролцож эхэлдэг. Гэсэн хэдий ч тэд Ням Гарагийн Хичээлээ 1 сарын эхний долоо хоног эхлэх хүртэл Ням Гарагийн Хичээлийн үеэр Хүүхдийн Хэсгийнхээ ангид сууж болно.

“Пристийн Зэрэг Бидний Амьдралыг Адислаж Чадна” гэдэг онцгой хичээл энэ гарын авлагад орсон болно. Энэ хичээлийг дикон болохдоо бэлтгэж буй хөвгүүд болон Залуу Эмэгтэйчүүд болохдоо бэлтгэж буй охид болох 11 настай хүүхдүүдийн багш нар ашиглах болно. Энэ хичээлийг ангийн эхний хүүхэд 12 хүрэхээс өмнө заана. Хүүхдүүдэд пристийн зэрэг гэж юу болох, тэдний амьдралд хэрхэн адислал авчирч чадах болон пристийн зэргээ дээдлэхээр үүргээ хэрхэн биелүүлэхийг ойлгуулахын тулд хичээл бэлтгэж байхдаа болон тайлбарлаж байхдаа Их Эзэний удирдамжийг эрэлхийлэн залбир.

Тус Гарын Авлагаар Заах

Энэхүү сургалт нь Есүс Христийн амьдрал болон үүргийг онцгойлон Мормоны Номны сургаалууд дээр төвлөрдөг. Та эдгээр сургаалуудыг хуваалцаж ярилцаснаар хүүхдүүд Есүс Христийн үүрэг ба цагаатгалыг илүү сайн ойлгож, түүнд итгэх итгэл болон гэрчлэлээ улам ихээр хөгжүүлэх юм. Тэд Есүс Христийн сургаалыг амьдралдаа хэрхэн ашиглах болон түүний зарлигуудыг дагах илүү их хүсэлтэй болох ёстой.

Хүүхдүүдийг гэртээ Мормоны Ном уншиж Америкт үйлчилж байсан бошиглогчдын тухай, мөн Нифайчүүдийн дунд Аврагчийн үйлчлэлийн тухай сурахад нь урамшуулан дэмж. Хүүхдүүд эдгээр бошиглогчид болон Аврагчийн тухай суралцахдаа тэдний үлгэр жишээ, сургаалыг дагаж тэдэнтэй улам адил болохыг хичээх болно. Аврагчийн сургаал болон амьдралаас хүүхдүүдийн сурах чухал үнэнүүд нь тэднийг гэрээнүүдээ сахих, амьдралынхаа турш Сүмд үйлчлэл өгөхдөө бэлтгэхэд нь тусална. Эдгээр үнэнүүд нь тэдэнд өнөөгийн дэлхийн уруу таталтын эсрэг зогсох хүч чадлыг бас өгнө.

Өөрийгөө Заахад Бэлтгэх

Хүүхдүүдэд заах нандин дуудлагаа биелүүлэхдээ, та оюун ухаан болон сүнсээрээ хоёулангаар нь бэлтгэгдсэн байх ёстой. Энэ бэлтгэлийн нэг хэсэг нь зааж байгаа зарчмаа ойлгож, гэрчлэлтэй байх явдал юм. Бид бүгдийн агуу их багш Аврагч бидэнд түүний сургаалыг бусдад заахдаа хэрхэн бэлтгэхийг заасан.

- Сүнсийг даруухан, залбиралтайгаар эрэлхийл. Их Эзэн даруу бай, тэгвэл Их Эзэн Бурхан тань таныг гараас тань хөтөлж, залбирлууд тань хариулах болно гэж хэлжээ (С ба Г 112:10-ыг үз). Бид даруу байх юм бол Их Эзэн биднийг хүүхдүүдэд хэрхэн заагаасай гэж хүсч байгааг нь мэдэх эрхтэй байх болно.
- Судрууд болон амьд бошиглогч нарын үгсийг судал. Их Эзэний үгсийг эргэцүүлэн бодох, судлахад агуу хүч чадал байдаг. Тэр бидэнд эхлээд миний үгийг олж авахыг хичээ, тэгвэл хэл чинь тавигдаж, тэгээд хэрэв та хүсвэл миний Сүнс болон миний үг, тийм ээ хүн төрөлхтнийг үнэмшүүлэх Бурханы хүч чадал танд байх болно гэж тушаасан (С ба Г 11:21-ийг үз).

Хожмын үеийн бошиглогч, Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон Их Эзэний үгийг сурах бидний хэрэгцээг дахин баталсан: “Би та нарыг судраасаа суралцахыг өөрсөддөө дахин амлахыг маш их хүсэж байна. Та нарыг дуудлагад тань оруулах Сүнсний хүч чадалтай байхын тулд өдөр бүр өөрсдийгөө эдгээр зүйлст шимтүүл” (Ensign, 1986, х.82).

- Гэрээнүүдээ сахь. Таны Сүнсээр удирдагдах чадвар тань Тэнгэрлэг Эцэгтэй хийсэн гэрээнүүдээ сахих итгэлээс тань хамаарна. Та бас гэрээнүүдээ дагаж . . . тэдгээрийг хийснээрээ сайн жишээ болох болно (С ба Г 42:13-ыг). Хүүхдүүд таны Аврагчид зориулсан хайр болон сайн мэдээгээр амьдрах амлалтыг тань хараад, түүнийг дагахад илүү их өдөөгдөх болно.
- Хүүхдүүдэд Аврагчийн хайрыг мэдрэхэд туслах арга замуудыг эр. Тэдэнд ямар их хайртайгаа, тэдний зохистой байдал болон чадамжийг мэдэж байгаагаа байнга хэл. Таны хайр болон сайхан сэтгэл тань хүүхдүүдэд Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийн тэдэнд зориулсан хайрыг ойлгоход туслана. Энэ нь бас тэдэнд бусдыг хайрлаж сурахад туслах болно.

Хичээлээ Бэлтгэх Энэхүү гарын авлага нь сударт чиглэгдсэн хичээлүүдийг зохион байгуулахад тусалдаг. Хичээлүүд нь хүүхдүүдийг сайн мэдээний зарчмуудыг ойлгоход туслах Шинэ Гэрээний ишлэл, мэдээнүүдийг ашигладаг. Хичээлүүд нь судрын хэсгийг хэрхэн яг таг заахыг үзүүлдэггүй. Та Сүнсээр бэлтгэж заахдаа хүүхдүүдэд судрын хэсгүүд, тэдгээрт агуулагдаж буй зарчмууд болон эдгээр зарчмуудыг хүүхдүүд амьдралдаа хэрхэн ашиглаж болохыг илүү сайн ойлгоход нь тусалж чадна. Таны хичээлүүд сайн бэлтгэгдсэн, бас сонирхолтой байвал хүүхдүүд сонсч, сурахад илүү урамшуулагдах болно.

Доорхи алхмууд нь анги дахь хүүхдүүддээ үр дүнтэйгээр заахдаа бэлтгэхэд тань туслах болно:

1. Хичээл заахаас хоёр долоо хоногийн өмнөөс “Бэлтгэл” хэсэгт жагсаасан судрын хэсэг болон хичээлийн зорилгоо залбиралтайгаар судал. Хичээлийн зорилго болон судрын хэсгүүдийг дахин уншаад, анги дахь хүүхдүүддээ хэрхэн хандуулахаа бодож үз. Өөрөөсөө “Тэнгэрлэг Эцэг хүүхэд бүрээс юу сурч, энэ хичээлийн үр дүнд юу хийлгэхийг хүсч байна вэ? Энэ хичээл нь хүүхдүүдийг Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлэх, гэрчлэлээ хүчирхэгжүүлэх, тэдэнд нүүрлэх нүгэл хилэнцэт уруу таталтын эсрэг зогсох боломж олоход нь хэрхэн тусалж чадах вэ?” гэж асуу. Өөрт ирсэн санаануудаа бич.
Gospel Principles (31110) ном нь сайн мэдээний үндсэн зарчим болон сургаал дээр суурилсан хувиараа сурах удирдамж байхаар бэлтгэгдсэн юм. Зарим хичээлийн “Бэлтгэл” хэсэгт *Gospel Principles*-аас онцгойлсон бүлгүүдийг жагсаасан байгаа. Эдгээр бүлгүүд нь танд хичээлд агуулагдаж буй гол зарчим болон сургаалыг заахад тань тусалдаг. Номыг цуглааныхаа байрны номын сангаас авах юмуу орон нутгийнхаа бэлтгэн хангах төвөөс худалдан авч болно.
2. Хичээлийн эхэн дэх санал болгосон анхаарал татах ажиллагааг юмуу зааж байгаа судрын хэсэгт тохирсон, түүнд хамаатайд нь итгэлтэй байгаа өөрийнхөө зохиосон үйл ажиллагааны алийг нь ашиглахаа шийд.
3. Хичээлүүд нь танд судрын хэсгийг хэрхэн заахыг хэлж өгөхгүй. Та юуг, хэрхэн заахаа тодорхойлоход туслуулахаар Сүнсийг эрэлхийл. Долоо хоног бүр хэд хэдэн заах аргуудыг ашигла (Судраас Заах гарчигийг үз). Сурах үйл ажиллагаанд ангийн гишүүдийг аль болох ихээр нь татан оруулахаар төлөвлөөд, хүүхдүүд судрын хэсгийг бусдад эргүүлэн ярьж чадахаар хичээлээ заа.
4. “Ярилцлага ба Тавьж Болох Асуултууд”-аас хүүхдүүдэд судруудаас ойлгоход болон тэдгээрийг амьдралдаа ашиглахад илүү сайн туслахыг нь сонго. Та хичээлийн аль ч үед асуултуудаа тавьж болно. Та тэднийг бүгдийг нь хэрэглэх албагүй.
5. “Баяжуулах Үйл Ажиллагаа”-г уншаад, ангийн хүүхдүүдэд судрууд болон хичээлийн зорилгыг ойлгоход илүү сайн тусална гэж мэдэрсэн зүйлээ хэзээ, хэрхэн ашиглахаа төлөвлө. Хичээл бүр өөр байх бөгөөд нэг бүлэгт маш сайн тохирч байсан зарим үйл ажиллагаанууд нь нөгөө бүлэгт нь тийм сайн тохирохгүй байж болно.
6. Хичээлийн зорилгыг дэмжиж өгөх тохиромжтой хувийн туршлагаасаа хуваалцахаар төлөвлө. Ангид туршлагаа хуваалцахдаа болон ангийн гишүүдийг тантай болон өөр хоорондоо туршлагаасаа хуваалцаж байх

үед Сүнсээр удирдуул. Зарим гэр бүлийн болон хувийн туршлага нь маш нандин, нууцлаг байдаг учраас нийтийн дунд ярилцах хэрэггүй.

Судраас Заах

Та хичээлээ бэлтгэх болон зааж байхдаа ямагт Сүнсийг эрэлхийлэх ёстой (Алма 17:2–4, С ба Г 42:12–14, 50:17–22-г үз). Сүнс танд хүүхдүүдэд зориулж хичээлээ хэрхэн сонирхолтой, утга учир бүхий болгохоо мэдэхэд тань туслах болно.

Ангид байгаа хүүхдүүдийн зарим нь судруудтай танил биш байж болно. Та хамтдаа уншиж байхдаа судраас хэрхэн эрж хайхаа сурч байгаа ангийн гишүүдэд анхааралтай ханд. Хэрэв, та ялангуяа бага насны хүүхдүүдэд зааж байвал тэдэнд судрын ишлэлийг хэрхэн олохыг үзүүлэхийн тулд жилийн эхэнд хэсэг хугацаа хэрэгтэй болж болох юм.

Хүүхдүүдийн сонирхлыг хэвээр байлгахын тулд материалыг танилцуулах янз бүрийн аргыг үз. Дараах зөвлөмжүүд нь танд судраас заах аргаа өөрчлөхөд тусалж чадна.

1. Судрын үгийг өөрийн үгээр хэл. Хүүхдүүдэд үйл явдлууд болон эдгээр дэх хүмүүсийг санаандаа төсөөлөхөд нь туслахыг оролд. Өөрийн ярьсан хүмүүсээ үнэхээр амьдарч байсан хийгээд тухайн үйл явдал нь үнэн хэрэгтэй болсон гэдгийг ойлгоход нь хүүхдүүддээ тусал.
2. Хүүхдүүдээр шууд судраас бүхэл хэсэг болон сонгосон хэсгүүдийг уншуул. Тэгэхдээ бүх хүүхдүүд сайн уншиж чаддаггүй хийгээд унших чадвар нь насаар тодорхойлогддоггүй гэдгийг байнга санаарай. Хэрэв бүх хүүхдүүд тань уншиж чаддаг бол та тэдэнд чимээгүй унших хэсэг хугацаа өгч болно. Үүнийхээ дараа та тэдэнтэй юу уншсаныг нь ярилцаж болно. Хүүхдүүдийг уншиж дууссаны дараа тэдэнд хэцүү үг ба хэсгүүдийг ойлгоход нь туслахаар ярилцлагын цагийг ашигла.
3. Юу болсныг санаандаа төсөөлөхөд нь хүүхдүүдэд туслахаар зөвлөмж болгогдсон судрын хэсгийн зургуудыг ашигла. Ихэнх хичээлүүд “Шаардагдах Материалууд” хэсэгтээ зөвлөмж болгогдсон зургуудыг багтаадаг. Зургууд нь дугаарлагдаад гарын авлагатай хамт байна. Зарим зургууд нь Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга болон цуглааны байрны номын санд (Цуглааны байрны номын сангийн дугаар нь “Шаардагдах Материалууд” хэсэгт жагсаагдсан) байгаа. Ихэнх зургуудын ард хураангуй түүх нь хэвлэгдсэн байдаг. Та бас өөр тохиромжтой зургуудыг хэрэглэж болно.
4. Хүүхдүүдээр судрын хэсгийг жүжиглүүлэн тоглуул. (Жүжигчилсэн тоглолт нь судрын нандин байдлыг багасгаагүй гэдгийг анхаар.) Та энгийн нөмрөг, хүзүүний ороолт гэх зэрэг зүйлсийг авчирч хүүхдүүдийг судрын бүх юмуу аль нэг хэсгийг тоглуул. Тэднээс хэрэв тэд өөрсдөө тэдний төлөөлж байгаа хүн нь байсан бол ямар мэдрэмжтэй байх байсныг нь асуу.
5. Судрын хэсгийг унших буюу хэлж байхдаа самбар дээр энгийн дүрс юмуу дүрслэн үзүүлсэн зүйлсийг зур, эсвэл хайчилбар дүрс юмуу зураг ашигла.
6. Судрын хэсгийн хүмүүсийн дүрийг тогдох хэдэн хүүхэдтэй уншигчдын театрыг хөтлөн явуул. Тохиромжтой газар нь хүүхдүүдийг судраас шууд харилцан уншуул.
7. Хэсгийг яриулахаар эцэг эх, хэсэг юмуу салбарын гишүүн, эсвэл ангийн гишүүнийг урь. Тухайн хүндээ нэг юмуу хоёр долоо хоногийн

урьдчилан бэлтгэх хугацаа болон танилцуулах хугацааных нь хязгаарыг тогтоож өг.

8. Хүүхдүүдэд судрын хэсгийг заахаасаа өмнө үнэн-худал юмуу богино хариулт бүхий асуулт хариултын тэмцээн зэрэг энгийн урьдчилгаа шалгалтыг хий. Ангийнхандаа, тэднийг уг хэсгийн талаар хир зэрэг мэдэж байгааг нь мэдэхийг хүсч байгаагаа тайлбарла. Тэгээд тэдэнд юу сурсныг нь харуулахын тулд өмнөхтэйгөө адил шалгалтыг хий.
 9. Судрын хэсгийн чухал үгс буюу хүмүүсийн нэрсийг самбар дээр жагсаа. Тухайн хэсгээ ярьж хүүхдүүдэд эдгээр үгс буюу нэрсийг хэл. Хүүхдүүдэд үгсийн сангаа нэмэгдүүлэхэд тусал, тэгснээр тэд судруудыг илүү ойлгож, гэртээ уншихдаа баяртай байх болно.
 10. Хичээл эхлэхээсээ өмнө уг хэсгийн тухай асуултуудыг самбарт бич. Хүүхдүүд уг хэсгийн үеэр хариултыг сонссоны дараа тэдгээрийн талаархи ярилцлагаа дуусга.
 11. Хэсгийг хэлээд хүүхдүүдээр сайн дураараа дуртай хэсгийг нь эргүүлэн яриул. Та ангийн нэг гишүүнээс хэсгийг эхлэхийг хүсээд, дараа нь бусад хүүхдүүдээр үргэлжлүүлүүлж болно.
 12. Судрын сонгосон шүлгүүдийн бичлэгийг тоглуулж сонсго.
 13. Тохируулдаг тоглоомыг тогло. Дөрвөөс найман ширхэг жижиг хэмжээтэй хөзөр буюу цаас бэлтгэ. Дараах жишээнд та нэг хөзрийн нүүрэн тал дээр жаргал цэнгэлийг, бас нэг өөр хөзрөн дээр буюу өөр нэг хөзрийн нүүрэн тал дээр адислалуудыг бич. Тэгээд хөзөр буюу цаасаа холиод нүүрийг нь доош харуулан ширээ юмуу газар тавь. Хүүхдүүдийг нэг нэгээр нь ирүүлэн нэгэн зэрэг хоёр хөзөр эргүүлүүл. Хөзөр бүрт юу бичсэнийг чангаар уншуул. Хэрэв хөзөр тохирсон бол (энэ нь жаргал цэнгэлийг бүрдүүлсэн тохиолдолд) тэд дээш нь харуулж орхино. Хэрэв хөзөр тохироогүй бол тэд дахин доош нь харуулж тавиад, өөр хүүхдийн ээлж болно. Бүх хөзрүүд зөв тохирох хүртэл үргэлжлүүл.
- Жишээлбэл, та Лихайн зүүдэнд (1Нифай 8;11) үндэслэн 5 тохируулах бүрдэл хийж болно. Хүүхдүүдэд улам сонирхолтой болгохын тулд 3 бүрдэл нэмж өгч болно.

Бүрдэл 1: Мод — Бурханы хайр

Бүрдэл 2: Төмөр бариул — Бурханы үг

Бүрдэл 3: Жимс — Мөнхийн амьдрал

Бүрдэл 4: Харанхуй манан — Уруу таталт

Бүрдэл 5: Агуу хийгээд нүсэр барилга — Дэлхийн бардамнал

Бүрдэл 6: Од — Од

Бүрдэл 7: Сар — Сар

Бүрдэл 8: Нар — Нар

14. Тоглоомыг асуулт тавин тогло. Хэд хэдэн асуултыг том амсартай шилэн сав юмуу хайрцганд хийгээд, ангийн гишүүдийг ээлжээрээ ирж эдгээр асуултуудаас нэг нэгийг авхуулан хариулуул.

Ангид
Ярилцлагуудыг
Хөтлөн Явуулах

Ярилцлагуудад болон бусад сурах үйл ажиллагаануудад оролцох нь хүүхдүүдэд сайн мэдээний зарчмуудыг сурахад тусалдаг. Дараах удирдамжууд нь таныг утга төгөлдөр асуултуудыг тавьж, ангийг ярилцлагад өдөөхөд тань туслах болно.

1. Ангийн гишүүдэд асуулт тавьж судрын заалтуудыг хэлж өгөөд хариултыг нь судруудаас олуулж хариулуул.
2. “Тийм”, эсвэл “үгүй” гэж хариулагдахааргүй харин бодох болон ярилцахыг шаардах асуултуудыг тавь. Асуултууд нь яагаад, хэрхэн, хэн, юу, хэзээ, хаана гэж эхлэж байвал ихэвчлэн илүү үр дүнтэй байдаг.
3. Байнга оролцоод байдаггүй хүүхдүүдийг нэрээр нь дуудан хариулж чадах байх гэж бодсон асуултуудыг тавьж оролцуул. Тэдэнд хариулах хугацаа өг. Шаардлагатай бол тусал, гэхдээ зөвхөн бодож хариулах хугацаа өгсөнийхөө дараа л тусал.
4. Судраас сурсан зүйлийнхээ талаар сэтгэгдлээ хуваалцахад нь хүүхдүүдийг урамшуулан уриал. Тэдний өгсөн яриаг сайшаан дэмж.
5. Хүүхдүүдийг асуултанд хариулахад нь чин сэтгэлээсээ магт. Тэдний бодол, мэдрэмж нь чухал гэдгийг мэдэхэд нь тэдэнд тусал.

Хүүхдүүдэд
Судар
Ашиглахад
нь Туслах

Хүүхдүүдэд сурсан зүйлээ амьдралдаа хэрэгжүүлэхэд нь тусал. Нифай “Бидэнд эрдэм болон тус байж болохын тулд бид бүхий л судруудыг өөр-сөдтэйгөө адилтгах” ёстой хэмээн бидэнд зөвлөмж болгосон (1 Нифай 19:23). Дараах санаанууд таныг энэ зорилтоо биелүүлэхэд туслах болно.

1. Та сүнсээр өдөөгдөх үедээ зааж буй үнэнүүдийнхээ тухай хувийн гэрчлэлээ ярь. Та чин сэтгэлээсээ үнэмшилтэй заах юм бол таны хичээл илүү хүчтэй болох болно.
2. Хүүхдүүдийг гэртээ өөрсдөө болон гэр бүлийнхэнтэйгээ судруудаас уншихад нь урамшуул. Хүүхдүүдийг ангидаа өөрсдийнхөө судруудыг авчрахаар урамшуулан дэмж. Хэрэв хүүхдүүд өөрийн гэсэн сударгүй байх юмуу тэднийгээ ангид авчрахаа мартсан бол тэдгээр хүүхдүүдэд ашиглуулахаар ангид илүү судар байлгаарай. Хэрэв танайд хэсэг юмуу салбарын номын сан байвал та тэндээс хэд хэдэн судрын хувийг авч болно.
3. Хүүхдүүдээс юу сурснаа хуваалцахыг хүс. Тэднээс хичээл дээр заалгасан сайн мэдээний зарчмуудыг амьдралдаа хэрхэн ашиглаж болохыг нь асуу.
4. Хүүхдүүдээс сурвалжлагчийн дүрээр судрын баатаруудаас авч байгаа мэтээр ярилцлага ав. Тэднээс судрын хэсгийн нарийн учир болон болсон явдлын талаар сэтгэгдлийг нь асуу.
5. Ангийг хоёр юмуу түүнээс дээш бүлэгт хуваа. Судрын хэсгийг хуваалцсаны дараа бүлэг бүрээр тухайн хэсгийн чухал зарчмуудыг бичүүл. Тэгээд бүлгүүдийг ээлж ээлжээр нь эдгээр зарчмуудыг амьдралдаа хэрхэн ашиглаж болох талаар яриул.
6. Судрын судалгаа хий. Тэднийг амьдралдаа ашиглаж болох утга учир бүхий судрын онцгой шүлгүүдийг тэмдэглэхийг жилийн турш урамшуулан дэмж. Жишээлбэл, тэд 1 Нифай2:16, 1 Нифай3:7, эсвэл 1 Нифай4:6-г тэмдэглэж болно. Тэдэнд үйл явдал, нөхцөл байдал, эсвэл асуудал зэрэг түлхүүрүүдийг өг, тэгээд холбоотой судраа үзүүлж байрлуулахыг ангийн гишүүдэд уриал. Түрүүлж олсон хүүхдээр ангийн бусад хүүхдүүдэд судрыг олоход нь туслуул. Тэгээд тэднээр яагаад энэ судар нь учигт түлхүүртэй тохирч байгааг хэлүүл.
7. Ярилцсан зарчмуудыг дуулгавартай дагаж байгаа хүүхдүүдийг харсан онцгой тохиолдлуудаасаа хуваалц. Жишээ нь, хэрэв та эелдэг

харьцааны тухай хичээл зааж байгаа бол та бусдад эелдэг хандаж байсан хүүхдүүдийг харсан зарим жишээг дурьдаж болно.

8. Даалгаваруудаа эргэн шалга. Хэдийд ч даалгавар өгсөн бай, дараагийнх нь Ням Гарагийн хичээлийн эхэнд хүүхдүүдээс үүнийгээ асуу.

Хүүхдүүдэд
Судраас
Цээжлэхэд
нь Туслах

Судраас цээжлэх нь сайн мэдээний үнэнийг заах үр дүнтэй арга болж болно. Хэрэв та хөгжилтэй бүтээлч арга хэрэглэвэл ихэнх хүүхдүүд цээжлэхдээ дуртай байх болно. Дараах зөвлөмжүүд нь хүүхдүүдэд цээжлэхэд нь туслах тааламжтай арга болж өгч болно.

1. Цээжлэх гэж буй үг бүрийнхээ эхний үсгийг самбарт бичих юмуу хүснэгт хий. Жишээ нь, та итгэлийн тунхгийн нэгдүгээрт байдаг үгсээр дараах хүснэгтийг хийж болно.

Б Б М Э Т Х И Х Б А С И

Үг бүрийг хэлэхдээ холбогдох үсгийг заа. Хэдэн удаа давтаад хүүхдүүдээр чадах хэрээр нь давтуул. Урт ишлэлийн өмнө хүснэгт байх хэрэггүй.

2. Судрыг богино хэллэгүүдэд хуваа. Төгсгөлөөс нь эхэлж хэллэг бүрийг чангаар давтан хүүхдүүдийн сайн мэдэхгүй хэсгийг давтуулан хойш ухрах маягаар хий. Жишээ нь, Алма 37:35-д “Бурханы зарлигуудыг сахь” гэдгийг хэд хэдэн удаа хүүхдүүдээр давтуул. Тэгээд та “Тиймээ, залуудаа мэргэн ухааныг сур” гэсэн дараагийн хэллэгийг нэм. Тэгээд тэр шүлгийг бүхэлд нь давтаж болно.
3. Хүүхдүүд сайн уншдаг бол хүүхэд тус бүрт зориулан судрын хувийг бичиж бэлд. Хувь бүрийг үг үгээр нь юмуу хэллэгүүдээр нь тууз болгон хайчил. Шүлгийг хамтдаа хэдэн удаа хэлсний дараа хүүхдүүдэд хольсон туузнуудыг өгөөд тэднээр тус тусад нь юмуу ангиар нь туузнуудыг зөв байрлалд нь оруулуул.
4. Судрыг хэд хэдэн удаа давт, тэгээд зогсоод дараагийн үг, хэллэгийг нэг хүүхдээр хэлүүл. Тэгээд өөр нэг хүүхдээр хэдэн үг нэмж хэлүүл. Бүх хүүхдүүдэд наанадаж нэг удаа ээлж таартал үргэлжлүүл.
5. Хүүхдүүдэд цээжлэхэд нь туслахын тулд хөгжим ашигла.
6. Хүүхдүүдийг хоёр бүлэгт хуваа. Бүлэг бүрээр ээлж ээлжээр нь үг, хэллэгийг дарааллаар нь давтан хэлүүл. Та эхний бүлгээр эхний үгийг, нөгөө бүлгээр хоёр дахийг нь гэх мэтээр шүлгийг дуустал нь хэлүүлж болно.
7. Хүүхдүүдээр цээжлүүлэхийг хүсч буй судрын хэсгээ сонго. Судрыг самбарт юмуу үзүүлэн дээр бич. Хүүхдүүд судрыг бүтнээр нь цээжилтэл аажмаар үг үгээр нь хаах юмуу арилгасаар хэсгийг хэд хэдэн удаа давт.

Илүү Цагийг
Ухаалгаар
Ашиглах

Хэрэв та хичээлийн цаг дуусахаас өмнө бэлдсэн хичээлээ дууссан бол үлдсэн цагийг гүйцээх үйл ажиллагаа бодох хэрэгтэй болно. Дараах зөвлөмжүүд нь таныг энэ цагаа үр бүтээлтэй ашиглахад тусална.

1. Хүүхдүүдийн заримаар тэдний дуртай судрын түүхүүдээс яриул.
2. Хүүхдүүдийн тэмдэглэсэн байгаа чухал судрын заалтуудын түлхүүрийг тэдэнд өгснөөр судрын судалгааг хөтлөн явуул. Тэднийг судрын зөв хэсгийг илрүүлэхэд нь жижиг бүлэг юмуу хос хосоор нь ажиллуул.

3. Хүүхдүүдэд хичээлээс судар буюу итгэлийн тунхгийг цээжлэхэд нь тусал.
4. Хүүхдүүдээр хичээлээс сурсан зарчмуудаа гэртээ, сургууль дээрээ болон найз нөхөдтэйгөө хэрхэн ашиглаж чадаж байгаа тухай санаануудыг нь хуваалцуул.
5. Ангийг бүлгүүдэд хуваагаад ээлж ээлжээр бие биенээс нь хичээлийнх нь тухай асуулга.
6. Хүүхэд бүрээр хичээлтэй холбоотой зураг зуруулах юмуу ишлэлийг бичүүлээд гэрт нь хичээлийн зорилгын санамж болгон өгч явуул.
7. Ирээдүйн сургалтанд зориулан судрын заалтуудыг тэмдэглэхэд нь хүүхдүүдийг урь. Та хүүхдүүдээс тэдэнд хичээлээс тухайлан таалагдсан шүлгүүдийг юмуу, эсвэл хичээлийн зорилгыг хүүхдүүдэд сануулна гэж өөрийн бодсон шүлгийг тэмдэглэхийг зөвлөж болно.
8. Судрын номнуудыг дарааллаар нь хүүхдүүдэд цээжлэхэд нь тусал.
9. Өмнөх хичээлүүдийн зарчмууд буюу судрын түүхүүдийг давт.

Анги Дахь Хөгжим Сайн мэдээг сурах явдлыг хөгжмөөр баяжуулж, бэхжүүлж болно. Хүүхдүүд ихэвчлэн хөгжмөөр дамжуулан илүү сайн сурч, санаж чаддаг. Та хүүхдүүдэд Сүнсийг мэдэрч, сайн мэдээг сурахад нь туслахын тулд тохиромжтой хөгжмийг ашиглахдаа заавал хөгжимчин байх албагүй. Хөгжимд хуурцаг юмуу хичээлийн эхэнд, эсвэл дундуур тоглох хөгжмийн хэсэг орж болно. Та мөн хичээлдээ хүүхдүүдийг оролцуулахын тулд дуунуудыг дуулах буюу үгийг нь уншиж болно.

Хуваалцах Цаг Заримдаа ангиар Хүүхдийн Хэсгийн Хуваалцах Цагийн үеэр сайн мэдээний энгийн танилцуулгыг өгүүлдэг. Эдгээр танилцуулгууд нь бага зэргийн давталт шаардсан хичээлүүдээс ирэх ба таны зааж буй зарчмуудыг батжуулахад тусална. Та хуваалцах цагт дараах зөвлөмжүүдийг ашиглаж болно.

1. Судрын түүхүүдийг жүжигчлэн үзүүл.
2. Цээжилсэн судруудыг хамтдаа цээжээр унш.
3. Итгэлийн тунхгийг давтах буюу дуулаад утга санааг нь тайлбарла.
4. Сайн мэдээний зарчмуудыг орчин үед хэрхэн ашиглаж буй тухай тогло.

Итгэлийн Тунхаг Та Итгэлийн Тунхгийг хичээлдээ хамруулан хүүхдүүдийг Хүүхдийн Хэсгээс төгсч гарахаас нь өмнө Итгэлийн Тунхгийг цээжлэхэд нь хүүхэд бүрийг урамшуулан дэмж. Хүүхдүүдийг Итгэлийн Тунхгийг цээжилж, ойлгоход нь туслах бүх боломжийг ашигла.

**Наймаас Арван
Нэгэн Насны
Хүүхдүүдийг
Ойлгох**

Хүүхдүүдэд сурч, өөрийн хүчинд итгэх чадвартай болоход нь туслахын тулд та тэдний хэрэгцээ, онцлогийг ойлгож тохирсон үйл ажиллагаа, хичээлүүдийг төлөвлөх хэрэгтэй.

Онцлог шинж

Биеийн

Мацаг барих үе байдаг, өсөлт нь удаан
Болхи
Олуулаа тоглох дуртай

Оюуны

Сурах эрмэлзэлтэй
Өнгөрсөн явдлаа боддог
Шийдвэрээ логик ухаан дээр тулгуурлан гаргаж эхэлсэн
Яагаад гэдгийг мэдэхийг хүсдэг
Шүүмжлэлтэй ханддаг
Баатруудыг шүтдэг
Илүү хариуцлагатай болсон
Цээжээр хийх зүйлд дуртайк

Нийгмийн

Эсрэг хүйстэнд дургүй байхаасаа илүү охид хөвгүүдийн хоорондох
харилцаа холбоог илүү хүсдэг болсон
Олуулаа байх, мөн ганцаараа байх цагийн аль алинд нь дуртай
Биеэ даасан байдлын хүчтэй хэрэгцээг мэдэрсэн
Хошигнох мэдрэмжийг хөгжүүлж байгаа
Бусдыг сонирхох болсон

Сэтгэлийн

Шүүмжлэлд дургүй
Үетэнгийнхнийхээ дунд гарсан асуудлуудад дургүйцлээ илэрхийлдэг
Илүү их итгэл найдвар хүлээдэг болж байгаа
Шударга байдлын тухай ухамсарласан
Өөрийн болон бусдын зохистой байдлын талаар эргэлздэг болж
эхэлсэн
Өөрийнхөөрөө шийдэж, захирах нь бага болсон

Сүнсний

Сайн мэдээний зарчмуудыг сурч, хэрэгжүүлэхдээ дуртай байдаг
Бусдын гэрчлэл нөлөөлдөг
Сайн мэдээний зарчмуудыг ойлгох бэлэн байдалд өсөж байгаа
Зөв буруугийн тухай хүчтэй мэдрэмжтэй

Тахир Дутуу Хүүхдүүдийг Хамруулах Онцгой Удирдамж

Аврагч тахир дутуу хүмүүст энэрэл болон тэднийг ойлгож байгаагаа харуулан бидэнд жишээ болсон билээ. Дахин амилсныхаа дараа тэрээр Нифайчуудын дунд айлчлахдаа,

“Тэдний дунд өвчтэй хүмүүс байгаа эсэхийг асууж, Түүнд өвчтэй хүмүүсийг авчрахыг хүсчээ. Тэдний дунд доголон, сохор, зэрэмдэг, хамуу өвчтэй, хатингаршсан, дүлий, эсвэл өөр ямар нэгэн өвчтэй хүмүүс байгаа эсэхийг лавлав. Тэрээр тэдэнд энэрэл үзүүлдэг тул тэдгээр хүмүүсийг Түүн дээр авчирч эмчлүүлэхийг,” Тэр хэлэв (3 Нифай 17:7).

Та Хүүхдийн Хэсгийн багшийн хувьд энэрэл үзүүлэх хамгийн боломжтой байр сууринд байгаа. Хэдийгээр та мэргэжлийн тусламж өгөхөөр бэлтгэгдээгүй ч, тахир дутуу хүүхдүүдийг ойлгож, асарч чадна. Анхаарал, ойлголцол, оролцуулах хүсэл зэрэг нь ангийн гишүүн бүрт боломжийн хирээр суралцахад нь хэрэгтэй.

Тахир дутуу хүүхдүүд ойлгоцын түвшингээс үл хамааран Сүнсийг мэдэрч чадна. Зарим хүүхдүүд Хүүхдийн Хэсэгт бүхэлд нь оролцож чадахгүй ч гэсэн тэд Сүнсийг мэдрэхийн тулд бага ч гэсэн оролцох боломжтой байх хэрэгтэй. Хүүхдийн хэсэгт хүүхдийн хэрэгцээг ойлгодог бөгөөд шаардлагатай үед нь хэсгээс тусгаарлах хүнийг дэргэд нь байлгах шаардлагатай байж болно.

Ангийн тахир дутуу гишүүд нь сурах чадвар, оюун ухаан, хэл яриа, хараа ба сонсгол, зан чанар ба нийгэм, хөдөлгөөн, эсвэл архаг өвчтэй байж болно. Заримд нь хэл яриа, соёлын орчин нь хэцүү, танил бус байж болно. Хүүхэд бүр хувийн нөхцөл байдлаас үл хамааран хайрлуулах, зөвшөөрөгдөх, сайн мэдээ заалгах, Сүнс мэдрэх, амжилттайгаар оролцож, бусдад үйлчлэх гэх мэт бусдын адил хэрэгцээтэй. Дараах удирдамжууд тахир дутуу хүүхдүүдэд заахад тань тусална.

Эдгээр удирдамжууд тахир дутуу хүүхдүүдэд заахад тань тусална:

Хүүхдийг тахир дутуу гэж бодохгүйгээр таньж мэд. Энгийн, нөхөрсөг, дотно бай.

Хүүхдийн хүч чадал, шалгуурыг судал.

Ангийн гишүүн бүрт бусад гишүүн бүрийг хүндэтгэх нь үүрэг болохыг зааж, сануулахад бүхий л хүчээ дайчил. Ангийнхаа тахир дутуу гишүүнд туслах нь нийт ангийнхны хувьд Христтэй адил байхыг сурах явдал болж чадна.

Эцэг эх, бусад гэр бүлийн гишүүд болон тохирсон үед хүүхэдтэй өөртэй нь ярьж, уг хүүхдэд заах хамгийн сайн арга барилыг олж мэд.

Тахир дутуу хүүхдийг унших, залбирах, эсвэл өөр ямар нэгэн аргаар оролцуулахаар дуудахаасаа өмнө түүнээс хичээлд оролцох талаар саналыг нь асуу. Хүүхэд бүрийн чадвар, авъяасыг онцолж, хүн бүр тавтай, амжилттай оролцож чадах аргуудыг хай.

Хичээлийн материалуудыг бодит орчин тойронтой зохицуулан тахир дутуу хүүхдүүдийн хувийн хэрэгцээнд нийцүүл.

Тахир дутуу хүүхдүүдэд заах нэмэлт материалууд нь Сүмийн Хангамжийн Төвөөс олдох боломжтой. (Бүсийнхээ хангамжийн төвийн лавлахаас “Тахир Дутуу Хүмүүст Зориулсан Материалууд”-ыг үз).

Зүй Бусаар Харьцах Асуудлыг Шийдвэрлэх нь

Та Хүүхдийн Хэсгийн багшийн хувьд, сэтгэл санаа болон бие махбодоороо шаналан зовж байгаа ангийнхаа хүүхдүүдийн талаар мэддэг болсон байж болно. Хэрэв та ангийнхаа хүүхдийн талаар санаа зовж байвал бишоп, эсвэл салбарын ерөнхийлөгчтэйгөө зөвлөнө үү. Та хичээлээ бэлтгэж, заахдаа Их Эзэний заавар, удирдамжийг хүсэж залбир. Ангийнхаа хүүхэд бүрт тэрээр Тэнгэрлэг Эцэгийн эрхэм хүүхэд, Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христ бид бүгдэд хайртай бөгөөд биднийг аз жаргалтай, аюулгүй байлгахыг хүсдгийг мэдрэхэд нь тусал.

Мормоны Ном Бол Хайрт Тэнгэрлэг Эцэгээс Ирсэн Бэлэг Юм

Зорилго

Хүүхдүүдэд Мормоны Номыг хайрлан дээдлэхэд нь тусална.

Бэлтгэл

1. Мормоны Номны өмнөх хэсэгт буй Удиртгал ба Бошиглогч Иосеф Смитийн Гэрчлэл (эсвэл Иосеф Смит—Түүх 1:29–35, 42–54, 59–60)-ийг залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii-ыг үз).
2. Нэмэлт уншлага: Мормоны Номны эхний хуудас, Гурван Гэрчийн Гэрчлэл, Найман Гэрчийн Гэрчлэл, Мормон 6–7.
3. Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго.
4. Шаардлагатай материалууд:
 - а. Хүүхэд бүрт Мормоны Ном
 - б. Бэлэг болгон боосон Мормоны Ном
 - в. Боломжтой бол хүүхэд бүрт номны хавчуурга (хичээлийн төгсгөл дэх загварыг үз).
 - г. Зурагнууд: 4-1, Мормон Ялтсуудыг Хураангуйлсан нь (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 306, 62520), 4-2, Моронай Ялтсуудыг Кумора Толгойд Нуусан нь (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 320, 62462), 4-3, Иосеф Алтан Ялтсуудыг Хүлээн Авсан нь (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 406, 62012).

Хичээл Заах

Зөвлөмж

Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.

Анхаарал Татах
Ажиллагаа

Хүүхдүүдэд бэлэг болгон боосон Мормоны Номыг үзүүл.

- Бид яагаад бэлэг өгдөг вэ?
- Таны өгсөн бэлгэнд хэн нэг нь сэтгэл хангалуун байвал та нарт ямар санагдах вэ?

Тэнгэрлэг Эцэг бидэнд маш их хайртай учир бидэнд мөнхийн амьдралд хүрэхэд туслах бэлгийг өгсөн гэж тайлбарла. Энэ бэлэгт бид бүгдэд зориулсан чухал захиас байдаг. Энэ нь бидэнд бидний Аврагч Есүс Христ болон бид Тэнгэрлэг Эцэгтээ эргэн очихын тулд хэрхэн амьдрах ёстой вэ гэдгийг заадаг. Сүмийн арван гурав дахь Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон: “Энэ нь хүн төрөлхтөнд орчин үеийн анагаах ухаанд гарсан бидний мэдэх олон гайхамшигт ололт амжилтуудаас ч илүү үнэ цэнэтэй бэлэг юм. Энэ нь хүн төрөлхтөнд нислэг буюу сансар огторгуйн аялалын хөгжилт дэвшилтээс ч илүү их үнэ цэнэтэй” (Conference Report, Oct. 1986, p. 3, or *Ensign*, Nov. 1986, p. 4).

- Үүнийг ямар бэлэг гэж та нар бодож байна вэ?

Хүүхдүүдэд бэлгийг задлахад нь тусал. Мормоны Номыг судлах нь таны амьдралыг хэрхэн адисласан хийгээд Аврагчтай илүү адил болоход хэрхэн тусалсан тухай гэрчил.

Судрын Хэсэг

Бошиглогч Иосеф Смитийн Гэрчлэлээс Мормоны Ном гарч ирсэн тухай хэсгийг заа. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii-аас үз.) Өнөөдөр бидэнд байгаа судрын энэ номны үнэ цэнийг ойлгоход нь хүүхдүүдэд туслахын тулд Мормоны Номон дахь Удиртгалыг ашигла. Зургуудыг тохиромжтой үед хэрэглэ.

Ярилцлага ба
Тавьж Болх
Асуултууд

Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншнаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.

- Мормоны Ном гэж юу вэ? Үүнийг хэн бичсэн бэ? (Удиртгал, догол мөр 1-2. Америк дахь эртний бошиглогчид.)
- Энэ нь яагаад Моронайн Ном, эсвэл Иосеф Смитийн Ном бус харин Мормоны Ном хэмээн нэрлэгдсэн бэ? (Удиртгал, догол мөр 2. Бошиглогч Мормон бусад бошиглогчдын бичсэнийг иш татан, дүгнэж, алтан ялтсууд дээрх ихэнх зүйлийг бичсэн.)
- Мормоны Номон дээрх хамгийн чухал үйл явдал нь юу байсан бэ? Яагаад? (Удиртгал, догол мөр 3. Есүс Христийн Нифайчууд дээр ирсэн айлчлал.)
- Иосеф Смит Мормоны Номны тухай юу гэж хэлсэн бэ? (Удиртгал, догол мөр 6.) (Баяжуулах үйл ажиллагаа 3-ыг үз.) Мормоны Номыг уншиж, судлах нь та нарт хэрхэн тусална гэж та нар бодож байна вэ?
- Биднийг Мормоны Номтой байлгахын тулд олон бошиглогчид (Нифай, Мормон, Моронай болон Иосеф Смит) агуу их зовлон зүдгүүр болон гачигдлыг туулсан. Мормоны Ном нь үнэн гэдгийг мэдэхийн тулд та нар ямар гурван зүйлийг хийх хэрэгтэй вэ? (Удиртгал, догол мөр 8. Үүнийг уншаад, захиасыг эргэцүүлэн бодоод, Бурханаас үнэн эсэхийг нь асуух.)
- Бид Мормоны Номны тухай гэрчлэлтэй болж байхдаа өөр юу мэдэж авах вэ? (Удиртгал, догол мөр 9. Есүс Христ бол Аврагч, Иосеф Смит бол бошиглогч ба Сүм бол үнэн.)
- Тэнгэрийн элч Моронай анх Иосеф Смитэд үзэгдэхэд тэр юу хийж байсан бэ? (Бошиглогч Иосеф Смитийн Гэрчлэл, догол мөр 2-3. Иосеф Смит—Түүх 1:29–30.)
- Тэнгэрийн элч Моронай Иосеф Смитэд юу гэж хэлсэн бэ? (Бошиглогч Иосеф Смитийн Гэрчлэл, догол мөр 6–9. Иосеф Смит—Түүх 1:34–35, 42.)
- Дараагийн өдөр аавтайгаа ажиллаж байхад нь Иосеф Смитэд юу тохиолдсон бэ? (Бошиглогч Иосеф Смитийн Гэрчлэл, догол мөр 15–16. Иосеф Смит—Түүх 1:48–49.)
- Тэнгэрийн элч Моронай Иосеф Смитэд айлчлахдаа түүнийг нэрээр нь дуудсан. Тэнгэрлэг Эцэг та нарын нэрийг мэддэг болохыг мэдсэнээр та нар ямар сэтгэгдэлтэй байх вэ?
- Тэнгэрийн элч Моронай Иосефыг үзэгдлийнхээ тухай аавдаа хэлэхийг тушаасан. Хэрэв та нар Иосефынхтай адил тохиолдолтой учирвал та нар хэнд хэлэх вэ? Яагаад?

- Аавдаа хэлснийхээ дараа Иосеф юу хийсэн бэ? (Бошиглогч Иосеф Смитийн Гэрчлэл, догол мөр 17–19. Иосеф Смит—Түүх 1:50–52.)
- Иосеф алтан ялтсуудыг авах боломжтой болтол яагаад дөрвөн жил болсон бэ? (Бошиглогч Иосеф Смитийн Гэрчлэл, догол мөр 20. Иосеф Смит—Түүх 1:54.)
- Алтан ялтсуудыг авсныхаа дараа Иосеф ямар сэрэмжлүүлэг хүлээн авсан бэ? (Бошиглогч Иосеф Смитийн Гэрчлэл, догол мөр 22. Иосеф Смит—Түүх 1:59.)

Баяжуулах Үйл Ажиллагаа

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно.

1. Хүүхдүүдийг Мормоны Номны эхний хуудсыг уншихыг урь. Тэдэнд эхний хуудсан дээрх болон Удиртгалд өгүүлсэн номны зорилгуудыг өөрсдийнхөө Мормоны Номон дээр тэмдэглэхийг зөвлө.
2. Хүүхдүүдэд Моронай 10:4-ийг цээжлэхэд нь тусал.
3. Бошиглогч Иосеф Смитийн дараах мэдэгдлийг ярилцаад, цээжлэхэд нь хүүхдүүдэд тусал.
“Би ах нарт хэлсэнчлэн Мормоны Ном бол энэ дэлхий дээрх бусад бүх номноос хамгийн зөв нь, мөн шашны маань шаантаг чулуу, мөн бусад ямар ч номноос илүүгээр, үүний зааврыг мөрдсөнөөр хүмүүн Бурханд илүү ойртох болой” (Удиртгал, догол мөр 6.)
4. Хүүхдүүдэд итгэлийн тунхгийн наймдугаарыг ойлгож, цээжлэхэд нь тусал.
5. Мормоны Номыг гарч ирэхэд хөтөлсөн үйл явдлуудын заримыг жүжигчлэн тогло.
6. “Алтан Ялтсууд” дууг дуулах буюу үгийг нь уншуул (*Хүүхдийн Дууны Ном*, х. 86).

Дүгнэлт

Гэрчлэл

Иосеф Смит бол үнэн бошиглогч байсан бөгөөд Мормоны Ном нь үнэн гэсэн гэрчлэлээ хуваалц.

(Сонголтоор.) Боломжтой бол Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсоны гэрчлэлийг дээр нь хэвлэсэн номны хавчуургыг хүүхэд бүрт өг (хичээлийн төгсгөл дэх загварыг үз).

Зөвлөмж
Болгогдсон
Гэрийн Уншлага

Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ Бошиглогч Иосеф Смитийн Гэрчлэлийг судлахыг зөвлө. Энэ хэсгийг тэдэнд Мормоны Номны эхэн болон Иосеф Смит—Түүх 1:29–35, 42–54, 59–60-ын хаанаас нь олж болохыг үзүүл.

Хүүхдүүдийг Мормоныхоо Номыг Ням Гараг бүр ангидаа авч ирэхэд нь урамшуул.

Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.

“Тэнгэрлэг Эцэг та

нарыг өдөр бүр

Мормоны Номноос

үргэлжлүүлэн

судлахыг хүсдэг.

Энэ нь Тэнгэрлэг

Эцэгээс та нарт

өгсөн онцгой

бэлэг.

Үүн дээрх

сургаалыг

дагаснаараа та

нар Тэнгэр дэх

Эцэгийнхээ

хүслийг биелүүлж

сурах болно.”

Эзра Тафт Бэнсон

“Тэнгэрлэг Эцэг та

нарыг өдөр бүр

Мормоны Номноос

үргэлжлүүлэн

судлахыг хүсдэг.

Энэ нь Тэнгэрлэг

Эцэгээс та нарт

өгсөн онцгой

бэлэг.

Үүн дээрх

сургаалыг

дагаснаараа та

нар Тэнгэр дэх

Эцэгийнхээ

хүслийг биелүүлж

сурах болно.”

Эзра Тафт Бэнсон

“Тэнгэрлэг Эцэг та

нарыг өдөр бүр

Мормоны Номноос

үргэлжлүүлэн

судлахыг хүсдэг.

Энэ нь Тэнгэрлэг

Эцэгээс та нарт

өгсөн онцгой

бэлэг.

Үүн дээрх

сургаалыг

дагаснаараа та

нар Тэнгэр дэх

Эцэгийнхээ

хүслийг биелүүлж

сурах болно.”

Эзра Тафт Бэнсон

“Тэнгэрлэг Эцэг та

нарыг өдөр бүр

Мормоны Номноос

үргэлжлүүлэн

судлахыг хүсдэг.

Энэ нь Тэнгэрлэг

Эцэгээс та нарт

өгсөн онцгой

бэлэг.

Үүн дээрх

сургаалыг

дагаснаараа та

нар Тэнгэр дэх

Эцэгийнхээ

хүслийг биелүүлж

сурах болно.”

Эзра Тафт Бэнсон

Нифай Бошиглогч Эцэгээ Дагасан

Хичээл

2

Зорилго

Амьд бошиглогчийг дагах хүүхэд бүрийн хүслийг нь батжуулна.

Бэлтгэл

- 1 Нифай 1–2-ыг залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii-ыг үз).
2. Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго.
3. Шаардлагатай материалууд:
 - а. Хүүхэд бүрт Мормоны Ном
 - б. Зургадугаар Итгэлийн Тунхгийн хүснэгт (65006). Бошиглогчид гэсэн үгийг нугалсан цаасаар хаа. Цаасны дотор талд нь “Бошиглогч бол Бурханы өмнөөс ярихаар Түүгээр дуудагдсан хүн юм. Бошиглогч Бурханы өмнөөс ярих нь Бурхан өөрөө ярьж байгаатай адил юм” гэж бич. Хэрэв итгэлийн тунхгийн зургадугаагийн хүснэгт байхгүй бол өөрөө хийх, буюу самбар дээр бичиж болно.
 - в. Зурагнууд: 4-4, Лихай Ирусалим Дахь Хүмүүсийн Тухай Зөгнөн Хэлсэн нь (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 300, 62517), 4-5, Лихайн Гэр Бүл Ирусалимыг Орхин Явсан нь (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 301, 62238) болон амьд бошиглогч, эсвэл Иосеф Смитийн зураг (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 401, 62002).

Хичээл Заах Зөвлөмж

Анхаарал Татах
Ажиллагаа

Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.

Бошиглогчид гэсэн үгийг нь хаасан итгэлийн тунхгийн зургадугаарыг үзүүл. Хэрэв хүүхдүүд хаасан үгийг мэдэж байвал тэднийг гараа өргөхийг урь. Нэг хүүхдээр тэр цаасыг авахуулаад өөртөө авчирч өгөхийг хүс. Хүүхдүүдийг хамтдаа итгэлийн тунхгийн зургадугаарыг давтахыг урь.

Амьд бошиглогч, эсвэл бошиглогч Иосеф Смитийн зургийг үзүүлээд хүүхдүүдээс энэ хүн хэн болохыг асуу.

- Бошиглогч гэж хэн бэ?

Ярилцлагын дараа хүүхдүүдийн нэгээс нугалсан цаасны дотор талд бичсэн зүйлийг уншихыг хүс (“Бэлтгэл”-ийг үз).

Бошиглогчид үргэлж Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийн тэднээс юу хийхийг хүсч байгааг хүмүүст хэлдэг хэмээн гэрчил. Бид бошиглогчийг дагахдаа адислагддаг гэдгийг тайлбарла.

Судрын Хэсэг

1 Нифай 1–2-оос бошиглогч Лихай болон түүний гэр бүл Иерусалимыг орхин явж байгаа хэсгийг заа. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii-аас үз.) Зургуудыг тохиромжтой үед ашигла. Бид бүгд Нифайтай адил байж, амьд бошиглогчийг дагахыг хичээх ёстойг онцол.

Ярилцлага ба
Тавьж Болох
Асуултууд

Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншнаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.

- Лихай ард түмнийхээ төлөө юу хийсэн бэ? (1 Нифай 1:5.) Их Эзэн Лихайн зүүдэнд юу үзүүлсэн бэ? (1 Нифай 1:6–13.)
- Үзэгдэл хүлээн авсныхаа дараа Лихай юу хийсэн бэ? (1 Нифай 1:18.)
- Лихай хэний тухай бошиглосон бэ? (1 Нифай 1:9, 19. Месая бол Есүс Христ гэдгийг тайлбарла.) Бошиглогчид ямагт Есүс Христийн тухай гэрчилдэг гэдгийг ойлгоход нь хүүхдүүдэд тусал. Та нар хэрхэн Есүс Христийн тухай гэрчлэлтэй болж чадах вэ? Хүүхэд бүр залбиралтайгаар Мормоны Номноос сурч, зарлигуудыг дуулгавартай дагаснаараа Есүс бол Аврагч юм гэдгийг мэдэж чадна гэдгийг гэрчил.
- Бошиглогч Лихайн үгсийг сонсоод хүмүүс юу хийсэн бэ? (1 Нифай 1:19–20.) Хэрэв та нар Есүс Христ болон түүний сүмд итгэснээсээ болоод дооглуулах, эсвэл шоолуулбал та нар юу хийх вэ?
- Хүмүүс Лихайг алахаар оролдсоны дараа Их Эзэн түүнд юу хийхийг тушаасан бэ? (1 Нифай 2:1–3.)
- Лихайн гэр бүл Иерусалимыг орхин явахдаа юу юу авч явсан бэ? (1 Нифай 2:4.) Нөөц бэлтгэл гэж юу вэ? (Хоол хүнс, хувцас, майхан, багаж хэрэгсэл гэх мэт.) Лихайн гэр бүл ардаа юу орхисон бэ?
- Лэмэн, Лэмүэл хоёр гэр орон болон алт, мөнгөө орхин явахдаа яасан бэ? (1 Нифай 2:11–13.) *Бувтналдах* гэдэг нь юу гэсэн үг вэ? (Гомдол гаргах) Зөрүүд араншин гэж юу вэ? (Гөжүүд зан болон бардамнал.) Хэрэв та нараас гэр болон эзэмшлээ орхихыг хүссэн бол та нарт ямар санагдах вэ?
- Нифай яагаад эцгийнхээ эсрэг босоогүй вэ? (1 Нифай 2:16.) *Их Эзэнээс гуйн залбирах* гэдэг нь чин сэтгэлээсээ хүчтэй залбирах, *зүрх сэтгэлээ зөөлрүүл* гэдэг нь сонсох, дуулгавартай дагах гэсэн утгатай болохыг тайлбарла. Залбирал нь хэрхэн та нарын зүрх сэтгэлийг зөөлрүүлж, бошиглогчийг дагахад туслах вэ?
- Лэмэн, Лэмүэл хоёр Нифайд итгэхгүй байхад тэр тэдэнд хайраа хэрхэн үзүүлсэн бэ? (1 Нифай 2:18.) Та нар ер нь зарлигуудыг сахиагүй хэн нэгний төлөө залбирч байсан уу?
- Нифайг итгэлтэй байсны төлөө Их Эзэн түүнд юу гэж амласан бэ? (1 Нифай 2:19–22.) Итгэл гэдэг нь та нарын хувьд юу гэсэн үг вэ?
- Лихайн гэр бүлийг явсны дараа Иерусалимд юу болсон бэ? (2 Нифай 1:4.) Их Эзэн судар дээрх бошиг болон амлалтууд нь бүгдээрээ ямагт биелэгдэх болно хэмээн заасан. Тэнгэр болон газар дэлхий үгүй болсон ч Их Эзэний хэлсэн нь биелэгдэх болно (С ба Г 1:37–38-г үз).

- Лихайн гэр бүл Иерусалимыг хэзээ орхисон бэ? (Мормоны Номон дээрх хуудасны доод талын хаалтан дахь он, сар, өдрүүд нь тухайн зүйлс хэзээ болсныг бидэнд хэлж өгдөг.) Х.Ө буюу МЭӨ гэдэг нь юу гэсэн утгатай вэ? (Христээс өмнө.)
- Өнөөдрийн бошиглогч хэн бэ? (Боломжтой бол түүний зургийг үзүүл.) Тэр биднээс юу хийхийг хүсдэг вэ? Та сүүлчийн захиасуудаас цөөн хэдэн ишлэлийг хүүхдүүдтэй хуваалцаж болно. Амьд бошиглогчдыг дагаснаараа бид хэрхэн адислагдах вэ?

Баяжуулах Үйл Ажиллагаа

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно.

1. Лихайн гэр бүл цөл рүү явахдаа авч явсан байж болох майхан, хөнжил, хоолны сав болон данх, хутга, нум сум, олс дээс, эсвэл үр тариа зэрэг зүйлсийн зураг юмуу цөөн тооны юмсыг авчир. Хүүхдүүдийг Лихайн гэр бүл авч явсан байж болох бусад зүйлсийг төсөөлөөд нэрлэхэд нь урамшуул.
 - Лихайн гэр бүлд эдгээр зүйлс яагаад хэрэгтэй байсан гэж та нар бодож байна вэ? Хэрэв та нар Лихайн адил аялалд явж байсан бол өөр юу авч явах хэрэгтэй вэ?
 - Ямар зүйлсийг орхивол та нарт хэцүү байх вэ?
2. Хожмын Үеийн Бошиглогчдын зургийг үзүүлээд (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 506, 62575), хүүхдүүдээр тэдний нэрсийг үйлчилсэн дарааллаар нь цээжлүүл.
3. Сүмийн арван гурав дахь Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсоны хэлсэн дараах мэдэгдлийг хуваалц:

“Би одоо Сүмийн хүүхдүүдэд хандан ярихыг хүсэж байна. . . .

“Би та нарт ямар их хайртай вэ! Тэнгэрлэг Эцэг маань та нарт ямар их хайртай вэ!

“Өнөөдөр би та нарт хандан Тэнгэрлэг Эцэг та нарыг мэдээсэй гэж хүсдэг зүйлийг заахыг хүсч байгаа бөгөөд ингэснээр та нар түүний хүсэл хийгээд жинхэнэ аз жаргалыг эдэлж сурах юм. Энэ нь та нарт одоо болон амьдралын тань туршид туслах болно.

“Би та нарыг Мормоны Номонд хайртайг сонсоод ямар их баяртай байна вэ. Би ч бас хайртай ба Тэнгэрлэг Эцэг та нарыг өдөр бүр Мормоны Номноос үргэлжлүүлэн уншиж судлаасай хэмээн хүсдэг. Энэ бол Тэнгэрлэг Эцэгийн та нарт өгсөн онцгой бэлэг юм. Үүн дээрх сургаалыг дагаснаараа та нар Тэнгэр дэх Эцэгийнхээ хүслийг бие-лүүлж сурах болно” (Conference Report, Apr. 1989, pp. 102, or *Ensign*, May. 1989, p. 81–82).
4. Салангид цааснууд дээр амьд бошиглогчийн саяхны чуулганы илтгэл буюу Тэргүүн Зөвлөлийн Захиас бичгээс товч хэсгийг хувиран ав. Мэдэгдлийг хайрцаг, эсвэл цаасан уутанд хийгээд хүүхдүүдийг ээлж ээлжээр нэг нэг ишлэл сугалж авахыг урь. Хүүхэд бүрийг ишлэлээ уншсаных нь дараа бошиглогчийн зөвлөлгөөг хэрхэн дагахыг нь хэлүүл.

5. Хүүхдүүдтэй итгэлийн тунхгийн зургадугаарыг ярилцаад, цээжлэхэд нь тусал.
6. “Бурхан минь, Бошиглогч Илгээсэн Танд Талархъя” дууг дуулах, эсвэл үгийг нь унш (*Хүүхдийн Дууны Ном*, х. 36).

Дүгнэлт

Гэрчлэл	Тэнгэрлэг Эцэг бидэнд хайртай учраас тэр бидэнд амьд бошиглогчийг өгсөн хэмээн гэрчлэлээ хуваалц. Хэрэв хүүхдүүд амьд бошиглогчийг дагах юм бол тэд адислагдах болно гэдгийг гэрчил.
Зөвлөмж Болгогдсон Гэрийн Уншлага	Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ 1 Нифай 2-г судлахыг зөвлө. Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.

Гуулин Ялтсуудыг Олж Авсан нь

Хичээл
3

Зорилго Тэнгэрлэг Эцэг өөрт нь итгэж, түүний зарлигуудыг дуулгавартай дагадаг хүмүүст тусалдаг гэдгийг ойлгоход нь хүүхдүүдэд тусална.

Бэлтгэл

- 1 Нифай 3–5-ыг залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii-ыг үз).
2. Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго.
3. Боломжтой бол “Би явж, Их Эзэний зарлиг болсон тэр зүйлүүдийг биелүүлэх болно” (1 Нифай 3:7) гэсэн мэдэгдлийг хүүхэд бүрт зориулан тэдний нэрийг дэр нь бичиж бэлтгэ (хичээлийн төгсгөл дэх загварыг үз).
4. Шаардлагатай материалууд:
 - а. Хүүхэд бүрт Мормоны Ном
 - б. Хичээлийн төгсгөл дэх нууц түлхүүрээр битүүмжлэгдсэн нууцлагдсан захиас. Үүнийг цаас, эсвэл самбар дээр бичиж болно.
 - в. Зурагнууд: 4-6, Лэбэнд Эд Баялагаа Өргөж Буй Лихайн Хөвгүүд, 4-7, Тэнгэр Элч Лэмэн, Лэмүэл Хоёрыг Зогсоож Байгаа нь, 4-8, Нифай Лихай руу Гуулин Ялтсуудтай Эргэж Ирсэн нь.

**Хичээл Заах
Зөвлөмж**

Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.

Анхаарал Татах
Ажиллагаа

Нууц түлхүүрээр битүүмжлэгдсэн нууц захиасыг үзүүлээд, хэн нэг нь үүнийг уншиж чадах эсэхийг асуу. Уншихад хэцүү яг энэ захиас бичиг шиг дуулгавартай дагахад хэцүү мэт санагдаж болох Тэнгэрлэг Эцэгийн зарим зарлигуудыг тайлбарла. Захиас бичгийг бид ямар нэг тусламжтайгаар уншиж чадна. Яг ийм аргаар Тэнгэрлэг Эцэгийн тусламжтайгаар бид бүх зарлигуудыг дуулгавартай дагаж чадна.

- Тэнгэрлэг Эцэг бидэнд зарим ямар зүйлүүдийг хийхийг тушаасан бэ?
- Тэнгэрлэг Эцэг бидэнд түүний тушаалуудыг сахихад хэрхэн тусална гэж та нар бодож байна вэ?

Хэрэв бид түүнд итгэлтэй байгаад мөн найдах юм бол Тэнгэрлэг Эцэг бидэнд туслах болно гэдгийг тайлбарла. Хүүхдүүд энэ хичээлээс Тэнгэрлэг Эцэг Лихайн хөвгүүдийг тэдэнд эхлээд гүйцэтгэхэд боломжгүй мэт санагдаж байсан зарлигуудыг дуулгавартай дагахад нь хэрхэн тусалсныг сурах болно гэдгийг тайлбарла.

Судрын Хэсэг

Зөвлөмж болгогдсон зургуудыг ашиглаад 1 Нифай 3–5-аас Нифай болон түүний ах нар гуулин ялтсуудыг олж авахаар Иерусалим руу эргэн

ирж байгаа хэсгийг заа. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii-аас үз.) Хэрэв тэд итгэлтэй байвал зарлигуудыг дагахад Нифайн адил тусламжуудыг авч чадна гэдгийг ойлгоход нь хүүхдүүдэд тусал.

Ярилцлага ба
Тавьж Болох
Асуултууд

Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншнаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.

- Лихайн зүүдэнд Тэнгэрлэг Эцэг юу гэж тушаасан бэ? (1 Нифай 3:2–4.) Лихайн гэр бүлд яагаад гуулин ялтсууд хэрэгтэй болсон бэ? (1 Нифай 3:19–21.) Гуулин ялтсууд нь Лихайн үр удамд хэрхэн адислал болж чадах вэ? (1 Нифай 5:21–22.)
- Лэмэн, Лэмүэл хоёр Иерусалим руу эргэж очоод гуулин ялтсуудыг авч ирэх тушаал аваад яасан бэ? (1 Нифай 3:5, 28, 31.)
- Нифайд ялтсуудыг авч ирэхийг тушаахад тэр яасан бэ? (1 Нифай 3:5–7, 15, 21.) Нифай яагаад Их Эзэн түүнээс юуг ч хамаагүй хийхийг асуухад тэр хийхэд бэлэн байсан бэ? Түүнийг ялтсуудыг авахад Их Эзэн туслах болно гэдгийг тэр хэрхэн мэдсэн бэ?

Нууц түлхүүрүүдийг лавлаад, ангийнхандаа захиасыг тайлах боломжийг өг. 1 Нифай 3:7- гийн утгыг ярилц.

- Нифайд гуулин ялтсуудыг авахад хэн тусалсан бэ? (1 Нифай 4:6.) Бид Ариун Сүнсний тусламж болон удирдамжийг авахын тулд хэрхэн зохистой байж чадах вэ?
- Яагаад заримдаа зарлигуудыг дуулгавартай дагах нь хэцүү байдаг вэ? Зарлигуудыг дуулгавартай дагахад Нифайн жишээ бидэнд хэрхэн туслах вэ? (1 Нифай 7:12.)
- Бид хэрхэн Нифайн адил Есүсийг дагаж сурах вэ?

Баяжуулах Үйл Ажиллагаа

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно.

1. Хүүхдүүдэд 1 Нифай 3:7-г цээжлэхэд нь тусал. Тэдэнд энэ шүлгийг өөрсдийнхөө Мормоны Номон дээр тэмдэглэхийг санал болго.
2. Ангийнхантайгаа итгэлийн тунхгийн гуравдугаарыг цээжлээд ярилц. Бид ямагт Тэнгэрлэг Эцэгийн зарлигуудыг дуулгавартай дагах ёстойг болон хэрэв бид үүнийг хийвэл тэр биднийг адислана гэдгийг онцол.
3. Хэдэн хүүхдийг “Би _____ -аараа Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христэд итгэх итгэлээ харуулна” гэсэн мэдэгдлийг дуусгахыг урь.
4. Тэнгэрлэг Эцэг биднийг хийгээсэй хэмээн хүссэн зүйлсийг сануулах дараахтай адил хэдэн зураг болон юмсыг үзүүл (цуглааны байрны номын сангийн зурагнуудын дугааруудыг хавсралтанд жагсаасан болно). Зарлигууд болон дагалдах адислалуудыг нь ярилц.

Залбир (62217)
 Номлолд үйлчил (62611)
 Хүн болгонд эелдэг болон хүндэтгэлтэй ханд (62316)
 Ариун сүмд оч (62559)
 Ариун ёслолоос хүрт (62021)
 Аравны нэгийг төл (аравны нэгийн дугтуйг үзүүл)
 Судраас унш (62373)
 Мэргэн Ухааны Үгээр амьдар (идэхэд тохиромжтой хоол болон дасгалуудын зургийг үзүүл)
 Гэр бүлийн үдшийг явуул (62521)

Дүгнэлт

Гэрчлэл

Тэнгэрлэг Эцэг бидэнд түүний зарлигуудыг дуулгавартай дагахад туслах болно гэдэг гэрчлэлээ хуваалц. Та Хүндэтгэлийн өдрийг ариунаар нь сахих, эсвэл бусадтай эелдэг байх зэрэг зарлигуудыг сахиж итгэлээ хөгжүүлэх үедээ тохиолдсон явдал болон хэрхэн адислагдаснаа хуваалцаж болно.

Боломжтой бол “Би явж, Их Эзэний зарлиг болсон тэр зүйлүүдийг бие-лүүлэх болно” (1 Нифай 3:7) захиасыг хүүхдүүдэд өг. Хуудас бүрийн дээр нь хүүхдүүдийн нэрсийг бичиж үүнийг өөрсдийнхөө амлалт болгохыг тэдэнд уриал.

Зөвлөмж
 Болгогдсон

Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ 1 Нифай 3:1–8, 4-ийг судлахыг зөвлө.

Гэрийн Уншлага

Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.

<u>26</u>	<u>32</u>	<u>0</u>	<u>16</u>	<u>6</u>	<u>47</u>	<u>18</u>	<u>13</u>	<u>6</u>	<u>27</u>	<u>8</u>	<u>45</u>	<u>2</u>	<u>5</u>	<u>6</u>	<u>7</u>								
				<u>2</u>	<u>45</u>	<u>8</u>	<u>2</u>	<u>4</u>	<u>3</u>	<u>13</u>	<u>1</u>	<u>2</u>											
<u>8</u>	<u>9</u>	<u>27</u>	<u>5</u>	<u>9</u>	<u>9</u>	<u>18</u>	<u>6</u>	<u>27</u>	<u>7</u>	<u>26</u>	<u>27</u>	<u>5</u>	<u>9</u>	<u>9</u>	<u>5</u>	<u>1</u>	<u>4</u>	<u>7</u>	<u>2</u>	<u>45</u>	<u>3</u>	<u>4</u>	
НУУЦ ТҮЛХҮҮР: 2=Б 6=И 32=Я 0=В 16=Ж 47=Х 1=Э 8=З 3=Н 27=Й 45=А 2=Р 5=Л 7=Г 4=О 82=С 13=Т 9=Ү 18=Д 27=Е																							

“Би явж, Их Эзэний
зарлиг болсон
тэр зүйлүүдийг
биелүүлэх болно”

1 Нифай 3:7

“Би явж, Их Эзэний
зарлиг болсон
тэр зүйлүүдийг
биелүүлэх болно”

1 Нифай 3:7

“Би явж, Их Эзэний
зарлиг болсон
тэр зүйлүүдийг
биелүүлэх болно”

1 Нифай 3:7

“Би явж, Их Эзэний
зарлиг болсон
тэр зүйлүүдийг
биелүүлэх болно”

1 Нифай 3:7

Зорилго

Хүүхэд бүрийн Бурханы үгийг дуулгавартай дагах болон мөнхийн амьдралд орохын тулд зохистой байх хүслийг хүчирхэгжүүлнэ.

Бэлтгэл

- 1 Нифай 8, 11 болон 15:21–36-г залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii- ыг үз).
 2. Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго.
 3. Боломжтой бол хүүхэд бүрт амьдралын мод гэсэн шошготой үзүүлэн бэлд (хичээлийн төгсгөл дэх загварыг үз).
 4. Шаардлагатай материалууд:
 - а. Хүүхэд бүрт Мормоны Ном
 - б. Ойролцоогоор таван метр олс, дээс, эсвэл уяа, нүдний боолт болон нэгийг нь *Төрөлт*, нөгөөг нь *Мөнхийн Амьдрал* гэж хаягласан хоёр үгийн хайчилбар.
 - в. Утга санаануудыг нь цаасаар хаасан, амьдралын модны бэлэгдлүүд болон утга санаануудын хүснэгт.
 - г. Зурагнууд: 4-9, Есүс бол Христ (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 240, 62572) 4-10, Есүс Мэндэлсэн нь (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 200, 62116) 4-11, Цовдлолт (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 230, 62505) 4-12, Амьдралын Модны Тухай Лихайн Зүүд (62620), 4-13, Амьдралын Мод ба Төмөр Бариул болон 4-14, Лихай Жимсэнд Хүрч Байгаа нь.
-

Хичээл Заах**Зөвлөмж**

Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.

Анхаарал Татах
Ажиллагаа

Хоёр хүүхдийг ангийнхны урд гаргаж ирээд, нэгийг нь өрөөний нэг талд нөгөө нэгийг нь нөгөө талд нь зогсоо. Эхний хүүхдээр нь *Төрөлт* гэсэн хаягтай цаас буюу хөзрийг, хоёр дахь хүүхдээр нь *Мөнхийн Амьдрал* гэсэн хаягтай цаас буюу хөзрийг бариул. Гурав дахь хүүхдийн нүдийг боо. Хүүхдийг хэд хэдэн удаа дор нь эргүүлсний дараа, түүнийг нэг дэх хүүхдээс хоёр дахь хүүхэд рүү гадны ямар ч тусламжгүйгээр очиж чадах эсэхийг нь хар. Тэгээд хоёр хүүхдийг олс юмуу уяаны үзүүрүүдээс бариулаад хоёр тийш нь татуул. Нүдийг нь боосон хүүхдээр энэ удаад олсноос бариулан, нэг дэх хүүхдээс хоёр дахь хүүхэд рүү дахин очихыг оролдуул. Хоёр дахь удаад яагаад эхний удаагийнхаас хялбар байсныг ярилц. Бид дэлхий дээр амьдарч байхдаа бүгд Тэнгэрлэг Эцэг рүү эргэн очихыг хичээдэг гэж тайлбарла. Биднийг түүн рүү эргэн очих замаа олоход тусалж, тэр бидэнд барьж явах зарим нэг зүйлсийг өгсөн.

- Тэнгэрлэг Эцэг өөрт нь буцаж очиход биднийг удирдахын тулд бидэнд юу өгсөн бэ? (Судрууд, бошиглогчид, Ариун Сүнс.)

Есүс Христийн зургийг үзүүлээд, энэ хичээл Христийн сургаалыг дагах нь биднийг Тэнгэрлэг Эцэгт эргэн очиход хэрхэн тусалж чадахыг тайлбарлах болно гэж хүүхдүүдэд хэл.

Судрын Хэсэг

Санал болгосон зургууд болон Мормоны Номыг ашиглан 1 Нифай 8-аас Лихайн зүүд болон 1 Нифай 11 ба 15:21–36-гаас зүүдний тайллын тухай хэсгийг заа. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii-аас үз.) Судрууд нь голдуу бэлэгдлүүдийг ашигладаг гэдгийг тайлбарла. Бэлэгдэл нь ихэвчлэн зарчим болон сургаалыг төлөөлөхөд хэрэглэгдэж ирсэн танил зүйлс байдаг. Жишээлбэл, хурга нь цэвэр байдлын бэлэгдэл байж болох учраас Есүс Христийг Бурханы Хурга гэж нэрлэдэг. Энэ хичээл дээр хүүхдүүд Лихайн зүүдэндээ харсан бэлэгдлүүд болон тэдгээрийн утгын тухай сурах болно гэдгийг тайлбарла.

Ярилцлага ба Тавьж Болох Асуултууд

Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншнаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.

- Лихай яагаад гэр бүлийхнийгээ амьдралын модны жимсийг идээсэй гэж хүссэн бэ? (1 Нифай 8:10–12.) Тэнгэрлэг Эцэг өөрийнхөө бүх хүүхдүүдэд юу хүсдэг вэ?
- Яагаад Лихайн хөвгүүдийн зарим нь жимснээс идээд, зарим нь идээгүй гэж та нар бодож байна вэ? (1 Нифай 8:13–17.) Бид Тэнгэрлэг Эцэгийн зарлигуудыг тэр болгон дагадаггүйн ямар ямар шалтгаанууд байдаг вэ?
- Лихайн зүүдэн дэх бэлэгдлүүд юу гэсэн утгатай вэ? Амьдралын модны бэлэгдлүүд болон утга санаануудын хүснэгтийг үзүүлээд утга бүрийг нь нээ.

Бэлэгдэл:	Утга санаа:
1. Амьдралын мод (1 Нифай 8:10)	1. Цорын Ганц Хүүгээ дэлхийд өгсөн Бурханы хайр (1 Нифай 11:21–22, Иохан 3:16)
2. Жимс (1 Нифай 8:11)	2. Мөнхийн амьдрал (1 Нифай 15:36, С ба Г 14:7)
3. Төмөр бариул (1 Нифай 8:19)	3. Бурханы үг (1 Нифай 15:23–24)
4. Харанхуй манан (1 Нифай 8:23)	4. Муу ёрын сүнсний уруу таталтууд (1 Нифай 12–17)
5. Агуу хийгээд нүсэр барилга (1 Нифай 8:26–27)	5. Дэлхийн баардамнал (1 Нифай 11:36)

- Нифай тэнгэр элчээс модны утга санааг үзүүлэхийг хүсээд, тэр Аврагчийн мэндэлсэн болон үйлчлэлийн тухай үзэгдлийг харсан. Есүс Христийн мэндэлсэн явдал болон үйлчлэл нь бидэнд зориулсан Бурханы агуу хайрыг хэрхэн үзүүлдэг вэ?
- Модны жимс юуг төлөөлдөг бэ? (Мөнхийн амьдралын бэлэг.) Нифай Есүс Христ бидэнд хайртай учраас бидний гэм нүглийн төлөө цовдлогдож ингэснээрээ бид нүглээ наманчилж, мөнхийн амьдралыг авах болно

гэдгийг харсан. Мөнхийн амьдрал гэдэг нь гэр бүлээрээ Сэлэсчел хаант улсад Тэнгэрлэг Эцэгтэй хамт амьдарна гэсэн утгатай болохыг тайлбарла. Мөнхийн амьдралыг авахын тулд бид юу хийх ёстой вэ?

- Төмөр бариул юуг төлөөлдөг вэ? (Бурханы үг.) Өдөр тутам Мормоны Номноос унших нь Тэнгэр дэх Эцэг рүүгээ эргэн очих зам дээр үлдэхэд бидэнд хэрхэн тусалдаг вэ? (1 Нифай 15:24.) Мормоны Номыг унших нь та нарыг хэрхэн адисладаг вэ?
- Харанхуй манан юуг төлөөлдөг вэ? (Биднийг будилуулж, төөрөгдүүлж чаддаг муу ёрын сүнсний уруу таталтыг.) Сатан биднийг нарийн бөгөөд шулуун замыг орхиулахын тулд ямар ямар аргаар уруу татдаг вэ? Түүний уруу таталтыг эсэргүүцэн бид юу хийж чадах вэ? Нарийн бөгөөд шулуун зам дээр үлдвэл бид яагаад илүү жаргалтай байх вэ?
- Агуу хийгээд нүсэр барилга юуг төлөөлдөг вэ? (Дэлхийн бардамнал.) Та нар зөвийг хийхийг оролдсоноосоо болж яаж дооглуулж байсан бэ? Биднийг дооглодог хүмүүст хэн нөлөөлдөг вэ?

Боломжтой бол хүүхэд бүрт Лихайн зүүдний зургийг гэрт нь өгч явуул. Хүүхдүүдээр ирэх долоо хоногт тэдэнд төмөр бариулаас барьж явахад нь туслах ямар сонголтуудыг хийж болохыг санал болгуул. (Хариултанд нь өдөр тутам Мормоны Номноос унших, эцэг эхдээ дуулгавартай байх, залбирах, шударга байх, сайн найз нөхдийг сонгох, зугаа цэнгэлийн сайн хэлбэрүүдийг сонгох зэрэг багтаж болно.)


Баяжуулах Үйл Ажиллагаа

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно.

1. Тохируулдаг тоглоом тогло. Амьдралын модны бэлэгдэл болон утгын хүснэгтийг ашиглан тусдаа 7,5/ 12,5см-ын хэмжээтэй цаас буюу хөзрөн дээр Лихайн зүүдэн дэх бэлэгдэл бүрийг болон бэлэгдэл бүрийн утга санааг бич. Өөр зургаан 7,5/ 12,5см-ын хэмжээтэй цаас буюу хөзрийг ашиглан инээсэн дүрс, одод болон зүрхнүүдийн зураг, эсвэл бэлэгдлүүдийг тохируулах гурван хосыг хий. Хөзрүүдийг хольж доош нь харуулан шал, эсвэл ширээн дээр дөрвөн багана болгон байрлуул. Хүүхдүүдийг ээлж, ээлжээр нь ирүүлээд, хоёр хөзрийг дээш нь эргүүлүүл. Тус бүр нь юу гэж өгүүлснийг чангаар уншуул. Хэрэв хөзрүүд тохирвол дээш нь харуулан үлдээ. Бүх хөзрүүд дээшээ харахад тоглоом дуусах болно.
2. Хүүхдүүдэд 1 Нифай 15:23–24-ийг цээжлэхэд нь тусал.
3. “Би Бурханы Хүүхэд” дууг дуулах, эсвэл үгийг нь унш (*Хүүхдийн Дууны Ном*, х. 58).

Дүгнэлт

Гэрчлэл	Зарлигуудыг дуулгавартай дагаснаараа бид Тэнгэрлэг Эцэгтэйгээ эргэн хамт амьдарч чадна гэсэн гэрчлэлээ хуваалц.
Зөвлөмж Болгогдсон Гэрийн Уншлага	Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ 1 Нифай 8:5–34-г судлахыг зөвлө. Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.



1 Мод
(1 Нифай 8:10)

Заясан Ганц
Хүүгээ дэлхийд
өгсөн Бурханы
хайр (1 Нифай
11:21–22,
Иохан 3:16)

2 Жимс
(1 Нифай 8:11)

Мөнхийн
амьдрал
(1 Нифай 15:36,
С ба Г 14:7)

3 Төмөр бариул
(1 Нифай 8:19)

Бурханы үг
(1 Нифай
15:23–24)

4 Харанхуй манан
(1 Нифай 8:23)

Муу ёрын
сүнсний уруу
таталтууд
(1 Нифай 12:17)

5 Агуу хийгээд
нүсэр барилга
(1 Нифай 8:26–27)

Дэлхийн
бардамнал
(1 Нифай 11:36)

Лихай ба Түүний Гэр

Бүл Цөлд Удирдагдсан нь

Хичээл
5

Зорилго	Тэд чадах бүхнээ хийж, Тэнгэрлэг Эцэгт итгэх үед тэр тэднийг удирдах болно гэдгийг ойлгоход нь хүүхдүүдэд тусална.
Бэлтгэл	<ol style="list-style-type: none">1 Нифай 16, Алма 37:38–46 болон Сургаалт Үгс 3:5–6-г залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii-ыг үз).2. Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго.3. Анхаарал татах ажиллагааг хэрхэн хийж болохоо мэдэхийн тулд хичээл заахаасаа өмнө туршиж үз.4. Шаардлагатай материалууд:<ol style="list-style-type: none">а. Хүүхэд бүрт Мормоны Номб. Хүүхэд бүрт Библив. Хүүхэд бүрт 50 см-ийн уяаг. Зурагнууд: 4-15, Лиахона (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 302, 62041) болон 4-16, Нифай ба Түүний Хугархай Нум.
Хичээл Заах Зөвлөмж	Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.
Анхаарал Татах Ажиллагаа	<p>Хүүхэд тус бүрт 50 см-ийн урт уяа өг. Тэднээр уяаны нэг үзүүрийг баруун гараар нь нөгөө төгсгөлийг нь зүүн гараар нь бариул. Тэднээс үзүүрүүдийг нь тавилгүйгээр уяанд зангилаа зангидахыг хүс. Хэрэв танд хангалттай уяа байхгүй бол нэг хүүхдийг ангийнхны өмнө гаргаж үйлдлийг хийлгэ.</p> <ul style="list-style-type: none">• Энэ нь хийхэд хэцүү ч юмуу боломжгүй мэт санагдаж байна уу? <p>Хүүхдүүдээр зангилааг дахин зангидахыг хүс, харин энэ удаад эхлээд цээжинд нь гарыг нь авахуул, гарыг нь нугалсан чигээр уяаны нэг үзүүрийг баруун гараар нь, нөгөө үзүүрийг нь зүүн гараар нь авахуул. Тэднээс үзүүрүүдийг нь барьсан чигтээ гараа дэлгэхийг хүс. Уяа нь зангилагдах болно. Хүүхдүүдээс уяануудыг цуглуул. Та нар хүүхдүүдэд үүнийг хэрхэн хийдгийг үзүүлснээр тэд зангилааг зангидсан болохыг анхааруул. Үүний адилаар бид бүгд амьдралдаа шийдэх боломжгүй мэт санагдах тийм сорилтуудтай байх болно гэдгийг хүүхдүүдэд хэл. Хэрэв бид чадах бүхнээ хийж Тэнгэрлэг Эцэгтээ итгэвэл тэр бидэнд хариултуудыг олж авахад тусална.</p>
Судрын Хэсэг	Тохиромжтой үед нь зургуудыг ашиглан 1 Нифай 16:17–32-оос Лихайн гэр бүл Лиахонагаар удирдуулж байсан болон Нифайн хугарсан нумын хэсгийг заа. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii-аас үз.) Хүүхдүүдэд юу ч тохиолдсон өөрсдийн чадахаа хийж Аврагчид итгэхэд нь урам өгч зоригжуул.

Ярилцлага болон
Тавьж Болох
Асуултууд

Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншнаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.

- Цөлд аялаж байхдаа Лихай итгэл болон дуулгавартай байсныхаа төлөө хэрхэн адислагдсан бэ? (1 Нифай 16:10.)
- Нифайг ган нумаа хугалахад Нифайн аав болон ах нар яасан бэ? (1 Нифай 16:17–21.) Юмс нь та нарын хүссэн замаар явагдахгүй байх үед гомдол гаргах нь яагаад амархан байдаг вэ?
- Хэдийгээр Нифай ядарч, өлсөж байсан ч тэр гомдол гаргаагүй. Асуудлыг шийдэхэд туслахын тулд тэр юу хийсэн бэ? (1 Нифай 16:22–32.)
- Нифай яагаад ааваасаа туслахыг хүссэн бэ? (1 Нифай 16:23–24.) Та нарыг асуудалтай байхад эцэг эх чинь хэрхэн тусалдаг вэ?
- Та нар Нифайн адил эцэг эх, ах, эгч нартаа хэрхэн сайн жишээ байж чадах вэ?
- Лиахона (гуулин бөмбөлөг) хэрхэн ажилладаг вэ? (1 Нифай 16:26–30.)
- Тэнгэрлэг Эцэг бидэнд өөр лүү нь буцаж очих замыг зааж өгөх ямар зүйлийг бидэнд өгсөн бэ? (Алма 37:44–45.) Христийн үгийг бид хаанаас олж чадах вэ? (Судруудаас.) Христийн үгээр удирдуулах боломжтой байхын тулд бид юу хийж чадах вэ? (Алма 37:46.)
- Хэрэв бид Тэнгэрлэг Эцэгээс тусламж авахыг хүсвэл юу хийх ёстой вэ?
- Хэрэв бид Тэнгэрлэг Эцэгт итгэлтэй байгаад, түүнд найдвал тэр яах вэ? (Сургаалт Үгс 3:5–6.) Та нар Тэнгэрлэг Эцэгт итгэж, найдаж байгаагаа хэрхэн үзүүлж чадах вэ? Тэнгэрлэг Эцэг биднээс түүнд итгэж чадах бүхнээ хийхийг яагаад хүсдэг гэж та нар бодож байна вэ?

Баяжуулах Үйл Ажиллагаа

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно.

1. Хүүхдүүдээр Нифайн хугархай нумын тухай түүхийг дахин яриул. Тэднээр бэрхшээлүүдтэй тулгарахдаа Лихайн гэр бүлийн гишүүдийн хэнтэй нь адилхан байхыг хүсч байгааг нь ярилцуул.
2. Хугархай нумын тухай түүхийг жүжигчлэн тоглуул. Тэгээд хэрэв Лэмэн, Лэмүэл нар Их Эзэнд итгэж найдаж байсан бол юу болох байснаар жүжигчилсэн тоглолт хийлгэ.
3. Сайн мэдээний анхны зарчим юу болох эсэхийг хүүхдүүдээс асуу. Тэд Есүс Христэд итгэлтэй байх ёстой гэдгийг онцол. Тэдэнд итгэлийн тунхгийн дөрөвдүгээрийг цээжлэхэд нь тусал.
4. 1 Нифай 3–5-д өгүүлсэн Нифай гуулин ялтсуудыг авч байгаа тухай түүхийг дахин товч ярилц. Нифай тэгэхэд юу хийснийг, нумаа хугалчихаад юу хийсэнтэй харьцуул. Тэр хоёуланд нь юу чаддагаа хийсэн, мөн Тэнгэрлэг Эцэг өөрт нь туслана гэдэгт итгэж байсныг ойлгоход нь хүүхдүүдэд тусал.

Дүгнэлт

Гэрчлэл ба Сорилт	Та ямар нэгэн хэцүү зүйл хийхдээ Тэнгэрлэг Эцэг туслана гэдэгт итгэж байсан үеийнхээ талаар хүүхдүүдтэй хуваалц. Бид чадах бүхнээ хийгээд, тэгээд Тэнгэрлэг Эцэгт итгэхийн ач холбогдлын талаарх гэрчлэлээ ярь. Хүүхдүүдийг ирэх долоо хоногт Нифайн тухай бодож, асуудлууд гарч ирвэл түүнтэй илүү адил болохыг хичээж үзэхийг уриал.
Зөвлөмж Болгогдсон Гэрийн Уншлага	Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ 1 Нифай 16:18–32-г судлахыг зөвлө. Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.

Тэнгэрлэг Эцэг Нифайд Усан Онгоц Барихыг Тушаасан

Зорилго Тэнгэрлэг Эцэгийнхээ зарлигуудыг дуулгавартай дагаснаар гэр бүлийнхэндээ сайн үлгэр дуурайл болж сүнслэг нөлөөтэй байхыг хүсэхэд нь хүүхдүүдэд тусална.

Бэлтгэл

- 1 Нифай 17-г залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii-ыг үз).
2. Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго.
3. Шаардлагатай материалууд:
 - а. Хүүхэд бүрт Мормоны Ном
 - б. Хүүхэд бүрт харандаа, цаас
 - в. Зурагнууд: 4-17, Нифай Хүдэр Хайлуулж, Багаж Зэвсэг Хийж Байгаа нь; 4-18, Нифай Дуулгаваргүй Ах Нараа Номхотгосон нь (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 303, 62044).

Хичээл Заах Зөвлөмж

Анхаарал Татах
Ажиллагаа

Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.

Ангийн нэг гишүүнийг өнгөрсөн долоо хоногийн хичээл дээр үзсэн Нифайн хугархай нум болон Нифай гэр бүлдээ хэрхэн хоол хүнс олж ирж байгаа түүхийг товч ярихыг урь (1Нифай 16:17–32-г үз).

Усан онгоцны зураг үзүүл, эсвэл хүүхэд бүрт цаас, харандаа өгөөд, тэднээр усан онгоцны зургийг хурдан зуруул. Тэгээд тэднээс дараах асуултуудын заримыг асуу.

- Та нарыг болон гэр бүлийг тань далайгаар авч явж чадах хангалттай том, хүчтэй усан онгоц барихад ямар ямар материал шаардагдана гэж та нар бодож байна вэ?
- Ямар ямар төрлийн тусламж та нарт хэрэгтэй вэ?
- Усан онгоц хэрхэн барихыг сурахаар та нар хаашаа явж болох вэ?

Нифайд усан онгоц барихад Тэнгэрлэг Эцэг хэрхэн тусалсныг тэд сурах болно гэдгийг хүүхдүүдэд тайлбарла.

Судрын Хэсэг

1 Нифай 17-гоос Нифай болон түүний ах нар усан онгоц барихдаа бэлтгэж байгаа хэсгийг заа. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii-аас үз.) Тохиромжтой үед нь зургуудыг ашигла. (Та хүүхдүүдээр зураг бүр дэх хүмүүсийг тодруулуулж мөн тэд юу хийж байгааг нь хэлүүл.)

Ярилцлага ба
Тавьж Болох
Асуултууд

Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншнаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.

- Хэрэв бид Их Эзэний зарлигуудыг дуулгавартай дагах юм бол тэр бидэнд юу амладаг вэ? (1 Нифай 17:3.) Дуулгавартай байдлаас тань үүдэн та нар болон танай гэр бүл хэрхэн адислагдаж байсан бэ?
- Их Эзэн яагаад Нифайг усан онгоц барихыг тушаасан бэ? (1 Нифай 17:8.) Энэ зарлигт Нифай ямар хариулт өгсөн бэ? (1 Нифай 17:9.) Нифайд юу ийм агуу итгэлийг өгсөн бэ? (1 Нифай 17:14–15.)
- Их Эзэн тэдэнд яагаад зүгээр л усан онгоц өгөөгүй гэж та нар бодож байна вэ?
- Лэмэн, Лэмүэл хоёр яагаад Нифайд усан онгоц барихад нь туслахыг хүсээгүй вэ? (1 Нифай 17:17–19, 45–46.) Хамтран ажиллах нь усан онгоц барихыг хэрхэн илүү хялбар болгосон байна вэ?
- Та нарыг Тэнгэрлэг Эцэгийн зарлигуудыг сахисны төлөө ах нар чинь та нарыг дооглосон бол та нарт ямар санагдах байсан вэ? Та нар гэр бүлдээ хэрхэн тусалж чадах вэ? Та нар гэр бүлдээ тусалсан, эсвэл туслаагүй үедээ ямар сэтгэгдэлтэй байдаг вэ?
- Нифайг ах нар нь алахыг оролдоход Тэнгэрлэг Эцэг түүнд юу хийх хүч чадлыг өгсөн бэ? (1 Нифай 17:48, 54.)
- Нифай Есүс Христэд итгэх итгэлээ хэрхэн үзүүлсэн бэ? (1 Нифай 17:50–51.) Та нар Нифайн адил байж эр зориг болон Есүс Христэд итгэх итгэлээ хэрхэн харуулж чадах вэ?

**Баяжуулах Үйл
Ажиллагаа**

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно.

1. Ангийг хоёр хэсэгт хуваа. Нэг хэсгээр нэгэн дуугаар 1 Нифай 17:3-ыг, тэгээд нөгөө хэсгээр 1 Нифай 3:7-г нэгэн дуугаар уншуулан биднийг хүлцэнгүй байхад Их Эзэн бидэнд юу амладгийг сонсохыг тэднээс хүс. Хэрэв тэд зарлигуудыг сахиж, Тэнгэрлэг Эцэгээс удирдамж хүсвэл тэд адислагдах болно гэдгийг ойлгоход нь хүүхдүүдэд тусал.
2. 1 Нифай 17:3-ын “Мөн хүмүүний үрс”-ээр эхлээд “арга замуудыг хангаж өгөх бөлгөө” хүртэл хүүхдүүдэд цээжлэхэд нь тусал. Тэдэнд бас 1 Нифай 17:50-ийн “Хэрэв Бурхан надад бүх зүйлийг зарлигласан бол би тэдгээрийг хийж чадах бөлгөө” хэсгийг цээжүүлж болно.
3. Ширээн дээр тагтай шилэн сав байрлуулаад, шилэн савыг нэг гараараа онгойлгохыг оролдохыг нэг хүүхдээс хүс. (Тэр хүүхдийн нөгөө гарыг нь нурууных нь ард авахуул) Хэд хэдэн оролдлогын дараа өөр нэг хүүхдээс зөвхөн нэг гараараа туслахыг хүс. Бид хамтдаа ажиллах үед даалгаварууд нь гүйцэтгэхэд ямагт хялбар байх болно гэдгийг тайлбарла. Тогтмол гэр бүлийн үдэш, гэр бүлийн залбирал, гэр бүлээрээ судраас судлах зэрэг гэр бүлийн зорилтуудыг ярилцаад

хүүхдүүдээс гэр бүлийнхнээ эдгээр зорилтуудад хүрэхэд нь хэрхэн тусалж чадахыг нь асуу.

4. Цаас, харандаа тарааж өгөөд ангийн гишүүдээс өдөр тутмын судрын сургалтыг дэмжих, гэр бүлийн залбиралд хүсэлтэйгээр оролцох, гэр бүлийн үдшийг зохион байгуулахад тусалж мөн оролцох, эцэг эхээ дуулгавартай дагах, орон гэрээ цэвэр цэмцгэр байлгахад туслах, гэр бүлийнхнийхээ төлөө залбирах, бие биедээ хайр болон эелдэг байдлыг үзүүлэх, Хүүхдийн Хэсэг дээр юу сурснаа хуваалцах зэргээр гэр бүлийнхнээ сайн мэдээнээс суралцаж, зарлигуудыг сахихад туслахын тулд хийж чадах зүйлээ жагсаахыг хүс. Тэднээр ирэх долоо хоногт сайжруулахаар ажиллахыг хүсэж байгаа нэг зүйлийг нь сонгуул.
5. Самбар дээр Лихай болон түүний гэр бүлийн аялал хийгээд Израилын хүүхдүүд цөлд хэсүүчлэн явсны хоорондох адил талуудыг жагсаа (1 Нифай 17:22–46). Бид эдгээр явдлуудаас юу сурч болохыг хүүхдүүдээс асуу.
6. “Зөв замыг сонго” дууг дуулах, эсвэл үгийг нь унш (*Сүмийн Дуулал*, х. 64).

Дүгнэлт

Гэрчлэл	Хүүхэд бүр гэр бүлийнхэндээ сайн үлгэр дуурайл үзүүлж чадахыг гэрчил. Бид болон гэр бүлүүд маань зарлигуудыг дагаснаараа адислагдах болно гэдгийг анхааруул.
Зөвлөмж Болгогдсон Гэрийн Уншлага	Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ 1 Нифай 17:3–22, 45–55-ыг судлахыг зөвлө. Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.

Зорилго Ариун Сүнсийг байнгын хамтрагчаа байлгахуйц зохистой байхыг хүсэхэд нь хүүхдүүдэд тусална.

Бэлтгэл

- 1 Нифай 18-ыг залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii-ыг үз).
2. Нэмэлт уншлага: *Gospel Principles*, бүлэг 7.
3. Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго.
4. Шаардлагатай материалууд:
 - а. Хүүхэд бүрт Мормоны Ном
 - б. Нүд боох даавуу
 - в. Зурагнууд: 4-15, Лиахона (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 302, 62041); 4-19, Нифай Хүчээ Нэгтгэсэн нь болон 4-20, Лихай болон Түүний Хүмүүс Амласан Газарт Ирсэн нь (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 304, 62045).

**Хичээл Заах
Зөвлөмж**

Анхаарал Татах
Ажиллагаа

Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.

Ангийн өмнө сандал буюу бусад зүйлсийг ашиглан жижиг саадыг бий болго. Сайн дураараа нүдээ боолгох хүүхдийг урь. Хүүхдийг хэд хэдэн удаа дор нь эргүүл, тэгээд нүдээ боосон хүүхдэд өөр нэг хүүхэд чиглэлийг нь шивнэх, эсвэл намуун дуугаар хэлж саадыг давахад нь удирдах болно гэдгийг тайлбарла. Үйл ажиллагааг давтан хий, энэ удаад буруу чиглэлийг чанга дуугаар өгөхийг өөр хүүхдээс хүс. Ингэснээр нүдээ боолгуулсан хүүхэд намуун дуу хоолойг сонсохоор анхаарлаа төвлөрүүлэх хэрэгтэй болно.

Нүдээ боолгуулсан хүүхдээр хоёр тохиолдол дахь ялгааны талаар яриул.

- Ариун Сүнс гэж хэн бэ? Тэр бидэнд хэрхэн тусалдаг вэ? (*Gospel Principles*, Бүлэг 7-г үз.)
- Саадыг давахад удирдагдах явдал нь Ариун Сүнсийг сонсохтой хэрхэн адил байх вэ?
- Бидний эргэн тойронд буй ямар муу ёрын нөлөөлөл буюу “чанга дуунууд” нь биднийг будилуулах, эсвэл буруу замаар хөтлөхийг оролдож чадах вэ?

Судрын Хэсэг

1 Нифай 18-аас Лихайн гэр бүл тэнгисийг гаталж байгаа тухай түүхийг заа. Зургуудыг тохиромжтой үед нь ашигла. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii-аас үз.)

Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншнаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.

- Нифай гэр бүлийг нь далайгаар аюулгүй авч явах усан онгоцыг хэрхэн барьсан бэ? (1 Нифай 18:1–3.)
- Лэмэн, Лэмүэл, Ишмэилийн хөвгүүд болон тэдний эхнэрүүд Лиахонагийн ажиллахыг зогсоох шалтгаан болсон ямар зүйлийг хийсэн бэ? (1 Нифай 18:9–12.) Тэнгэрлэг Эцэг бидэнд Лиахонагийн адил биднийг удирдах ямар зүйлийг өгсөн бэ? (Ариун Сүнс.) Бидний болон гэр бүлүүдийн маань Ариун Сүнсний удирдамжийг алдагдуулдаг ямар зүйлүүд байдаг вэ?
- Лэмэн, Лэмүэл нарын дуулгаваргүй байдал тэдний эцэг эх болон гэр бүлийн бусад гишүүдэд хэрхэн нөлөөлсөн бэ? (1 Нифай 18:12–19.) Бидний дуулгавартай болон дуулгаваргүй байдал эцэг эх болон гэр бүлийн бусад гишүүдэд маань хэрхэн нөлөөлдөг вэ?
- Нифайг ах нар нь дээрэлхэж байхад тэр ямар хариу үйлдэл үзүүлсэн бэ? (1 Нифай 18:16.) Нифай зовж байхдаа Их Эзэнд гомдоллохынхоо оронд яагаад магтан дуулсан гэж та нар бодож байна бэ?
- Ямар арга байдлаар та нар Нифайтай илүү адил болохыг хүсч байна вэ?
- Ямар арга замуудаар Ариун Сүнсний илчлэлт бидэнд ирж болох вэ? (Энэ нь амар амгалан, эсвэл тайвшралын мэдрэмж, биднийг зөв сонголт хийхэд өдөөсөн бодол, удирдах намуун дуу хоолой, аюулаас сэрэмжлүүлсэн мэдрэмж зэргээр ирж болно.)
- Ангийн гишүүдийг Ариун Сүнсний нөлөөллийг мэдэрсэн үеийнхээ тохиолдлуудаас хуваалцахад урь. Бид Ариун Сүнсний нөлөөллийг таньдаг болоход өөрсдийгөө бэлтгэхийн тулд юу хийж чадах вэ?
- Ариун Сүнсний нөхөрлөлд зохистой байхад Нифай ямар сонголтуудыг хийсэн бэ? (1 Нифай 18:3, 10, 16.) Та нар Ариун Сүнсний нөхөрлөлд зохистой байхын тулд өдөр тутам ямар сонголтуудыг хийдэг вэ?

Баяжуулах Үйл Ажиллагаа

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно.

1. *Залбирал, найз нөхдөө сонгох, бидний хэрэглэдэг үгс, телевизийн шоу, дүрс бичлэгийн хөтөлбөрүүд, хөгжим, кинонууд, эцэг эхчүүддээ дуулгавартай байх, зарлигуудыг дагах, ах, эгч нартаа эелдэг хандах, бусад хүмүүсийг хүндэтгэх, үйлчлэл г.з. үгсийг, эсвэл бусад тохиромжтой үйл ажиллагаануудыг тусдаа цааснууд дээр бич. Цааснуудаа жижиг саванд хий. Хүүхэд бүрээр нэг нэг цаас сугалуулаад, ангийнханд нь чангаар уншуулж бичигдсэн зүйл нь бидний амьдралд Ариун Сүнсийг байлгах чадварт хэрхэн нөлөөлөхийг хэлүүл.*
2. Итгэлийн тунхгийн нэг ба дөрөвдүгээрийг давт.

3. Есүсийн сургаал номлолуудыг дагах нь амьдралдаа Ариун Сүнсний нөлөөлөлтэй байхад бидэнд хэрхэн туслахыг хүүхдүүдтэй ярилц. Хүүхдүүдээр ирэх долоо хоногт илүү бүрэн дүүрнээр амьдрахыг хүсч байгаа Есүсийн сургаал номлолуудаас нэгийг сонгуулан санамж болгон цаасан дээр бичүүлээд гэр лүү нь өгч явуул.

Дүгнэлт

Гэрчлэл	Та Ариун Сүнс нөлөөлж байсан үеийнхээ тохиолдлоос хуваалцаж болно. Амьдралдаа Ариун Сүнсний нөлөөллийн ач холбогдол болон түүний байнгын нөхөрлөлтэй байхын чухал болох талаар гэрчлэлээ хуваалц.
Зөвлөмж Болгогдсон Гэрийн Уншлага	Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ 1 Нифай 18:5–25-ыг судлахыг зөвлө. Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.

Шерим Бошиглогч Иаковтай Маргасан нь

Зорилго

Есүс Христийн талаарх хүүхдүүдийн гэрчлэлийг хүчирхэгжүүлж ингэснээр тэд муу ёрын нөлөөллийн эсрэг зогсох хүч чадалтай болно.

Бэлтгэл

1. Иаков 7:1–23-ыг залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii-ыг үз).
2. Нэмэлт уншлага: 1 Нифай 18:7, 2 Нифай 2:1–4, 11:2–3, Иаков 1:17–19 болон Мормоны Номны Индекс: Лихайн Хүү—Иаков.
3. Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго.
4. Шаардлагатай материалууд:
 - а. Хүүхэд бүрт Мормоны Ном
 - б. Ойролцоогоор 60 см-ийн урт хэврэг уяа болон 60 см-ийн урт бөх бат олс
 - в. Хүүхэд бүрт цаас, харандаа
 - г. Зураг 4-9, Есүс бол Христ (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 240, 62572)

Хичээл Заах Зөвлөмж

Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.

Анхаарал Татах
Ажиллагаа

Нэг хүүхдэд 60 см-ийн уяа өг. Түүнд уяаг тасал гэж хэл. Тэгээд уг хүүхдээр олс таслахыг оролдуул. Өөр хэдэн хүүхдүүдээр бас олс таслахыг оролдуул. Бидний гэрчлэл ширхэг уяа шиг эхлэдэг боловч энэ нь тасрахгүй болтлоо бөх бат болж чадна гэдгийг тайлбарла. Бусад хүмүүс биднийг болон бидний итгэлийг сорих, эсвэл биднийг мэхлэхийг оролдоход бидэнд туслах хүчтэй гэрчлэлүүдийг бид хөгжүүлж чадна. Энэ хичээл нь хувирашгүй гэрчлэлтэй байсан Иаковын тухай болохыг хүүхдүүдэд хэл.

Судрын Хэсэг

Иаков 7:1–23-аас Иаков, Шерим хоёрын түүхийг ярь. Тохиромжтой үед нь зургийг ашигла. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii-аас үз.)

Ярилцлага ба
Тавьж Болох
Асуултууд

Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншнаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.

- Иаков гэж хэн байсан бэ? (Нифайн дүү нарын нэг.) Иаков, Шерим нар Христийг мэндлэхээс ойролцоогоор хэдэн жилийн өмнө амьдарч байсан бэ? (Иаков 7 дахь хуудасны доод талыг үз.)

- Хараахан мэндлээгүй байсан Есүс Христийн тухай Иаков хэрхэн мэдэж авсан бэ? (Иаков 7:5, 10–12.)
- Шерим Есүс Христ ирэхгүй хэмээн хүмүүст итгүүлэхийг оролдон юу хийсэн бэ? (Иаков 7:2–4.) Зусардалт гэдэг нь юу гэсэн утгатай вэ? (Чин сэтгэлээсээ бус, хэтэрхий их магтах, шударга бус байдлын нэг хэлбэр)
- Шеримд хэн нөлөөлсөн бэ? (Иаков 7:4, 18.) Сатан бидэнд нөлөөлөхийг хэрхэн оролддог вэ?
- Шеримийн зарим худал зүйлс нь юу байсан бэ? (Иаков 7:7, 9–10, 19.)
- Иаков яагаад Шеримийн муу ёрын нөлөөллийн эсрэг зогсож чаддаг байсан бэ? (Иаков 7:5, 8, 10–12.) Хэдийгээр бид тэнгэрийн элчүүдийг харж, Бурханы дуу хоолойг сонсож чадахгүй ч хүмүүс биднийг буруу зүйл хийлгэхээр уруу татахад нь хүчирхэг байхын тулд бид юу хийж чадах вэ? Тохиолдлоосоо ярь, эсвэл нэг хүүхдээр хэн нэгний муу ёрын нөлөөллийн эсрэг зогсож байсан тухай нь яриул.
- Иаков яагаад Шеримд тэмдэг үзүүлэхийг хүсээгүй вэ? (Иаков 7:13–14.) Их Эзэн итгэл нь тэмдгээр ирдэггүй харин тэмдгүүд нь итгэгчдийг дагадаг хэмээн хэлсэн (С ба Г 63:7–12.) Тэмдгүүд нь биднийг итгэл болон дуулгавартай байдлаа үзүүлсний дараа ирэхээс биш бид тэдгээрийг хайх ёсгүй гэдгийг тайлбарла. Өнгөрсөн хичээлүүдээс Лэмэн, Лэмүэл хоёр хэдийгээр тэмдгүүдийг харж байсан ч тэдэнд итгэл дутагдсаныг товч давт (Багшийн товч тойм: 1 Нифай 3:29–31, 16:39, 17:45, 18:20).
- Шеримийн наманчлал болон үхэл нь хүмүүст ямар нөлөө үзүүлсэн бэ? (Иаков 7:21–23.)
- Бид яагаад Есүс Христийн тухай хүчтэй гэрчлэлтэй байх хэрэгтэй вэ? Бид Аврагчийн талаарх гэрчлэлээ хэрхэн олж авч, мөн хүчирхэгжүүлж чадах вэ? (Баяжуулах үйл ажиллагаа 2-ыг үз.) Бид бусадтай гэрчлэлээ хэрхэн хуваалцаж чадах вэ? Биднийг бусадтай гэрчлэлээ хуваалцахад яагаад гэрчлэл маань улам хүчтэй болдог вэ?

Баяжуулах Үйл Ажиллагаа

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно.

1. Жижиг цааснууд дээр хэн нэг нь хүүхдийг ямар нэгэн буруу зүйл хийхэд итгүүлэхээр оролдож болох нөхцлүүдийг болон судраас үүнтэй дүйцсэн зарлигийг бич. Жишээлбэл, найз чинь чамтай дэлгүүр явж чамаар чихэр хулгайлуулахыг оролдох (Египетээс гарсан нь 20:15, эсвэл Мозая 13:22), хэн нэг нь та нарыг согтууруулах ундаа амсаж үзэхийг санал болгох (С ба Г 89:7), эсвэл та нар Сүмдээ явахын оронд гэртээ үлдэхээр уруу татагдах (С ба Г 59:9). Хүүхдүүдээр судар бүрийг олуулж уншуул. Судар юу заадгийг мэдэх нь Есүс Христийн тухай гэрчлэлийг хүчирхэгжүүлж, муу ёрын нөлөөллүүдийн эсрэг зогсоход бидэнд хир их тусалдгийг ярилц.

Та хүүхдүүдээр эдгээр нөхцлүүдээр пантомими тоглуулж, бусад хүүхдүүдээр юуг жүжиглэж байгааг таалгаж болно.

2. Ангийг хоёр бүлэгт хуваа. Нэг бүлэгт нь Алма 5:46, нөгөөд нь Алма 37:35-ыг даалга. Хүүхдүүдээр эдгээр судруудаас Есүс Христийн тухай гэрчлэлээ хүчирхэгжүүлэх арга замуудыг олуул. Тэдний хариултуудыг самбар дээр хураангуйлан бич.

Дүгнэлт

Гэрчлэл

Хүүхдүүдэд эргэн тойрондоо байгаа муу ёрын нөлөөллийн эсрэг зогсож чадахын тулд Есүс Христийн тухай гэрчлэлийг олж авч хүчирхэгжүүлэх нь хир их ач холбогдолтойг хэл. Аврагчийн тэнгэрлэг байдлын тухай гэрчлэлээ хуваалц. Хүүхдүүдэд гэрчлэлүүдээ хүчтэй болгох нэг арга замыг сонгож, санаж байхын тулд цаасан дээр бичиж гэртээ аваачаад ирэх долоо хоногт үүн дээр ажиллахыг уриал.

Зөвлөмж

Болгогдсон

Гэрийн Уншлага

Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ Иаков 7:1–23-ыг судлахыг зөвлө.

Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.

Зорилго Тэнгэрлэг Эцэгт хандсан чин сэтгэлийн залбирлаар ирэх адислалуудыг эрэлхийлэхэд нь хүүхдүүдийг урамшуулна.

Бэлтгэл

1. Иносын номыг залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii-ыг үз).
2. Нэмэлт уншлага: *Gospel Principles*, бүлэг 8.
3. Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго.
4. Шаардлагатай материалууд: а. Хүүхэд бүрт Мормоны Ном

**Хичээл Заах
Зөвлөмж**

Анхаарал Татах
Ажиллагаа

Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.

Дараах тааврыг хэлээд, хариултыг мэдсэн үедээ гараа өргөхийг хүүхдүүдээс хүс.

Би хүн, газар, эсвэл эд зүйл биш.

Би өөр хэн ч сонсож чадахааргүй тийм чимээгүй, эсвэл өрөөн дэх бүх хүмүүс сонсож чадахаар тийм чанга байж чадна.

Та нар ганц нэгээрээ, эсвэл олуулаа байхдаа намайг хэрэглэж болно.

Намайг хэзээ ч, хаана ч, ямар ч нөхцөлд хэрэглэж болно.

Намайг та нар өөртөө, эсвэл өөр хэн нэгний төлөө талархал, удирдамж, тайтгарал, өршөөл, хамгаалалт, тусламж, сайн эрүүл мэнд, эсвэл аливаа адислалуудыг хүсэхдээ зориулан ашигладаг.

Та нар намайг Тэнгэрлэг Эцэгтэй ярихдаа ашигладаг.

Би юу вэ?

Хүүхдүүдийн хариултуудыг самбарт бич. Зөв хариулт нь залбирал гэдгийг мэдсэний дараа тэдэнд залбирлын тухай ямар нэгэн асуулт байгаа эсэхийг нь лавла. Асуултуудыг нь самбарт хураангуйлан бичээд хариултуудыг нь таныг Иносын түүхийг ярьж өгч байхад сонсохыг хүүхдүүдээс хүс. Түүхийн төгсгөлд асуултууд руу эргэн ороод, тэдгээрийн талаар ярилц.

Судрын Хэсэг

Иносын номны хэсгээс заа. Инос бол 8-р хичээл дээр суралцсан Иаковын хүү байсан гэдгийг тайлбарла. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii-аас үз.)

Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншнаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.

- Инос яагаад залбирахаар явсан бэ? (Инос 1:1–4.) Хэн түүнд Есүс Христийн тухай заасан бэ? Эцэг эх тань та нарт Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийн тухай сурахад хэрхэн тусалсан бэ?
- “Хүчит залбирал болон гуйлтаар” гэж юу вэ? Ийм төрлийн залбирал нь бусад залбирлаас юугаараа ялгаатай гэж та нар бодож байна вэ? Тэнгэрлэг Эцэг Иносын залбиралд хэрхэн хариулсан бэ? (Инос 1:5.)
- Инос түүний гэм нүгэл өршөөгдсөн гэдгийг хэрхэн мэдсэн бэ? (Инос 1:5–6.)
- Тэнгэрлэг Эцэг яагаад Иност гэм нүгэл нь өршөөгдсөн гэж хэлсэн бэ? (Инос 1:8.) Есүс Христ бидний гэм нүглийн төлөө зовсон учраас хэрэв бид нүглээ наманчилвал бид өршөөгдөх болно гэдгийг тайлбарла.
- Гэм нүгэл нь өршөөгдсөний дараа Инос хэний төлөө залбирсан бэ? (Инос 1:9.) Их Эзэн Иност Нифайчуудын талаар ямар хариулт өгсөн бэ? (Инос 1:10.)
- Лэмэнчүүд нь Нифайчуудын дайсан байсаар байхад Инос яагаад тэдний төлөө залбирсан гэж та нар бодож байна бэ? (Инос 1:11.) Та нарт эелдэг бус байдаг хэн нэгэнд өгөх ямар адислалуудыг та нар Тэнгэрлэг Эцэгээс хүсч болох вэ? Инос Лэмэнчүүдэд юу хүссэн бэ? (Инос 1:13.)
- Инос ард түмнийхээ бичээсийг аюулгүй байлгахын төлөө залбирсан. Эдгээр бичээс нь яагаад тийм чухал байсан бэ? Их Эзэн Иност юу амласан бэ? (Инос 1:15–18.) Итгэл байж гуйх гэдэг нь юу гэсэн үг вэ?
- Иност ямар амлалтуудыг өгсөн бэ? (Инос 1:8, 12, 15.) Бид үүнтэй адил амлалтуудыг хэрхэн хүртэж чадах вэ?
- Нифайчуудын Лэмэнчүүдэд үзүүлсэн сургаал номлол болон хичээл зүтгэлүүд ямар нөлөө үзүүлсэн бэ? (Инос 1:20.)
- Иносын түүхээс та нар залбирлын тухай юу сурсан бэ?
- Та нар залбирч байхдаа Тэнгэрлэг Эцэгтэй хэрхэн ярьдаг вэ? Бид залбирлаа хэрхэн илүү чин сэтгэлийнх болгож чадах вэ?
- Инос Их Эзэний дуу хоолойг залбирлынхаа хариултанд оюун санаандаа сонссон. Бид залбирлынхаа хариултыг авч болох өөр ямар ямар арга байдаг вэ? (Амар амгалангийн мэдрэмж, ямар нэгэн зүйлийг буруу гэсэн мэдрэмж, тайтгарал, бидний оюун санаанд ирж байгаа санаанууд, онцгой нөхцөл байдлыг ойлгох ойлголтыг авчрах судрууд, Их Эзэнээс илгээгдсэн Сүмийн удирдагчид, эцэг эх болон бусдаас ирэх зөвлөмж, зүүд, эсвэл үзэгдлүүд.) Залбирлынхаа хариултыг хүлээн авч байсан тохиолдлоосоо хуваалцахыг ангийн гишүүдийг урь.
- Тэнгэрлэг Эцэг бидний залбиралд яагаад “үгүй” гэж хариулж болох вэ? Тэнгэрлэг Эцэгийн хариулт “үгүй” гэдгийг бид хэрхэн мэдэж болох вэ?

- Яг Иностой адил залбирсныхаа дараа бидэнд яагаад сонсох хугацаа хэрэгтэй вэ?
- Инос үхлийн дараах амьдралын тухай юу сурсан бэ? (Инос 1:27.) Та энэ шүлгийг уншиж өгөх, эсвэл ангийнхнаараа нэгэн дуугаар уншуулж болно.

Хүүхдүүдийн бүх асуултууд хариулагдсан эсэхийг шалгаж самбар дээрх жагсаалтан дээр тэмдэглэ.

Баяжуулах Үйл Ажиллагаа

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно.

1. Хүүхэд бүрт цаас харандаа өгөөд, тэднээр *Бид хэзээ залбирч болох вэ? Бид хаана залбирч болох вэ?* Болон *Бид юуны талаар залбирч болох вэ?* гэсэн асуултуудыг хооронд нь хариултыг бичих зайг үлдээлгэн бичүүл. Та асуултуудыг ярилцаж байхдаа тэднээр хариултуудыг бичүүл.
2. Залбирлын загварыг давт:
 - а. Тэнгэр дэх Эцэгтээ хандан эхэл.
 - б. Түүнд юунд талархаж байгаагаа хэл.
 - в. Түүнээс хүсч байгаа зүйлээ гуй.
 - г. “Есүс Христийн нэрээр, амэн” гэж хэлж дуусга.
3. Залбирахдаа хэл яриагаа хянаж бай. Чи, чиний, чинийх үгсийг биш харин та, таны, таных гэсэн үгсийг хэрэглэснээрээ хүндэтгэлээ харуулдаг гэдгийг хүүхдүүдэд ойлгуул (Dallin H. Oaks, in Conference Report, Apr. 1993, pp. 16–20; or *Ensign*, May 1993, pp. 15–18- ыг үз).
4. Зайнуудыг хоосон орхин Ахлагч Боид Б. Пакерын дараах мэдэгдлийг самбарт бич (Conference Report, Oct. 1979, p. 30, or *Ensign*, Nov. 1979, p. 21). Ахлагч Пакерын мэдэгдэл дэх зайнуудыг бөглөснөөр хариулт авах зарим аргуудыг сурах болно гэдгийг хүүхдүүдэд хэл.

“Зарим _____ (б) _____ (а) _____ уншснаар, зарим нь _____ (д) _____ сонссоноор ирэх болно. Тэгээд, ялангуяа энэ нь маш их чухал бол, зарим нь шууд болон _____ (г) _____ (е) _____ ирнэ. Өдөөлт нь _____ (в) _____, андуурамгүй байх болно.”

Зайг бөглөхөд дараах үгсийг ашигла:

- а. Судруудыг
 - б. Хариултууд
 - в. Цэвэр
 - г. Хүчтэй
 - д. Яриа өгөгчдийг
 - е. Илчлэлтээр
5. Бичээсийг хамгаалах талаар Иносын залбирал нь олон зуун жилийн дараа Мормоны Номтой хамт хэрхэн хариулагдсныг тайлбарла (Инос 1:14–16). Их Эзэн Иност амласан ёсоор өнөөдрийн хүмүүс Мормоны Номоор дамжуулан Есүс Христийн тухай гэрчлэлийг олж авч чаддаг. Та нэг эргэж ирсэн номлогчийг ангидаа ирэхийг уриад, залбирал

болон Мормоны Номоор дамжуулан Есүс Христийн тухай гэрчлэл олж авсан хүний тухай түүхийг яриул.

6. Иосеф Смитийн анхны үзэгдэл дэх түүний итгэлийн чин сэтгэлийн залбирал хэлсэн хэсгийг давт (Иосеф Смит—Түүх 1:14–16). Та Анхны Үзэгдлийн тухай зургийг ашиглаж болно (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 403, 62470).
7. Итгэлийн тунхгийн долоо болон есдүгээрийг товч ярилц. Хүүхдүүдээр нэгийг сонгуулж ангидаа, эсвэл гэртээ ирэх долоо хоногт цээжлэхэд зоригжуул.

Дүгнэлт

Гэрчлэл	Амьдрал дахь залбирлынхаа хүч чадлын тухай гэрчлэлийг хуваалц. Таны итгэл болон залбирлын гэрчлэлийг хүчирхэгжүүлсэн тохиолдлоосоо өгүүлж болно. Хүүхдүүдийг залбиралтай холбоотой туршлагаа ярихыг урь.
Зөвлөмж Болгогдсон Гэрийн Уншлага	Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ Инос 1:1–8, 21–27-г судлахыг зөвлө. Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.

Бэнжамин Хаан Ард Түмэндээ Заасан нь

Хичээл
10

Зорилго

Хүүхдүүдийн усан баталгааны гэрээгээ сахих болон Есүс Христийг дагана гэсэн амлалтыг хүчирхэгжүүлнэ.

Бэлтгэл

- 2 Нифай 31:5–12 болон Мозая 2:1–22, 3:2–19, 4:11–16, 5:5–8, 13–16-г залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х. viii-ыг үз).
 - Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго.
 - Шаардлагатай материалууд:
 - Хүүхэд бүрт Мормоны Ном
 - Зураг 4-21, Бэнжамин Хаан Хүмүүстээ Хандан Үг Хэлсэн нь (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 307, 62298).
-

Хичээл Заах Зөвлөмж

Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.

Анхаарал Татах
Ажиллагаа

Ангийнхаа хүүхдүүдийн овгийг самбар дээр бич. Тэд яагаад ийм нэрстэй байгаагаа тайлбарлахыг тэднээс хүс.

- (Гэр бүлийн нэрийг ашиглаж) байх нь та нарын хувьд юу гэсэн үг вэ?

Бид нэг гэр бүлд төрөөд, өөртөө тэр гэр бүлийн нэрийг авдаг гэдгийг тайлбарла. Энэ нэр нь бидний өв, итгэл, тухайн зүйлүүдийг хийж байгаа арга замууд гэх зэрэг олон чухал зүйлсийг төлөөлдөг. Бид усаар батлуулаад, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн болж Есүс Христийн нэрийг өөртөө авдаг. Бид Есүс Христийн нэрийг өөртөө авч түүнд итгэх итгэл болон түүний сургаалуудыг дагах хүслээ тунхагладаг. Бэнжамин Хаан бол Есүс Христийн нэрийг өөртөө авахын чухлыг заасан бошиглогч гэдгийг тайлбарла.

Судрын Хэсэг

Мозая 2:1–22, 3:2–19, 4:11–16, 5:5–8, 13–16-гаас Бэнжамин Хаан ард түмэндээ заасан хэсгийг хүүхдүүдэд заа. Зургийг тохиромжтой үед нь ашигла. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х. viii-аас үз.)

Ярилцлага ба
Тавьж Болох
Асуултууд

Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншнаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.

- Бэнжамин Хаан яагаад хүмүүсийг хамтад нь дуудаж цуглуулсан бэ? (Мозая 1:10.) Зарахемлагийн хүмүүс өөрсдийнхөө бошиглогч, хааныг сонсохоор ариун сүмд цуглуулахаар дуудахад яаж хариулсан бэ?

(Мозая 2:1–6.) Амьд бошиглогчдын үгсийг бид хэрхэн сонсож хүлээн авдаг вэ? (Ерөнхий чуулган, Сүмийн хэвлэлүүд, Сүмийн цуглаанууд гэх зэрэг.) Бид удирдагчдынхаа үгсийг сонсохоор өөрсдийгөө хэрхэн бэлтгэж чадах вэ? (Мозая 2:9.)

- Бэнжамин Хаан ард түмэндээ хэрхэн үйлчилсэн бэ? (Мозая 2:12–15.) Бид Тэнгэрлэг Эцэгтээ үйлчилж чадна гэж Бэнжамин Хаан хэрхэн хэлсэн бэ? (Мозая 2:16–19.) Бусдад үйлчлэх нь өөрсдийн талархал болон хайрыг Тэнгэрлэг Эцэгт хэрхэн үзүүлнэ гэж та нар бодож байна вэ?
- Хэрэв бид Тэнгэрлэг Эцэгийн зарлигуудыг дуулгавартай дагавал тэр бидэнд юу амласан бэ? (Мозая 2:22.)
- Бэнжамин Хаан ард түмэндээ Есүс Христийн тухай юу заасан бэ? (Мозая 3:5–7, 9–10.) Христ бидний төлөө, хүн тус бүрийн маань төлөө үйлчлэлийн ямар агуу үйлдлийг гүйцэтгэсэн бэ? (Мозая 3:11–13.) Есүс Христ тарчлан зовж, нас барснаар бид гэм нүглээ наманчилж, усаар батлуулж, дахин амилах болон Тэнгэрлэг Эцэгтэйгээ үүрд хамт амьдрах боломжтой болсон гэдгийг тайлбарла. Бидний төлөөх Түүний золиослолыг Цагаатгал гэж нэрлэдэг.
- Өөртөө Есүс Христийн нэрийг авах нь бидэнд яагаад чухал вэ? (Мозая 3:17.) Есүс Христ биднээс түүний нэрийг өөртөө авахын тулд юу хийхийг хүсдэг вэ? (2 Нифай 31:5–12, Мозая 2:22. Усаар батлуулж зарлигуудыг сахь. Мозая 3:19. Өөрсдийнхөө хүслийг Аврагчийн хүсэлд захируулах.)
- Бэнжамин Хаан дуулгавартай дагах ёстой ямар зарлигуудыг ард түмэндээ хэлсэн бэ? (Мозая 3:21, 4:11–15, 5:5. Та баяжуулах үйл ажиллагаан дахь үгийн хайчилбарыг ярилцлагынхаа нэгэн хэсэг болгон ашиглаж болно.) Хэрэв бид зарлигуудыг дуулгавартай сахивал юу болох болно гэж Бэнжамин Хаан хэлсэн бэ? (Мозая 2:41.)
- Бэнжамин Хааны сургаал номлолуудад хүмүүс хэрхэн хариулсан бэ? (Мозая 5:2.) Энэ хүчтэй өөрчлөлтийг үзэхийн тулд бид юу хийж чадах вэ? (Мозая 3:19.)
- Бэнжамин Хааны хүмүүс юу хийх гэрээ байгуулсан бэ? (Мозая 5:5–9.)

Баяжуулах Үйл Ажиллагаа

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно.

1. Дараах үгийн хайчилбаруудыг хийгээд, үзүүл. Бэнжамин Хаан ард түмэндээ заахдаа хэрэглэсэн цамхгийн зургийг зур. Та Есүс Христийн нэрийг өөртөө авч чадах арга замуудыг ярилцаж байхдаа зураг дээр үгийн хайчилбаруудыг байрлуул. Хүүхдүүдээр үгийн хайчилбарууд дээр дүрслэн үзүүлсэн зарлигуудыг дуулгавартай дагах арга замуудыг бодож олуул.

Есүс Христэд итгэлтэй байх (Мозая 3:21)

Нүглээ наманчлах (Мозая 3:21)

Усан баталгааны гэрээнүүдийг хийж сахь (Мозая 5:5)

Өдөр бүр залбир (Мозая 4:11)

Бусдад эелдэг бай (Мозая 4:13)

Бүү зодолд, бүү хэрэлд (Мозая 4:14)
 Бусдад үйлчил (Мозая 4:15)
 Ядууст тусал (Мозая 4:16)
 Сайн мэдээний дагуу амьдар (Мозая 4:15)

2. Энгийн хувцас, эсвэл тавиур ашиглан Бэнжамин Хаан ард түмэндээ хандан ярьж байгааг жүжигчлэн тогло. Хүүхдүүд сандлуудаа өрөөний урд тал руу харуулан майхан маягаар тавьж урагшаа харсан “майхан” дотроо газар сууж болно. Бэнжамин Хааны дүрд тоглож байгаа нь өрөөний урд байгаа сандал дээр зогсож тэдэнд ярьж болно. Тэр хүүхдээр Мозая 2:9-өөс Бэнжамин Хааны үгсийг уншуул.
3. Хүүхдүүдэд Сүмийн сүүлчийн ерөнхий чуулганы тухай ярь. Энэ чуулганыг Бэнжамин Хааны ард түмэнтэйгээ хийсэн цуглаантай харьцуул. Сүм бүх гишүүддээ Сүмийн Ерөнхийлөгч болон бусад Ерөнхий Эрх Мэдэлтнүүдээс ирдэг захиасуудыг радио, зурагт, хиймэл дагуул болоод хэвлэгдмэл материалуудаар дамжуулан хүлээн авахад нь хэрхэн тусалдаг болохыг тайлбарла. Сүүлчийн Чуулганы зарим сэдвүүдийг ярилц. Хүүхдүүдийг дараагийн ерөнхий чуулганаас ирэх захиас бичгүүдийг унших, эсвэл сонсох хийгээд бошиглогчид болон удирдагчдын зөвлөгөөг дагахад нь урамшуул.
4. Хүүхдүүдэд Мозая 2:17-гийн сүүлчийн өгүүлбэр болох “Та нар бусаддаа үйлчилж байх үед та нар зөвхөн өөрсдийн Бурханд үйлчилж байгаа” хэсгийг ойлгож цээжлэхэд нь тусал.
5. Итгэлийн тунхгийн арван гурав Бэнжамин Хааны хэлсэн үгтэй хэрхэн холбогдож байгааг ярилц. Хүүхдүүдэд энэ итгэлийн тунхгийг цээжлэхэд нь тусал.
6. “Бие Биенээ Хайрлаач” дууг дуулах, эсвэл үгийг нь унш (*Дуулал*, х.33).

Дүгнэлт

Гэрчлэл	Есүс Христийн цагаатгал болон энэ нь бидний амьдралыг хэрхэн адисладаг тухай гэрчлэлээ хуваалц. Бид Есүс Христийн нэрийг өөртөө хүлээн авснаар зарлигуудыг сахихын чухлыг онцол.
Зөвлөмж Болгогдсон Гэрийн Уншлага	Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ Мозая 2:1–18-ыг судлахыг зөвлө. Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.

Зорилго

Есүс Христийн гэрчээр зогсохдоо зоригтой байхад нь хүүхдүүдийг зоригжуулна.

Бэлтгэл


1. Мозая 11–13, 15:1, 6–8, 16:14–15 болон 19:4–20-ийг залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii-ыг үз).
2. Нэмэлт уншлага: Мозая 14–16.
3. Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго.
4. Шаардлагатай материалууд:
 - а. Хүүхэд бүрт Мормоны Ном
 - б. Хоёрдогч анхаарал татах ажиллагаанд зориулан дараах зүйлсийг уут, эсвэл цүнхэнд хий:
 - Цаасан сахал (хичээлийн төгсгөл дэх зургийг үз)
 - Гар чийдэн
 - Арван Зарлигийн хуулбар зураг (хичээлийн төгсгөл дэх зургийг үз)
 - Христийн зураг
 - Олс, эсвэл уяа
 - Чүдэнз
 - в. Зураг 4-22, Абинадай Ноа Хааны Өмнө (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 308, 62042).

Хичээл Заах**Зөвлөмж**

Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.

Анхаарал Татах
Ажиллагаа

Хүүхэд бүрт есөн цэгтэй жишиг зургийг өг, эсвэл самбар дээр зур. Хүүхдүүдэд харандаагаа цааснаас, эсвэл шохойг самбарнаас салгалгүйгээр үргэлжилсэн 4 шулуун шугам зурж бүх цэгүүдийг холбо гэж хэл. Тэднийг хэд хэдэн шийдлээр оролдсоны дараа бусад хүүхдүүдэд хэлэлгүйгээр нэг хүүхдэд зөв хариултыг үзүүл. Тэр хүүхдээр өөр нэг хүүхдэд үзүүлэх гэх мэтээр бүх хүүхдүүд цэгүүдийг холботол үргэлжлүүл. Бид ямар нэг зүйл сураад, сурч мэдсэнээ бусдад зааснаар тэдэнд тусалж чадна гэдгийг тайлбарла. Бид Тэнгэрлэг Эцэгийн тухай сураад, түүний тухай бусад хүмүүст ярьснаар тэдэнд тусалж чадна.



Хоёрдогч
Анхаарал Татах
Ажиллагаа

Хүүхдүүдээр ээлжлүүлэн уутнаас эд зүйлсийг гаргуул. Хүүхэд бүрийг тухайн зүйлийнхээ талаар ганц хоёр юм хэлэхийг хүс. Хүүхдүүд Абинадай хэмээх зөв шударга, зоригтой бошиглогчийн талаар суралцсанаар тухайн зүйл тус бүр нь түүний амьдралтай хэрхэн холбогдохыг мэдэх болно гэдгийг тайлбарла.

Судрын Хэсэг

Абинадай Ноа Хааны өмнө гэдэг зургийг үзүүлээд Мозая 11–13, 15:1, 6–8, 16:14–15, 17 болон 19:4–20-иос Абинадайн тухай хэсгийг заа. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii-аас үз.) Хэдийгээр энэ нь түүний аминд хүрсэн ч Абинадай Есүс Христийн зоригтой гэрч байсан гэдгийг онцол. Хэрэв та хоёрдогч анхаарал татах ажиллагааг ашиглавал зүйл бүр нь Абинадайн амьдралтай хэрхэн холбогдож байгааг тайлбарла.

Сахал: Абинадай зүсээ хувирган ирсэн нь (Мозая 12:1).

Гар чийдэн: Абинадайн царай гялалзсан өнгөөр гэрэлтсэн (Мозая 13:5).

Арван Зарлиг: Абинадай Арван Зарлигийг заасан (Мозая 13:11–24)

Христийн Зураг: Абинадай Есүс Христийн тухай зоригтойгоор гэрчилсэн (Мозая 15, 16, 17:8).

Олс эсвэл уяа: Абинадайг хүлсэн (Мозая 17:13)

Чүдэнз: Абинадайг галд шатааж алсан (Мозая 17:20)

Ярилцлага ба
Тавьж Болох
Асуултууд

Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншнаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.

- Их Эзэн Абинадайд эхлээд Ноа Хаан болон түүний ард түмэнд юу хэлэхийг тушаасан бэ? (Мозая 11:20–21)
- Ямар байдлаар Ноа Хаан болон түүний ард түмэн амьдарч байсан бэ? (Мозая 11:1–7, 14–15, 19.)

- Ноа Хаан болон түүний ард түмэн Абинадайн үгэнд хэрхэн хариулсан бэ? (Мозая 11:26–29.) Хүмүүс яагаад өөрсдийг нь нүглээ наманчлахыг хэлж дуудсан тэдгээр хүмүүст уурладаг гэж та нар бодож байна вэ?
- Абинадай бусармаг Ноа Хаан болон түүний зэрэгтнүүдэд зарлигуудын талаар юуг зоригтойгоор гэрчилсэн бэ? (Мозая 12:33–36, 13:11–24.) Тэнгэрлэг Эцэгийн зарлигуудыг дуулгавартай дагах нь бидэнд яагаад чухал вэ?
- Ноа Хааны хүмүүс яагаад Абинадайд гар хүрэхээс айсан бэ? (Мозая 13:3–5.)
- Абинадай Есүс Христийн тухай юу гэрчилсэн бэ? (Мозая 15:1, 6–8, 16:14–15.)
- Абинадай эр зоригоо хэрхэн үзүүлсэн бэ? (Мозая 17:7–10.) Заримдаа яагаад зөв зүйлийн төлөө зогсоход хэцүү байдаг вэ? Зөвийн төлөө бид хэрхэн зогсож чадах вэ?
- Абинадайг яагаад шатааж алсан бэ? (Мозая 17:20.) Ийм юм болохыг Их Эзэн яагаад зөвшөөрсөн гэж та нар бодож байна вэ? (Алма 60:13.)
- Ноа Хаанд юу чухал байсан бэ? (Мозая 11:14, 19:7–8.) Абинадайд юу чухал байсан бэ? (Мозая 13:4, 17:7–10.) Бидэнд юу чухал байх ёстой вэ?
- Абинадайг үхэхийн өмнө түүний гэрчлэл хэнд нөлөөлсөн бэ? (Мозая 17:1–4.)
- Мозая 12:3 дахь Абинадайн бошиглол хэрхэн биелэгдсэн бэ? (Мозая 19:19–20.)
- Өнөөдөр хэн Есүс Христийн гэрчээр зогсохдоо зоригтой байна гэж та нар бодож байна вэ?

Баяжуулах Үйл Ажиллагаа

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно.

1. Хүүхдүүдээр Абинадай болон Ноа Хааны түүх дэх баатруудын дүрийг сонгуулаад, сурвалжлагчаар тэднээс ярилцлага авахуул. Сурвалжлагчид зориулан тухайн баатруудаас асуух асуултын жагсаалтыг гарга, үүнд:

Сурвалжлагч Ноад:	Та өөрийнхөө тансаг барилгуудаа яаж худалдаж авсан бэ?
Сурвалжлагч зэрэгтнүүдэд:	Та нар Абинадайг яагаад баривчилж хорьсон бэ?
Сурвалжлагч Алмад:	Та Абинадайн сургаалын талаар юу бодож байна вэ?
Сурвалжлагч Абинадайд:	Эдгээр хүмүүс таныг яагаад алахыг хүсч байсан бэ? Та тэдгээр хүмүүст хэлсэн үгээ яагаад үгүйсгээгүй вэ?


2. Устай аяганд чинжүү цац. Аягыг бүх хүүхдүүдэд харагдах газарт тавь. Тэдэнд чинжүү нь зоригтой байхыг сонгосон тэдгээр хүмүүсийг төлөөлж байгааг хэл. Эдгээр зоригтой хүмүүсийн дэргэд бусармаг

явдалтнуудыг байрлуулахад юу болохыг харахыг хүүхдүүдээс хүс. Аяганы голд бусармаг явдалтнуудыг төлөөлөн сав угаагч шингэн дусаа. Чинжүү маш хурдан зайлах болно. Алма Абинадайн гэрчлэлд итгэж бошиглогчийг дуулгавартай дагахдаа зоригтой байхыг сонгож, Ноа Хааны нүгэлт замаас нүүр буруулсан. Хүүхдүүдээс зоригтой байхын тулд ямар зүйлсээс нүүр буруулах ёстойг асуу.

3. Мозая 12:34–36, 13:12–24 дэх Арван Зарлигийг ярилц.
4. Зөв шударга Бэнжамин Хааны зоригтой зан төрхийг Ноа Хааны зан төрхтэй харьцуул.
Бэнжамин Хаан: Мозая 2:10–14, 4:9–10.
Ноа Хаан: Мозая 11:2, 6–7, 27, 19:8.
5. Абинадайд бусармаг Ноа Хаан болон түүний ард түмэн хэрхэн хандаж байсны болон Христэд хэрхэн хандаж байсны адил төстэй зүйлүүдийг ярилц.
Христ: Мозая 15:5, Матай 26:66, Лук 24:20.
Абинадай: Мозая 13:1, 17:7, 10, 13.

Дүгнэлт

Гэрчлэл	Хэдийгээр бид зөв шударга байсан ч өвчин, зовлонгоос чөлөөлөгдөхгүй, мөн хэрэв бид Есүс Христийн тухай гэрчлэлдээ зоригтой байвал Тэнгэрлэг Эцэг биднийг энэ амьдралд амар амгалан ба ирэх амьдралд түүнд юу байна тэр бүгдээрээ адислах болно гэдгийг гэрчил.
Зөвлөмж Болгогдсон Гэрийн Уншлага	Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ Мозая 11:1–2, 20–21, 26–29, 12:1–9-ийг судлахыг зөвлө. Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.



Зорилго	Хүүхдүүдэд усан баталгааных нь учир утга болон тэдгээрийг сахихын ач холбогдлыг заана.
Бэлтгэл	<ol style="list-style-type: none">1. Мозая 17:2–4, 18-ыг залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii-ыг үз).2. Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго3. Шаардлагатай материалууд:<ol style="list-style-type: none">а. Хүүхэд бүрт Мормоны Номб. Сонголтоор: Анхаарал татах ажиллагаанд зориулан цоож, түлхүүр (жишээ нь, өлгөдөг цоож, түгжээтэй өдрийн тэмдэглэл, түгжээтэй гоёл чимэглэлийн хайрцаг болон чемодан).в. Дээр нь <i>Гэрээ</i> гэж бичсэн цаасан түлхүүрийн хайчилбар (хичээлийн төгсгөлд үз).г. Хүүхэд бүрт зориулан “Миний Усан Баталгааны Гэрээнүүд” үзүүлэн (хичээлийн төгсгөлд үз).д. Зураг 4-23, Алма Мормоны Усанд Усаар Баталсан нь (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 309, 62332).

**Хичээл Заах
Зөвлөмж**

Анхаарал Татах
Ажиллагаа

Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.

Түлхүүрийг үзүүл. Хүүхдүүдээс түлхүүрийг юунд ашигладгийг асуу. Та нэг хүүхдээр түлхүүр ашиглан цоожийг онгойлгуулж болно. Хүүхдүүдэд *Гэрээ* гэсэн үг нь харагдахааргүй байхаар цаасан түлхүүрийг бариад, дундуур нь ур. Хэрэв танд түлхүүрний ердөө л хагас нь байх юм бол үүнийг хэрэглэж болохгүй гэдгийг тайлбарла. *Гэрээ* гэсэн үг нь харагдахаар 2 хэсэг түлхүүрийг эргүүлж барь. Хүүхдүүдээс энэ үгний утгыг мэдэх эсэхийг нь асуу. Сайн мэдээнд гэрээ гэдэг нь Тэнгэрлэг Эцэг болон түүний хүүхдүүдийн хоорондох ариун нандин тохиролцоо буюу амлалт гэдгийг тайлбарла. Бид Тэнгэрлэг Эцэгтэй хийсэн гэрээнүүдээ сахих юм бол тэр ямагт өөрийн үүргийг биелүүлэх болно. Харин, хэрэв бид гэрээнийхээ амлалтуудыг сахихгүй бол гэрээ цуцлагдана. Усан баталгааны гэрээнүүдээ сахих нь адислалууд болон мөнхийн амьдралд хүрэх түлхүүр юм. Мөнхийн амьдрал гэдэг нь Тэнгэрлэг Эцэгтэй адил болж түүнтэй үүрд хамтдаа амьдрахыг хэлдэг гэдгийг тайлбарла. Хүүхдүүд Алма болон түүний хүмүүсийн талаар судалснаар усан баталгааныхаа гэрээнүүдийг болон тэдгээрийг хэрхэн илүү сайн сахихаа санах болно гэдгийг тайлбарла.

Судрын Хэсэг

Мозая 17:2–4, 18-аас Алма Мормоны Усанд усаар баталж байгаа хэсгийг хүүхдүүдэд заа. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii-аас үз.) Бидний усан баталгааныхаа үеэр хийдэг гэрээнүүд болон тэдгээрийг сахихын ач холбогдлыг онцол. Зургийг тохиромжтой үедээ хэрэглэ.

Ярилцлага ба
Тавьж Болох
Асуултууд

Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншнаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.

- Алма өөрийгөө усан баталгаанд бэлтгэж юу хийсэн бэ? (Мозая 17:2–4, 18:1.) Та нар усан баталгаандаа хэрхэн бэлдсэн бэ?
- Мормон гэдэг газрын ямар хэсэг нь Алмаг хүмүүст заахад сайн нуугдах газар болж өгч байсан бэ? (Мозая 18:4–5.) Тэд яагаад нуугдах хэрэгтэй байсан бэ?
- Алмагийн хүмүүс усаар батлуулж болох юм байна гэдгийг сурч мэдээд ямар сэтгэгдэлтэй байсан бэ? (Мозая 18:11.) Та нар усаар батлуулж байхдаа ямар сэтгэгдэлтэй байсан бэ? Та нар тэр өдрийн талаар юу дурсан санадаг вэ?
- Бид бүгд усаар батлуулж байхдаа ямар амлалтуудыг хийдэг вэ? Тэнгэрлэг Эцэг бидэнд юу амласан бэ? (Мозая 18:8–10.) “Миний Усан Баталгааны Гэрээнүүд” гэсэн үзүүлэнг үзүүлээд, амлалт бүрийг ярилц. Бидний хэн маань ч төгс биш боловч бид чадах чинээгээрээ усан баталгааныхаа гэрээг сахих ёстой гэдгийг тайлбарла.
- Бид Есүс Христийн нэрийг өөртөө авч, түүний гэрчээр зогсож байна гэдгээ хэрхэн үзүүлж чадах вэ?
- Бие биенийхээ ачаанаас хуваалцаж, гашуудаж байгаа бусадтай гашуудана гэдэг нь юу гэсэн үг вэ? Христ дэлхий дээр амьдарч байхдаа бидэнд ямар ямар аргаар үйлчилдэг байсан бэ? Бид хэрхэн Есүс Христийн үлгэр жишээг дагаж бусдад үйлчилж чадах вэ?
- Алма хүмүүстээ усан баталгааных нь гэрээнүүдийг сахихад тусалж ямар зарлигуудыг өгсөн бэ? (Мозая 18:21–23, 27–29.) Бид хэрхэн Алмагийн хүмүүстэй илүү адил амьдарч чадах вэ?
- Ням Гараг бүр бид ямар ёслолоор дамжуулан усан баталгааны гэрээнүүдээ шинэчилж чаддаг вэ? Шинэчилнэ гэдэг нь шинээр буюу дахин эхлэнэ гэсэн утгатай гэдгийг та тайлбарлаж болно. Ариун ёслолын залбирлыг хүүхдүүдтэй давтаад, тэдгээрт агуулагдаж байгаа гэрээнүүдийг олоход нь тэдэнд тусал (Моронай 4:3, 5:2-ыг үз). Хүүхэд бүрт үзүүлэнгээ өгөөд усан баталгаануудынх нь гэрээнүүдийг давтуул.

Баяжуулах Үйл Ажиллагаа

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно.

1. Та нэг хүүхдээс таныг усан баталгааны гэрээнүүдийн талаар ангийнхандаа ярьж байхад чинь нэг гараараа нэг их хүнд биш ном

бариад гараа шулуун байлгахыг хүс. Ном барьж байгаа хүүхдээс гар нь ядарч байгаа эсэхийг асуу. Өөр нэг хүүхдээр ном барихад нь туслуул. Бид усаар батлуулж байхдаа хийдэг гэрээнүүдийн маань нэг “бие биенийхээ ачааг хөнгөлөхөөр үүрэлцэх” явдал юм гэдгийг тайлбарла. Тэдний насны хүүхдүүдэд тохиолдож болох дооглуулах, өвчтэй байх, гэр бүлийнхээ гишүүдтэй зохицохгүй байх, ямар нэг бүлэгт харьяалагдахыг хүсэх, сургууль дээрээ хэцүү асуудалтай тулгарах зэрэг ачаануудын талаар ярилц. Хүүхдүүдээс бие биенийхээ ачааг хөнгөн болгоход тэд хэрхэн тусалж чадахыг нь асуу.

2. Хичээлийн өмнө хүүхдүүдийн эцэг эхээс, хүүхэд нь хэн нэгэнд үйлчилж байсан үеийнх нь тухай та өөртөө ярьж өгөхийг хүс. Эдгээр тохиолдлуудыг ангийнхантайгаа хуваалцаад, хүүхдүүдийг эдгээр үйлчлэлийнх нь төлөө урамшуулан магт. Эдгээр үйлчлэлийн үйлдлүүд нь тэдний үйлчилсэн хүмүүсийн ачааг хөнгөн болгож байгааг онцол.
3. Биднийг усаар батлуулж байхдаа хийсэн гэрээний маань нэг хэсэг бол Есүс Христийн нэрийг өөртөө авах хүсэлтэй байх, мөн жинхэнэ Христэд итгэгч, эсвэл Христийг дагагч байх явдал юм гэдгийг хүүхдүүдэд тайлбарла. Бид түүний нэрээр зохистой амьдрах ёстой. Таныг Сүмийн найм дахь Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Жорж Алберт Смитийн дараах түүхийг ярьж байх хооронд Есүс Христийн нэрийг хир сайн дээдэлж байгаа талаараа бодож байхыг хүүхдүүдээс хүс.

“Хэдэн жилийн өмнө би маш хүнд өвчилсөн юм. . . . Би бүр хөдөлж чадахгүй болтлоо сул дорой байлаа.

“Нэг өдөр би . . . гадаад орчноосоо ухаан балартсан ба би өөрийгөө Нөгөө Ертөнц рүү явчихлаа л гэж бодов. . . .

“Би эргэн тойрноо ажиглаж эхэлсэн . . . ба ой модон дундуур . . . хэсэг хугацаанд явсны дараа над руу ирж яваа нэгэн хүнийг харав. Би түүнийг маш их том хүн байна гэдгийг мэдсэн ба түүнийг өвөөгөө болохыг таньсан учраас түүнд хүрэхээр алхаагаа хурдасгав. . . . Түүний ирж явааг хараад би ямар их баярласнаа санаж байна. Би түүний нэрийг авсан ба үүгээрээ ямагт бахархдаг байв.

“Өвөө маань надаас хэдэн алхмын зайнд ирээд зогсчихов. Тэр над руу маш сүрхий хараад, ингэж хэлэв.

“ ‘Чи миний нэрээр юу хийснийг би мэдэхийг хүсч байна’

“Миний хийсэн бүгд дэлгэцэн дээрх зураг мэт өмнүүр минь нисээд өнгөрөв. . . . Бүхэл амьдрал маань миний өмнүүр өнгөрөв. Би инээмсгэлж өвөө рүүгээ харан:

“ ‘Би таныг ичээх юуг ч нэрээр тань хийгээгүй’ гэж хэлсэн.

“Тэр урагшаа алхаж намайг гараараа тэвэрсэн ба яг энэ үед би дэлхийн хүрээлэн буй орчинд дахин ухаан оров. Дэр маань дээрээс нь ус асгачихсан юм шиг миний ичилгүйгээр хариулж чадсан талархлын нулимсанд норсон байлаа” (“Your Good Name” *Improvement Era*, Mar. 1947, p.139).

Хүүхдүүдэд зарлигуудыг хүсэлтэйгээр сахиж, бусдад үйлчилж байхдаа тэд Есүс Христийн нэрийг хүндэтгэж байдаг гэдгийг тайлбарла.

Дүгнэлт

Гэрчлэл

Бид усан баталгааныхаа гэрээнүүдийг сахиснаараа бие биедээ илүү сайн үйлчлэхийг сурч мөн Есүс Христтэй илүү адилхан болох болно гэсэн гэрчлэлээ хуваалц.

Зөвлөмж


Болгогдсон


Гэрийн Уншлага

Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ Мозая 18:1–11, 30–35-ыг судлахыг зөвлө.

Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.

Тайлбар: Хэрэв та баяжуулах үйл ажиллагаа 1-ийг дараагийн хичээлд ашиглахаар шийдэж байгаа бол даалгаварыг наанадаж нэг долоо хоногийн өмнө өг.





Миний Усан Баталгааны Гэрээнүүд

(Би Ариун Ёслолоос Хүртэх Бүрдээ Шинэчлэгддэг)

Усан Баталгаагаар Би Их Эзэнтэй Ингэж Гэрээ Байгуулдаг:

1. Бурханы сүрэгт нэгдэнэ (Есүс Христийн Сүмийн гишүүн болох).
2. Түүний хүү, эсвэл охин хэмээн нэрлэгдэнэ (Христийн нэрийг өөртөө авах).
3. Бусдын ачаануудыг хөнгөлөхөөр үүрэлцэх, гашуудаж байгаа тэдгээртэй гашуудах тайтгарал хэрэгтэй хүмүүсийг тайтгаруулна (бусдад туслах).
4. Хэзээ ч, бүх зүйлд, бүх газруудад Бурханы гэрчээр зогсох болно (Христийг гэрчилж, үргэлж сайн үлгэр жишээ байх).
5. Бурханд үйлчилж, түүний зарлигуудыг сахина.

Намайг Усан Баталгааныхаа Гэрээнүүдийг Сахихад Их Эзэн Ингэж Амладаг:

1. Гэм нүглүүдийг маань өршөөнө.
2. Бидэн дээр Сүнсээ элбэг дэлбэгээр асгана (Ариун Сүнсний нөхөрлөлийг надад өгнө).
3. Би эхний дахин амилалтын тэдгээр хүмүүстэй хамт тоологдох бөгөөд мөнхийн амьдралтай байхаар намайг гэтэлгэнэ (Тэнгэрлэг Эцэгтэй болон Есүс Христтэй хамт амьдрахаар Сэлэсчел хаант улсад орохыг надад зөвшөөрнө).

Зорилго

Төлөв төвшин байдал болон Есүс Христэд итгэх итгэл нь бидэнд гай зовлон тулгарахад хүч тэнхээ өгч чадна гэдгийг хүүхдүүдэд заана.

Бэлтгэл

1. Мозая 21:1–16, 22, 23:1–6, 29–39 ба 24-ийг залбиралтайгаар судлаад, Мозая 12:2, 4–5- ыг давт. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii-ыг үз).
2. Нэмэлт уншлага: Мозая 20–25 (бүх л хэсэгт зориулж).
3. Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго.
4. Хэрэв та баяжуулах үйл ажиллагаа 1-ийг дараагийн хичээлд ашиглахаар шийдэж байгаа бол даалгаврыг наанадаж нэг долоо хоногийн өмнө өг.
5. Шаардлагатай материалууд:
 - а. Хүүхэд бүрт Мормоны Ном
 - б. Зурагнууд: 4-24, Лэмэнчүүдийн Хараа Хяналтанд Буй Нифайчууд; 4-25, Лимхай Хааны Хүмүүсийн Аврал.

Хичээл Заах Зөвлөмж

Анхаарал Татах
Ажиллагаа

Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.

Дараах үгс болон тодорхойлтуудыг самбар, эсвэл зурагт хуудсан дээр бич. Хүүхдүүдэд судрын хэсгээс зарим чухал үгсийг сурах болно гэдгийг тайлбарла. Хүүхдүүдээр сайн дураар нь нэг үг хэлүүлж, тодорхойлолтыг нь сонгуул.

Саад тотгор	а. Үүрч явахад хэцүү ачаа буюу зовлон
Боолчлол	б. Сурахад бэлэн байх, бардам зангүй байх
Төлөв төвшин	в. Золгүй явдал, зовлон юмуу бэрхшээл байдал
Хавчлага	г. Эрх чөлөөгүй байх, боолчлол
Итгэл	д. Амар заяа үзүүлэхгүй байх, шаналгаа буюу дайрч давшлах
Ачаа	е. Харахгүйгээр итгэх

Хариултууд: саад тотгор: в; боолчлол: г; төлөв төвшин байдал: б; хавчлага:д; итгэл: е; ачаа: а.

Судрын Хэсэг

Мозая 12:2, 4–5-аас Нифайчуудын талаар Абинадайн бошиглолыг давт. Хэдийгээр Нифайчууд хоёр тусдаа бүлэгт хуваагдсан ч эдгээр бошиглолууд нь үгчлэн биелэгдсэн. Мозая 21:1–16, 22, 23:1–6, 29–39 болон 24 дүгээр бүлгээс Лимхай Хааны хүмүүс болон Алмагийн хүмүүсийн тухай хэсгийг заа. Зургуудыг тохиромжтой үед хэрэглэ. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii-аас үз.)

Ярилцлага ба
Тавьж Болох
Асуултууд

Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншнаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.

Лимхай Хааны хүмүүс

- Лэмэнчүүд Лимхайн хүмүүсийг ямар аргаар хавчиж байсан бэ? (Мозая 21:3.) Яагаад ийм зүйл тохиолдох болсон бэ? (Мозая 21:4, 12:2, 4–5.)
- Лэмэнчүүдтэй хийсэн тулалдаанд гурван удаа ялагдсан нь Лимхай Хааны хүмүүст ямар нөлөө үзүүлсэн бэ? (Мозая 21:13–14.) Даруу байна гэдэг нь юу гэсэн үг вэ? Нифайчууд эцэстээ яагаад өөрсдийгөө даруусгасан гэж та нар бодож байна вэ?
- Тэнгэрлэг Эцэг яагаад Лимхайн ард түмний гуйлтыг сонсохдоо удсан бэ? (Мозая 21:15.) Эцэст нь тэр тэдний тусламж гуйсан гуйлтанд хэрхэн хариулсан бэ? (Мозая 21:15–16.) Лимхайн хүмүүс боолчлолд амьдарснаар юу сурч авсан бэ? Бидний амьдрал дахь зовлон зүдгүүр бидэнд хэрхэн илүү даруу, дуулгавартай болон залбиралтай болоход тусалж чадах бэ?
- Лимхай Хаан болон түүний ард түмэн Бурхантай гэрээ буюу амлалт хийснийхээ дараа Түүнтэй хийсэн гэрээгээ хүндэтгэж байгаагаа үзүүлэхээр юу хийхийг хүссэн бэ? (Мозая 21:35.) Бид Тэнгэрлэг Эцэгтээ усан баталгааны гэрээнүүдээ хүндэтгэж байгаагаа хэрхэн үзүүлж чадах вэ?

Алмагийн хүмүүс

- Ямар шалтгаануудын улмаас Алмагийн хүмүүсийн итгэл болон тэвчээртэй байдал нь шалгагдсан бэ? (Мозая 23:21.) Хэрэв бид тэвчээртэй байдал болон итгэлээрээ шалгагдаж байхдаа Их Эзэнд итгэлтэй байвал тэр тэдэнтэй болон бидэнтэй ямар амлалтыг хийдэг вэ? (Мозая 23:22.) Та нар Их Эзэнд итгэснээрээ хэрхэн адислагддаг вэ?
- Яагаад Алма өөрийнхөө хүмүүст тэд айх ёсгүй гэж хэлсэн бэ? (Мозая 23:27.) Хүмүүс нь түүний зөвлөмжинд хэрхэн хариулсан бэ? (Мозая 23:28.) Их Эзэн тэдэнд хэрхэн тусалсан бэ? (Мозая 23:29.) Эр зориг олж авахад Их Эзэн та нарт хэрхэн тусалсан бэ?
- Гай зовлонгоор дамжуулан илүү хүчтэй болохын тулд та нар юу хийж чадах вэ? Тэнгэрлэг Эцэг та нарыг болон та нарын гэр бүлийг гай зовлонтой үед нь хэрхэн адисладаг вэ?
- Бусармаг удирдагч Амюлон тэднийг чангаар залбирахыг хориглоход Алма болон түүний хүмүүс юу хэрэгтэйгээ Тэнгэрлэг Эцэгт хэрхэн хэлж байсан бэ? (Мозая 24:12.) Тэнгэрлэг Эцэг тэдний залбиралд

хэрхэн хариулж, өгсөн амлалтаа хэрхэн сахисан бэ? (Мозая 24:13–16.) Тэнгэрлэг Эцэг та нарт өгсөн амлалтаа хэрхэн сахидаг вэ?

- Алма болон түүний хүмүүс Лэмэнчүүдээс суллагдсныхаа дараа юу хийх ёстойгоо санасан бэ? (Мозая 24:21–22.) Гай зовлонтой байгаа ч гэсэн талархаж байгаагаа үзүүлэх нь яагаад чухал вэ? Бид адислалууддаа талархаж байгаагаа Тэнгэрлэг Эцэгт хэрхэн үзүүлж чадах вэ?
- Гай зовлонгоороо дамжуулан хүмүүс хэрхэн сүнслэгээр адислагддаг вэ?
- Гай зовлонгийн үед Есүс Христэд итгэх итгэл болон төлөв төвшин байх нь биднийг хэрхэн хүчирхэгжүүлдэг вэ?

Баяжуулах Үйл Ажиллагаа

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно.

1. Хоёр том хүнийг Лимхай Хаан болон Алма шиг хувцаслахыг урь. Лимхай Хаан Мозая 21, 22-оос өөрийн ард түмний тухай хэсгийг ярьж өгч болно. Алма Мозая 23, 24-өөс ард түмнийхээ тухай хэсгийг ярьж өгч болно. Хүүхдүүдээр тухайн хэсгүүд дээрх үйл явдлуудын тухай асуултуудыг асуулга. Ярилцлага ба тавьж болох асуултуудыг ишлэл татах үеэр болон ишлэлийг тоймлохдоо ашиглаж болно.
2. Ангийнхаа хэмжээнээс шалтгаалан ангиа хоёр, эсвэл дөрвөн багт хуваа. Баг бүрээр ээлжлүүлэн түүхийн таалагдсан хэсгээр нь пантомими жүжиглүүлж, бусад багуудаар тэд юу жүжиглэж байгааг нь таалга.
3. Итгэлийн тунхгийн дөрөвдүгээрийг цээжил.
4. Хүүхдүүдээс дараах судруудыг чимээгүй уншаад чухал утга санааг нь тэмдэглэхийг хүс.
 - Мозая 23:7, 15, 21–22
 - Мозая 24:12–16, 21–22
 - Мозая 25:10, 15–16, 22–24

Дүгнэлт

Гэрчлэл	Гай зовлонгийн үед Их Эзэнээс танд ирсэн адислалуудын гэрчлэлээ болон үүний төлөөх талархлаа илэрхийл.
Зөвлөмж Болгогдсон Гэрийн Уншлага	Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ Мозая 21:6–16 болон 24:10–15-ыг судлахыг зөвлө. Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.

Бага Алма ба Мозаягийн Хөвгүүд Нүглээ Наманчилсан нь

Зорилго

Хүүхдүүдэд наманчлал нь дэлхийн аз жаргал болон мөнхийн амьдралд шаардлагатай гэдгийг заана.

Бэлтгэл

1. Мозая 27, 28:1–9 болон Алма 36:11–24-ийг залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii-ыг үз).
2. Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго
3. Шаардлагатай материалууд:
 - а. Хүүхэд бүрт Мормоны Ном
 - б. Үүргэвч, эсвэл цүнх болон дөрвөөс таван ширхэг ном, чулуу, тоосго гэх мэтийн хүнд зүйлс. Зүйл бүрийг худлаа хэлэх, бусдыг дооглох, тамхи татах гэх зэрэг гэм нүглээр хаягла.
 - в. Зураг 4-26, Тэнгэрийн Элч Алма болон Мозаягийн Хөвгүүдэд Үзэгдсэн нь.

Хичээл Заах Зөвлөмж

Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.

Анхаарал Татах Ажиллагаа

Үүргэвч, эсвэл цүнхээ хэд хэдэн хүнд зүйлээр дүүргэн ангидаа авчир. (Та энэ насны хүүхдүүд уруу татагдаж болох зарим зүйлсийг мэдэж болно. Хаяглахдаа эдгээрийг ашигла.) Хүүхдүүдээр ээлж ээлжээр нь хүнд цүнхийг үүрүүл. Тэгээд нэг хүүхдээр зүйл бүрийг нэг нэгээр нь гаргуул.

Бүх “нүглүүдийг” гаргахад хүүхдийн “дарамт” буюу хүнд ачаа нь хөнгөрөх болно. (Та уг зүйлсийг тэднээс эргэн лавлаж байхын тулд хичээлийн турш үзүүлэн дээр байлгаж болно.) Хүнд цүнх болон хөнгөн цүнхний жинг харьцуул. Хэрэв бид итгэл, наманчлал болон усан баталгаагаар дамжин түүнд ирэх юм бол бидний ачаа дарамт хөнгөрөх болно гэж Есүс хэлсэн. Наманчлал гэдэг нь үйлдсэн нүгэлдээ гэмших, үүнийгээ дахин хийхгүй байх болон Аврагчтай илүү адилхан болохоор амьдрахыг хичээх явдал юм. Энэ хичээл дээр хүүхдүүд Бага Алма ба Мозаягийн хөвгүүд нүглийн ачаа дарамт хийгээд Есүс Христэд итгэх итгэл ба наманчлалаар дамжуулан ачаагаа хөнгөлөхөд ирдэг тэрхүү аз жаргалыг хэрхэн олж мэдснийг харах болно.

Судрын Хэсэг

Зургийг тохиромжтой үед нь ашиглан Мозая 27 болон 28:1–9-д тэмдэглэгдсэнээр Бага Алма болон Мозаягийн хөвгүүдийн амьдралд тохиолдсон агуу өөрчлөлтийн тухай түүхийг заа. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii-аас үз.) Энэ хичээл нь Бага Алмагийн тухай юм гэдгийг ойлгоход нь хүүхдүүдэд тусал (түүний эцэг бол

Абинадайн номлолоор хөрвүүлэгдсэн Алма болох Ахлагч Алма юм). Бага Алмагийн хийсэн наманчлалын үйл явц нь бидний нүглээ наманчлахдаа хийх ёстой үйл явцтай адил гэдгийг ярилц (Алма 36:16–21-ийг үз).

1. Нүглээ таньж мэдэх
2. Нүглээ хүлээн зөвшөөрч, өршөөлийн төлөө залбирах
3. Алдаагаа засахаар чадах бүхнээ хийх
4. Нүглээ бүрмөсөн орхих
5. Зарлигуудыг дуулгавартай дагаж, Аврагчтай илүү адил амьдрах

Ярилцлага ба
Тавьж Болох
Асуултууд

Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншнаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.

- Үл итгэгчид Сүмийн гишүүдийг яаж байсан бэ? Хавчигдана гэдэг нь юу гэсэн үг вэ? Эдгээр хүмүүс яагаад Сүмийн гишүүдийг хавчсан гэж та нар бодож байна вэ? (Мозая 27:1, 8–10.) Өнөөдөр Сүмийн гишүүд ямар байдлаар хавчигдаж болох вэ?
- Хэн Бага Алма болон Мозаягийн хөвгүүдийн төлөө залбирсан бэ? Тэд юуны төлөө залбирсан бэ? (Мозая 27:14.) Эцэг эх тань та нарын төлөө залбирч байхдаа юуны талаар залбирдаг гэж та нар бодож байна вэ?
- Хариулт авахын тулд бид хэрхэн залбирах ёстой вэ? (Мозая 27:14.) Ангийн гишүүдийг залбирлынхаа хариултыг хүлээн авсан тохиолдлоосоо хуваалцахыг урь. Та ч бас иймэрхүү түүхээсээ ярьж болно.
- Алма болон түүний дөрвөн найз Тэнгэрлэг Эцэгийн хүч чадлыг хэрхэн мэдэрсэн бэ? (Мозая 27:11, 15, 18.)
- Энэ сүнслэг явдлаас үүдэн Алмад юу тохиолдсон бэ? (Мозая 27:19.) Энэ нь Алмагийн амьдралд хэрхэн агуу том адислал болсон бэ?
- Ахлагч Алма хүүдээ тохиолдсон зүйлийг сонсоод юу хийсэн бэ? (Мозая 27:20–23.) Яагаад эцэг эх маань биднийг Тэнгэрлэг Эцэгийнхээ зарлигуудыг дуулгавартай дагахыг хүсдэг вэ?
- Алма өөртэй нь тэнгэрийн элч ярьсны дараа ямар сэтгэгдэлтэй байсан бэ? (Алма 36:11–17.) Гэм нүглийнхээ төлөө шаналах нь бидэнд яагаад чухал вэ?
- Алмагийн Есүс Христийн цагаатгалын тухай мэдлэг нь түүнийг нүглээ наманчлахад хэрхэн тусалсан бэ? (Алма 36:17–18.) Алма Аврагчийг санаад юу хийсэн бэ? (Алма 36: 18.) Бид нүглээ наманчлахдаа гэм нүглээ хүлээн зөвшөөрч, өршөөлийн төлөө залбирах нь яагаад чухал вэ?
- Алма хийсэн буруугаа засахын тулд хэрхэн хичээсэн бэ? (Алма 36:24.) Наманчлалын нэг хэсэг болгон хийсэн буруу зүйлүүдээ өөрчлөн алдаагаа засахыг оролдох нь яагаад чухал бэ?
- Бага Алма болон Мозаягийн хөвгүүд гэм нүглээ наманчлаад, нүгэлт замаасаа гарчихаад бусдад туслахын тулд юу хийхийг хүссэн бэ? (Мозая 27:32, 35, 28:1.) Бид гэр бүл, найз нөхдийнхөө дунд хэрхэн сайн үлгэр жишээ болж чадах вэ?

**Баяжуулах Үйл
Ажиллагаа**

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно.

1. Нялх хүүхдийн зургийг ашигла, эсвэл нялх хүүхэдтэй хэн нэгнийг ангид хүүхдээ авчрахыг урь. Хүүхдийн цэвэр ариун байдлыг нүглээ наманчилсан хүний цэвэр ариун байдалтай харьцуул.
2. Амьдрал болон аз жаргалд нь нөлөөлсөн наманчлал болон усан баталгааны зарим арга замуудаас нь хуваалцуулхаар саяхан хөрвүүлэгдсэн нэг хүнийг урь.
3. Нүглээс чөлөөлөгдсөн хүнийг төлөөлүүлэн цэвэр устай лонх ашигла. Усанд бага зэрэг хүнсний будаг дусаагаад будаг усанд хэрхэн тарж байгааг нь анхааруулж хэл. Үүнийг нүгэлтэй харьцуул. Тэгээд будгийг арилгахын тулд хэдэн дусал шингэн цайруулагч нэмээд, үүнийгээ наманчлал нь биднийг нүглээс хэрхэн цэвэрлэдэгтэй харьцуул. (Та хүнсний будаг болон цайруулагчийг хир их хэрэглэгдэхийг мэдэхийн тулд үүнийг урьдчилан туршиж үзэж болно.)

Дүгнэлт

Гэрчлэл

Зөвхөн наманчлал болон Есүс Христийн цагаатгалаар дамжуулан нүглийн маань ачаа хөнгөрч, бид өршөөл болоод баяр баясгалангийн оргилыг хүлээн авч чадна гэсэн гэрчлэлээ хуваалц.

Зөвлөмж

Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ Мозая 27:10–24-ийг судлахыг зөвлө.

Болгогдсон

Гэрийн Уншлага

Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.

Алма, Амюлек нарын Аммонайхад Хийсэн Номлол

Хичээл

15

Зорилго Тэнгэрлэг Эцэгийн зарлигуудыг итгэлтэйгээр дагахын чухлыг хүүхдүүдэд заана.

Бэлтгэл


1. Алма 8:8–9:34 болон 11:21–12:19-ийг залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii-ыг үз).
2. Нэмэлт уншлага: Алма 10
3. Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго.
4. Шаардлагатай материалууд:
 - а. Хүүхэд бүрт Мормоны Ном
 - б. Зураг 4-27, Аммонайхын Ард Түмэнд Зааж Буй Алма.

**Хичээл Заах
Зөвлөмж**

Анхаарал Татах
Ажиллагаа

Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.

Дараах зургийг самбар дээр зур:



Нэг хүүхдээр шохойг цэгэн дээр байрлулуулаад доорх зааврын дагуу шугам зуруул.

1. Гурван нүд баруун тийш
2. Хоёр нүд доошоо
3. Нэг нүд зүүн тийш
4. Нэг нүд дээшээ
5. Хоёр нүд зүүн тийш
6. Нэг нүд доошоо
7. Нэг нүд баруун тийш
8. Нэг нүд доошоо
9. Хоёр нүд баруун тийш

- Хэрэв (хүүхдийн нэр) миний зааварчилгаануудыг дагаагүй бол шугам одон дээр очиж дуусах байсан уу?

Зааварчилгаа бүрийг дагаж дуулгавартай байсных нь төлөө хүүхдэд таларх. Энэ хичээл дээр хий гэсэн бүгдийг дуулгавартай хийж байсан хоёр номлогчийн тухай судлах болно гэдгийг хүүхдүүдэд хэл.

Судрын Хэсэг

Алма 8:8–9:34 болон 11:21–12:19-өөс Алма, Амюлек хоёр ба тэдний Аммонайхад хийсэн номлолын тухай түүхийг заа. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii-аас үз.) Зургийг тохиромжтой үед нь ашигла.

Ярилцлага ба
Тавьж Болох
Асуултууд

Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншнаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.

- Яагаад Аммонайхын хүмүүс Алмаг сонсохгүй байсан бэ? (Алма 8:9.) Хүмүүсийн зүрх сэтгэлийг зөөлрүүлэхийн тулд Алма юу хийсэн бэ? (Алма 8:10.)
- Алма Аммонайха руу анх удаа очихдоо хийсэнтэй адил зүйл та нарт тохиолдвол та нар юу хийх байсан гэж бодож байна вэ? (Алма 8:13–14.) Яагаад Тэнгэрийн элч Алмад баясагтун хөөр гэж хэлсэн бэ? (Алма 8:15.) Та нар Тэнгэрлэг Эцэгийн зарлигуудыг дагасан үедээ ямар мэдрэмжтэй байдаг вэ?
- Энэ тэнгэрийн элч анх удаа хэдийд Алмад захиас илгээсэн бэ? (Алма 8:15 дахь хүлээн авсан гэсэн үгийг заагаад, хэн нэгнээр Мозая 27:11–16-г уншуул.) Алма хэрхэн нүглээ наманчилсан бөгөөд Тэнгэрлэг Эцэгийн дуулгавартай үйлчлэгч болсныг товч давт (хичээл 14-ийг үз).
- Алмагийн тэнгэрийн элчийн тушаалд хариулсан аргаас бид юу сурч чадах вэ? (Алма 8:18.)
- Яагаад Амюлек Алмад туслах тийм их хүсэлтэй байсан бэ? (Алма 8:20.) Алма, Амюлек хоёрт юу хийхийг тушаасан бэ? (Алма 8:29.)
- Тэнгэрлэг Эцэг Алма, Амюлек хоёрт Аммонайхын бусармаг хүмүүстэй учрахад нь хэрхэн тусалсан бэ? (Алма 8:30–32.) Хүнд нөхцөлд Тэнгэрлэг Эцэгийн тусламжийг авахуйц зохистой байхын тулд бид юу хийж чадах вэ?
- Хэрэв Аммонайхын хүмүүс нүглээ наманчлан зарлигуудыг дуулгавартай дагахгүй бол тэдэнд юу тохиолдоно гэж Алма бошиглосон бэ? (Алма 9:18.)
- Алма, Амюлек хоёр Есүс Христийн тухай юу гэрчилсэн бэ? (Алма 9:26–28.)
- Мацаг барих гэдэг нь юу гэсэн үг вэ? Алма Аммонайхын хүмүүсийн төлөө яагаад мацаг барьсан бэ? (Алма 10:7.) Мацаг барилт нь та нарт хэрхэн адислал болж чадах вэ?
- Зиезром Амюлекийг хэрхэн уруу татах гэж оролдсон бэ? (Алма 11:22.) Энэ уруу таталтанд Амюлек хэрхэн хариулсан бэ? (Алма 11:23–25.) Хэн нэг нь та нарыг ямар нэгэн буруу зүйл хийлгэхээр хуурч, уруу татдахыг

оролддог байсан уу? Та нар энэ мэт уруу таталтыг хэрхэн эсэргүүцэж чадах вэ?

- Зиезром Алма, Амюлек хоёрын дуулгавартай байдлаар хэрхэн адислагдсан бэ? Зиезромыг нүглээ наманчлахад юу нөлөөлсөн бэ? (Алма 12:7–8.) Та нарын гэрчлэлээ хуваалцах нь бусдыг гэрчлэлтэй болоход хэрхэн тусалдаг вэ? Алма Зиезромд Бурхан биднийг хэрхэн шүүх талаар юу заасан бэ? (Алма 12:12–15.)

Баяжуулах Үйл Ажиллагаа

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно.

1. Эргэж ирсэн номлогчийг номлогчийн дүрэм болон Есүс Христийн сургаалуудыг дуулгавартай дагах нь түүнд ямар их чухал байсныг хуваалцуулахаар ангид ирэхийг урь. Өглөө бүр номлогчид Есүс Христийн сайн мэдээг заахаар гарахаасаа өмнө судраас судлах болон залбирлаар өөрсдийгөө хүчирхэгжүүлдэг гэдгийг тайлбарла. Зарлигуудыг дуулгавартай дагах нь тэдэнд итгэл, эр зориг, Сатанаас хамгаалах хамгаалалттай болоход тусална гэдгийг хүүхдүүдэд заа.
2. Нэг хүүхдийг Алма шиг хувцаслахын тулд нэг, эсвэл түүнээс илүү зүйл авчир. Хэдэн хүүхдээр Алмагийн Аммонайхад хийсэн номлолыг жүжигчлэн тоглуул. Алмагийн дүрийг авсан хүүхдэд дараах захиасыг бичсэн цаасыг өг: “Би бол Алма. Би та нарт бидний Аврагч, Есүс Христ болон түүний зарлигуудыг хэрхэн дуулгавартай дагах тухай заахаар ирсэн. Би орж болох уу?” Бусад хүүхдүүдэд дараах захиасуудтай цааснуудыг өг:

Бид цаашид Сүмийн гишүүд биш болсон, Алма. Бид чиний хэлсэн нэг ч үгэнд итгэхгүй.

Алма чи орж болохгүй. Бидний гэр орон, хотыг маань орхи.

Ор, ор. Би чиний захиасыг сонсохыг хүсч байна.

Үгүй! Би чиний хэрхэн эсэргүүцэж байсныг санаж байна. Алма, бид хоёр нүүртэнг сонсохгүй.

Номлогч нарт байх ёстой эр зориг болон Есүс Христэд итгэх итгэл, түүний зарлигуудад дуулгавартай байх нь бидэнд хэрхэн эр зоригийг өгдөг тухай ярь.
3. Нэг хүүхдээс Амюлекийн дүрд тоглохыг хүс. Өөр нэг хүүхдээс Зиезромын дүрд тоглож, гартаа зургаан мөнгөн онтайтай юм шиг дүр үзүүлэхийг хүс. Энэ хүүхдэд дээр нь дараах захиасыг бичсэн хөзрийг өг: “Хараач, энд зургаан мөнгөн онтай байна. Хэрэв та Эрхэм Агуу Нэгний оршин буйг үгүйсгэх аваас би энэ бүгдийг танд өгөх болно.”

Жүжигчилсэн тоглолтыг зогсоогоод, хүүхдүүдээс Амюлек энэ хахуульд юу хэлэх ёстой гэж бодож байгааг асуу. Амюлекийн зөвийг хийж байгаа эр зоригийг нь онцол. Дуулгавартай байхын тулд бидэнд байгаагаар гэж Тэнгэрлэг Эцэг Есүс Христийн хүсдэг эр зоригийн талаар ярь.
4. Хүүхдүүдээс залбирал хэлэх, сүмдээ ирэх, дуу дуулах, гэрчлэлээ ярих, ариун ёслолоос хүртэх, ариун ёслолын үеэр Есүс Христийн тухай

бодох, үйлчлэлийн сайн санааны үйлс бүтээх, аравны нэг төлөх зэрэг тэдний дуулгавартай дагасан, эсвэл өнөөдөр дагах ямар зарлигууд байдгийг асуу. Хүүхдүүдийг ирэх долоо хоногт үйлдэл, үг яриа, бодлуудаа мэдэж байхад нь болон Тэнгэрлэг Эцэгийн зарлигуудыг дагах эр зоригтой байхад нь зоригжуул.

5. “Зөв Замыг Сонго” дууг дуулах, эсвэл үгийг нь унш (*Дуулал*, х. 64).

Дүгнэлт

Гэрчлэл

Тэнгэрлэг Эцэг өөрийнхөө зарлигуудыг дуулгавартай дагахыг биднээс хүсдэг, ингэснээр бид түүний Сүнсийг бидэнтэй хамт байхуйц зохистой байж, мөн түүнд эргэж очиход тэр бидэнд туслах болно гэсэн гэрчлэлээсээ хуваалц.

Зөвлөмж
Болгогдсон

Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ Алма 8:14–20-ийг судлахыг зөвлө.

Гэрийн Уншлага

Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.

Зорилго

Хүүхдүүдэд Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлэхэд нь туслах ба ингэснээр тэд зөв шударгын төлөө зогсож чадна.

Бэлтгэл

1. Алма 14:1–16:10-ыг залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii-ыг үз).
 2. Нэмэлт уншлага: Алма 60:13.
 3. Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго.
 4. Шаардлагатай материалууд:
 - а. Хүүхэд бүрт Мормоны Ном
 - б. Шүхэр
 - в. Зурагнууд: 4-28, Алма, Амюлек Хоёр Аммонайхад; 4-29, Алма Амюлек Хоёр Нурсан Шоронгоос Гарч Ирж Байгаа нь.
-

**Хичээл Заах
Зөвлөмж**

Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.

Анхаарал Татах
Ажиллагаа

Хүүхдүүдэд шүхэр (эсвэл шүхэртэй байгаа дүр үзүүл) болон Мормоны Номыг үзүүл. Эдгээр хоёр зүйл нь юугаараа адил байж болохыг асуу. Шүхрийг нээж дор нь зогсохоос нааш энэ нь биднийг хамгаалахгүй гэдгийг ойлгоход нь хүүхдүүдэд тусал. Үүнтэй адил Мормоны Номыг нээж залбиралтайгаар судалж сургаалынх нь дагуу амьдрахгүй бол энэ нь Есүс Христэд итгэх итгэлийг маань өсгөж чадахгүй.

Хүүхдүүдийг Мормоны Номоо нээж хоёр номлогч хэрхэн шоронгийн хана газарт нурж унатал ямар их итгэлтэй байсныг судлахыг урь.

Судрын Хэсэг

Алма 14:1–16:10-аас Алма, Амюлек хоёрын шоронд байсан тухай хэсгийг заа. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii-аас үз.) Зургуудыг тохиромжтой үед нь ашигла.

Ярилцлага ба
Тавьж Болох
Асуултууд

Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншнаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.

- Сүүлчийн хичээлээс Зиезромын түүхийг товч давт. Зиезром хүмүүсийн оюун санааг сохолсноо мэдээд ямар мэдрэмжтэй байсан бэ? (Алма 14:6.)
- Зиезром гэм нүгэлдээ гэмшиж байгаагаа хэрхэн харуулсан бэ? (Алма 14:7.) Хүмүүс түүнд хэрхэн хандсан бэ? Хүмүүс яагаад заримдаа Тэнгэрлэг Эцэгт итгэдэг хүмүүсийг хавчдаг вэ?

- Аммонайхын хүмүүс Зиезром болон Алма, Амюлек нарт итгэсэн хүмүүсийг яасан бэ? (Алма 14:7, 9.) Та нарт ийм зүйл тохиолдсон бол та нарт ямар байх байсан вэ?
- Алма, Амюлек нар судрууд болон гэмгүй эхнэр, хүүхдүүдийг шатааж байгааг харан гашуудаж байхад Ариун Сүнс Алмад юу гэж хэлсэн бэ? (Алма 14:11.) Тэнгэрлэг Эцэг яагаад Алмаг хүмүүсийг галаас аврахыг зөвшөөрөөгүй вэ?
- Үнэний хамгаалалтанд нас бардаг зөв шударга хүмүүст юу тохиолдсон бэ? (Алма 60:13.) Заримдаа зөв шударга хүмүүс үнэнийг хамгаалан нас бардаг гэдгийг ойлгоход нь хүүхдүүдэд тусал.
- Яагаад Алма, Амюлек нар тэр аймшигт хавчлагыг тэвчиж гарч чадсан гэж та нар бодож байна вэ? Алма, Амюлек нарт байсан Есүс Христэд итгэх тэрхүү итгэлийг олж авч чадахын тулд та нар юу хийж чадах вэ? Үнэний төлөө зогсох нь яагаад эр зоригийг шаарддаг вэ?
- Алма, Амюлек нарыг шоронд байхад тэдэнд юу хийх хүч чадал өгөгдсөн бэ? (Алма 14:25–28.) Хэн тэдэнд энэ хүч чадлыг өгсөн бэ? Яагаад хотын хүмүүс Алма, Амюлек нараас зугтаасан гэж та нар бодож байна вэ? (Алма 14:29.)
- Зиезром яагаад халуурч өвдсөн бэ? (Алма 15:3.) Юу Зиезромыг бие махбод болон сүнс хоёулангаар нь эдгэрэх боломжтой болгосон бэ? (Алма 15:6–8.) Та нар ямар нэг буруу зүйл хийхдээ ямар мэдрэмжтэй байдаг вэ? Та нар нүглээ наманчлахаараа ямар мэдрэмжтэй байдаг вэ? (Хүүхдүүдийг эвгүй байдалд оруулж болох асуултуудыг ярилцахгүй байхыг анхаар.)
- Зиезром эдгэж усаар батлуулсныхаа дараа юу хийсэн бэ? (Алма 15:12.) Та нар одоо бусадтай сайн мэдээг хуваалцахаар юу хийж байна вэ? Та нар бүрэн цагийн номлолд үйлчлэхийн тулд хэрхэн бэлтгэж чадах вэ? Амюлек номлогч байсан учраас түүнд юу тохиолдсон бэ? (Алма 15:16.) Номлогчид өнөөдөр номлолд явахын тулд ямар золиослоуудыг хийж байна вэ?
- Аммонайхын хүмүүс нүглээ наманчлахаас татгалзвал тэдэнд юу тохиолдоно гэж Алма бошиглосон бэ? (Алма 9:18.) Энэ бошиглол нь хэрхэн биелсэн бэ? (Алма 15:15, 16:2–3, 9–10.)
- Та нарыг Есүс Христэд итгэх итгэлтэй байж зөв шударгын төлөө зогсоход туслах Алма, Амюлек нарын энэ түүхээс та нар юу сурсан бэ?

Баяжуулах Үйл Ажиллагаа

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно.

1. Хичээлийн төгсгөл дэх Зөвийн Төлөө Зогс гэсэн хүснэгтийг хийгээд хүүхэд бүрт нэгийг өг. Хийхэд эр зориг шаардагдах зүйлүүдийг тодорхойлохын тулд зүүн талд байгаа үг бүрийг баруун талд байгаа үгтэй холбох шугамыг хүүхдүүдээр зуруул. Хүүхдүүдийг дуусахаараа

босож зогсохыг хүс. Бүгд босч зогсоход, тэднийг суулгаад итгэлтэйгээр хийхэд тэд бэлэн байгаа нэг зүйлийг сонгуул. Хүүхэд бүрт ангийн урд гарч ирээд, шүхрийг дэлгэн дор нь зогсож байхдаа чангаар зорилгоо давтан хэлэх боломжийг өг. Жишээлбэл: “Би хэзээ ч хуурч мэхлэхгүй гэдгээ амлаж байна!” (Хэд хэдэн хүүхэд адилхан зорилт тавьж болно.) Шүхэр нь биднийг Сатанаас хамгаалах Есүс Христийн сургаалыг төлөөлж байгаа гэдгийг тайлбарла.



2. Хүүхдүүдтэй хамт, Есүс Христэд итгэх итгэлээ хүчирхэгжүүлэхийн тулд хүүхдүүдийн хийж чадах зүйлсийг самбарт жагсаан бич. Хүүхэд бүрийг ирэх долоо хоногт хийх нэг зүйлийг жагсаалтаас сонгохыг хүс. Хүүхдүүдээр нүдийг нь аниулаад, өөрсдийнхөө зорилгуудыг биелүүлж байна хэмээн төсөөлөхийг хүс. Хүүхдүүдийг дараагийн долоо хоногт хир их сайн амжилттай байснаа ярихыг урь.
3. Итгэлийн тунхгийн дөрөвдүгээрийг уншаад, хүүхдүүдээс жагсаагдсан алхам бүрийг Зиезром хэрхэн биелүүлснийг нь тогтоохыг хүс.

Дүгнэлт

Гэрчлэл

Бид Алма, Амюлек нарын адил зарлигуудыг дуулгавартай дагавал бидний Есүс Христэд итгэх итгэл өсч, бид зөвийн төлөө зогсох эр зоригтой байх болно гэсэн гэрчлэлээ ярь.

Зөвлөмж

Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ Алма 14:23–29 болон 15:1–13-ыг судлахыг зөвлө.

Болгогдсон

Гэрийн Уншлага

Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.

ЗӨВИЙН ТӨЛӨӨ ЗОГС

Сонго	Залбиралуудыг
Хэл	Өмч хөрөнгө
Хэзээ ч бүү	Сайхан сэтгэл
Дуулгавартай дага	Мэхэл
Хүндэл	Үнэнийг
Бай	Хараахаа
Зайлсхий	Зөвийг
Хэл	Зарлигуудаа
Дага	Судраас
Суралц	Есүс

ЗӨВИЙН ТӨЛӨӨ ЗОГС

Сонго	Залбиралуудыг
Хэл	Өмч хөрөнгө
Хэзээ ч бүү	Сайхан сэтгэл
Дуулгавартай дага	Мэхэл
Хүндэл	Үнэнийг
Бай	Хараахаа
Зайлсхий	Зөвийг
Хэл	Зарлигуудаа
Дага	Судраас
Суралц	Есүс

Зорилго

Хүүхэд бүрийг сайн үлгэр жишээ үзүүлж Есүс Христийн тухай гэрчилснээрээ сайн мэдээг хуваалцахад нь урамшуулна.

Бэлтгэл

1. Алма 17–19-ийг залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii-ыг үз).
 2. Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго.
 3. Шаардлагатай материалууд:
 - а. Хүүхэд бүрт Мормоны Ном
 - б. Зураг 4-30, Аммон Ламонай Хааны Хонин Сүргийг Хамгаалсан нь (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 310, 62535).
-

**Хичээл Заах
Зөвлөмж**

Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.

Анхаарал Татах
Ажиллагаа

Нэг хүүхдийг гишүүн бус хүний дүрд тоглуул. Энэ үед хоёр хүүхдийг номлогч болго. (Хэрэв та хүсвэл цаасаар нэрийн тэмдэг хийж болно.) Хос номлогч болгоноор сонирхогчийн нэг, эсвэл хоёр асуултанд хариулуул, асуулт нь доорхтой адил байна.

- Та нар Тэнгэрлэг Эцэг амьдардаг гэдгийг хэрхэн мэдэх бэ?
- Тэнгэрлэг Эцэг юутай адил вэ?
- Есүс Христ гэж хэн бэ?
- Есүс Христ бидний төлөө юу хийсэн бэ?
- Ариун Сүнс гэж хэн бэ?
- Ариун Сүнс бидэнд хэрхэн тусалдаг вэ?

Хүүхдүүдээс тэд Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ болон Ариун Сүнсний тухай хэн нэгэнд ярьж байхдаа тэдний сэтгэгдэл ямар байдгийг нь асуу. Хүүхдүүд Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ болон Ариун Сүнсний талаар юу мэддэгээ тайлбарлаж байхдаа гэрчлэлээ хуваалцсан гэдгийг ойлгож мэдэхэд нь тэдэнд тусал.

Баяжуулах үйл ажиллагаа 1 нь хоёрдогч анхаарал татах ажиллагаа болон ашиглагдаж болно.

Энэ хичээл нь хүчтэй гэрчлэлтэй нэгэн агуу номлогчийн тухай гэдгийг тайлбарла.

Судрын Хэсэг

Зургийг тохиромжтой үед нь ашиглан Алма 17–19-өөс Аммон болон Лэмонай Хааны тухай хэсгийг хүүхдүүдэд заа. Аммон Лэмонай Хаанд Тэнгэрлэг Эцэгийн талаарх өөрийн мэдлэгийн тухай гэрчлэлээ хуваалцсан гэдгийг тайлбарла. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii-аас үз.)

Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншнаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.

- “Их Эзэний мутарт зэмсэг болох” гэдэг нь юу гэсэн үг вэ? (Алма 17:9.) *Зэмсэг* гэдэг нь багаж хэрэгсэл юм гэдгийг тайлбарла. Мозаягийн хөвгүүд нүглээ наманчилсны дараа номлолдоо хэрхэн бэлдэцгээсэн бэ? (Алма 17:2–3.) Та нар одоо сайн мэдээг бусадтай хуваалцахын тулд юу хийж байна вэ? Итгэлтэй номлогч байхаар бэлтгэхийн тулд та нар юу хийж чадах вэ?
- Мозаягийн хөвгүүд яагаад Лэмэнчүүд рүү номлол хийхээр явахыг хүссэн бэ? (Алма 17:16.) Тэнгэрлэг Эцэгийн бүх хүүхдүүд Есүс Христийн сайн мэдээг сонсож, ойлгох нь яагаад чухал вэ?
- Аммон бусармаг Лэмэнчүүдтэй тэмцэлдэж байхдаа юунд найдаж байсан бэ? (Алма 17:29.)
- Их Эзэн Мозаяд хөвгүүдийнх нь талаар ямар амлалт өгсөн бэ? (Алма 17:35.) Энэ удаад Их Эзэн амлалтаа хэрхэн биелүүлсэн бэ? (Алма 19:22–23.)
- Аммоны жишээ Лэмонай Хаанд ямар сэтгэгдэл төрүүлсэн бэ? (Алма 18:9–11.) Хэн та нарт сайн жишээ үзүүлдэг вэ? Та нар хэнд сайн жишээ үзүүлж чадах вэ?
- Аммоны гэрчлэл болон Их Эзэний Сүнс Лэмонай Хаанд хэрхэн нөлөөлсөн бэ? (Алма 18:40–43.) Бусдын гэрчлэл та нарт хэрхэн тусалдаг вэ? Ямар ямар байдлаар та нар бусадтай гэрчлэлээ хуваалцаж болох вэ?
- Хатан болон түүний үйлчлэгч Эбиш нар өөрсдийн агуу итгэлээ хэрхэн үзүүлсэн бэ? (Алма 19:8–12, 17.)
- Лэмонай Хаан болон Хатан хоёр хоёулаа юун тухай гэрчилсэн бэ? (Алма 19:12–13, 29–30.) Лэмонай Хаан Есүс Христийг харсныхаа дараа ямар сэтгэгдэлтэй байсан гэж та нар бодож байна вэ? (Алма 19:12–13.)
- Аммон, Лэмонай Хаан хоёрын адил бид Есүс Христийн тухай сурахад бусдад туслах нь яагаад чухал вэ?

Баяжуулах Үйл Ажиллагаа

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно.

1. Хүүхдүүдэд барилгачид, эмч нар, цэцэрлэгчид, будагчид зэрэг хүмүүсийн хэрэглэдэг хэд хэдэн багаж хэрэгслийг үзүүл. Хүүхдүүдээс тус бүрийнх нь тухай, хэн үүнийг хэрэглэдэг, мөн хэрхэн ашигладаг зэрэг мэдэх зүйлсээ ярихыг хүс.

Багаж хэрэгслийн ач холбогдлын тухай ярь. Хүүхэд бүр хэрхэн Бурханы гар дахь багаж хэрэгсэл байж болохыг тайлбарла.

2. Хүүхдүүдэд тус бүрт нь цаас харандаа өгч, тэднээр Сүм болон Есүс Христийн сайн мэдээний тухай гэрчлэл болон сэтгэгдлийг нь бичүүл.

Тэд үүнд Тэнгэрлэг Эцэгт ойр байна гэсэн мэдрэмжийг төрүүлдэг бодол санаа болон сэтгэгдлээ багтааж болно. Тэд гэрчлэлээ хуваалцаж болох хэн нэгнийг тэднээр бодож олуул.

3. Хүүхэд бүрээр дараах хөзрийг гэртээ авч явахаар хийлгэ:

Би одоо _____-аараа номлогч байж чадна. (Хүүхдүүдээр зайг нөхүүл.)

Дүгнэлт

Гэрчлэл

Биднийг түүний тухай болон түүний сайн мэдээний тухай гэрчлэлээ хуваалцахад Их Эзэн биднийг адисладаг гэдгийг гэрчил. Бид Есүс Христийн сайн мэдээний дагуу амьдардаг учраас өөрсдийн үлгэр дууриаллаараа бусадтай сайн мэдээг хуваалцаж чадна.

Зөвлөмж

Болгогдсон

Гэрийн Уншлага

Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ Алма 17:19–25, 18:8–40-ийг судлахыг зөвлө.

Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.

Зорилго

Хүүхдүүдэд гэтэлгэлийн төлөвлөгөөний дагуу бид гэм нүглээсээ өршөөгдөх болно гэдгийг ойлгоход нь тусална.

Бэлтгэл

1. Алма 20:1–22:26 болон 23:1, 4–5-ыг залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii-ыг үз).
 2. Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго.
 3. Дараах найман үгийн хайчилбарыг бэлд (эсвэл самбар дээр бичихээр төлөвлө):
 - Бүтээлт
 - Адам, Ева хоёр—Уналт
 - Нүгэл
 - Бие Махбодын Үхэл
 - Есүс Христ—Цагаатгал
 - Дахин Амилалт
 - Наманчлал
 - Гэтэлгэлийн Төлөвлөгөө
 4. Шаардлагатай материалууд:
 - а. Хүүхэд бүрт Мормоны Ном
 - б. Зурагнууд: 4-9, Есүс бол Христ (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 240, 62572); 4-31, Аммон, Ламонай Хоёр Ламонайгийн Эцэгтэй Тааралдсан нь; 4-32, Ламонайгийн Эцэгт Судруудаас Уншиж Буй Аарон.
-

Хичээл Заах**Зөвлөмж**

Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.

Анхаарал Татах
Ажиллагаа

Хүүхдүүдээс хар дарж зүүдэлж байхдаа юу мэдэрч байснаа санахыг хүс. Нэг юм уу хоёр хүүхдээр юу мэдэрснийг нь яриул. Тэгээд тэднээс сэрээд, энэ нь жинхэнэ биш, харин ердөө л зүүд байсныг мэдэхээрээ ямар их тайвширч байснаа санахыг нь хүс.

Тэнгэрлэг Эцэгийн зарлигуудад дуулгаваргүй байх нь аз жаргалгүй байдал, өвчин, гэмшлийн шалтгаан болдгийг тайлбарла. Дуулгаваргүй байсныхаа төлөө буруутай юм шиг санагдаж байгаа хүмүүс нь “сэрээд” гэм нүгэл нь үгүй болсныг олж мэдэхийг хүсч болно. Гэм нүглүүдийнхээ өршөөлийг хүртэх нь хялбар энгийн зүйл биш юм, гэвч Тэнгэрлэг Эцэг бидэнд гэм нүглийнхээ төлөө өршөөгдсөн байх арга замуудыг өгсөн.

Дараах үгийн хайчилбаруудыг үзүүл: “Бүтээлт”, “Адам, Ева хоёр—Уналт”, “Нүгэл”, “Бие Махбодын Үхэл”. Дэлхий бүтээгдэхээс өмнө бид Тэнгэрлэг Эцэгийн сүнсэн хүүхдүүд байж түүнтэй хамт амьдарч байсныг товчхон

тайлбарла. (Хоёр минутанд багтахаар төлөвлөн) Есүс Христ Тэнгэрлэг Эцэгийнхээ удирдлаган дор энэ дэлхий болон түүн дээрх бүх зүйлсийг бүтээсэн. Адам, Ева хоёр Едений цэцэрлэгт байсан бөгөөд тэнд тэд Тэнгэрлэг Эцэгийн идэхийг хориглосон жимснээс хүртэхийг сонгосон. Жимснээс хүртсэн Адам, Ева хоёрын дуулгаваргүй байдлыг Уналт гэдэг. Адам, Ева хоёр биднийг дэлхий дээр төрөх боломжтой болгосон учраас бид тэдэнд талархдаг гэдгийг тайлбарла. Уналт бол зайлшгүй байсан, гэвч энэ нь бид бүгдийг хоёр ноцтой үр дагавартай болгосон.

Бид бүгд сайн муугийн хооронд буруу сонголтуудыг хийснээр нүгэл үйлдэнэ.

Бид бүгд бие махбодын үхлээр зовж шанална.

Дэлхий бүтээгдэхээс өмнө Тэнгэрлэг Эцэгт биднийг нүглээ наманчилбал биднийг гэтэлгэх буюу аврах төлөвлөгөө аль хэдийнээ байсан гэдгийг тайлбарла (Алма 12:22–25). Энэ хичээл дээр хүүхдүүд ноцтой гэм нүгэл үйлдсэн гэдгээ ойлгосон Лэмонай Хааны тухай болон тэрээр гэм нүглийнхээ өршөөлийг хэрхэн хүртэж байгааг судлах болно гэдгийг тайлбарла.

Судрын Хэсэг

Алма 20:1–22:26-д бичигдсэн Лэмонай Хааны эцэгийн хөрвүүлэлтийн тухай хэсгийг заа. Ярилцлагадаа Лэмонай Хааны эцэг гэтэлгэлийн төлөвлөгөөний талаар юу сурсаныг нь багтаа. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii-аас үз.) Зургуудыг тохиромжтой үед нь ашигла.

Ярилцлага ба Тавьж Болх Асуултууд

Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншнаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.

- Лэмонай Хаан яагаад Аммонтой хамт Миддойнайн нутаг руу явсан бэ? (Алма 20:1–5.) Аарон бол Аммоны шоронд орсон номлогч ах нарын нэг гэдгийг тайлбарла.
- Лэмонайгийн эцэг Аммонтой анх уулзахдаа сайн мэдээг хүлээн авахдаа бэлэн биш байсан гэдгийг бид хэрхэн мэдэх вэ? (Алма 20:10,13–14.)
- Хожим нь сайн мэдээний захиасыг хүлээн авахад нь Лэмонайгийн эцэгийн зүрх сэтгэлийг юу зөөлрүүлсэн бэ? (Алма 20:26–27.) Та нарт хайраа үзүүлж байгаа хүмүүсийн талаар та нар ямар сэтгэгдэлтэй байдаг вэ? Та нар хайраа бусдад хэрхэн үзүүлдэг вэ?
- Лэмонайгийн эцэг рүү очихоо Аарон хэрхэн мэдсэн бэ? (Алма 22:1.)
- Лэмонайгийн эцгийг сэтгэл зовоход юу нөлөөлсөн бэ? (Алма 22:4–6.)
- Аммоныг “Хэрэв та нар наманчилбал аврагдах болно, мөн хэрэв та нар наманчлахгүй бол, та нар эцсийн өдөр зайлуулагдах болно” гэж хэлэхэд Лэмонайгийн эцэг яагаад сайн мэдээг сонирхох болсон гэж та нар бодож байна вэ? (Алма 22:6)
- Аарон Лэмонай Хааны эцэгт заахдаа юу хэрэглэсэн бэ? (Алма 22:12.) Судраа унших нь бидэнд хэрхэн тусалж чадах вэ?
- Аароны Лэмонайгийн эцэгтэй ярилцсан анхны зүйл нь юу байсан бэ? (Алма 22:7–8.) Тэнгэрлэг Эцэгт итгэх нь яагаад ийм их чухал вэ?

- Аарон Лэмонайгийн эцэгт Бүтээлтийн талаар юу заасан бэ? (Алма 22:10.)
- Бид хэний дүр төрхөөр бүтээгдсэн бэ? (Алма 22:12.) Та нарт Тэнгэрлэг Эцэгийн дүр төрхөөр бүтээгдсэн гэдгээ мэдэх нь яагаад чухал бэ?
- Аарон Лэмонайгийн эцэгт Уналт болон Цагаатгалын талаар юу заасан бэ? (Алма 22:12–14.)

Бидний гэм нүглийн төлөө зовж, бидний төлөө амиа өгч, дахин амилснаараа Есүс Христ Уналтын үр нөлөөг даван туулсан гэдгийг ойлгоход нь хүүхдүүдэд тусал. “Адам, Ева Хоёр—Уналт” гэсэн үгийн хайчилбарын дээр “Есүс Христ—Цагаатгал” гэсэн үгийн хайчилбарыг байрлуул.

Есүс дахин амилсан учраас бид бүгд бас дахин амилах болно. “Бие Махбодын Үхэл” гэсэн үгийн хайчилбарын дээр “Дахин Амилалт” гэсэн үгийн хайчилбарыг тавь.

Есүс бидний гэм нүглийн төлөө зовсноор биднийг нүглээ наманчлах болон өршөөгдөх боломжтой болгосон. “Нүгэл” гэсэн үгийн хайчилбарын дээр “Наманчлал” гэсэн үгийн хайчилбарыг тавь.

“Гэтэлгэлийн Төлөвлөгөө” гэсэн үгийн хайчилбарыг бусад үгийн хайчилбаруудын дээр тавиад, энэ нь биднийг түүнтэй улам адил болоход туслах Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөө гэдгийг тайлбарла.

- Аароныг гэтэлгэлийн төлөвлөгөөг тайлбарласны дараа Лэмонайгийн эцэг юу мэдэхийг хүссэн бэ? (Алма 22:15.)
- Аарон Лэмонайгийн эцэгт юу хийхийг хэлсэн бэ? (Алма 22:16.) Бид гэм нүглийнхээ өршөөлийг авч, мөнхийн амьдралыг хүлээн авахдаа зохистой байхын тулд юу хийх ёстой вэ?
- Лэмонайгийн эцэг нүглээ наманчлахыг хүсэж байгаагаа үзүүлэхийн тулд юу хийсэн бэ? (Алма 22:17–15.) Хааны хөрвүүлэгдсэний үр дүнд юу болсон бэ? (Алма 22:22–23, 25–26, 23:1, 4–5.)

Баяжуулах Үйл Ажиллагаа

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно.

1. Хүүхдүүдийг өөрсдийнх нь уншсан ялангуяа тэдэнд чухал гэж бодогдсон дараахтай адил хэсгүүдийг судар дээрээ тэмдэглэхийг урь:

“Хэрэв та нар наманчилбал аврагдах болно, мөн хэрэв та нар наманчлахгүй бол, та нар эцсийн өдөр зайлуулагдах болно” (Алма 22:6).

“Би таныг мэдэхийн тул би өөрийн бүх нүглүүдийг орхих болно” (Алма 22:18).
2. Итгэлийн тунхгийн хоёр болон гуравдугаарыг давтаад, үүнийг ойлгож, цээжлэхэд нь хүүхдүүдэд тусал.
3. Самбар, эсвэл цаасан дээр том дөрвөлжин зураад үүнийгээ есөн тэнцүү дөрвөлжинд хуваа. Дөрвөлжингүүдийг үзүүлсний дагуу нэгээс ес хүртэл дугаарла.

1	2	3
4	5	6
7	8	9

Ангийг хоёр багт хуваа. Баг бүрт Х, О гэх зэрэг тэмдэг өг. Эхний багаас хэн нэгнийг нэгээс ес хүртэлх тооноос нэг дугаарыг сонгуулаад доороос заагдсан асуултыг нь уншуул. Багийн аль ч гишүүн асуултанд хариулж болно. Хэрэв багийн гишүүд асуултанд зөв хариулбал асуултанд хариулсантай адил дугаартай дөрвөлжинд багийнх нь тэмдгийг тавь. Хэрэв тэд асуултанд зөв хариулаагүй бол дөрвөлжинг хоосон орхи. Хоёр багаар ээлжлүүл. Аль нэг баг нь хөндлөнгөөр, босоогоор, диагнолиар нэг эгнээнд гурван тэмдэг авахад тоглоом дуусах болно.

- 1) Тэнгэрлэг Эцэгийн бидэнд зориулсан агуу төлөвлөгөөг юу гэж нэрлэдэг вэ? (Авралын төлөвлөгөө, гэтэлгэлийн төлөвлөгөө, аз жаргалын төлөвлөгөө.)
- 2) Гэтэлгэх гэдэг нь юу гэсэн үг вэ? (Биднийг нүглийн боолчлолоос аврах.)
- 3) Хэн дэлхийг бүтээсэн бэ? (Тэнгэрлэг Эцэгийн удирдлаган дор Есүс Христ.)
- 4) Дэлхий дээрх анхны хүмүүс хэн байсан бэ? (Адам, Ева хоёр.)
- 5) Адам, Ева хоёр хориотой жимс идсэнээс болж юу болсон бэ? (Тэд Едений цэцэрлэгээс хөөгдөж, хүүхдүүдтэй болж, мөнх бус биетэй болж, зөв буруугийн хооронд сонгох чадвартай болсон.) Мосе 5:11-ийг үз)
- 6) Хаанд Аарон судрууд буюу гуулин ялтсуудаас заасан. Бид сайн мэдээ буюу гэтэлгэлийн төлөвлөгөөг заахдаа ашигладаг ямар дөрвөн судар байдаг вэ? (Ариун Библи, Мормоны Ном, Сургаал ба Гэрээ, Агуу Их Үнэт Сувд.)
- 7) Аарон Лэмонай Хааны эцэгт заасан анхны зүйл нь юу байсан бэ? (Бурхан байдаг.)
- 8) Есүс бидэнд түүнтэй дахин хамт амьдрахаар эргэн очих боломжийг хэрхэн бий болгосон бэ? (Тэр бидний гэм нүглийн төлөө зовж, мөн үхсэн.)
- 9) Тэнгэрлэг Эцэгтээ эргэж очиж чадахын тулд бид юу хийх ёстой вэ? (Гэм нүглээ наманчилж, гэрээнүүдээ сахиж, сайн үйлс хийх.)

Хичээлээс асуултуудыг бэлдэж тоглоомыг дахин тогло.

4. “Гэр Бүлүүд Мөнхөд Хамт Амьдарч Чадна” (Дуулал, х. 29), “Би Бурханы Хүүхэд” (Дуулал, х. 28) дуунуудыг дуулах, эсвэл үгийг нь унш.

Дүгнэлт

Гэрчлэл

Тэнгэрлэг Эцэг маань бидэнд хайртай бөгөөд гэтэлгэлийн төлөвлөгөөг өгсөн учир бид гэм нүглээ наманчлан түүнтэй адил болж чадна гэсэн гэрчлэлээ хуваалц.

Зөвлөмж
Болгогдсон

Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ Алма 22:1–16-г судлахыг зөвлө.

Гэрийн Уншлага

Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.

Тайлбар: Хэрэв та баяжуулах үйл ажиллагаа 1-ийг дараагийн хичээлд ашиглахаар шийдэж байгаа бол даалгаварыг наанадаж нэг, эсвэл хоёр долоо хоногийн өмнө өг.

Зорилго

Хүүхэд бүрийн нандин гэрээнүүдээ сахих хүслийг нь нэмэгдүүлнэ.

Бэлтгэл

1. Алма 23–24, 26:23–33 болон 27-г залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii-ыг үз).
2. Нэмэлт уншлага: Алма 25:1–26:22.
3. Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго
4. Шаардлагатай материалууд:
 - а. Хүүхэд бүрт Мормоны Ном
 - б. Хоёрдогч анхаарал татах ажиллагаанд: нимгэвтэр хайрцаг, эсвэл хайруулын таваг, хайрцагт нимгэн үе цацахад хүрэлцхүйц давс буюу элс, тодруулагч юмуу тосон харандаа ба чулуу.
 - в. Зураг 4-33, Антай-Нифай-Лихайчууд Зэр Зэвсгээ Булсан нь (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 311, 62565).

**Хичээл Заах
Зөвлөмж**

Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.

Анхаарал Татах
Ажиллагаа

Антай-Нифай-Лихайчууд Зэр Зэвсгээ Булсан нь зургийг үзүүл. Хэрэв хүүхдүүд аюултай дайралтанд өртөгдөх гэж байгаага мэдэж байсан бол зэр зэвсгээ булахыг хүсэх байсан эсэхийг тэднээс асуу. Антай-Нифай-Лихайн хүмүүс дайснууд нь тэднийг алахаар төлөвлөж байгаа гэдгийг мэдсэн боловч тэд Тэнгэрлэг Эцэгтэй тулалдахгүй байх болно гэсэн чухал гэрээг байгуулсан. Сайн мэдээний гэрээ гэдэг нь Тэнгэрлэг Эцэг болон түүний хүүхдүүдийн хоорондох холбогч гэрээ буюу амлалт гэдгийг тайлбарла. Таныг Антай- Нифай-Лихайн тухай түүхийг унших хооронд тэд яагаад энэ гэрээг хийх болсон, тэд амлалтаа хэрхэн сахисан болохыг олж мэдэхийн тулд хүүхдүүдээс анхааралтай сонсохыг хүс.

Хоёрдогч
Анхаарал Татах
Ажиллагаа

Савны ёроолд давс юмуу элс цац. Хуруугаараа Амлалт гэсэн үгийг давс юмуу элсэн дээрээ бич. Хүүхдүүдэд дараах асуултуудыг тавь:

- Та нар ер нь өөрийнхөө амлалтыг зөрчиж байсан хэн нэгэнтэй гэрээ, эсвэл амлалт хийж байсан уу? (Зөөлөн үлээж давс юмуу элсэн дээрх үгийг арилгаад, гэрээ цуцлагдахад тэд ямар мэдрэмжтэй байсныг нь хүүхдүүдээр яриул.)
- Тэнгэрлэг Эцэгтэй хийсэн амлалтаа бид юу гэж нэрлэдэг вэ? (Гэрээ.)
- Бид хэзээ Тэнгэрлэг Эцэгтэй амлалтуудыг хийсэн бэ? (Усаар батлуулахдаа.)

Амлалт нь хайхрамжгүйгээр хийгдэх ёсгүй гэдгийг хүүхдүүдэд сануул. Амласнаа биелүүлэхийн чухлыг онцол. Чулуун дээр тодруулагч юмуу тосон харандаагаар *Гэрээ* гэсэн үгийг бич. Сайн мэдээний гэрээ нь Тэнгэрлэг Эцэг болон түүний хүүхдүүдийн хоорондох амлалт гэдгийг тайлбарла. Чулуу руу үлээгээд үг нь хялбархан арилчихгүй болохыг үзүүл. Бид гэрээ хийж байхдаа тэдгээр нь нандин хийгээд бид тэдгээрийг сахина гэдгээ шийдэх хэрэгтэй гэдгийг санах ёстой.

Судрын Хэсэг

Алма 23–24, 26:23–33 болон 27-гоос Антай-Нифай-Лихайчууд гэрээнүүдээ хэрхэн хүндэтгэж байгаа хэсгийг заа. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii-аас үз.)

Ярилцлага ба Тавьж Болох Асуултууд

Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншнаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.

- Мозаягийн дөрвөн хүүг хэн гэдэг байсан бэ? (Мозая 23:1.)
- Мозаягийн дөрвөн хүү яагаад Лэмэнчүүдийн дунд сайн мэдээг тунхаглахыг хүссэн бэ? (Мозая 28:3.) Зарахэмла дахь Нифайчууд Мозаягийн хөвгүүдийг төлөвлөгөөгөө тэдэнд хэлэхэд яагаад инээлдсэн бэ? (Мозая 26:23–25.)
- Лэмэнчүүд Есүс Христэд хэрхэн хөрвүүлэгдэж байсан бэ? (Мозая 23:5–6.) Эдгээр хөрвүүлэгчдийн хэд нь Есүс Христэд итгэх итгэлдээ хүчтэй үлдсэн бэ? Есүс Христэд итгэх итгэлээ хүчтэй байлгасаар байхын тулд бид юу хийж чадах вэ?
- Лэмэнчүүдийн хөрвүүлэгчид яагаад нэрээ сольсон бэ? (Алма 23:16–17.) Сүүлд нь, эдгээр хөрвүүлэгчид Жэршоны нутаг руу нүүхдээ ямар нэрээр танигдах болсон бэ? (Алма 27:26.) Та нар гэрээ хийхдээ өөртөө ямар нэр авсан бэ? (Мозая 5:7–8.)
- Антай-Нифай-Лихайчууд яагаад дахин хэзээ ч дайсантайгаа тулалдахгүй гэж шийдсэн бэ? (Алма 24:10–13, 16.)
- Антай-Нифай-Лихайчууд зэр зэвсгээ булж байхдаа Их Эзэнтэй ямар гэрээ хийсэн бэ? (Алма 24:17–18.) Антай-Нифай-Лихайчууд энэ гэрээгээ сахихын тулд юу хийсэн бэ? (Алма 24:19–22.) Бид ямар зарлигуудыг дуулгавартай дагана гэж амласан бэ? (Мэргэн Ухааны Үг, аравны нэг, Хүндэтгэлийн өдрийг ариунаар нь сахих болон бодол, үйл хөдлөлдөө цэвэр байх.)
- Бурханы хүмүүс тулалдахгүй, харин алуулахаар хэвтэцгээж байгааг хараад Лэмэнчүүдийн цэргүүдийн ихэнх нь яасан бэ? (Алма 24:24–27.) Бидний жишээ бусдыг Сүмд нэгтгэхэд хэрхэн тусалдаг вэ? Бидний гэрээнүүдээ сахиж байгаа жишээ маань бусдад гэрээнүүдээ сахихад нь хэрхэн тусалж чадах вэ?
- Антай-Нифай-Лихайчууд зэр зэвсгээ булснаар дайснууддаа ямар хандлага үзүүлсэн бэ? (Алма 26:32–33.) Есүс Христийн сайн мэдээнд үнэнээр хөрвүүлэгдсэн хүмүүс яагаад бүх хүмүүсийг бүр дайснаа хүртэл хайрлаж, тэдний төлөө санаа тавьдаг гэж та нар бодож байна вэ?
- Антай-Нифай-Лихайчууд яагаад үхэхээс айгаагүй вэ? (Алма 27:28.)

- Яагаад Антай-Нифай-Лихайчуудын Хаан өөрөө болон түүний хүмүүс Нифайчуудын боол байх болно гэж хэлсэн бэ? (Алма 27:4–8.)
- Гэрээгээ хүндлэн дээдэлж Антай-Нифай-Лихайчуудтай илүү адил болохын тулд бид юу хийж чадах вэ?

Баяжуулах Үйл Ажиллагаа

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно.

1. Нэг том хүнээр Лэмэнчүүдийн Хааны дүрд тоглуул түүний хүмүүс яагаад ах дүү нартайгаа тэмцэлдэхээр сэлмээ авахгүй вэ гэдгийг нь хэлүүл. Түүний сэлмээ булж байхдаа хийсэн гэрээг давт (Алма 24:6–13, 16–18-ыг үз).
2. Итгэлийн тунхгийн арван гуравдугаарыг давт. Аммоны хүмүүс эдгээр зарчмуудын дагуу амьдарсан эсэхийг хүүхдүүдээс асуу.
3. “Бие Биенээ Хайрлаач” дууг дуулах, эсвэл үгийг нь унш (*Дуулал*, х. 33).

Дүгнэлт

Гэрчлэл

Христийн Сүмийн гишүүнийнхээ хувьд бид нандин гэрээнүүдийг хийдэг гэдгийг гэрчил. Хэрэв бид амлагдсан адислалуудыг хүртэхийг хүсвэл бид гэрээнүүдээ хүндэтгэх ёстой.

Зөвлөмж
Болгогдсон

Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ Алма 24:6–27-г судлахыг зөвлө.

Гэрийн Уншлага

Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.

Зорилго

Есүс Христийг дагаснаараа тэд Сатанд мэхлэгдэхээс зайлсхийж чадна гэдгийг ойлгоход нь хүүхдүүдэд тусална.

Бэлтгэл

1. Алма 30 болон Моронай 7:15–17-г залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii-ыг үз).
2. Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго.
3. Шаардлагатай материалууд:
 - а. Хүүхэд бүрт Мормоны Ном
 - б. Дээр нь эерэг сайн үгс бичсэн цааснууд болон наадаг тууз.
 - в. Зурагнууд: 4-9, Есүс бол Христ (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 240, 62572); 4-34, Алма Корихорт Бурхан Байдгийг Гэрчилж Байгаа нь; 4-35, Корихор Бурхан Байдгийг Мэднэ Гэдгээ Бичиж Байгаа нь.

Хичээл Заах Зөвлөмж

Анхаарал Татах
Ажиллагаа

Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.

Хичээл эхлэхээс өмнө эерэг сайн үгс (жишээлбэл, доорхи хос бүрийн эхний үг)-ийг цаасан дээр бичээд хүүхэд бүрийн сандлын дор нэг үг наа (эсвэл хүүхдүүдийг ангид орж ирэхэд нь тарааж өгч болно). Хүүхдүүдийг сандлын доорхи үгсийг олоход нь урь. Хүүхэд бүрийг өөрсдийн цаасан дээрх үгний эсрэг утгатай үгийг бодож олохыг хүс. Бусад хүүхдүүд тухайн хүүхдийн цаасан дээрх эерэг сайн үгийг таахыг оролдож байх үеэр хүүхэд бүрээр бодож олсон эсрэг үгийг нь хэлүүл.

Үгний Жишээнүүд:

Гэрэл/харанхуй	зөв/буруу	цэвэр/бохир
амьдрал/үхэл	үнэн/худал	баяртай/уйтгартай
сайн/муу	энх тайван/дайн	эрүүл/өвчтэй
хайр/үзэн ядалт	үнэн/худал	санаа сайтай/санаа муутай
амжилт/бүтэл муутай	цэвэр ариун/заваан	баяртай/гунигтай

Хүүхэд болгоны ээлж оногдосны дараа яг энэ үйл ажиллагааны үг бүр нь эсрэг утгатай үгтэй байдгийн адил Есүс Христийн сургаал бүрийн эсрэг Сатан хуурамч, буюу эсрэг сургаалтай байдаг гэдгийг тайлбарла. Тэнгэрлэг Эцэгийг дагах нь бидэнд аз жаргал, Сатаныг дагах нь золгүй байдлыг авчирдаг. Хүүхдүүдээс хүмүүс худлаа хэлэхдээ ямар мэдрэмжтэй байдаг, мөн үнэнийг ярихдаа ямар мэдрэмжтэй байдгийн ялгааг асуу.

Бид ямар нэг зүйлийг илүү их сурах тусмаа тэр зүйл болон түүний эсрэг зүйлсийн хоорондох ялгааг илүү сайн хэлж чадна гэдгийг хүүхдүүдэд

заа. Бид Есүс Христийн талаар илүү ихийг сурч, түүнийг дагавал бид Сатаны уруу таталт болон хуурах оролдлогын эсрэг илүү сайн зогсох чадвартай байх болно.

Есүс Христийн эсрэг зүйл болох Антай-Христийн тухай сурах болно гэдгийг хүүхдүүдэд тайлбарла. Есүс Христийг улайран эсэргүүцэж байгаа (ил ба далд) хэн нэгэн юмуу ямар нэг зүйлийг Антай-Христ гэнэ.

Судрын Хэсэг

Алма 30-аас Корихорын тухай хэсгийг заа. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii-аас үз.) Та тэднийг Алма 30:37–45-аас асуулт хариултуудыг уншиж байх хооронд нэг хүүхдээр Алмагийн дүрийг, өөр нэг хүүхдээр Корихорын дүрийг сонгуул. Зургуудыг тохиромжтой үед нь хэрэглэ.

Ярилцлага ба Тавьж Болох Асуултууд

Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншнаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.

- Корихор яагаад хүмүүсийг тэнэг гэж хэлсэн бэ? (Алма 30:12–16.) Бид Есүс Христийг амьд гэдгийг өөрсдөө хэрхэн мэддэг вэ? (Есүс Христийн тухай гэрчлэл олж авснаараа.) Бид хэрхэн гэрчлэлтэй болж чадах вэ? (Судраас судалж, залбирч, бошиглогчдыг сонсох гэх мэтээр.)
- Есүс Христийн цагаатгал хэрэгтэй гэдэг талаар Корихор юу хэлсэн бэ? (Алма 30:17.) Бид яагаад өөрсдөө гэм нүглийг давж чадахгүй вэ? Есүс Христ бидэнд өөрсдийнхөө гэм нүглийг даван туулах боломжийг хэрхэн бий болгосон бэ?
- Алмагийн Христийн талаарх гэрчлэлийн юу нь та нарын сэтгэлийг хөдөлгөсөн бэ? (Алма 30:39–41.) Хэрэв та нар Алма байсан бол Корихорт Есүс Христийн талаар юу хэлэх байсан бэ?
- Корихорыг Алмагаас Бурхан байдаг гэсэн түүнийг итгүүлэх тэмдгийг хүсэхэд Алма түүнд ямар жишээнүүдийг өгсөн бэ? (Алма 30:44.) Та нарт Тэнгэрлэг Эцэг байдаг гэдгийг мэдэхэд тусалдаг ямар зүйлийг өдөр бүр эргэн тойрондоо хардаг вэ? Тэнгэрлэг Эцэг байдаг гэдгийг мэдэхэд та нарт тусалдаг ямар тохиолдлууд бий вэ?
- Корихор ямар тэмдэг хүлээн авсан бэ? (Алма 30:48–50.) Корихор хэлгүй болсныхоо дараа Бурхан болон Сатаны тухай юу бичсэн бэ? (Алма 30:52–53.)
- Сатан өөрт нь үйлчилдэг хүмүүсийг хэрхэн дэмждэг вэ? (Алма 30:60.) Тэнгэрлэг Эцэг өөрт нь үйлчилдэг хүмүүсийг хэрхэн шагнадаг вэ? (Мозая 2:41.) Ангийн гишүүдийг зарлигуудыг дагасныхаа төлөө адислагдаж байсан туршлагаасаа хуваалцахыг урь.
- Та Есүс Христийн сургаалыг эсэргүүцдэг ямар нэгэн нөлөөллүүдийг мэдэх үү? Та нар ямар зүйлсийг Христийнхтэй адил зүйл биш гэдгийг нь мэддэг учраас хийхээс зайлсхийдэг вэ? Ямар зүйл та нарыг Христэд итгэхэд урьдаг буюу итгүүлдэг вэ? (Моронай 7:15–17.)
- Та нар Сатанд мэхлэгдэхээс хэрхэн хамгаалагдаж чадах вэ? (Зарлигуудыг сахиж, Ариун Сүнснийг сонсож, судраас судалж, амьд бошиглогчийг дагаснаар.)

**Баяжуулах Үйл
Ажиллагаа**

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно.

1. Хүүхдүүдэд хичээлийн төгсгөл дэх “Энэ нь намайг Есүс Христэд итгүүлж байна уу?” гэсэн үзүүлэнг хүүхэд бүрт өг. *Итгүүлэх* гэдэг нь хүнийг ямар нэгэн зүйлд итгэх, эсвэл хийхэд ухуулахыг хэлнэ гэдгийг тайлбарла. Энэ нь сайн мууг ялгаж дүгнэхэд зориулсан бошиглогч Моронайгаас бидэнд өгөгдсөн заавар юм (Моронай 7:15–17-г үз). Хэрэв ямар нэгэн зүйл тэднийг сайн зүйл хийх болон Христэд итгүүлж байвал энэ нь сайн, хэрэв үгүй бол энэ нь муу ёрын сүнс юм гэдгийг хүүхдүүд ойлгосон эсэхийг нь шалга. Хүүхдүүд санаж байхын тулд цаасаа гэр лүүгээ авч явж болно.
2. Хүүхдүүдэд итгэлийн тунхгийн арван гуравдугаарыг цээжлэхэд нь тусалж, энэ нь бас хэрхэн зөвийг сонгох удирдамж болдгийг ярилц.
3. Тэнгэрлэг Эцэг амьдардгийг гэрчилдэг байгаль дахь юмсын зургуудыг үзүүл. Та Сүмийн номын сан дахь дараах зургуудыг олж болно. Бүтээл–Амьд Бүтээлүүд (62483), Дэлхий (62196), Хаврын Цэцгүүдийг Харж Буй Хүүхдүүд (62270), Нялх Хүүхэдтэй Гэр Бүл (62307) гэх мэт. Хүүхдүүдийг эдгээр зургуудыг хараад ямар сэтгэгдэлтэй байгаа болон зургууд хэрхэн Бурханы талаарх гэрчлэлийг хуваалцаж байгааг илэрхийлэхийг урь.
4. Сүмийн арван гурав дахь Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсоны дараах мэдэгдлийг уншиж ярилц. Мормоны Ном нь хууртагдахаас зайлсхийхэд ямар хүчирхэг багаж болохыг онцлон хэл.
“Та нар энэ номыг чин сэтгэлээсээ судалж эхлэх мөчид та нарын амьдралд орж ирэх хүч чадал [Мормоны Номонд] бий. Та нар уруу таталтыг эсэргүүцэх агуу хүч чадлыг олох болно. Та нар хууртагдахаас зайлсхийх хүч чадлыг олж авна. Та нар нарийн бөгөөд шулуун зам дээрээ үлдэх хүч чадлыг олно” (A Witness and a Warning, p. 21–22).

Дүгнэлт

Гэрчлэл	Хэрэв бид зарлигуудыг сахиж, Ариун Сүнсний өдөөлтийг дагаж, судруудыг судалж, амьд бошиглогчдыг дагавал хууртагдахгүй байх болно гэсэн гэрчлэлээ хуваалц.
Зөвлөмж Болгогдсон Гэрийн Уншлага	Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ Алма 30:12–18, 37–56, 60-г судлахыг зөвлө. Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.

**Энэ нь намайг Есүс Христэд
итгэхэд ятгаж байна уу?**

Моронай 7:15–17-г үз

**Энэ нь намайг Есүс Христэд
итгэхэд ятгаж байна уу?**

Моронай 7:15–17-г үз

**Энэ нь намайг Есүс Христэд
итгэхэд ятгаж байна уу?**

Моронай 7:15–17-г үз

**Энэ нь намайг Есүс Христэд
итгэхэд ятгаж байна уу?**

Моронай 7:15–17-г үз

**Энэ нь намайг Есүс Христэд
итгэхэд ятгаж байна уу?**

Моронай 7:15–17-г үз

Зорилго	Тэнгэрлэг Эцэгийг төлөв төвшин байдал болон чин сэтгэлээсээ шүтэхийг хүүхдүүдэд заана.
Бэлтгэл	<ol style="list-style-type: none"> 1. Алма 31, 34:1–30, 38–41, 35:1–9-ийг залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х. viii-ыг үз). 2. Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго. 3. Шаардлагатай материалууд: <ol style="list-style-type: none"> а. Хүүхэд бүрт Мормоны Ном б. Хоёр хэсэг идэх юм в. Зураг 4-36, Зорамчууд болон Рагмеумптом.

Хичээл Заах Зөвлөмж	Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.
Анхаарал Татах Ажиллагаа	Үдийн зоог барьж байгаагаар тогло. Хоосон хоёр таваг, хоёр шилэн аяга, хоёр хүнд зориулсан хоол идэх хэрэгсэл бэлтгэ. Идэж байгаа дүр үзүүлээд, амттай хоолны тухай бахдаж байгаагаар жүжиглэ. Нэг хүүхдийг нийлэхийг урь. Хоосон савнаас ингэж идэхийг энэ хичээл дээр дүрслэн үзүүлсэн Зорамчуудын худал, чин сэтгэлийн бус шүтлэгийн хоосон байдалтай харьцуулж болно. Ийм хоосон шүтлэг нь бидний сүнсний тэжээлд бие махбодынхоо тамир тэнхээнд зориулан идэхгүй байхаас ч илүү муу зүйл юм. Энэ хичээл дээр хүүхдүүд зөв болоод чин сэтгэлээсээ Бурханыг шүтэх аргуудыг сурна.
Судрын Хэсэг	Алма 31-ээс Зорамчууд болон тэдний хуурамч шүтлэгийн тухай хэсгийг заа. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х. viii-аас үз.) Зургийг тохиромжтой үед нь ашигла.
Ярилцлага ба Тавьж Болох Асуултууд	<p>Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншнаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.</p> <ul style="list-style-type: none"> • Зорамчууд гэж хэн байсан бэ? (Алма 31:1–3, 8.) Тэд Сүмийн сургаалаас хэрхэн урвасан бэ? (Алма 31:8–11.) • Зорамчууд хэрхэн, хэзээ, хаана шүтдэг байсан бэ? (Алма 31:13–18, 21–23.) Бид Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийг хэрхэн шүтэх ёстой вэ? • Зорамчуудын итгэсэн ямар ямар зүйл нь буруу байсан бэ? (Алма 31:15–17, 20.) Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христ үнэхээр байдаг ба тэд юутай адилхан байсан болохыг мэдэх нь яагаад чухал вэ?

- Зорамчуудын залбирал чин сэтгэлийнх биш байсан гэдгийг бид хэрхэн мэдэх вэ? (Алма 31:23,27.) Бид залбирлаа хэрхэн илүү их чин сэтгэлийнх болгож чадах вэ?
- Яагаад Зорамчууд өөрсдийгөө бусдаас илүү гэж боддог байсан вэ? (Алма 31:24–25, 27–28.) Бид заримдаа ямар байдлаар өөрсдийгөө бусдаас илүү гэж санадаг вэ? Яагаад бардам байдал нь ноцтой гэм нүгэл вэ? (Энэ нь биднийг Бурханаас холдуулдаг.)
- Алма болон бусад удирдагчид үнэнээс урваж байгаа хүмүүсийг хараад ямар мэдрэмжтэй байсан бэ? (Алма 31:19, 24, 30–31.) Үнэнийг мэдэхгүй байгаа тэдгээр хүмүүст бид хэрхэн тусалж чадах вэ? Бид идэвхгүй гишүүдэд хэрхэн тусалж чадах вэ?
- Зорамчуудын зүрх сэтгэл юунд эзэмдэгдсэн бэ? (Алма 31:28.) Өнөөдөр та нарын насны зарим хүүхдүүд зүрх сэтгэлээ өгч болох ертөнцийн ямар ямар зүйлүүд байдаг вэ? Зүрх сэтгэлээ дэлхийн ертөнцийн зүйлүүдэд эзэмдүүлэх нь яагаад буруу вэ?
- Алма өөртөө болон хамтрагчийнхаа төлөө юу гэж залбирсан бэ? (Алма 31:31–35.) Тодорхой зүйлсийн төлөө залбирах нь залбирлаа илүү чин сэтгэлийн болгоход хэрхэн тусалж чадах вэ? Та нарт хэцүү байхад залбирал хэрхэн тусалж чадах вэ?
- Амюлек Есүс Христийн тухай юу гэрчилсэн бэ? (Алма 34:8.) Зорамчууд Есүс Христийн талаар хэрхэн гэрчлэлтэй болж чадсан бэ? (Алма 34:17.)
- Бид хэрхэн, хэзээ залбирах ёстой вэ? Бид юуны төлөө залбирах ёстой вэ? (Алма 34:18–27.) Бид Тэнгэрлэг Эцэгийг долоо хоногийн өдөр бүр хэрхэн шүтэж чадах вэ?
- Бид залбирлаа илүү үр дүнтэй болгохын тулд залбирсныхаа дараа юу хийх ёстой вэ? (Алма 34:28.)
- Аммоны хүмүүс (Антай-Нифай-Лихайчууд) тэдэнтэй нэгдсэн Зорамчуудад яаж хандсан бэ? (Алма 35:9.) Бид гадны хүн, эсвэл бидний дунд байгаа ядуу хүмүүст хэрхэн хандах ёстой вэ? Энэ нь Тэнгэрлэг Эцэгт хайрыг хэрхэн үзүүлж байна вэ? (Матай 25:40, Мозая 2:17.)

Баяжуулах Үйл Ажиллагаа

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно.

1. Дараах судрын ишлэлүүдийг самбар дээр бич. Зорамчуудын алдаатай итгэж байсан зүйлүүдийг дүрслэн үзүүлсэн шүлгүүдийг Алма болон Амюлекийн зөв сургаал номлолуудыг агуулсан шүлгүүдтэй тулгахыг хүүхдүүдээс хүс:

Алма 31:16 (Зорамчууд Христ байхгүй гэдэгт итгэдэг.)

Алма 31:20–23 (Бүх Зорамчууд нэг маягаар залбирч, дараа нь бүхэл бүтэн долоо хоног дахиад ердөө ч шүтдэггүй.)

Алма 31:24 (Зорамчуудын зүрх сэтгэл эд баялагт эзэмдэгдсэн.)

Алма 34:8 (Амюлек Христийн тухай гэрчилсэн.)

Алма 34:19–27 (Амюлек бид байнга, бүх зүйлийн талаар залбирах ёстойг заасан.)

Алма 34:28–29 (Амюлек бид эд баялагаасаа ядууст өгөх ёстой гэдгийг заасан.)

2. Хэрэв тэднийг дооглосон бол тэд ямар мэдрэмжтэй байх байсныг нь хүүхдүүдээс асуу. Хүмүүсийн бардам байдаг арга замуудыг ярилц. Лихайн зүүдэн дэх агуу бөгөөд нүсэр барилгууд дэлхийн бардамналыг төлөөлсөн гэдгийг хүүхдүүдэд сануул. Даруу байх нь бардам байхын эсрэг зүйл гэдгийг тайлбарла. Хүүхэд бүрээр тэд илүү даруу болохыг хичээх нэг аргыг цаасан дээр бичүүл.
3. Хүүхдүүдийг дараах шүлгүүдийг, эсвэл хичээлийн бусад чухал шүлгүүдийг уншиж тэмдэглэхийг урь. (Хүүхдүүд чухал гэж үзсэн шүлгийг бүтнээр нь, эсвэл хагасыг нь цээжилж болно.)
 - Алма 31:34–35
 - Алма 34:8
 - Алма 34:26–28
 - Алма 34:38

Дүгнэлт

Гэрчлэл	Хэрэв бид Тэнгэрлэг Эцэгийг дарууханаар ба чин сэтгэлээсээ шүтвэл, тэр биднийг адислаж, бид залбирлынхаа хариултуудыг авч чадна гэсэн гэрчлэлээ хуваалц.
Зөвлөмж	Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ Алма 3:18–25 болон 34:17–29-ийг судлахыг зөвлө.
Болгогдсон	
Гэрийн Уншлага	Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.

Зорилго	Бурханы үгийг итгэлээрээ тэжээхэд энэ нь зүрх сэтгэлд маань Есүс Христийн гэрчлэл болон өсдгийг хүүхдүүдэд заана.
Бэлтгэл	<ol style="list-style-type: none">1. Алма 32–33-ыг залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii-ыг үз).2. Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго.3. Хичээлийн төгсгөл дэх үзүүлэн таниулах материалуудыг үзээд хичээлийн үеэр хэрхэн үзүүлэхээ шийд. Та тайлбар зураг бүрийг цаасан дээр буулгах, тайлбар зургийг хатуу цаасан дээр хуулах, эсвэл самбарт зурахаар бэлд.4. Шаардлагатай материалууд:<ol style="list-style-type: none">а. Хүүхэд бүрт Мормоны Номб. Боломжтой бол хүүхэд бүрт үр өгөхв. Хичээлийн төгсгөл дэх үзүүлэн таниулах материалын цаасан хувь (үр, нахайлж байгаа үр, зулзган мод, мод, бороо, нар, хөрс, бордоо).
Хичээл Заах Зөвлөмж	Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.
Анхаарал Татах Ажиллагаа	<p>Хүүхэд бүрт үр өгөх, үрний тайлбар зураг үзүүлэх, эсвэл самбар дээр үр зур.</p> <ul style="list-style-type: none">• Үр юу болж чадах вэ? (Үрний төрлөөс хамааран ургамал, эсвэл мод.)• Үр ургаж эхлэхээс өмнө юу болох ёстой вэ? (Нахайлж байгаа үрний тайлбар зургийг үзүүлэх, эсвэл самбарт зур.)• Мод залуу байхдаа юутай адил харагддаг вэ? (Зулзган модны тайлбар зургийг үзүүлэх, эсвэл нэгийг самбарт зур.) Энэ нь боловсорч гүйцээд юутай адил болох вэ? (Модны тайлбар зургийг үзүүлэх, эсвэл самбарт зур.)• Үрийг ургамал юмуу мод болтол ургахад туслах ямар тэжээл арчилгаа хэрэгтэй вэ? (Тэжээл гэдэг нь юмсыг ургах, эсвэл амьд сайхан хэвээр нь байлгахад тусалдаг ус, бордоо, нарны гэрэл, хөрс зэрэг зүйлс юм гэдгийг тайлбарла. Үрний зургийн дэргэд нар, бороо, хөрс, бордооны тайлбар зургуудыг байрлуул.) <p>Энэ хичээл дээр хүүхдүүд хэрхэн хүчтэй гэрчлэлтэй болж чадахыг сурах болно гэдгийг хүүхдүүдэд тайлбарла. Та хичээл дэх зарчим бүрийг ярилцахдаа баяжуулах үйл ажиллагаа 1-ийн үгийн хайчилбаруудыг ашиглаж болно.</p>

Судрын Хэсэг

Алма 32–33-аас Алма Зорамчуудад зааж байгаа хэсгийг заа. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii-аас үз.) Зөв арчилгаа, тэжээлтэй сайн үр нь жимстэй мод болдгийн яг адил бидний зүрх сэтгэлд суулгагдаж зүй ёсоор нь тэжээгдсэн Бурханы үг хүчтэй гэрчлэл болон хөгждөг гэдгийг онцол.

Ярилцлага ба
Тавьж Болох
Асуултууд

Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншнаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.

Өнгөрсөн хичээл дээр хүүхдүүд баян бардам Зорамчуудын тухай сурсан гэдгийг тайлбарла.

- Ядуу Зорамчууд яагаад даруу байсан бэ? (Алма 32:2–3.) Ямар зовлон зүдгүүрүүд хүмүүсийг сайн мэдээг сонстол хангалттай даруу болгож чадах вэ?
- “Зүрхэн дотроо ядуу” байна гэдэг нь юу гэсэн үг вэ? (Даруухан, зааж болмоор, үнэхээр гэмшсэн, бардамналгүй.)
- Ядуу байсан нь эдгээр хүмүүст яагаад адислал болсон бэ? (Алма 32:12–13.) Зовлон зүдгүүр, эсвэл ядуугийн зовлонг амсаагүй хүмүүс ч гэсэн даруу байж чаддаг боловч заримдаа баян хүмүүс бардам болдгийг тайлбарла. Сайн мэдээг заалгаад, даруу байх нь бидэнд яагаад зайлшгүй чухал вэ?
- Итгэл гэж юу вэ? (Алма 32:21.) Сайн мэдээний гэрчлэлийг хөгжүүлэхэд бид яагаад итгэлтэй байх ёстой вэ? (Алма 32:26.) Гэрчлэлтэй болоход цаг шаардагдана гэдгийг тайлбарла. Зарлигуудыг сахих нь үнэний гэрчлэлтэй болоход бидэнд тусалж чадна.
- Алма бидэнд итгэлээ хөгжүүлэхийн тулд юу хийх ёстой гэж хэлсэн бэ? (Алма 32:27.) Бид итгэх хүслээ нэмэгдүүлэхийн тулд юу хийж болох вэ?
- Зарлигуудад дуулгавартай байх нь хэрхэн Бурханы үгэн дэх “сорилт буюу туршилт” болдог вэ? (Сорилт буюу туршилт гэдэг нь мэдэхгүй буюу итгэлтэй бус байгаа ямар нэг зүйлийг хийж үзэхийг хэлнэ. Бид соригдож, эсвэл Мэргэн Ухааны Үг зэрэг зарлигуудыг сахих үедээ дуулгавартай байдлынхаа төлөө адислалуудыг хүлээн авч гэрчлэлүүд маань хүчтэй болно.) Зарлигуудад дуулгавартай байснаар та нарын итгэл хэрхэн өссөн бэ?
- Гэрчлэлээ өсгөхийн тулд бид Бурханы үгийг хэрхэн зүрх сэтгэлдээ суулгаж чадах вэ? (Судруудаас тогтмол унших, Хүүхдийн Хэсэг, ариун ёслолын цуглаан, гэр бүлийн үдэшт сонсох, залбирах болон амьдралдаа сайн мэдээний зарчмуудыг тогтмол хэрэглэснээр.)
- Бидний дотор сайн үр, эсвэл сайн мэдээний гэрчлэл ургаж эхэлж байна гэдгийг бид хэрхэн мэдэж болох вэ? (Алма 32:28, 34.) Ангийн хүүхдүүдийг гэрчлэлээ хуваалцах болон тэдгээрийг хэрхэн олж авснаа дүрслэн үзүүлэхийг урь. Хүүхдүүдийг гэрчлэлүүдээ олж авч, хүчирхэгжүүлэхэд нь зоригжуул. Хэрэв тэдэнд итгэл байвал тэд сайн мэдээний хүчтэй гэрчлэлтэй болж болно гэдгийг баталж хэл.
- Үрийг тэжээж арчилна гэдэг нь юу гэсэн үг вэ? (Тэжээж арчилна гэдэг нь хооллох буюу анхаарал тавих явдал юм гэдгийг тайлбарла.) Сайн

мэдээний гэрчлэлээ тэжээхийн тулд бид ямар чанаруудтай байх ёстой гэж Алма хэлсэн бэ? (Алма 32:41–42.) Яагаад тэвчээр болон хичээнгүй байдал нь итгэл, гэрчлэлээ хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай гэж та нар бодож байна вэ?

- Судраас суралцах нь бидний итгэл, гэрчлэлийг хэрхэн хүчирхэгжүүлж чадах вэ? (Алма 33:14.)
- Ямар чухал сургаал бидний гэрчлэлийн нэг хэсэг байх ёстой вэ? (Алма 33:22.)
- Хүчтэй гэрчлэл нь яаж модтой адил байх вэ? (Алма 33:23) Гэрчлэлтэй байх нь та нарыг мөнхийн амьдралтай болоход хэрхэн туслах вэ? Гэрчлэл тань таны асуудлуудыг хэрхэн хялбар болгож, танд хэрхэн баяр баясгалан авчирдгийг ярьж болно.

Баяжуулах Үйл Ажиллагаа

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно.

1. Дараах үгийн хайчилбаруудыг хий.

Бурханы үг
Есүс Христийн тухай гэрчлэл
Залбирал
Судруудаас суралцах
Зарлигуудыг дуулгавартай дагах
Үйлчлэх

Та хүүхдүүдэд судрын хэсгийг зааж байхдаа Алма 32 дэх Бурханы үгийг үртэй харьцуулсан гэдгийг тайлбарла. “Бурханы үг” гэсэн үгийн хайчилбарыг үрний тайлбар зурган дээр байрлуул. (Энэ сударт Бурханы үг гэдэг нь сайн мэдээ буюу Есүс Христийн сургаал гэсэн үг болохыг тайлбарла.) Үр нь мод болж ургахын адил хэрэв бид Бурханы үгийг судалж, дуулгавартай дагавал бид сайн мэдээний талаар хүчтэй гэрчлэлтэй болох болно.

“Есүс Христийн Тухай Гэрчлэл” гэсэн үгийн хайчилбарыг үрний тайлбар зурган дээр байрлуул. Үр нь мод болон ургахдаа арчилгаа, тэжээл шаардлагатай байдгийн адил сайн мэдээний гэрчлэл маань хүчтэй болон хөгжихдөө итгэл, анхаарал шаарддаг. Хүүхдүүдээс гэрчлэлээ хүчтэй болгохын тулд тэд юу хийж чадахыг нь асуу. Тэднийг хариулах хооронд нь “Залбирал”, “Судруудаас суралцах”, “Зарлигуудыг дуулгавартай дагах” болон “Үйлчлэх” гэсэн үгийн хайчилбаруудыг модыг тэтгэдэг зүйлсийн тайлбар зурган дээр байрлуул.





2. Энэ хичээлд холбогдолтой зарим үгсийг тус тусдаа цааснууд дээр бичиж хайчлаад эвлүүлдэг тоглоом болго. Тэдгээрт *төлөв төвшин байдал*, *хүсэл*, *тэжээл*, *дуулгавартай байдал* зэрэг үгс багтаж болно. Танд хэдэн үг байна тэр тоогоор ангийг бүлэгт хуваа. Аль нэг бүлэг нь үгийг нийлүүлэхэд тус бүлгийн нэг хүүхдээр тэр үгний талаар хичээл дээр юу заасныг товч давтан хэлүүл.

3. Мацаг барилт, аравны нэг, Мэргэн Ухааны Үг зэрэг сайн мэдээний зарчмыг тус бүр цаасан дээр бичиж бэлд. Эдгээр цаасаа хүүхдүүдэд

харуулалгүй тус бүрийнх нь нуруун дээр зүү, эсвэл наадаг туузаар тогтоо. Хүүхдүүдээр уг зарчмыг таалгах буюу бусад хүүхдүүдээр хариу түлхүүрийг хэлүүл. Хүүхдийг зөв хариулт өгсөний дараа түүнээс хүн хэрхэн энэ зарчмын талаар гэрчлэлтэй болж чадах тухай асуу. Хариулт нь аль ч тохиолдолд залбирах, тэр зарчмын дагуу амьдрах гэсэн хариултыг агуулах ёстой.

Дүгнэлт

Гэрчлэл	Хүүхдүүд багаасаа Бурханы үгийг судалж, зарлигуудыг дуулгавартай дагавал тэд Есүс Христийн сайн мэдээний үнэний хүчтэй гэрчлэлтэй болох болно гэдгийг гэрчил. Аврагчид итгэх итгэл болон түүний сайн мэдээний талаарх сэтгэгдлээ ярь.
Зөвлөмж Болгогдсон Гэрийн Уншлага	Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ Алма 32:21–22, 26–28, 40–43 ба 33:14–23-ыг судлахыг зөвлө. Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.



Алма Хиламан, Шиблон Нарын Хөвгүүддээ Зөвлөсөн нь

Зорилго

Судрууд нь энэ амьдралд баяр баясгалангийн эх булаг байхын тулд, мөн Тэнгэрлэг Эцэгтээ эргэн очиж мөнхийн амьдралыг олж авахад зориулсан удирдамж байхын тулд бидэнд өгөгдсөн гэдгийг хүүхдүүдэд заана.

Бэлтгэл

1. Алма 37–38-ыг залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii-ыг үз).
2. Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго.
3. Хүүхэд бүрт “Судрууд” (хичээлийн төгсгөл дэх) гэсэн үзүүлэнг бэлд. (Сонголтоор.)
4. “Мөнхийн амьдрал” гэсэн үгийн хайчилбар бэлд.
5. Шаардлагатай материалууд:
 - а. Хүүхэд бүрт Мормоны Ном
 - б. Есүс Христийн жижиг хэмжээний зураг, эсвэл “Есүс Христ” гэсэн үгийн хайчилбар.
 - в. Зурагнууд: 4-9, Есүс бол Христ (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 240, 62572); 4-15, Лиахона (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 302, 62041).

Хичээл Заах Зөвлөмж

Анхаарал Татах
Ажиллагаа

Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.

Хичээл эхлэхээс өмнө ангийн хаа нэгтээ Есүс Христийн жижиг хэмжээтэй зураг, эсвэл “Есүс Христ” гэсэн үгийн хайчилбарыг нуу. “Мөнхийн амьдрал” гэсэн үгийн хайчилбарыг үзүүл. Сүмийн гишүүдийн хувьд бид энэ амьдралдаа баяр баясгаланг олж, Тэнгэрлэг Эцэг рүү эргэн очиж, Бурханы өмнө гэр бүлээрээ мөнхөд хамт амьдрах мөнхийн амьдралыг хүлээн авахыг хүсдэг гэдгийг тайлбарла. Мөнхийн амьдрал гэдэг нь Бурханы хүүхдүүддээ зориулсан хамгийн агуу бэлэг гэдгийг ойлгоход нь хүүхдүүдэд тусал. Тэнгэрлэг Эцэг бид бүгдийг өөртэй нь хамт мөнхөд амьдрахуйц зохистой байгаасай гэж хүсдэг. Тэдэнд мөнхийн амьдралыг олж авахад нь туслахыг хүсдэг хэн нэгний жижиг зургийг (эсвэл үгийн хайчилбарыг) өрөөний хаа нэгтээ нуусан гэдгийг хүүхдүүдэд хэл. Хүүхдүүдэд зураг (эсвэл үгийн хайчилбарыг) олоход нь зориулж 30 секунд өг. Тэнгэрлэг Эцэг бидэнд мөнхийн амьдрал руу биднийг хөтлөх хөтчийг өгсөн гэдгийг тэдэнд сануул. Шаардлагатай бол бяцхан санамжуудыг өг.

Хүүхдүүд нуусан Есүс Христийн зураг (эсвэл үгийн хайчилбарыг) олсны дараа тэдэнд Христийн том зураг болон судруудаа үзүүл. Бидэнд Есүс Христийн тухай сурах, мөн түүнтэй адил болоход туслах судруудыг хөтөч болгон өгсөн учраас бид Тэнгэрлэг дэх Эцэгтээ эргэж очно гэдгийг тайлбарла.

Судрын Хэсэг

Санал болгосон зургуудыг ашиглан Алма 37–38 дахь Алмагийн өөрийн хөвгүүд болох Хиламан, Шиблон хоёрт өгсөн зөвлөгөөг заа. Судрын тухай болон тэдгээр нь бидний амьдралд хэрхэн хөтөч болж чадах талаар Алмагийн сургаалыг онцол. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii-аас үз.)

Ярилцлага ба Тавьж Болох Асуултууд

Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншнаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.

- Яагаад Мормоны Номны бошиглогчдод гуулин ялтсуудыг хадгалж хамгаалах нь чухал байсан бэ? (Алма 37:4, 8, хичээл 3-ыг үз.)
- Яагаад Лихайд Лиахонаг өгсөн бэ? Энэ нь хэрхэн ажилладаг байсан бэ? (1 Нифай 16:10, 28.)
- Судрууд нь Лиахонатай юугаараа адил вэ? (Алма 37:44–45.) Биднийг Тэнгэрлэг Эцэгтэй амьдрахаар эргэж очиход судрууд хэрхэн тусалж чадах вэ?
- Судрууд Лэмэнчүүдэд нүглээ наманчлахад нь нөлөөлсөн ямар зүйлийг заасан бэ? (Алма 37:9.)
- Алма хүү Хиламанаасаа ард түмэндээ юу заахыг хүссэн бэ? (Алма 37:32–34.) Бид уруу таталтыг хэрхэн давж чадах вэ?
- Алма “Залуудаа мэргэн ухааныг сур” гэж Хиламанд зөвлөхдөө юу хэлэх гэсэн бэ? (Алма 37:35.) Залуудаа сайн мэдээний дагуу амьдрах нь яагаад чухал вэ?
- Алма Хиламанд залбирлын тухай юу заасан бэ? (Алма 37:36–37.) Та нар хаана, хэрхэн залбирах ёстой вэ? “Эцсийн өдөр өргөгдсөн байна” гэдэг нь юу гэсэн үг вэ? Зарлигуудыг дуулгавартай дагаж Тэнгэрлэг Эцэгийн өмнө очиж, түүнтэй үүрд хамт амьдрах бүх хүмүүсийн эцсийн шүүлтэнд энэ нь хамаатай гэдгийг ойлгоход нь хүүхдүүдэд тусал.
- Алмагийн хүү Шиблон түүнд хэрхэн агуу баяр баясгаланг авчирсан бэ? (Алма 38:2–24.) Та нарын зарлигуудад дуулгавартай байх явдал нь эцэг эхэд тань хэрхэн баяр баясгалан авчирдаг вэ?
- Бардамнал гэж юу вэ? (Алма 38:11. Даруу бус, эсвэл юм сурахаар хүн биш. Бардам хүмүүс өөрсдийгөө бусдаас илүү чухал гэж боддог. Бардам хүмүүс Тэнгэрлэг Эцэгийн хүслээс илүү өөрийнхөө хүслийг дагадаг.) Алдаагаа хүлээн зөвшөөрч засаж сурах нь биднийг Тэнгэрлэг Эцэгт хэрхэн илүү ойртуулдаг вэ? Бардах гэдэг нь юу гэсэн үг вэ?
- Алма хүүдээ заасан зүйлсээ хэрхэн мэдсэн бэ? (Алма 38:6–8.) Ариун Сүнс Алмад зааж тусалсантай адил бидэнд зааж туслахад нь бид юу хийх ёстой вэ? Ариун Сүнс та нарт зөвийг хийхэд хэрхэн зааж сургаж, тусалж чадах вэ?

- Алма Шиблонд Есүс Христийн тухай юу гэрчилсэн бэ? (Алма 38:9.)
Үүнтэй адил гэрчлэлтэй болохын тулд бид судруудыг хэрхэн ашиглах вэ? (Тэдгээрийг өдөр бүр уншиж, эргэцүүлэн бодох, тэдгээрийг ойлгохын тулд Сүнсний тусламжийг эрэлхийлэх, тэдгээрийг өөрсдийн тохиолдол, нөхцөл байдалтай адилтгах.)

Баяжуулах Үйл Ажиллагаа

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно.

1. Судруудыг бидэнд өгсөн шалтгаануудын нэг бол биднийг бэрхшээлүүдээ даван туулж, шийдэхэд туслах явдал юм гэдгийг тайлбарла. Ангийн гишүүн бүрт дөрвөн нөхцөл байдлыг бичсэн цаасыг өг. Хүүхэд бүрийг жагсаасан судрууд, нөхцөл бүрт хэрхэн тусалж чадахыг хамтрагчтайгаа ажиллан шийдэхийг хүс. Доор дурьдсан дөрвөн нөхцөл байдал нь зөвхөн жишээ юм. Та ангийнхаа хүүхдүүдэд илүү хамааралтай байх өөр жишээнүүдийг ашиглаж болно. (Нөхцөл бүрт нэгээс илүү судар ашиглаж болно.)

Жиймийг усаар батлуулахад гэрийнхэн нь түүнд уурлаж байв. Бишоп Жиймээс бүрэн цагийн номлолд үйлчлэх дуудлага хүлээн авахыг хүсэхэд Жиймд хүрэлцхүйц мөнгө байсангүй.

Шэллид маш чухал шийдвэр гаргах хэрэгтэй байсан ба тэр олон хүнтэй ярьсныхаа дараа ч юу хийхээ шийдэж чадсангүй.

Хифэрийн найзууд түүнийг байнга тэдэнтэй хамтарч дэлгүүрээс юм хулгайлуулахыг оролддог. Түүнийг татгалзахад тэд түүнийг дооглодог.

Доугт хугацаанд нь дуусгахад хэцүү хичээлийн даалгавар өгөгдсөн байлаа.

Алма 26:12, 1 Нифай 3:7, Алма 37:37, 1 Нифай 17:3

2. Хоёр тусдаа цаасан дээр Алма 37-гоос дараах үгсийг хуулж бич.

“Өөрийн залууд мэргэн ухааныг суралц; тий мээ, өөрийн залууд Бурханы зарлигуудыг дагаж сурагтун” (Алма 37:35.)

“Бүх ажил үйлүүдээ Их Эзэнтэй зөвлөгтүн, мөн тэрээр чамайг сайны тул чиглүүлэх болно” (Алма 37:37.)

Судар бүрийг салангид үгсүүдэд хуваан хайчил. Эхний судрыг нэг саванд, хоёр дахийг нь өөр нэг саванд хийгээд ангийн урд байрлуул. Ангийг хоёр бүлэгт хуваа. Бүлэг бүрт нэг цаас, нэг харандаа өг. Бүлэг бүрээс нэг нэг хүүхэд сав руу очуулж, нэг үг авахуулаад багт нь эргэн очуул. Дараа дараагийн хүүхдээр мөн үүнийг үргэлжлүүлэн хийлгэ. Бүлэг бүр үгсийг зөв дарааллаар нь цуглуулна. Хэрэв хүүхдүүдэд тусламж хэрэгтэй бол судрын ишлэлийг өг. Бүлгүүд судруудаа ойлгож мэдсэн үедээ, тэдгээрийг бичиж аваад цээжилж болно. Төгсгөлд нь бүлэг бүр хамтдаа нэг дуугаар энэ судрыг цээжээр уншиж болно.

3. Ангийнхандаа 1 Нифай 16:28-ыг унш: “Мөнхүү улиран тохиох дор би Нифай, уг бөмбөрцөгт буй зүүнүүдийг болгоов, тэдгээр нь бидний тэдэнд хандуулсан итгэл болон хичээнгүй байдал мөн анхаарлын дагуу ажилладаг байв.” Лиахона Лихай болон түүний гэр бүлийн төлөө

хэрхэн ажилладаг байсныг ярилц. Ангийн гишүүдийг гурван бүлэгт хуваагаад, бүлэг бүрт (*итгэл, хичээнгүй байдал, анхаарал*) гэсэн гурван үгнээс нэгийг тодорхойлолттой нь өг.

Итгэл: Хараагүй зүйлээ үнэн гэдэгт итгэх итгэл.

Хичээнгүй Байдал: Ямар нэг зүйлийг биелүүлэхийн төлөө хүчээ зориулах.

Анхаарал: анхааруулга, сануулга.

Бүлэг бүрээр үгийг нь утга санааг, мөн энэ зарчим тэднийг Тэнгэрлэг Эцэгтээ эргэж очихын тулд судруудыг хэрхэн удирдамж болгон ашиглахад нь тусалж болохыг ярилцуул. Тэднээр дүрслэн үзүүлэх жишээ бодож олуул. Хоёр, эсвэл гурван минутын дараа тэр зарчим нь судруудыг Лиахонагийн адил ашиглахад нь хэрхэн тусалж чадах талаар ангийнхандаа тайлбарлах хэн нэгнийг бүлэг тус бүрээр нь сонгуул.

4. Хэсгийн нэг гишүүнийг ангид тань ирж, судрууд түүнд удирдамж өгч, залбирлуудад нь хариулсан тохиолдлоосоо хуваалцахыг урь.
5. Итгэлийн тунхгийн наймдугаарыг уншиж ярилц. Судрууд биднийг Тэнгэр дэх Эцэгтээ эргэж очиход хэрхэн тусалдгийг онцол. Та итгэлийн тунхгийг ашиглаж болно

Дүгнэлт

Гэрчлэл

Өдөр тутам судруудаас судлах нь өөрсдийн асуудлуудыг шийдэж, уруу таталтыг даван туулж, Тэнгэр дэх Эцэгтээ эргэн очих ба мөнхийн амьдралыг олж авахад хүргэдэг нарийн бөгөөд шулуун зам дээр үлдэхэд тусалж чадна гэсэн гэрчлэлээ хуваалц.

Хүүхэд бүрт үзүүлэн өг. Тэдэнд үүнийг судартаа номын хавчуурга болгон ашиглахыг зөвлө.

Зөвлөмж

Болгогдсон

Гэрийн Уншлага

Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ Алма 37:33–47 болон 38:1–12-ыг судлахыг зөвлө.

Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.

СУДРУУД

*Тэнгэр дэх Эцэгтээ Эргэж Очин Мөнхийн
Амьдралыг Олж Авах Миний Хөтөч.*

1. Би судруудыг өдөр бүр уншиж эргэцүүлэн бодно.
2. Би тэдгээрийг ойлгохын тулд Сүнсний тусламжийг эрэлхийлнэ.
3. Би тэдгээрийг өөрийн тохиолдол, нөхцөл байдал-
тай адилтгана.

СУДРУУД

*Тэнгэр дэх Эцэгтээ Эргэж Очин Мөнхийн
Амьдралыг Олж Авах Миний Хөтөч.*

1. Би судруудыг өдөр бүр уншиж эргэцүүлэн бодно.
2. Би тэдгээрийг ойлгохын тулд Сүнсний тусламжийг эрэлхийлнэ.
3. Би тэдгээрийг өөрийн тохиолдол, нөхцөл байдал-
тай адилтгана.

СУДРУУД

*Тэнгэр дэх Эцэгтээ Эргэж Очин Мөнхийн
Амьдралыг Олж Авах Миний Хөтөч.*

1. Би судруудыг өдөр бүр уншиж эргэцүүлэн бодно.
2. Би тэдгээрийг ойлгохын тулд Сүнсний тусламжийг эрэлхийлнэ.
3. Би тэдгээрийг өөрийн тохиолдол, нөхцөл байдал-
тай адилтгана.

СУДРУУД

*Тэнгэр дэх Эцэгтээ Эргэж Очин Мөнхийн
Амьдралыг Олж Авах Миний Хөтөч.*

1. Би судруудыг өдөр бүр уншиж эргэцүүлэн бодно.
2. Би тэдгээрийг ойлгохын тулд Сүнсний тусламжийг эрэлхийлнэ.
3. Би тэдгээрийг өөрийн тохиолдол, нөхцөл байдал-
тай адилтгана.

Алма Кориантон

Хүүдээ Зөвлөсөн нь

Хичээл
24

Зорилго

Бидний сонголтоос хамааран сайн, муу үр дагавар байдаг гэдгийг ойлгоход нь хүүхдүүдэд тусална.

Бэлтгэл

1. Алма 39-ийг залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii-ыг үз).
2. Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго.
3. Анхаарал татах ажиллагаан дээр жагсаасан зүйлүүдийн хүснэгтийг хий, эсвэл тэдгээрийг самбарт бич.
4. Шаардлагатай материалууд:а. Хүүхэд бүрт Мормоны Ном

Хичээл Заах Зөвлөмж

Анхаарал Татах
Ажиллагаа

Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.

Хүүхдүүдийг ганцаараа тэнгисийн дунд салан дээр байна гэж төсөөлөхийг хүс. Сал нь живэх гэж байгаа учраас тэд ачаагаа хөнгөлөх хэрэгтэй гэдгийг олж мэдэв. Тэд өөрсдийнхөө хангамжаас зөвхөн хоёр зүйлээс бусдыг нь хаях хэрэгтэй боллоо. Дараах жагсаалтаас өөрсдийн авч үлдэх хоёр зүйлийг сонгохыг тэднээс хүс.

Аврах хантааз

Анхны тусламжийн хайрцаг

Алтаар дүүргэсэн авдар

Загасны уураг, загасны хэрэгсэл, өөш

12 лонхтой нэг авдар цэвэр ус

Хоёр долгионт радио

Нэг хайрцаг аваарын гэрлэн дохио

Аварга загас дайжуулах нэг хайрцаг бодис

Сонголтуудыг самбар дээр жагсаагаад, хүүхдүүдийг сонголтуудынхаа учир шалтгааныг тайлбарлахыг хүс. Тус үйл ажиллагаан дахь сонголтууд нь яах ч аргагүй байдалд тавигдсан байх ёстой. Тэд ирээдүйд юу болохыг мэдэхгүй учраас сонголт нь маш хүнд байх болно гэдгийг анхааруул: тэд живэх гэвэл аврах хантааз хэрэг болно, цангавал уух ус хэрэгтэй болно, өлсвөл загасны уураг хэрэгтэй, аварга загас ирвэл дайжуулах бодис хэрэгтэй, тусламж эрэлхийлэхийн тулд радио хэрэгтэй, шархадвал анхны тусламжийн хайрцаг хэрэгтэй, шөнийн цагт аврагдахын тулд гэрлэн дохио хэрэгтэй, эсвэл цөөн хэдэн цагийн дараа аврагдаад эрдэнэсээ хадгалаад үлдэхийг хүсч болно.

Бид энэ амьдралдаа олон хүнд хэцүү сонголтуудыг хийдэг ч Тэнгэрлэг Эцэг бидэнд туслах зарлигуудыг өгсөн гэдгийг тайлбарла. Энэ хичээл нь сонголт хийх тухай болно.

Судрын Хэсэг

Алма 39-өөс хүү Кориантондоо Алмагийн зөвлөж байгаа хэсгийг хүүхдүүдэд заа. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii-аас үз.) Тайлбар: Алма 39:3–6 -аас нарийн тодорхой утга санааг бүү заа. Кориантон Зорамчуудын дунд номлол хийж байхдаа маш ноцтой нүгэл үйлдсэн гэдгийг тайлбарласнаар үүнийг энгийнээр тоймло. Хэрэв хүүхдүүд Кориантоны гэм нүглийн мөн чанарын тухай асуувал үүнийг тэдэнд эцэг эхтэйгээ ярихыг зөвлө.

Ярилцлага ба Тавьж Болх Асуултууд

Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншнаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.

- Кориантоны ах түүнд ямар үлгэр дууриалал үзүүлсэн бэ? (Алма 39:1.) Та нар хэнийг нь зөв үлгэр дууриалал болгон харах вэ? Ямар зөв шударга сонголтуудыг тэд хийсэн бэ?
- Кориантонд баярлахгүй байна гэж Алма яагаад хэлсэн бэ? (Алма 39:2.) Кориантон аавынхаа үгэнд анхаарал хандуулаагүй гэдэг нь юу гэсэн үг вэ? (Кориантон Алмад дуулгавартай байгаагүй.) Бид яагаад эцэг эхдээ дуулгавартай байх хэрэгтэй вэ? Сагсуурах гэдэг нь юу гэсэн үг вэ? (Бардамнах, эсвэл өөрсдийгөө бусдаас дээгүүр тавих.) Бардамнах нь яагаад буруу вэ?
- Алма яагаад Кориантонд түүний гэм нүглүүдийг сануулж байна гэж хэлсэн бэ? (Алма 39:7–9. “Эдгээр зүйлд өөртөө хориг тавь” [шүлэг 9] гэдэг нь эдгээр бусармаг зүйлүүдийг үйлдэхгүй байх гэсэн үг болохыг тайлбарла.) Хэн бидний бүх гэм нүглийг мэддэг вэ? (Алма 39:8.) Гэм буруутайн мэдрэмж нь хүнийг наманчлал руу хэрхэн хөтөлдөг вэ?
- Кориантонд сонголтуудыг хийхэд хэн сайн зөвлөгөө өгч чадна гэж Алма хэлсэн бэ? (Алма 39:10.) Эцэг эх болон гэр бүл тань та нарыг зөв шийдвэр гаргахад хэрхэн тусалдаг вэ? Өөр ямар эх сурвалжаас та нар зөв шударга зөвлөгөөг хүлээн авч чадах вэ?
- Кориантоны шударга бус үйлдлүүд нь Зорамчуудад хэрхэн нөлөөлсөн бэ? (Алма 39:11.) Ямар байдлаар бидний сонголтууд бусдад нөлөөлдөг вэ?
- Ямар сонголтуудыг та нар хийх ёстой байдаг вэ? Та нарыг ямар нэг буруу зүйл хийж байгаагаа мэдэхэд Ариун Сүнс та нарт хэрхэн тусалж болох вэ? Та нарыг сайн шийд гаргасан гэдгээ мэдэхэд Ариун Сүнс та нарт хэрхэн туслах вэ? Ангийн гишүүдийг шийдвэр гаргахад нь Ариун Сүнс тусалсан тохиолдлуудаасаа ярихыг урь.
- Алма Кориантонд наманчлалын тухай юу заасан бэ? (Алма 39:13.) “Бүх оюун, хүч мөн чадлаараа Их Эзэнд хандана” гэдэг нь юу гэсэн үг хэмээн та нар бодож байна вэ? Буруу сонголтуудаараа гомдоосон тэдгээр хүмүүсээсээ бид яагаад уучлал эрэх ёстой вэ?
- Баялаг эрэх талаар Алма юу гэж зөвлөсөн бэ? (Алма 39:14.) Эд баялаг амьдралынх нь хамгийн чухал зүйл болсон хүмүүст юу тохиолддог вэ?
- Алма Кориантонд Есүс Христийн үүргийн тухай юу заасан бэ? (Алма 39:15.) Кориантон юун тухай заах ёстой байсан бэ? (Алма 39:16.) Хүрээлж байгаа хүмүүстэйгээ сайн мэдээг хуваалцахын тулд бид юу хийж чадах вэ?

Та амьдралдаа хийж байгаа сонголтуудын үр дагаварыг ойлгоход нь хүүхдүүдэд туслахын тулд баяжуулах үйл ажиллагаа 2, 3-ыг ашиглаж болно.

Баяжуулах Үйл Ажиллагаа

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно.

1. Итгэлийн тунхгийн хоёрдугаарыг давтаж ярилцаад хүүхдүүдээр цээжлүүл. Хүн бүр хийсэн зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээх болно гэдгийг анхааруул.
2. Дараах, эсвэл үүнтэй төстэй зүйлд өөрсдийнх нь хийж чадах сонголтуудыг хүүхдүүдтэй ярилц. Ангийн хүүхдүүдэд тань тулгарч болзошгүй асуудлууд болох санаануудыг ашигла. Есүс тэднийг ямар сонголтуудыг хийгээсэй хэмээн хүсч байгааг тэднээс асуу. Тэдний хийж чадах янз бүрийн сонголтуудын үр дагаваруудыг бодоход нь тусал.

Тэдний ярьдаг хэл яриа
Хүндэтгэлийн өдрийг ариунаар нь сахих
Тэдний өмсдөг хувцаснууд
Эцэг эхдээ дуулгавартай байх
Тэдний сонсдог хөгжим
Хулгай хийх
Тэдний үздэг кино, видео болон телевизийн шоуунууд
Үнэнийг хэлэх
Тэдний уншдаг ном, сэтгүүлүүд
3. Хүүхдүүдээр дараахтай адил сонголт болон үр дагавартай нөхцлүүдээр жүжигчилсэн тоглолт хийлгэ.

Хэн нэгний талаар худлаа хэлдэг найз.
Та нарыг тохиромжгүй кино, эсвэл видео үзүүлэхийг хүсдэг найз.
Та нарт тааламжгүй түүх ярьдаг найз.
Та нарыг сургууль дээр хуурахыг хүсдэг найз.
Та нарыг Мэргэн Ухааныг Үгийг зөрчүүлэхийг хүсдэг найз.
Та нарт хориотой эм санал болгодог хэн нэгэн.
4. Ерөнхийлөгч Спенсэр В. Кимболлын хийсэн дараах шийдвэрийн үр дагаварыг хүүхдүүдтэй ярилц.

“Би бүр жаахан байхдаа Мэргэн Ухааны Үгийг хэзээ ч зөрчихгүй гэж шийдсэн. . . . Их Эзэн үүнийг хэлэхдээ хүн төрөлхтөн эдгээр бүх сүйтгэгч элементээс хол байх нь түүнд таатай байх болно мөн миний хийхийг хүссэн зүйл Тэнгэрлэг Эцэгт таалагдах болно гэдгийг би мэдэж байлаа. Тиймээс би тэдгээр хорт зүйлүүдийг хэзээ ч барьж үзэхгүй гэж тууштай, бат шийдсэн юм. Бүрэн гүйцэд, тодорхой шийдсэнээрээ Тэнгэрлэг Эцэгтээ болон өөртөө хийсэн амлалтаа сахих нь тийм хүнд биш юм гэдгийг би олж мэдсэн” (Conference Report, Apr. 1974, p. 127 or *Ensign*, May 1974, p. 88)
5. *Би зөв шударга сонголтуудыг хийнэ* гэсэн үгтэй жижиг үзүүлэнгүүдийг ангийн хүүхэд бүрт зориулан хий. Тараах материалыг доош нь харуулан ширээн дээр байрлуулаад, хүүхдүүдийг нэг нэгээр нь урагш гаргаж тэднээр нэгийг авахуул. Дараах асуултуудад хариулахыг хүүхэд бүрээс хүс:

- Энэ долоо хоногт та нарыг зөв шударга сонголтуудыг хийхэд хөтлөх ямар зүйлийг та нар ашиглах вэ?
- Буруу сонголтуудыг хийхийн үр дагаварууд нь юу байж болох вэ?
- Зөв шударга сонголтуудыг хийхийн үр дүн нь юу байж болох вэ?

Үйл ажиллагааны төгсгөлд бид сонголтуудыг хийхээсээ өмнө үр дагаваруудыг бодохын чухлыг онцол.

6. Итгэлийн тунхгийн арван нэгдүгээрийг болон яагаад хүн бүр сонголтуудынхаа төлөө хариуцлага хүлээдэг болохыг ярилц.

- Яагаад бид хэн нэгнийг сайн мэдээнд итгэхэд нь албадахыг оролдох ёсгүй вэ?
- Яагаад бусад хүмүүс бидэнд Бурханыг өөрсдийнхөө хүссэнээр шүтэхийг маань зөвшөөрнө гэж бодох ёстой юм бэ?

Хүүхдүүдэд итгэлийн тунхгийн арван нэгдүгээрийг цээжлэхэд нь тусал.

7. “Зөв Замыг Сонго” дууг дуулах, эсвэл үгийг нь унш (*Хүүхдийн Дууны Ном*, х. 64).

Дүгнэлт

Гэрчлэл	Есүс Христийг дагахаар шийдэх нь зөв шударга сонголтуудыг хийхэд хөтөлдөг, мөн энэ нь жинхэнэ аз жаргалыг олох цорын ганц зам юм гэдгийг гэрчил.
Зөвлөмж Болгогдсон Гэрийн Уншлага	Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ Алма 39:12–19-ийг судлахыг зөвлө. Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.

Ахмад Моронай Зерахэмнаг Ялсан нь

Хичээл
25

Зорилго	Хүүхэд бүрийг муу ёрын сүнсний эсрэг хамгаалалт болгон Бурханы хуяг дуулгыг өмсөхөд урамшуулна.
Бэлтгэл	<ol style="list-style-type: none">1. Алма 43–44 болон Ефес 6:11, 13–18-ыг залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii-ыг үз).2. Нэмэлт уншлага: Сургаал ба Гэрээ 27:15–183. Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго.4. Шаардлагатай материалууд:<ol style="list-style-type: none">а. Хүүхэд бүрт Мормоны Номб. Библив. Та Бурханы хуяг дуулгыг хүүхдүүдэд хэрхэн заахыг хүсч байгаагаасаа шалтгаалан үгийн хайчилбарууд, хүүхэд бүрт хуяг дуулга болон хүний дүрстэй жижиг хайчилбарууд, самбарт зурсан дүрсэн дээр байрлуулах хуяг дуулганы том иж бүрдэл, эсвэл нэг хүүхдэд өмсгөх хатуу цаасаар хийсэн хуяг дуулганы иж бүрдлийг хий. (Хичээлийн төгсгөл дэх үзүүлэнг үз.)г. Зурагнууд: 4-37, Ахмад Моронайн Дайчид Лэмэнчүүдтэй Тулалдаж Байгаа нь; 4-38 Зерахэмнагийн Арми Зэвсгээ Хаяж Байгаа нь.

Хичээл Заах Зөвлөмж

Анхаарал Татах Ажиллагаа	<p>Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.</p> <ul style="list-style-type: none">• Эрт дээр үед хүмүүс сэлэм жадаа барин тулалдахаар явахдаа толгой, зүрх, гэдэс, гар, хөл, тавхайгаа хэрхэн хамгаалдаг байсан бэ? (Хуяг дуулгаар.) <p>Бид бүгд муу ёрын сүнсний эсрэг дайнд байгаа гэдгийг тайлбарла. Уруу таталт болон Сатаны хүч нь үнэхээр бодитой юм. Тэнгэрлэг Эцэг биднийг муу ёрын сүнсний эсрэг байлдаанд хамгаалалтгүйгээр тулалдахыг хүсдэггүй. Нэг хүүхдээр Ефес 6:11, 13–18-ыг уншуул. Үгийн хайчилбар, эсвэл хайчилбарыг ашиглан хуяг дуулганы хэсэг бүрийн тухай ярилц. Өөрсдийнхөө эргэн тойронд байгаа муу ёрын сүнснээс хамгаалуулахад бид хэрхэн амьдрах хэрэгтэйг хуяг дуулгын хэсэг тус бүртэй холбож тайлбарла.</p>
Судрын Хэсэг	Хүүхдүүдэд Алма 43–44-өөс Ахмад Моронай Зерахэмнаг ялж байгаа тухай хэсгийг заа. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii-аас үз.) Моронайн арми зөвхөн хүний гараар хийсэн хуяг дуулга өмсөөд зогсолгүй Бурханы хуяг дуулганы илүү хүчтэй хамгаалалттай байсан гэдгийг онцол. Зургуудыг тохиромжтой үед нь ашигла.
Ярилцлага ба Тавьж Болох Асуултууд	Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг

хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншнаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.


- Яагаад Лэмэнчүүдийн удирдагч Зерахэмна Лэмэнчүүдийн гол ахмадаар Амалекайчууд болон Зорамчуудыг томилсон бэ? (Алма 43:6–7.) Лэмэнчүүд яагаад Нифайчуудтай байлдахыг хүссэн бэ? (Алма 43:8, 29.)
- Яагаад Нифайчууд тулалдахад бэлэн байсан бэ? (Алма 43:45, 47.) Бидний гэр орон, гэр бүл, эрх чөлөө болон Сүмийнхээ төлөө тэмцэлдэх нь яагаад чухал вэ? Та нарт тэмцэлдэхэд юу нь илүү үнэтэй вэ?
- Ахмад Моронай өөрийнхөө армийг Жэршонд Лэмэнчүүдтэй уулзахад хэрхэн бэлдсэн бэ? (Алма 43:18–19.) Энэ бэлтгэл нь Лэмэнчүүдийг яагаад айлгасан бэ? (Алма 43:20–21.) Ямар ямар байдлаар та нар Бурханы сүнслэг хуяг дуулгыг өмсөж зөв гэсэн зүйлийнхээ төлөө зогсоход бэлтгэгдсэн байх вэ?
- Ахмад Моронай армиа хаашаа илгээх ёстойгоо хэрхэн олж мэдсэн бэ? (Алма 43:23–24.) Өнөөдөр бошиглогчид бидэнд хэрхэн тусалдаг вэ?
- Хэдийгээр Нифайчуудын арми хуяг дуулга өмссөн байсан ч яагаад тэд Лэмэнчүүдээс айж, зугтахыг хүссэн бэ? (Алма 43:48.) Моронай тэднийг хэрхэн зоригжуулсан бэ?
- Ахмад Моронайн арми тулалдах хүч болон зориг авахын тулд юу хийсэн бэ? (Алма 43:49–50.) Залбирал нь Бурханы хуяг дуулгыг өмсөхөд та нарт хэрхэн тусалдаг вэ? (Ефес 6:18.)
- Моронай Лэмэнчүүдийг бүсэлснийхээ дараа цус урсгадаг эр биш гэдгээ үзүүлэхийн тулд юу хийсэн бэ? (Алма 43:54, 44:1–2, 6.)
- Их Эзэн яагаад Лэмэнчүүдийг Моронайн армийн гарт өгсөн бэ? (Алма 44:3.) Хэрэв бид итгэлтэй байх юм бол Их Эзэн Нифайчууд болон мөн бидэнд ямар амлалтыг өгсөн бэ? (Алма 44:4.) Нифайчуудын хамгаалагдсан байгаа талаар Зерахэмна юу бодсон бэ? (Алма 44:9.)
- Ууртай Зерахэмна амар амгалангийн тангараг хийгээгүйгээс болж юу тохиолдсон бэ? (Алма 44:12.) Тулалдахгүй байхаар гэрээ хийсэн Лэмэнчүүдэд юу тохиолдсон бэ? (Алма 44:15.) Амлалт болон гэрээнүүдээ сахих нь бидэнд яагаад чухал вэ?

Баяжуулах Үйл Ажиллагаа

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно.

1. Тохируулдаг тоглоомыг тогло (“Судраас заах” х.viii-аас үз.) Зургаан цаас буюу хөзрөн дээр дараах хуяг дуулгуудын хэсэг бүрийн нэрийг, өөр зургаан хөзөр дээр тэдний юу төлөөлж байгааг бич. Хүүхдүүдээр хуяг дуулганы хэсэг бүрийн нэрийг Бурханы хуяг дуулганы юуг төлөөлүүлсэн болохыг тохируулуул.
 - Бүс—Үнэн (Ефес 6:14)
 - Хуяг—Зөвт байдал (Ефес 6:14)
 - Гутал—Амар тайвны сайн мэдээний бэлэн байдал (Ефес 6:15)
 - Бамбай—Итгэл (Ефес 6:16)
 - Дуулга—Аврал (Ефес 6:17)
 - Сэлэм—Бурханы Сүнс буюу Бурханы Үг (Ефес 6:17. С ба Г 6:2)

2. Ефес 6:13–18-ыг ашиглан Бурханы хуяг дуулганы тус бүр нь юуг төлөөлж байгааг цээжлэхэд нь хүүхдүүдэд тусал. Та хүүхэд рүү бөмбөгийг шидэх үедээ хуяг дуулганы нэг хэсгийг нэрлэ. Тухайн хүүхэд уг хуяг дуулганы хэсгийн утга учрыг нь хэлнэ дараа нь өөр хүүхэд рүү бөмбөг шидэх үедээ хуяг дуулганы өөр нэг хэсгийг нэрлэ, тэр хүүхэд утгыг нь хэлээд хуяг дуулганы шинэ хэсгийг сонгох зэргээр үргэлжилнэ.
3. Өнөөдөр Сатан биднийг сүнсээр шархлуулах юмуу алахыг хичээн ямар төрлийн зүйлс ашиглаж байгааг хүүхдүүдээс асуу. Тэд тодорхой зарим нэг кино, зурагтын хөтөлбөр, дүрс бичлэг, ном, эсвэл сэтгүүлүүд, Мэргэн Ухааны Үгийг зөрчүүлэх уруу таталтууд, сүмдээ явахгүй байх уруу таталтууд гэх зэрэг зүйлсийг нэрлэж болно. Хувийн болон гэр бүлийн залбиралтай байх, хувиараа болон гэр бүлээрээ судраас суралцах, гэр бүлийн үдшийг явуулах, сүмдээ очиж байх гэх зэрэг өөрсдийнхөө сүнслэг хуяг дуулгыг хүчтэй болгохын тулд хүүхдүүд юу хийж байгааг нь ярилц.
4. Алма 43:31–42-д өгүүлснээр Ахмад Моронай Лэмэнчүүдийн армийг хэрхэн мэхэлснийг ярилц. Нифайчууд болон Лэмэнчүүдийн армийн байрлалыг үзүүлэхийн тулд самбар ашигла.



5. “Зөв Замыг Сонго” дууг дуулах, эсвэл үгийг нь унш (*Хүүхдийн Дууны Ном*, х. 64).

Дүгнэлт

Гэрчлэл






Муу ёрын сүнснээс өөрсдийгөө хамгаалахын тулд Бурханы хуяг дуулгыг өмсөхийн ач холбогдлын тухай гэрчлэлээ хуваалц.


Зөвлөмж
Болгогдсон

Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ Алма 43:41–54 болон 44:1–4-ийг судлахыг зөвлө.

Гэрийн Уншлага

Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.





Зорилго

Жинхэнэ эрх чөлөө нь нүгэл хилэнцийг эсэргүүцэж Тэнгэрлэг Эцэгийн зарлигуудыг сахиснаар ирдэг гэдгийг хүүхдүүдэд заана.

Бэлтгэл

1. Алма 46, 48 болон 49:21–30-ийг залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii- ыг үз).
 2. Нэмэлт уншлага: Алма 47, 49:1–20.
 3. Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго.
 4. Шаардлагатай материалууд:
 - а. Хүүхэд бүрт Мормоны Ном.
 - б. Том цагаан даавуу (эсвэл та том цаас буюу самбар ашиглаж болно), таяг, эсвэл саваа мод, наадаг тууз.
 - в. Зурагнууд: 4-39, Ахмад Моронай Эрх Чөлөөний Далбааг Өргөн Мандуулсан нь (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 312, 62051).
-

**Хичээл Заах
Зөвлөмж**

Анхаарал Татах
Ажиллагаа

Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.

Ахмад Моронайн зургийг үзүүл. Хүүхдүүдийг судраасаа Алма 46-г нээхийг хүс. Хүүхдүүд хоёулаа цэргийн удирдагчид болох Ахмад Моронай, Амиликая гэдэг хоёр эрийн тухай сурах болно гэдгийг тайлбарла. Амиликая нь төрөхөөсөө Нифай хүн боловч тэр Их Эзэний тухай бүрмөсөн мартсан. Худал хуурмаг, луйвар, аллагаар тэр Лэмэнчүүдийн хаан болж чадсан. Амиликая нь Нифайчууд болон Лэмэнчүүдийн хоёулангийнх нь хаан болохын тулд тэрээр тулалдаанд Нифайчуудыг ялахыг хүсэж байв.

Ахмад Моронай Нифайчуудын армиудын ерөнхий удирдагч байв. Тэр Их Эзэн болоод өөрийн хүмүүстээ хайртай, хүчтэй чадалтай хүн байлаа. Тэр өөрийн хүмүүсээ Амиликая болон Лэмэнчүүдийн армиас нь хамгаалахаар тангараг өргөсөн юм.

Амиликая болон түүний арми Нифайчуудыг устгахаар бэлтгэж байхад нь Ахмад Моронай өөрсдийгөө хамгаалахаар хүмүүсээ бэлтгэж байв.

Даавуу (эсвэл цаас) өргөөд, том хэсгийг урж ав, эсвэл самбар дээр урсан хувцасны зургийг зур. Хүүхдүүдэд Ахмад Моронай өөрийнхөө цувнаас ураад, түүгээрээ эрх чөлөөний далбаа хэмээн нэрлэсэн туг, буюу далбаа хийсэн гэдгийг хэл. Хүүхдүүдийг хамтдаа Алма 46:12-ыг уншихыг урь. Даавуу, эсвэл цаасны урсан хэсгүүдийн нэг дээр дараах үгсийг бич: “Бурхан, шашин шүтлэг, эрх чөлөө, энх амгалан, эхнэр болон хүүхдийнхээ тухай санамж болгоё.” Хэрэв та даавуу, эсвэл цаас ашиглаж байгаа

бол хүүхдүүдээр тугийг саваа модонд тогтоолго. Нэг хүүхдээс тугийг ангийн урд барьж зогсохыг хүс.

Судрын Хэсэг

Хүүхдүүдэд Алма 46–49-өөс ард түмнээ өөрсдийнхөө эрх чөлөө болон чөлөөт байдлын төлөө тэмцэхэд бэлдсэн Бурханы хүчирхэг эр болох Ахмад Моронайн тухай хэсгийг заа. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii-аас үз.)

Ярилцлага ба Тавьж Болох Асуултууд

Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншнаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.

- Нифайчуудын дундах амар амгалан байдалд юу заналхийлж байсан бэ? (Алма 45:24, 46:1–2.) Яагаад өчнөөн олон хүн Амиликааяг дагасан бэ? (Алма 46:5.)
- Энэхүү тэрслэлүүдийг сонсоод Ахмад Моронай юу хийсэн бэ? (Алма 46:11–12.) Ахмад Моронай эрх чөлөөний далбаа хийснийхээ дараа яасан бэ? (Алма 46:13, 16.)
- Ахмад Моронай Нифайн ард түмнээс юу хийхийг хүссэн бэ? (Алма 46:19–20.) Эрх чөлөөний далбаа дээр бичигдсэн үгс нь яагаад Нифайчуудыг зоригжуулсан гэж та нар бодож байна вэ?
- Моронайг дагасан хүмүүс ямар гэрээ хийсэн бэ? (Алма 46:21–22.) Энэ гэрээг хийх нь хүмүүст эрх чөлөө болон шашныхаа төлөө тэмцэхэд хэрхэн тусалсан гэж та нар бодож байна вэ? Бидний хийсэн ямар гэрээнүүд байдаг вэ?
- Ахмад Моронай өөрийн хүмүүсийг юуг санаасай гэж хүссэн бэ? (Алма 46:23–24. Эдгээр шүлгүүд нь Хуучин Гэрээний Иосеф болон түүний олон өнгийн хувцастай хамаатай гэдгийг онцол.)
- Нифайчуудын бэлтгэл юугаараа Лэмэнчүүдийн бэлтгэлээс өөр байсан бэ? (Алма 48:7.) Нифайчууд хотуудаа хамгаалахын тулд яаж хичээсэн бэ? (Алма 49:2, 4.) Бид Сатаны нөлөөллүүдийг ялж гарахын тулд өөрсдийгөө хэрхэн бэлтгэж чадах вэ?
- Нифайчууд дайны тухай юу заалгасан бэ? (Алма 48:14.) Тэнгэрлэг Эцэг тэдний төлөө юу хийнэ гэж тэд итгэж байсан бэ? (Алма 48:15–16.)
- Энэ хэсгийг тэмдэглэн үлдээсэн бошиглогч Мормон Ахмад Моронайн талаар ямар сэтгэгдэлтэй байсан бэ? (Алма 48:11–13, 17–18.) Ямар арга замуудаар та нар Ахмад Моронайтай адил болохыг хүсч байна вэ?
- Нифайчууд дайнд явахыг хүсээгүй хэдий ч, тэд яагаад Лэмэнчүүдтэй байлдсан бэ? (Алма 48:23–24.)
- Нао Хотын эсрэг хийсэн сүүлчийн тулалдаанд нь Лэмэнчүүдэд юу тохиолдсон бэ? (Алма 49:21–25.) Энэ тулалдаанд тэмцэлдэхэд өгөгдсөн Нифайчуудын эр зоригийн талаар та нар юу гэж бодож байна вэ? Юу та нарт зөв шударга байдал болон эрх чөлөөгөө хамгаалах эр зоригийг өгдөг вэ?
- Лэмэнчүүд зугтааж, Нифайчууд дайснаасаа чөлөөлөгдсөний дараа Нифайчууд юу хийсэн бэ? (Алма 49:28.) Бид эдэлж байгаа эрх чөлөөнийхөө төлөө хэрхэн талархлаа илэрхийлж чадах вэ?

Баяжуулах Үйл Ажиллагаа

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно.

1. Хүүхдүүдэд Ахмад Моронайн зургийг харуул. Өөрсдийгөө муу ёрын сүнснээс хамгаалахын тулд Бурханы хуяг дуулгыг өмсөхийн ач холбогдлыг товч ярилц. Зөв шударга байдал болон үнэнийг хамгаалахаар Тэнгэрлэг Эцэг хүүхэд бүрийг энэ цаг үед дэлхий рүү илгээсэн гэдгийг сануул. Хүүхдүүдийг Моронайн байлдааны хуяг дуулганы хэсэг болгоныг нь тогтоож (Алма 46:13) үүний юу нь сүнсний хуяг дуулгыг төлөөлж байгааг хэлэхийг хүс (Хичээл 25 болон Ефес 6:11, 13–18-г үз).

Бүс: Үнэн. Энэ нь буруу зөвийг ялгаж, үнэнийг хайрлаж, өөрсдийн ариун байдлаа хадгалж мөн ёс суртахууны хувьд цэвэр байна гэсэн утгатай юм.

Хуяг: Шударга ёс. Энэ нь зөвийг сонгож Есүс Христийг дагах гэсэн утгатай.

Бамбай: Итгэл. Энэ нь Их Эзэн Есүс Христэд итгэлтэй байна гэсэн үг.

Дуулга: Аврал. Энэ нь Тэнгэрлэг Эцэгтэй мөнхөд амьдрахын тулд зохистойгоор шүүгдэнэ гэсэн үг.

Сэлэм: Сүнс буюу Ариун Сүнс. Энэ нь Ариун Сүнс болон Есүс Христийн илчлэгдсэн үгсээр удирдагдана гэсэн үг.

Гутал: Амар амгалангийн сайн мэдээний бэлэн байдал. Энэ нь бид сайн мэдээг ойлгож нарийн бөгөөд шулуун замаар алхана гэсэн үг.


Энэ хичээлтэй хавсаргасан үзүүлэнгийн хувийг хүүхэд бүрт өгөөд, цаасан дээрх хоосон зайг бөглөхөд нь хамтран ажилла. Хүүхэд бүрээр доор нь гарын үсгийг нь зуруул. Хоёр хүүхдийг ангийн өмнө гаргаад анхаарал татах ажиллагааны үеэр ашиглаж байсан эрх чөлөөний тэмдгийг өргөхийг урь. Хүн бүрээр цаасан дээрх сүүлчийн мэдэгдэл болох “Би бусармаг явдалтнуудын галт сумны эсрэг зогсохдоо бэлэн байна” гэснийг чангаар уншуулаад, энэ мэдэгдэл нь ямар утгатай болохыг ярилц. Хүүхдүүдэд өөрсдийнх нь “Бурханы Хуяг Дуулга” гэсэн цаасыг гэр бүлийнхэнд нь үзүүлүүлэхээр гэрт нь өгч явуул.

2. Өөрийн улсын далбааг үзүүл. Далбаа бол гайхамшигтай сануулагч юм гэдгийг тайлбарла. Үндэстэн болгон далбаатай, тэрхүү далбаа нь хүмүүст тэд нар хэн болох хийгээд тэр үндэстэн юуны төлөө зогсож байгаагийн билэгдэл болдог. Хүүхдүүдэд цаас эсвэл жижигхэн даавуу болон зурах материалууд өгөөд тэд хэн болох, тэд юунд сэтгэл хангалуун байдаг, тэд ямар хүн болно гэж найддаг, тэд юуны төлөө зогсдог гэх зэрэг тэдэнд чухал ямар нэгэн зүйлийг үзүүлсэн хувийн далбаагаа зохиохыг тэднээс хүс. Та эдгээр зүйлсийг төлөөлсөн зарим билэгдлүүдийг хуваалцаж болно.

3. Итгэлийн тунхгийн арван хоёрдугаарыг хүүхдүүдтэй ярилцаад, үүнийг цээжлэхэд нь тэдэнд тусал.

Дүгнэлт

Гэрчлэл	Эрх чөлөө бол агуу адислал юм гэсэн гэрчлэлээ хуваалц. Бид муу ёрын сүнсийг эсэргүүцэж, Тэнгэрлэг Эцэгийн зарлигуудыг дуулгавартай дагаснаараа жинхэнэ эрх чөлөөг олж авна гэдгийг гэрчил.
Зөвлөмж	Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ Алма 48:11–13, 17–18-ыг судлахыг зөвлө.
Болгогдсон Гэрийн Уншлага	Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.



БИ БУРХАНЫ БҮРЭН ХУЯГ ДУУЛГЫГ ӨМСӨНӨ

Би _____ төлөө бүсээ бүслээд зогсох болно.

Би _____ -ын хуягаар зүрх сэтгэлээ халхална.

Би хөлдөө _____ -ын гуталтай зогсоно.

Би _____ -ийн бамбайг гартаа авна.

Би _____ -ын дуулгыг толгойдoo өмсөнө.

Би _____ -ний сэлмийг гартаа авна.

Би бусармаг явдалтнуудын галт сумны эсрэг зогсохдоо бэлэн байна.

(Ефес 6:11–17, Сургаал ба Гэрээ 27:15–18-ыг үз.)

Зорилго

Хүүхдүүдэд зөв шударга эцэг эхийн жишээ болон сургаалуудыг дагах нь бидэнд үнэн болоод зөвийг хамгаалах хүч чадал өгдгийг заана.

Бэлтгэл

1. Алма 53:10–23 болон 56:1–58:27-г залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii-ыг үз).
 2. Нэмэлт уншлага: Алма 24.
 3. Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго.
 4. Шаардлагатай материалууд:
 - а. Хүүхэд бүрт Мормоны Ном.
 - б. Зурагнууд: 4-33, Антай-Нифай-Лихайчууд Зэр Зэвсгээ Булсан нь (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 311, 62565), 4-40, Хоёр Мянган Залуу Дайчид (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 313, 62050).
-

**Хичээл Заах
Зөвлөмж**

Анхаарал Татах
Ажиллагаа

Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.

Антай-Нифай-Лихайчууд Зэр Зэвсгээ Булсан нь зургийг үзүүл. Хүүхдүүдэд тэд энэ агуу хүмүүсийн талаар хэдэн долоо хоногийн өмнө суралцаж байсныг нь сануул (хичээл 19-ийг үз). Хүүхдүүдэд дараах асуултуудыг тавь:

- Антай-Нифай-Лихайчууд гэж хэн байсан бэ? Тэд яагаад зэр зэвсгээ булсан бэ?

Нэг хүүхдээр Алма 24:19-ийг уншуул. Антай-Нифай-Лихайчууд хүүхдүүдэд гайхамшигтай жишээ болсон гэдгийг тайлбарла.

Хүүхдүүдийг шударга явдал, сайхан сэтгэл, аравны нэгээ төлөх, Хүндэтгэлийн Өдрийг ариунаар нь сахих зэрэг эцэг эхээсээ сурсан чухал зарчмууд ба эдгээр зарчмуудыг дуулгавартай дагаснаараа тэд хэрхэн адислагдсан тухай жишээнүүдээсээ хуваалцахыг урь.

Тэнгэрлэг Эцэг бидэнд амьдралын маань туршид хайрлах, заах, удирдах эцэг эхийг өгсөн гэдгийг тайлбарла. Энэ хичээлээр хүүхдүүд Антай-Нифай-Лихайчуудын хөвгүүд болох хоёр мянган залуу дайчид эрх чөлөөгөө хамгаалах гэрээгээ сахих зөв шударга эцэг эхийнхээ сургаал ба жишээнүүдийг хэрхэн ашигласан тухай сурах болно гэдгийг тайлбарла.

(Тайлбар: Хэрэв хүүхдүүдийн хэн нэгнийг өвөө эмээ, хамаатан, эсвэл өөр бусад хүмүүс өсгөж байгаа бол тэдний чухал нөлөөллийг багтаахаар хичээлээ бэлтгэ.)

Судрын Хэсэг

Тохиромжтой үед нь зургуудыг ашиглан Алма 53, 56-58-аас Хиламан ба хоёр мянган залуу дайчдын тухай хэсгийг хүүхдүүдэд заа. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii-аас үз.) Эдгээр залуу эрс эцэг эхийнхээ сургаалуудыг хэрхэн дагаж тулалдаанд хамгаалагдсныг онцлон хэл.

Ярилцлага ба
Тавьж Болх
Асуултууд

Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншнаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.

- Хоёр мянган залуу дайчдын эцэг эхчүүд ямар гэрээ хийсэн бэ? (Алма 53:10–12.) Тэд яагаад энэ гэрээгээ зөрчих талаар бодсон бэ? (Алма 53:13.) Хиламан яагаад Антай-Нифай- Лихайчуудыг Лэмэнчүүдтэй байлдахад нь туслахыг хүсээгүй вэ? (Алма 53:14–15.) Гэрээнүүдээ сахих нь яагаад ийм чухал байдаг вэ?
- Яагаад хоёр мянган залуу эрс тулалдахаар шийдсэн бэ? (Алма 53:16.) Эдгээр залуу дайчид юуны төлөө тэмцэнэ гэж гэрээ хийсэн бэ? (Алма 53:17.)
- Эдгээр залуу эрс юутай адил байсан бэ? (Алма 53:20–21.) “Тэд итгэж даалгасан ямар ч зүйлд цаг үргэлж үнэнч” байна гэдэг нь юу гэсэн үг вэ? Ямар ямар арга замаар та нар Их Эзэний өмнө үнэнч байж, шударгаар алхаж чадах вэ?
- Эцгүүд байлдахгүй байна гэсэн гэрээгээ зөрчилгүйгээр хөвгүүддээ хэрхэн тусалсан бэ? (Алма 56:27.) Эцэг эхчүүд чинь ямар ямар арга замаар та нарт дэмжлэг үзүүлдэг вэ?
- Хиламан эдгээр залуу дайчдын хүч, эр зоригийн тухай Моронайд юу гэж хэлсэн бэ? (Алма 56:45.) Ээжүүд нь тэдэнд юу заасан бэ? (Алма 56:46–48.) Тэд яагаад үхлээс айгаагүй вэ? Эцэг эхчүүд тань та нарыг сорилтуудтай учрахдаа эр зориг болон итгэлтэй байхад бэлтгэхийн тулд хэрхэн хичээдэг вэ?
- Тулалдаанд энэ хоёр мянган залуу дайчдад хүч ба эр зоригийг юу өгсөн бэ? (Алма 57:26–27, 58:39–40.)
- Эдгээр дайчид Хиламаныг хэрхэн дагасан бэ? (Алма 57:21.) “Яг таг” дагана гэдэг нь юу гэсэн үг вэ? Удирдагчид болон эцэг эхийнхээ зөвлөгөөг яг таг дагах нь яагаад чухал вэ?
- Хоёр мянган залуу дайчид хүч тэнхээ хэрэгтэй үедээ юу хийсэн бэ? (Алма 58:10.) Тэдний залбирал хэрхэн хариулагдсан бэ? (Алма 58:11.) Ангийн гишүүдийг тэд болон гэр бүлийн гишүүд нь Ариун Сүнсээр өдөөгдсөн тохиолдлуудаа ярихыг урь.
- Эдгээр залуу эрсийн агуу итгэл, эр зориг нь хэрхэн шагнагдсан бэ? (Алма 56:56, 57:25, 58:39.) Ямар хүч чадал тэднийг үхлээс аварсан бэ? (Алма 57:26–27, 58:40.)

Баяжуулах Үйл Ажиллагаа

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно.

1. Хүүхэд бүрт гэртээ авч явахад нь зориулж хичээлийн төгсгөл дэх үзүүлэн хувилан бэлд.
2. Хүүхдүүдээр сайн дураар нь дараах мэдэгдлийг гүйцээлгэ.

Би хэрхэн _____ -аараа залуу дайчидтай адил байж чадна.

Эцэг эх минь надад _____ -ыг заасныг санаснаараа би залуу дайчидтай адил байж чадна.

Залуу дайчдын тухай _____ -ыг би хамгийн их бахаддаг.

Хоёр мянган залуу дайчдын түүхийн миний хамгийн их дуртай хэсэг бол _____ .
3. Хүүхдүүдийг хоёр мянган залуу дайчдын тухай дуртай шүлгүүдийнхээ заримыг нь судар дээрээ тэмдэглэхэд нь урамшуул. Тэд дараах жишээнүүдийн заримаас нь сонгож болно.

Алма 53:20–21

Алма 56:45–48


Алма 57:21, 25–27

Алма 58:10–11


Алма 58:39–40
4. Тав дахь зарлигийг цээжлэхэд нь хүүхдүүдэд тусал (Мозая 13:20-ийг үз).

Дүгнэлт


Гэрчлэл	Эцэг эхийнхээ зөв шударга сургаалууд болон жишээнүүдийг дагаснаар ирэх адислалуудын тухай гэрчлэлээ хуваалц.
Зөвлөмж Болгогдсон Гэрийн Уншлага	Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ Алма 53:16–21, 56:45–48 болон 57:25–27-г судлахыг зөвлө. Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.




“Тэд залуу, мөн тэдний оюун нь өөрчлөгдөшгүй, мөн тэд үргэлж Бурханд найдлагаа тавьдаг бөлгөө.” Алма 57:27



“Тэд залуу, мөн тэдний оюун нь өөрчлөгдөшгүй, мөн тэд үргэлж Бурханд найдлагаа тавьдаг бөлгөө.” Алма 57:27



“Тэд залуу, мөн тэдний оюун нь өөрчлөгдөшгүй, мөн тэд үргэлж Бурханд найдлагаа тавьдаг бөлгөө.” Алма 57:27



“Тэд залуу, мөн тэдний оюун нь өөрчлөгдөшгүй, мөн тэд үргэлж Бурханд найдлагаа тавьдаг бөлгөө.” Алма 57:27

Зорилго

Аврагчийн сургаал номлолуудаар амьдрахыг сонгож амьдралынхаа үндэс суурь болгоход нь хүүхдүүдийг урамшуулан урамшуулна.

Бэлтгэл

1. Хиламан 5-ыг залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii-ыг үз).
 2. Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго.
 3. Шаардлагатай материалууд:
 - а. Хүүхэд бүрт Мормоны Ном.
 - б. Чулуу, элс, эсвэл давс болон хайрцагны таг буюу хайруулын таваг.
 - в. Зураг 4-41, Нифай, Лихай Хоёр Шоронд.
-

**Хичээл Заах
Зөвлөмж**

Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.

Анхаарал Татах
Ажиллагаа

Барилга барихаасаа өмнө ажилчид тэр барилгыг тогтоож барьж байх бат бөх суурь хийдэг гэдгийг тайлбарла. Хүүхдүүдээр барилга барихад суурь болох чулуу болон элсний тогтвортой байдлыг харьцуулуул. Дунд зэргийн хэмжээтэй чулуу болон элс, эсвэл давстай хайрцагны таг буюу хайруулын тавгийг ширээн дээр тавь. Чулуу руу үлээгээд дараа нь элс буюу давс рүү үлээ.

Хүүхдүүдээс хэрэв тэд гэр орон барих бол яагаад элснээс илүү чулууг суурь болгохоор сонгохыг нь асуу. Судрууд нь Есүс Христийг бидний амьдралаа барих бат бөх суурь мэт байх чулуутай харьцуулсан гэдгийг тайлбарла. Бид Христийн сургаал номлолуудаар амьдрахыг сонгохдоо түүний чулуун суурин дээр амьдралаа барьдаг.

“The Wise Man and the Foolish Man” (*Children’s Songbook*, p. 281) дууг дуул. Та Хүүхдийн Хэсгийн хөгжмийн удирдаачийг ангидаа ирж хүүхдүүдэд дуу дуулахад нь туслуулж болно. Та дуу тоглуулагчаар дууг явуулах буюу ангийн гишүүдээр үгийг хамтад нь хэлүүлж болно.

Энэ хэсэгт Нифай, Лихай нар өөрсдийн амьдралыг Аврагчийн найдвартай бат бэх суурин дээр барьсан бөгөөд энэ нь тэд Есүс Христийн тухай хүчтэй гэрчлэлтэй байсан гэсэн үг юм. Тэд бас түүний тухай гэрчлэлүүдийг олж авахад нь олон Лэмэнчүүдэд тусалсан. Бид бас өөрсдийн амьдралыг цорын ганц найдвартай суурь болох Есүс Христ дээр барьж чадна.

Судрын Хэсэг

Хиламан 5 дахь Нифай, Лихай хоёрын тухай хэсгийг хүүхдүүдэд заа. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii-аас үз.) Энэ хоёр итгэлтэй эр Есүс Христийг хэрхэн амьдралынхаа суурь болгосныг онцол.

Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншнаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.

- Хиламан гэж хэн байсан бэ? (Хиламан 2:2.) Хиламан яагаад хөвгүүдээ Нифай, Лихайн нэрээр нэрлэсэн бэ? (Хиламан 5:6.)
- Усан баталгаа хийлгэхдээ бид хэний нэрийг өөртөө авдаг вэ? (2 Нифай 31:13.) Бид хэрхэн Есүс Христтэй илүү адилхан болж чадах вэ?
- Нифай яагаад дээд шүүгч байхаа больсон бэ? (Хиламан 5:2–4.)
- Есүс Христ гэм нүглээсээ аврагдах боломжийг бидэнд хэрхэн олгосон бэ? (Хиламан 5:9–10.) Есүс Христ биднийг гэм нүглээс маань гэтэлгэж чадна үүний тулд бид юу хийх ёстой вэ? (Хиламан 5:11.)
- “Бурханы Хүү, Христ болох Гэтэлгэгчийн маань хадан дээр та нар сууриа тавих ёстой” гэдэг нь юу гэсэн утгатай вэ? (Хиламан 5:12.) Яагаад Есүс Христ бидний цорын ганц найдвартай суурь вэ? Та нар хэрхэн Есүсийг амьдралынхаа суурь болгож чадах вэ?
- Өнөөдөр Сатан хувь хүмүүс болон гэр бүлүүд рүү хэрхэн “хүчит салхи, . . . дайралт . . . мөндрөө илгээж” байна вэ? Христийн суурин дээр амьдралаа барьсан тэдгээр хүмүүст муу ёрын сүнс хир их хүчтэй вэ? (Хиламан 5:12.)
- Хиламаны сургаалууд Нифай, Лихай нарт хэрхэн нөлөөлсөн бэ? (Хиламан 5:13–14.) Эцэг эхчүүд чинь та нарын амьдралд тус болсон ямар зүйлүүдийг заасан бэ?
- Нифай, Лихай нар Шоронд зургийг үзүүл. Нифай, Лихай хоёр шоронд хэрхэн хамгаалагдсан бэ? (Хиламан 5:22–23.) Зохистой байх нь бидэнд хэрхэн туслах вэ?
- Есүс Христ шорон дахь Лэмэнчүүдтэй хэрхэн холбоо барьсан бэ? (Хиламан 5:29–30.) Энэ дуу хоолой ямар байсан бэ? Их Эзэн Лэмэнчүүдэд юу гэж хэлсэн бэ? (Хиламан 5:29, 32.)
- Аминадаб Лэмэнчүүдэд харанхуйн үүлийг арилгахын тулд юу хийхийг хэлсэн бэ? (Хиламан 5:41.) Харанхуй арилсны дараа Лэмэнчүүдэд юу тохиолдсон бэ? (Хиламан 5:43–47.) Хэрэв та нар тэнд байсан бол ямар мэдрэмжтэй байх байсан гэж бодож байна вэ? Амьдралдаа Сүнстэй байх нь ямар санагдаж байна вэ? Хүүхдүүдэд амьдралдаа Сүнсийг мэдэрсэн тохиолдлоосоо хуваалцах боломж олго.
- Лэмэнчүүдэд хэн үзэгдсэн бэ? (Хиламан 5:48.) Лэмэнчүүд тэнгэрийн элчүүдийг харсныхаа дараа юу хийсэн бэ? (Хиламан 5:50.)
- Хөрвүүлэгдсэн тэдгээр хүмүүс үйлдлээ хэрхэн өөрчилсөн бэ? (Хиламан 5:51–52.) Есүс Христ бол бидний гэрчлэлүүдийн суурь гэдгийг үзүүлэхийн тулд бид ямар байдлаар амьдарч чадах вэ?

Баяжуулах Үйл Ажиллагаа

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно.

1. Хиламан 5:12-ын дараах үгсийг цээжлэхэд нь хүүхдүүдэд тусал: “Санагтун, Бурханы Хүү, Христ болох Гэтэлгэгчийн маань хадан дээр та нар сууриа тавих ёстойг санагтун.” Хүүхдүүдийг энэ долоо хоногт шүлгийг бүхэлд нь цээжлэхийг уриал.
2. Итгэлийн Тунхгийн дөрөвдүгээрийг давтаад, үүнийг цээжлэхэд нь хүүхдүүдэд тусал. Сайн мэдээний зарчмууд болон ёслолууд нь биднийг амьдралаа Есүс Христийн суурин дээр барихад хэрхэн тусалдгийг тэдэнд ойлгоход нь тусал.

Дүгнэлт

Гэрчлэл

Аврагчийн тухай болон таны амьдрал дахь түүний нөлөөллийн тухай гэрчлэлээ хуваалц. Таны гэрчлэл танд хэрхэн Сатаны уруу таталтуудын эсрэг зогсох хүч тэнхээ болон хүч чадал өгдгийг ярь. Есүс Христийн сургаалуудаар амьдрах болон үргэлжид түүнтэй илүү адил болохыг хичээхийг сонгосноороо түүнийг амьдралынхаа суурь болгохыг хүүхдүүдэд уриал.

Зөвлөмж

Болгогдсон

Гэрийн Уншлага

Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ Хиламан 5:12-ыг судлахыг зөвлө.

Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.

Зорилго

Тэнгэрлэг Эцэг Аврагчийн тухай бидэнд зааж, нүглээ наманчлахад тусалж мөн ирээдүйд болох зүйлүүдийн талаар сануулан сэрэмжлүүлэхээр бошиглогчдыг илгээдэг гэдгийг хүүхдүүдэд заана.

Бэлтгэл

1. Хиламан 6:18–23 болон 7–9-ийг залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii-ыг үз).
2. Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго.
3. Шаардлагатай материалууд:
 - а. Хүүхэд бүрт Мормоны Ном.
 - б. Хичээлийн төгсгөл дэх таван ширхэг хөлийн мөр. Хөлийн мөр тус бүр дээр дараах үгсийг бич: Бошиглогчийг, дага, тэр, замыг, мэддэг.
 - в. Амьд бошиглогчийн хэлсэн үгнээс нэг хувийг (*Ensign* буюу олон улсын сэтгүүлүүдийн нэг чуулганы дугаараас).
 - г. Амьд бошиглогчийн зураг.

**Хичээл Заах
Зөвлөмж**

Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.

**Анхаарал Татах
Ажиллагаа**

Хичээлийн өмнө ангийн шалан дээр хоосон талыг нь дээш харуулан, дараалалгүйгээр цаасан хөлийн мөрүүдээ наадаг туузаар тогтоо. Хөлийн мөрүүд амьд бошиглогчийн зураг руу хөтөлнө. Хүүхдүүдээс хөлийн мөрийг дагаж, хөлийн мөрүүдийг цуглуулан, тэдгээрийг зөв байрлалд оруулахыг хүс. Ангийнхнаар түүн дээр бичигдсэн үгсийг чангаар уншуул. Хэрэв бид эдгээр үгсийг дуулгавартай дагавал бид үнэнийг мэдэж, хууралтаас зайлсхийж чадна гэдгийг тайлбарла. Энэ хичээл нь бошиглогч Хиламаны хүү Нифайн тухай болохыг тайлбарла. Нифай хэргийн газар байгаагүй мөртлөө аллага болсон, мөн алуурчин нь хэн болохыг мэдсэн. Хүүхдүүд бошиглогч Нифайн талаар илүү ихийг сурснаар тэд амьд бошиглогчийн үгэнд итгэх итгэлээ хүчирхэгжүүлж чадна гэдгийг тэдэнд хэл.

Судрын Хэсэг

Хиламан 7–9-өөс Нифайн сэрэмжлүүлэг болон тохиолдсон явдлуудын тухай хэсгийг хүүхдүүдэд заа. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii-аас үз.) Тэнгэрлэг Эцэг Аврагчийн тухай бидэнд зааж, аз жаргалыг олж авахад тусалж, нүглээ наманчлахад тусалж, мөн ирээдүйд болох зүйлүүдийн талаар бидэнд сануулан сэрэмжлүүлэхээр бошиглогчдыг илгээдэг гэдгийг онцол.

Ярилцлага ба
Тавьж Болох
Асуултууд

Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншнаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.

- Гадионтоны дээрэмчид гэж хэн байсан бэ? (Хиламан 6:18.) Энэ бүлэглэл ямар тангараг тавьсан бэ? (Хиламан 6:21–22.) Гадионтоны дээрэмчид бусармаг ямар зүйлүүд үйлдсэн бэ? (Хиламан 6:23.)
- Хүмүүсийн бусармаг байдлаас болж Нифай юу хийсэн бэ? (Хиламан 7:6–7, 10.) Түүнийг цамхаг дээр байгааг хараад хүмүүс яасан бэ? (Хиламан 7:11–12.)
- Нифай хүмүүст юу хэлсэн бэ? (Хиламан 7:13–18.) Тэр яагаад наманчлалын талаар ярьсан гэж та нар бодож байна вэ? Нүглээ наманчлахын тулд бид юу хийх ёстой вэ?
- Хэрэв хүмүүс нүглээ наманчлахгүй бол тэдэнд юу тохиолдоно гэж Нифай хэлсэн бэ? (Хиламан 7:19, 22.) Эдгээр зүйлсийг тохиолдоно гэдгийг Нифай хэрхэн мэдсэн бэ? (Хиламан 7:29.) Хэрэв бид нүглээ наманчлахгүй бол бидэнд юу тохиолдоно гэж бусад бошиглогчид хэлсэн бэ? Бид бошиглогчдын үгсийг анхаарвал, тамын үүд бидний өмнө байхгүй байж Их Эзэн бидний сайн сайхны төлөө тэнгэрийг чичрээх болно хэмээн Их Эзэн хэлсэн (СбаГ21:4–6-г үз)
- Шүүгчид Нифайн сургаал номлолуудад хэрхэн хариулсан бэ? (Хиламан 8:1.) Зарим хүмүүс Нифайг яаж хамгаалсан бэ? (Хиламан 8:7–9.) Үнэний төлөө зогсоход заримдаа яагаад эр зориг хэрэгтэй болдог вэ? Бид амьд бошиглогчдыг дэмжихийн тулд юу хийж чадах вэ?
- Бүх ариун бошиглогчид юун тухай бошиглосон бэ? (Хиламан 8:14–16.) Амьд бошиглогч бидэнд Есүс Христийн тухай юу заасан бэ? (Та Есүсийн тухай амьд бошиглогчийн өгсөн ярианаас товч хуваалцаж болно.)
- Нифай хүмүүст шүүгчийнх нь талаар юу хэлсэн бэ? (Хиламан 8:27–28.) Нифай юу тохиолдсоныг хэрхэн мэдсэн бэ?
- Таван эр шүүгчийн суудал руу гүйж байхдаа юун тухай бодож байсан бэ? (Хиламан 9:2.) Тэр таван эр эцсийн эцэст Нифайн бүх үгэнд итгэсэн гэдгийг бид хэрхэн мэдэх вэ? (Хиламан 9:4–5, 39.) Бид амьд бошиглогчийн тухай гэрчлэлээ хүчирхэгжүүлэхийн тулд юу хийж чадах вэ?
- Бусад шүүгчид Нифай бол хуурамч бошиглогч гэдгийг хүмүүст хэрхэн итгүүлэхийг оролдсон бэ? (Хиламан 9:16.) Тэдний цээрлэлд өгсөн Нифайн хариулт юу байсан бэ? (Хиламан 9:25–35.)
- Нифайн хүлээн авсан илчлэлт зарим хүмүүст ямар нөлөө үзүүлсэн бэ? (Хиламан 9:39–41.) Бошиглогчдыг дагаснаараа та нар хэрхэн адислагдсан бэ? Та хүүхдүүдэд бошиглогчийн үүргийг ойлгоход нь тусалж баяжуулах үйл ажиллагаа 3-ыг ашиглаж болно.



**Баяжуулах Үйл
Ажиллагаа**

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно.

1. Хүүхдүүдээр Хиламан 8–9-ийн хэсгийг жүжигчлэн тоглуул.
2. Ахлагч Жэймс И. Фаустын дараах мэдэгдлийг уншиж ярилц.
“Сүмийн Ерөнхийлөгч Сүмийн илчлэгчийнхээ хувьд бид бүгдийн төлөөх удирдамжийг хүлээн авна гэж бидэнд амлагдсан билээ. Бидний аюулгүй байдал түүний хэлснийг хир анхаарч, зөвлөгөөг нь дагахаас хамаарна” (Conference Report, Oct. 1989, p. 11, or *Ensign*, Nov. 1989, p.10, see also D&C 21:4–6).
3. Хожмын үеийн бошиглогчид хэрхэн Тэнгэрлэг Эцэгээс мэдлэгийг үргэлжлүүлэн илчилсээр байгааг ярилц. Мэргэн Ухааны Үг (С ба Г 89-г үз) зэрэг хожмын үеийн илчлэлүүдийн жишээнүүдээс, мөн эдгээрийг дагадаг хүмүүсийн амьдралыг тэдгээр нь хэрхэн адислагдгийн зарим жишээнүүдийг өг. Сүүлийн чуулганы ярианаас амьд бошиглогчийн үгсийг уншиж өг (олон улсын сэтгүүлүүдийг үз). Хүүхдүүдээс бошиглогчийн зөвлөгөөг дагаснаараа хэрхэн адислагдаж болохыг асуу.
4. Итгэлийн тунхгийн есдүгээрийг давтаад, үүнийг цээжлэхэд нь хүүхдүүдэд тусал.

Дүгнэлт

Гэрчлэл	Амьд бошиглогч болон түүний заасан зүйлийн үнэний тухай гэрчлэлээ ярь. Та бошиглогчийн сургаалуудыг дагаснаараа хэрхэн адислагдаснаа хүүхдүүдэд хэл.
Зөвлөмж Болгогдсон Гэрийн Уншлага	Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ Хиламан 8:25–28, 9-ийг судлахыг зөвлө. Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.



Нифай Агуу Их Хүч Чадлыг Хүлээн Авсан

Зорилго

Пристийн Зэргийн хүч чадал, эрх мэдлээр Есүс Христ өөрийн дагагчид болон сүмээ удирдаж адисладаг гэдгийг хүүхдүүдэд заана.

Бэлтгэл

1. Хиламан 10-ыг залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii-ыг үз).
 2. Нэмэлт уншлага: Хиламан 11:1–18.
 3. Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго.
 4. Шаардлагатай материалууд: Хүүхэд бүрт Мормоны Ном
-

**Хичээл Заах
Зөвлөмж**

Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.

Анхаарал Татах
Ажиллагаа

Гэрэл асаахгүйгээр хичээлээ эхэл. Хүүхдүүдээс ямар нэгэн ер бусын зүйл анзаарсан эсэхийг нь асуу. Хэн нэгнээс гэрэл асаахыг хүс. Гэрэл өгдөг цахилгаан эрчим хүчний тухай ярь. Хүүхдүүдийн гэрт цахилгаанаар ажилладаг юу байдгийг ярилц (зуух, хөргөгч, сэнс, багаж хэрэгсэл гэх мэт). Энэ хичээл нь хүчний өөр нэгэн төрөл, цахилгаанаас илүү хүчтэй хүч болох Бурханы пристийн пэргийн хүч чадлын тухай гэдгийг тайлбарла.

Хоёрдогч Үйл
Ажиллагаа

Цахилгаан гэрэлгүй өрөөний талаар баяжуулах үйл ажиллагаа 1-ийг үз.

Судрын Хэсэг

Хиламан 10-аас Нифай Тэнгэрлэг Эцэгийн ажлыг хийхийн тулд холбох хүч болон пристийн зэргийн хамгаалалтыг хүлээн авч байгаа хэсгийг хүүхдүүдэд заа. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii-аас үз.)

Ярилцлага ба
Тавьж Болох
Асуултууд

Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншнаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.

- Нифай гэр лүүгээ харьж явах замдаа юу хийсэн бэ? (Хиламан 10:2–3.) Эргэцүүлэн бодно гэдэг нь юу гэсэн үг вэ? (Бодох, эсвэл гүнзгий эргэцүүлэх.) Бид юун тухай эргэцүүлэн бодох ёстой вэ?
- Нифайчуудад сайн мэдээг тунхаглан хөдөлмөрлөж байхдаа Нифайн зориг яагаад мөхсөн бэ? (Хиламан 10:3.)
- Нифайд Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христэд таалагддаг юу байсан бэ? (Хиламан 10:2–3.) Бид тэдгээрийг хэрхэн таашаах ёстой вэ?

- Есүс Христ Нифайд ямар адислалуудыг амласан бэ? (Хиламан 10:5.) Нифай “Христийн хүслийн эсрэг” ямар ч зүйлийн төлөө залбирахгүй гэдэг нь юу гэсэн үг вэ? Бид Есүс Христийн хүслийг хэрхэн дагаж сурах вэ?
- Нифайд юу хийх хүч өгөгдсөн бэ? (Хиламан 10:6–10.)
- Нифайд өгөгдсөн холбох хүч нь юу вэ? (Хиламан 10:7 ба С ба Г 132:7-г үз.) Пристийн зэргийн энэ холбох хүч нь биднийг өнөөдөр хэрхэн адислаж байна вэ? (Ариун сүмд гэр бүлүүд маань мөнхөд хамтдаа холбогдож чадна.) Та нарын гэр бүл мөнхөд хамтдаа амьдарч чадна гэдгийг мэдэх нь та нарт ямар санагдаж байна вэ? (Хүүхдүүдийн хэн нэг нь ариун сүмд холбогдсон бол та тэднээс гэр бүлийнхэнтэйгээ холбогдож байхдаа ямар сэтгэгдэлтэй байсныг нь яриулахыг хүсч болно.)
- Нифайд Их Эзэн хүмүүст юу хэлэхийг тушаасан бэ? (Хиламан 10:11.) Их Эзэн түүнд хандан ярьж дуусахад Нифай дуулгавартай байдлаа хэрхэн үзүүлсэн бэ? (Хиламан 10:12.) Ямар ямар аргаар Их Эзэн бидэнтэй ярьдаг вэ? Бид дуулгавартай байдлаа хэрхэн үзүүлж чадах вэ?
- Шүүгчийг алуулсан тухай Нифайн илчлэлт Нифайчуудын амьдралыг яагаад өөрчлөөгүй вэ? (Хиламан 10:13.)
- Нифай эдгээр хүмүүст Бурханы үгийг тунхаглаж байхдаа хэрхэн хамгаалагдсан бэ? (Хиламан 10:15–17.) “Бурханы хүч Нифайтай байсан” гэдэг нь ямар утгатай гэж та нар бодож байна вэ? Пристийн зэрэг нь өнөөдөр биднийг хэрхэн адислаж, хамгаалж байна вэ?
- Нифайн заасан сургаал номлолууд эдгээр хүмүүст хэрхэн нөлөө үзүүлсэн бэ? (Хиламан 10:18.)
- Пристийн зэргийн хүч чадлаар та нар болон та нарын гэр бүл хэрхэн адислагдсан бэ?

Баяжуулах Үйл Ажиллагаа

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно.

1. Хүүхдүүдэд нэг үг бодож байгаагаа хэл. Дараах тодорхойлолтуудыг сонсоод, уг үгийг олж мэдэхээрээ гараа өргөхийг Тэднээс хүс.
 - Энэ нь Бурханы хүч.
 - Энэ хүчээр дамжуулан Их Эзэн өөрийн хүүхдүүдийг болон сүмээ адисладаг.
 - Энэ хүчийг атгагчид Их Эзэн, Есүс Христийг төлөөлдөг.
 - Энэ хүчийг атгагчид Аврагчийн хийгдсэн байхыг хүсдэг зүйлүүдийг хийхээр томилогддог.
 - Энэ хүчийг юу гэдэг вэ? (Пристийн зэрэг.)
2. Дараах үгийн хайчилбаруудыг үзүүл: “Дикон”, “Багш”, “Прист”, “Ахлагч”, “Арван хоёр”, “Арван дөрөв”, “Арван зургаа”, “Арван найм”.

Хүүхдүүдийг дараах тодорхойлолтуудыг нэг нэгээр нь уншиж тодорхойлолтонд тохирч байгаа хоёр үгийн хайчилбарыг олж, тэдгээрийг самбар дээр тогтоохыг урь. Тодорхойлолтуудыг дараалалгүй уншвал

арай том хүүхдүүдэд илүү хэцүү байх болно. (Аароны Пристийн Зэргийн үүрэг хариуцлагын тодорхойлолтыг С ба Г 20:46–59-өөс авсан ба Мелкизэдэкийн Пристийн Зэргийн ахлагчийн албанд зориулсан тодорхойлолтыг С ба Г 20:38–45, 107:11–12-оос авсан болно.)

- а. Би надад олгосон Аароны Пристийн Зэрэгтэй. Би ариун ёслолыг түгээдэг. Би пристийн зэрэгтний удирдагчдын элч болж үйлчилдэг. Би мацгийн өргөл цуглуулдаг. Би Сүмийн барилга байгууламж болон талбайг харж хандахад тусалдаг. Би хэн бэ? Би томилогдох үедээ хэдэн настай байх вэ? (Үгийн хайчилбарууд: “Дикон”, “Арван хоёр”)
- б. Би Аароны Пристийн Зэрэгтэй. Надад туслагчийн бүх үүрэг хариуцлага болон хүч байдаг ба би ариун ёслолын талх усыг бэлддэг. Би гэрийн багшаар томилогдож болно. Би хэн бэ? Би томилогдох үедээ хэдэн настай байх вэ? (Үгийн хайчилбарууд: “Багш”, “Арван дөрөв”)
- в. Би Аароны Пристийн Зэрэгтэй. Надад туслагч болон багшийн бүх үүрэг хариуцлага болон хүч байдаг ба би ариун ёслолыг гүйцэтгэдэг (адисладаг). Надад усаар батлах эрх мэдэл байгаа ба бусад Аароны Пристийн Зэрэгтнүүдийг томилох ёслолд тусалдаг, Мелкизэдэк Пристийн Зэрэг атгагч байхгүй үед цуглаануудыг удирддаг. Би Сүмийн гишүүдэд зарлигуудын дагуу амьдрахад нь тусалдаг. Би хэн бэ? Би томилогдох үедээ хэдэн настай байх вэ? (Үгийн хайчилбарууд: “Прист”, “Арван зургаа”)
- г. Мелкизэдэк Пристийн Зэрэгтэй. Би бүрэн цагийн номлолд үйлчилж болно. Би зааж, тайлбарлаж, уриалж, усаар баталж, Сүмийг харж байхаар дуудагдсан. Би Ариун Сүнсний бэлгийг өгч, цуглааныг удирдаж, жаахан хүүхдүүдийг адислаж, өвчтөнийг адислаж, гэр бүлийн гишүүдийг адислаж болно. Би хэн бэ? Би томилогдох үедээ хэдэн настай байх вэ? (Үгийн хайчилбарууд: “Ахлагч”, “Арван найм”)

Эдгээр дөрвөн пристийн зэргийн албан үүрэг хариуцлагын талаар сурсан нэг зүйлээ нэрлэхийг хүүхдүүдээс хүс.

3. Пристийн зэргийн хүч чадлын тухай дараах түүхийг ярь:

Ахлагч Хью Б. Браун Арван Хоёр Төлөөлөгчийн Чуулганы гишүүн байсан. Ахлагч Браун залуу байхдаа Канадын армид офицер байсан ба Дэлхийн Нэгдүгээр Дайнд Английн хааны төлөө тулалдахаар явсан байлаа.

Ахлагч Браун хааны өмнөөс олон зүйлийг хийх хүч чадалтай байсан учраас түүнд хааны офицер байх нь таалагддаг байлаа.

Нэгэн өглөө Ахлагч Брауны утас дуугарав. Эмнэлэгт хэвтэж байсан нэг байлдагч Ахлагч Брауныг ирж, түүнтэй уулзахыг хүсэв. Эмнэлэгт байсан олон байлдагч Ахлагч Брауныг тэдэн дээр ирэхийг хүсдэг байлаа. Тэд түүнийг офицер учраас тэднийг гэр лүү нь илгээх хаанаас өгөгдсөн хүч чадалтай гэдгийг мэдэж байв. Ахлагч Браун эмнэлэг рүү явж байхдаа офицерийн хувьд түүнд байгаа хүч чадлын тухай бодож байлаа. Тэр хааны өмнөөс ярьж мөн байлдагчдыг үлдээх, эсвэл гэр лүү нь явуулахыг шийдэж байгаадаа сэтгэл хангалуун байв.

Ахлагч Брауныг нөгөө байлдагчийн өрөөнд ороход тэр түүнээс гэр лүү нь явуулж өгөхийг хүссэнгүй. Үүний оронд тэр “Браун ахаа, та надад

адислал өгч болох уу? Би үхнэ гэхээс айж байна. Та намайг амьд байлгахыг Бурханаас гуйж өгөхийг хүсч байна” гэж хэлэв.

Ахлагч Браун гайхав. Тэр байлдагч түүнийг офицер учраас, мөн хааны ажлыг хийдэг учраас ирүүлээгүй байлаа. Байлдагч түүнийг пристийн зэрэгтэй, мөн Тэнгэрлэг Эцэгийн ажлыг хийж чаддаг учраас түүнийг ирүүлжээ. Ахлагч Браун хааны хүч чадал байлдагчийн амийг аварч чадахгүй гэдгийг мэдэж байв. Байлдагчийг аврахын тулд Тэнгэрлэг Эцэгийн хүч чадалтай байх хэрэгтэй. Тэр гараа байлдагчийн толгой дээр тавьж түүнд адислал өгч байхдаа маш их даруу байдлыг мэдрэв.

Ахлагч Браун эмнэлгээс явахдаа офицерийнхаа хүч чадлын тухай бодоогүй. Тэр пристийн зэргийнхээ хүч чадлын тухай бодож байлаа. Тэрээр эрэгтэйчүүд дэлхий дээр Тэнгэрлэг Эцэгийн ажлыг хийхийн тулд пристийн зэрэгтэй байх ёстой гэдгийг мэдсэн. Тэр пристийн зэрэгтэй байж Бурханы ажлыг хийж чадаж байгаадаа маш их баяртай байлаа. (Хью Б. Браун, *Continuing the Quest*, p. 26–27.)

4. Хүүхэд бүрт дараах, эсвэл үүнтэй адил пристийн зэрэгтэй хүмүүс пристийн зэргээ ашиглаж байгаа зургуудын нэгийг өг. (Та зургуудыг цуглааны байрны номын сангаас авч болно.) Хүүхдүүдийг зургуудаа үзүүлээд, зураг бүрт ямар ёслол гүйцэтгэгдэж байгаа болон уг хүү ба эрэгтэй хүн нь пристийн зэргийн ямар албыг атгадаг болохыг дүрслэн хэлэхийг урь.
 - Усаар Батлуулж Буй Хүү (62018)
 - Батлуулж Байгаа Охин (62020)
 - Ариун Ёслол Түгээж Байгаа нь (62021)
 - Пристийн Зэргийн томилот (62341)
 - Өвчтөнд Үйлчлэл Үзүүлж Байгаа нь (62342)
 - Ариун Ёслол Адислаж Байгаа нь (62343)
5. Прист болон багш нар нь ахлагч нараар томилогддогийг тайлбарладаг Моронай 3-ыг уншиж ярилц.
6. Итгэлийн тунхгийн тав, зургадугаарыг уншиж ярилц. Эдгээр итгэлийн тунхгийг цээжлэхэд нь хүүхдүүдэд тусал.
7. “Пристийн Зэрэг Сэргээгдлээ” дууг дуулах, эсвэл үгийг нь унш (*Хүүхдийн Дууны Ном*, х. 57).

Дүгнэлт

Гэрчлэл	Өөрийн амьдрал дахь пристийн зэргийн хүч чадлын адислалын талаарх гэрчлэлээ хуваалц. Хүүхдүүдийг амьдралд нь пристийн зэрэг адислал болсон тохиолдлуудыг хуваалцахыг урь.
Зөвлөмж Болгогдсон Гэрийн Уншлага	Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ Хиламан 10:1–12-ыг судлахыг зөвлө. Хаалтын залбирал хийх хүүхдийг урь. Тайлбар: Хэрэв та дараагийн долоо хоногийн хичээлд анхаарал татах үйл ажиллагааг ашиглахаар шийдэж байгаа бол ангийн гурван гишүүнд жүжигчлэн тоглолт хийхийг урьдчилан даалга.

Зорилго Бошиглогчид Есүс Христийн амьдрал ба үүргийг урьднаас хэлж байсныг хүүхдүүдэд заана.

- Бэлтгэл**
1. Хиламан 13–14-ыг залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii-ыг үз).
 2. Нэмэлт уншлага: Хиламан 15
 3. Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго.
 4. Шаардлагатай материалууд:
 - а. Хүүхэд бүрт Мормоны Ном.
 - б. Нифай, Абинадай болон Алмагийн бошиглалуудын ишлэлтэй гурван хөзөр (Анхаарал татах ажиллагааг үз)
 - в. Хүүхдүүдэд Нифай, Абинадай болон Алмагийн дүрд тоглоход нь ашиглах хүзүүний ороолт, хүрэм, эсвэл нэрийн тэмдэг зэрэг туслах зүйлс.
 - г. Зураг 4-42, Ламанчуудын Самуэл Хэрмэн Дээр (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 314, 62370).

**Хичээл Заах
Зөвлөмж**

Анхаарал Татах
Ажиллагаа

Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.

Ангиасаа сайн уншдаг гурван хүүхдийг Нифай, Абинадай болон Алмагийн дүрд тоглуул. Тэд тус бүртээ нэрийн тэмдэг, эсвэл хэсэгчилсэн хувцастай байж болно. Тэд цаг үеийн машинаар ангид зочилж Есүс Христийн амьдрал ба үүргийн тухай өөрсдийн гэрчлэлийг дахин ярихаар ирсэн мэт үзүүлж болно.

“Би Христийг төрөхөөс бараг 600 жилийн өмнө амлагдсан газар ирсэн. Би өөрийн хүмүүстээ Христийн мэндэлсэн тухай болон үхлийнх нь тухай надад заасан үзэгдлийн талаар ярьсан. ‘Онгон бүсгүйг дахин харж гар дээрээ хүүхэд тэврэн байхыг болгоов. Мөн сахиулсан тэнгэр надад хандан: Бурханы Хургыг болгоогтун, гэж хэлэв.’ Тэгэхэд би ‘Тэрбээр энэ дэлхийн гэм нүглүүдийн тул загалмайд өргөгдөн алагдсаныг үзсэн’ (1 Нифай 11:20–21, 33). Би хэн бэ?” (Нифай.)

“Би Есүс Христээс 150 жилийн өмнө амьдарч байсан. Хүмүүс надад дургүй байсан ба миний тэдэнд хэлсэн зүйлүүдэд маань итгээгүй. Би Есүс Христ ‘хүмүүний үрсийн дунд доош ирэх болно . . . цовдлогдон, алагдах болно, өөр дээрээ тэдний гэмүүдийг авч тэднийг гэтэлгэсэн’ гэдгийг би бошиглосон. (Мозая 15:1, 7, 9) Би гэрчлэлийнхээ төлөө шон дээр шатаагдсан. Би хэн бэ?” (Абинадай.)

“Есүс Христийг төрөхөөс ойролцоогоор 100 жилийн өмнөх нэгэн онцгой үзэгдлийн дараа би зөвхөн тэр ирэх Гэтэлгэгчээрээ дамжуулан авраг-

дах болно гэдгийг мэдсэн. Би ‘Бурханы Хүү нь . . . бүх төрлийн өвчин, зүдгүүрүүд, уруу таталтуудыг тэвчин явах болно. Тэр үхлийг өөр дээрээ авах болно, тэр өөрийнх нь хүмүүсийг багладаг тэр үхлийн хүлээсийг тайлж тэдний сул дорой чанаруудыг авах болно’ гээд сурч мэдсэнээ хүмүүст хэлэхээр газар сайгүй явсан (Алма 7:10–12). Би хэн бэ?” (Алма.)

Зөвхөн энэ гурван бошиглогч Есүс Христийн тухай бошиглоод зогсоогүй бусад бүх бошиглогчид ч бас ингэсэн гэдгийг тайлбарла. Мозая 13:33 дахь “Мозэс тэдэнд Мессиагийн ирэлтийн талаар, мөн Бурхан өөрийн хүмүүсийг гэтэлгэх ёстойг бошиглоогүй гэж үү? Тийм ээ, мөн дэлхий эхэлснээс хойш бошиглож байсан бүр бүх бошиглогчид—тэд эдгээр зүйлийн талаар их бага боловч ярьсан бус уу?” Энэ хичээл дээр тэд агуу их эр зоригтойгоор зааж байсан өөр нэгэн чухал бошиглогч болох Лэмэны Сэмүэлийн тухай болон Христийн мэндэлсэн ба нас барсны тухай, үүргийнх нь хүч чадлын тухай сурах болно гэдгийг тайлбарла.

Судрын Хэсэг

Хиламан 13–14, 16-гаас Лэмэны Сэмүэлийн тухай хэсгийг хүүхдүүдэд заа. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii-аас үз.) Сэмүэл хүмүүст Есүс болон Цагаатгалын тухай зоригтойгоор заасан гэдгийг онцол.

Ярилцлага ба Тавьж Болох Асуултууд

Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншснаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.

- Лэмэны Сэмүэл ямар захиасыг Нифайчуудад илчлэхээр илгээсэн бэ? (Хиламан 13:6–7.) Сэмүэлийн заахаар илгээсэн баяртай мэдээнүүд нь юу байсан бэ? (Хиламан 14:9, 11–13. “Баяртай мэдээнүүд” гэдэг нь “сайн мэдээнүүд”, эсвэл сургаал гэсэн үг гэдгийг тайлбарла.) Есүс Христийн сургаал нь бидэнд яагаад сайн мэдээнүүд болж байна вэ? (Бид нүглээ наманчилж гэм нүглийнхээ өршөөлийг авч чадна.)
- Хэрэв Нифайчууд нүглээ наманчлахгүй бол тэдэнд юу тохиолдоно гэж Сэмүэл хэлсэн бэ? (Хиламан 13:6, 8–10.) Сүнсийг өөрсөдтэйгөө байлгах нь яагаад чухал вэ? Нүглээ наманчлахаа хойшлуулахгүй байх нь яагаад чухал вэ? (Хиламан 13:38.)
- Нифайчууд бошиглогчдын оронд хэнийг дагаж байсан бэ? (Хиламан 13:27–29.) Өнөөдөр хүмүүсийг ямар “тэнэг болон сохор хөтлөгчид” удирдаж байна вэ? Заримдаа бусад хүмүүс биднийг хэрхэн буруу зүйл хийлгэхийг оролддог вэ?
- Хүмүүс яагаад Сэмүэлийн сургаалуудыг эсэргүүцсэн бэ? (Хиламан 14:10.)
- Лэмэны Сэмүэл Хэрмэн Дээр зургийг үзүүл. Сэмүэл яагаад хотын хэрмэн дээр гарсан бэ? (Хиламан 14:11–12.) Таван жилийн дотор юу тохиолдож, ямар тэмдгүүд байх болно гэж Сэмүэл бошиглосон бэ? (Хиламан 14:2–6.) Христийн үхлийн үеийн тэмдгүүд нь юу байна гэсэн бэ? (Хиламан 14:20–28.) Их Эзэн яагаад Нифайчуудад эдгээр тэмдгүүдийг илчилж үзүүлсэн бэ? (Хиламан 14:12–13, 28.)
- Цагаатгалын тухай Сэмүэл юу заасан бэ? (Хиламан 14:15–18.) Цагаатгалын тухай ойлгосноороо бид ямар үүрэг хариуцлагатай болдог вэ? (Хиламан 14:19.) Үйл хэргийнхээ төлөө бид ямар үүрэг хариуцлагатай болдог вэ? (Хиламан 14:30–31.)

- Сэмүэлд итгэдэг Нифайчууд түүнийг номлож дууссаных нь дараа юу хийсэн бэ? (Хиламан 16:1.) Түүнд итгээгүй хүмүүс юу хийсэн бэ? (Хиламан 16:6.) Хүмүүс яагаад бошиглогчдод итгэхгүй байхыг сонгодог гэж та нар бодож байна вэ? Бошиглогчдын тухай гэрчлэлээ хүчирхэгжүүлэхийн тулд бид юу хийж чадах вэ?

Баяжуулах Үйл Ажиллагаа

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно

1. Амьд бошиглогчийн өгсөн саяхны зарим нэг яриануудыг ол (ялангуяа олон улсын сэтгүүлүүдийн чуулганы дугааруудыг үз). Яриануудаас зарим хэсгийг нь уншаад, хүүхдүүдээр өнөөдөр бошиглогч тэдэнд юу хийхийг нь зааж байгааг олуул. Хүүхдүүдийн хариултыг самбарт бич. Хүүхэд бүрээр дагахыг хүсч байгаа нэг зарчмыг сонгуулаад үүнийг тэмдэглэлийн цаасан дээр бичүүл.
2. Самбар дээр “Христ Мэндэлсний Тэмдгүүд” болон “Христийн Нас Барсны Тэмдгүүд” гэсэн гарчигтай хоёр багана бэлд. Энэ хичээл дээр яригдсан Есүс Христийн төрсний болон нас барсны бүх тэмдгүүдийг тусдаа цааснууд дээр бичиж хооронд нь хольж жижиг саванд хий. Хүүхдүүдийг ээлж ээлжээр нь нэгийг сугалуулж уншуулаад хоёр багананы нэгнийнх нь дор байрлуул.

Христ Мэндэлсний Тэмдгүүд (Хиламан 14:2–6.)

Тэнгэрт агуу их гэрлүүд байх болно

Шөнө нь харанхуйлахгүй ба өдөр мэр байх болно

Шинэ од

Тэнгэрт олон тэмдгүүд болон гайхамшгууд

Христийн Нас Барсны Тэмдгүүд (Хиламан 14:20–28.)

Нар, сар, одод харанхуйлах болно

Гурван өдөр гэрэлгүй байна

Олон цагийн турш тэнгэр дуугарч, цахилгаан цахина

Газар доргиж, чичирнэ

Хад чулуу бутарч хагарна

Аймшигт шуурга

Уулс тэгширнэ

Хөндийнүүд уулс болно

Замууд эвдэрнэ

Хотууд эзгүйрнэ

Булшнууд нээгдэж үхэгсдийнхээ олныг нь чөлөөлнө

3. Итгэлийн тунхгийн зургаа, долоо, есдүгээрийг цээжил.

Дүгнэлт

Гэрчлэл

Эртний болон одоогийн, аль аль үеийн бошиглогчдын бидэнд хэлсэн зүйлсийн үнэний тухай гэрчлэлээ хуваалц.

Зөвлөмж

Болгогдсон

Гэрийн Уншлага

Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ Хиламан 14:1–14, 20–31-ийг судлахыг зөвлө.

Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.

Есүс Христийн Мэндэлсний Америк дахь Тэмдгүүд

Хичээл
32

Зорилго

Бид итгэлтэй байвал тэмдгүүд нь Есүс Христийн тухай бидний гэрчлэлүүдийг хүчтэй болгож чадна гэдгийг хүүхдүүдэд заана.

Бэлтгэл

1. 3 Нифай 1-2-ыг залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii-ыг үз).
 2. Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго.
 3. Шаардлагатай материалууд:
 - а. Хүүхэд бүрт Мормоны Ном.
 - б. Энэ хичээлийн төгсгөлд хавсаргасан үзүүлэн (эсвэл та самбарт энгийн зураг зурж болно).
-

Хичээл Заах Зөвлөмж

Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.

Анхаарал Татах
Ажиллагаа

Та олон жилийн өмнө болсон нэгэн үйл явдлын тухай зарим түлхүүр үгсийг өгөх гэж байгаагаа хүүхдүүдэд хэл. Түлхүүр үгс нь ямар үйл явдлыг дүрсэлж байгааг мэдэж байвал тэднээс гараа өргөхийг хүс. Хүүхдүүдийг ангийн урд гарч ирээд таны тэдэнд тарааж өгсөн дараах зүйлсийн зургуудыг (хичээлийн төгсгөл дэх үзүүлэнг үз) барихыг урь:

Тэнгэрийн элч
Хоньчны таяг
Илжиг
Од
Тэвш
Нялх хүүхэд

Хүүхдүүдэд тэр үйл явдал нь Есүс Христийн төрөлт юм гэдгийг таалгахаар одыг үзүүлэхээр үлдээ. Энэ хичээл дээр Иерусалимаас алс хол орших хүмүүс Аврагчийн мэндэлсний тэмдгүүдийг ажиглаж, од харсан тухай заах болно гэдгийг тайлбарла.

Судрын Хэсэг

3 Нифай 1–22-оос Христийг мэндлэх үед Зарахемлад байсан хүмүүсийн тухай хэсгийг хүүхдүүдэд заа. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii-аас үз.) Энэ хэсэг дэх Нифай бол Хиламаны хүү болох Нифайн хүү гэдгийг тайлбарла.

Ярилцлага ба
Тавьж Болох
Асуултууд

Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншнаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.

- Лэмэны Сэмүэлийн бошиглолын тухай зарим хүмүүс юу ярьсан бэ? (3 Нифай 1:5–6.) Итгэгчид үл итгэгчдэд хэрхэн хариу үзүүлсэн бэ? (3 Нифай 1:7.)
- Тэд ямар тэмдэг хайж байсан бэ? (3 Нифай 1:8.) Тэдний туйлбартай байдал бидэнд тэдний итгэлийн тухай юу заасан бэ?
- Үл итгэгчид итгэдэг тэдгээр хүмүүсийг юу гэж заналхийлсэн бэ? (3 Нифай 1:9.) Зарим хүмүүс яагаад Бурханд итгэдэг тэдгээр хүмүүст уурласан гэж та нар бодож байна вэ?
- Хүмүүсийн бусармаг байдлыг хараад Нифай юу хийсэн бэ? (3 Нифай 1:12.) Нифайн залбирлын хариу юу байсан бэ? (3 Нифай 1:13–14.) Есүс Христ яагаад дэлхийд ирнэ гэж хэлсэн бэ?
- Бошиглол хэрхэн биелсэн бэ? (3 Нифай 1:15, 19.) Бошиглолын биелэгдсэн тэмдгүүдийг хараад үл итгэгчид яагаад айсан бэ? (3 Нифай 1:18.) Хэрэв та нар тэнд байсан бол ямар мэдрэмжтэй байх байсан бэ?
- Бетлехемд үзэгдсэн ямар тэмдгийг Нифайчууд бас харсан бэ? (3 Нифай 1:21.)
- Сатан хүмүүсийг тэмдгүүдэд итгэхээс холдуулахыг оролдож юу хийсэн бэ? (3 Нифай 1:22.) Хүмүүс Их Эзэнд өөрсдийнхөө итгэлийг хэрхэн үзүүлсэн бэ? (3 Нифай 1:22–23.)
- Хүмүүсийн итгэл болон зөв шударга байдал доройтоход шалтгаалсан ямар зүйл тохиолдсон бэ? (3 Нифай 1:29–30.) Эцэг эхийнхээ зөв шударга жишээ болон сургаалуудыг дагах нь яагаад чухал вэ? Та нар эцэг эхдээ дуулгавартай байснаараа хэрхэн адислагддаг вэ?
- Өөрсдийн харсан олон тэмдгүүдэд хүмүүсийн хандах хандлага ямар байсан бэ? (3 Нифай 2:1–2.) Тэмдгүүд дээр үндэслэгдсэн гэрчлэлүүдийн хүчийн талаар бид юу сурч болох вэ? Бид гэрчлэлээ хүчирхэгжүүлэхийн тулд юу хийж чадах вэ?
- Нифайчуудын үл итгэсний үр дүн нь юу байсан бэ? (3 Нифай 2:3, 11.) Зөв шударга Нифайчууд болон Лэмэнчүүд өөрсдийгөө хамгаалахын тулд юу хийсэн бэ? (3 Нифай 2:12.) Сүмийн бусад гишүүдтэй хамтдаа байж Тэнгэрлэг Эцэгийг шүтэх нь биднийг илүү хүчирхэг болж өсөхөд хэрхэн тусалж чадах вэ?
- Бусармаг байдлаас нь болж эцэст нь хүмүүст юу тохиолдсон бэ? (3 Нифай 2:17–19.)
- Есүс Христийн хоёр дахь дахин ирэлтийн тухай бошиглол нь биелэгдэх болно гэдгийг та нар хэрхэн мэддэг вэ? (3 Нифай 1:20.)
- Есүс Христийг дахин ирэхэд дэлхий ямар байх болно гэж та нар бодож байна вэ? Түүнийг ирэхэд та нар ямар хүн байхыг хүсч байна вэ? Бид Хоёр Дахь Ирэлтэнд бэлтгэхийн тулд одооноос юу хийж чадах вэ?




Баяжуулах Үйл Ажиллагаа

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно

1. Өмнөх хичээлүүдээс мэдэж авсан итгэлгүй хүмүүсийн нэрсийг нэрлэхийг хүүхдүүдээс хүсээд, тэдний гэрчлэлд нөлөөлсөн тэмдгүүдийн талаар ярилц. Хүүхдүүдэд тусламж хэрэгтэй бол дараах жишээнүүдийг ашигла.
Лэмэн, Лэмүэл хоёр (1 Нифай 3:28–31, 17:45)
Шерим(Иаков 7:13–20)
Корихор (Алма 30:43–56)
2. Хүүхдүүдээр тэд гэрийн багш, эсвэл айлчлагч багш гэж төсөөлүүл. Тэднээр Есүс Христийн тухай гэрчлэлдээ хүчтэй байхад туслах юуг хүмүүст зааж болохыг сайн дураар нь яриул.
3. Хүүхдүүдэд 3 Нифай 1:20-ийг цээжлэхэд нь туслаад үүнийг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлэхийг ярилц.
4. Хүүхдүүдэд итгэлийн тунхгийн аравдугаарыг цээжлэхэд нь тусал.

Дүгнэлт

Гэрчлэл	Тэнгэрлэг Эцэг хийгдсэн бүх бошиглолуудыг биелүүлэх болно гэсэн гэрчлэлээ хуваалц. Зөв шударга амьдарч, Аврагчийг дахин ирэхэд түүнтэй уулзахдаа бэлэн байхын чухлыг онцол.
Зөвлөмж Болгогдсон Гэрийн Уншлага	Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ 3 Нифай 1: 4–15, 19–22-г судлахыг зөвлө. Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.



Аврагч Нифайчууд Дээр Ирсэн нь

Хичээл
33

Зорилго	Хүүхэд бүрийн Есүс Христ бол Бурханы Хүү, тэр бидний Аврагч мөн тэр өнөөдөр амьд гэсэн гэрчлэлийг нь хүчирхэгжүүлнэ.
Бэлтгэл	<ol style="list-style-type: none">3 Нифай 8–11-ийг залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii-ыг үз).Нэмэлт уншлага: 3 Нифай 7Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго.Шаардлагатай материалууд:<ol style="list-style-type: none">Хүүхэд бүрт Мормоны Ном.Зурагнууд: 4-43, Христ Нифайчуудад Үзэгдсэн нь (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 315, 62047); 4-44, Дэлхийн Газрын Зураг; 4-45, Есүс Америк Тивд Сургаалыг Заасан нь (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 316, 62380).
Хичээл Заах Зөвлөмж	Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.
Анхаарал Татах Ажиллагаа	Хүүхдүүдээс хэн нэг нь аймшигтай, хүчтэй шуурганд өртөж байсан эсэхийг нь асуу. Хүүхдүүдээс нэг, эсвэл хоёрыг нь ийм тохиолдлоосоо хуваалцахыг урих, эсвэл та өөрийнхөө тохиолдлоос ярьж болно. Есүс Христ Иерусалимд цовдлогдох үед Америкт аймшигтай шуурга, аймшигт сүйрэл болж байсан гэдгийг тайлбарла. Газрын зураг ашиглан одоо Израил хэмээн нэрлэгдэх болсон түүний амьдарч, нас барсан газрыг үзүүл. Энэ хичээл нь Есүс Христийг үхэх үед Америкт юу тохиолдсон тухай болохыг тайлбарла.
Судрын Хэсэг	Зургуудыг тохиромжтой үед нь ашиглан 3 Нифай 8:5–11:41-ээс Аврагчийн нас барсны тэмдгүүд болон түүний Нифайчууд дээр очсон тухай хэсгийг хүүхдүүдэд заа. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii-аас үз.)
Ярилцлага ба Тавьж Болох Асуултууд	Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншнаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг. <ul style="list-style-type: none">Лэмэны Сэмүэл Аврагчийн үхлийн талаар Нифайчуудад юу бошиглосон бэ? (Хиламан 14:20–27.) Тэр яагаад тэднийг бэлтгэх гэж оролдож байсан бэ? (Хиламан 14:28–29.) Эдгээр бошиглолууд нь хэрхэн биелсэн бэ? (3 Нифай 8:5–25.)

- Хүмүүсийн алагдсан шалтгаан нь юу байсан гэж Аврагч хэлсэн бэ? (3 Нифай 9:2, 12.) Алагдаагүй хүмүүст тэр юу хэлсэн бэ? (3 Нифай 9:13–14.) Христэд ирэх гэдэг нь юу гэсэн үг вэ? Аврагчтай илүү адил болсноороо бид ямар адислалуудыг авах вэ?
- Есүс өөрийнхөө үүргийн талаар хүмүүст юу заасан бэ? (3 Нифай 9:15–17.) Есүс Христ бол Бурханы Хүү гэдгийг мэдэх нь бидэнд яагаад чухал вэ?
- Дэлхий дээр ирсэн шалтгаан нь юу байсан гэж Есүс хэлсэн бэ? (3 Нифай 9:21.) Гэм нүглүүдээсээ аврагдахын тулд бид юу хийх ёстой вэ? (3 Нифай 9:22.) Цагаатгалыг ойлгох нь хүмүүсийг ямар мэдрэмжтэй болгодог бэ? (3 Нифай 10:10.)
- Элбэг Дэлбэгийн газар дахь ариун сүмд байсан хүмүүс тэнгэрээс гарсан дуу хоолойг хэдэн удаа сонссон бөгөөд үүнийг ойлгоогүй вэ? (3 Нифай 11:3–4.) Дуу хоолойг ойлгохын тулд хүмүүс юу хийсэн бэ? (3 Нифай 11:5–6.) “Үүнийг сонсохоор сонороо дэлгэв” гэдэг нь юу гэсэн үг вэ? (Тэнгэрлэг Эцэг биднийг сонсоосой гэж хүсдэг тэр зүйлийг хүлээн авахын тулд бид сонсч мөн бэлэн байх ёстой.)
- Тэнгэрлэг Эцэг бидэнд гурав дахь удаагаа хэлснийг сонсохын тулд хүмүүс юу хийсэн бэ? (3 Нифай 11:6–7.) Эндээс бид ямар чухал зүйлийг сурч болох вэ? (Есүс Христ бол Бурханы Хүү, тэр хоёр бол тус тусдаа оршихуй ба Эцэг нь Хүүдээ хайртай бөгөөд бид Хүүг нь сонсох ёстой гэдгийг сурдаг.) Бид Есүс Христийн үгсийг илүү сайн сонсч ойлгохын тулд юу хийж чадах вэ?
- Хүмүүс тэнгэр өөд хараад юу үзсэн бэ? (3 Нифай 11:8.) Аврагч тэдэнд өөрийнхөө хэн болохыг хэлэхэд хүмүүс яагаад газар унасан гэж та нар бодож байна вэ? (3 Нифай 11:10–12.) Хэрэв та нар тэнд байсан бол ямар сэтгэгдэлтэй байх байсан бэ? Христ яагаад хүмүүсээр биенийхээ шархыг тэмтрүүлсэн бэ? (3 Нифай 11:14–15.)
- Нифайчууд ямар мэдрэмжтэй байсан бөгөөд Аврагчид талархал, хайраа хэрхэн үзүүлсэн бэ? (3 Нифай 11:16–17.) Бид түүнд болон түүний бидний төлөө хийсэн зүйлд хайр ба талархлаа хэрхэн үзүүлж чадах вэ?
- Есүс Христ Нифайд ямар чухал ёслол гүйцэтгэх хүч чадлыг өгсөн бэ? (3 Нифай 11:19–21.) Усан баталгаа нь хэрхэн гүйцэтгэгдэх ёстой вэ? (3 Нифай 11:22–27.)
- Аврагч маргаан зөрчлийн талаар юу хэлсэн бэ? (3 Нифай 11:28–30.)
- Мөнхийн амьдралыг авахын тулд тэр бид бүгдийг юу хий гэж хэлсэн бэ? (3 Нифай 11:33–38.)
- Есүс Христ амьд гэдэг нь өнөөдөр дэлхий дээрх хамгийн агуу мэдээ хэмээн тайлбарла. Маш олон хүмүүс түүнийг олон жилийн өмнө амьдарч загалмай дээр үхсэн гэдгийг л мэддэг. Түүний Сүмийн гишүүний хувьд биднийг, ялангуяа Аврагчтай илүү ойр байна гэж мэдрүүлдэг ямар мэдлэг бидэнд бий вэ? (Тэр бидний гэм нүглийн төлөө зовсон, бидний төлөө амиа өгсөн бөгөөд тэр амьд ба өнөөдөр сүмээ удирдаж байгаа гэдгийг бид мэднэ.)

Хүүхдүүдийг Есүс Христийн тухай сэтгэгдлээ илэрхийлэхийг урь.

Баяжуулах Үйл Ажиллагаа

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно

1. Итгэлийн тунхгийн нэг, хоёр, дөрөвдүгээрийг уншиж ярилц. Тэдгээрийн нэгийг цээжлэхэд нь хүүхдүүдэд тусал.
2. Гэрчлэлтэй байхын утга учрыг ярилц. Энэ амьдралд хүнд байж болох хамгийн чухал зүйлүүдийн нэг нь Есүс Христ бол үнэхээр хүн ба түүнийг тэнгэрлэг болгодог Бурханы Хүү гэсэн гэрчлэл юм. Гэрчлэл гэдэг нь мэдлэг болдог сүнслэг мэдрэмж, хүчтэй итгэл юм. Та нар гэрчлэлтэй болоод ирэхээрээ дотоод сэтгэлдээ сайн мэдээ нь үнэн гэдгийг мэдэрдэг. Энэ мэдрэмж нь та нарын суралцах, залбирах болон дуулгавартай байж үүнийг тэжээж арчилсаны хирээр өсч, хүчтэй болдог. Та нар Тэнгэрлэг Эцэг болон түүний Хүү, Есүс Христэд итгэх итгэл болон хайраараа зөв сонголтуудыг хийж эхлэх болно. Бид гэрчлэлээ хуваалцахдаа бусдад Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийн талаарх сэтгэгдэл, амлалтуудаа илэрхийлдэг. Бид бас амьдарч байгаа байдал, хувцаслалт, үйл хөдөллөөрөө гэрчлэлээ хуваалцдаг. Зөвийг сонгосноороо бид бусдад Есүс Христ болон түүний сайн мэдээний тухай гэрчлэлтэй гэдгээ үзүүлдэг.
3. Есүс Христийн тухай үргэлжлүүлэн сурах нь бидэнд яагаад чухал болохыг ярилц. Бид өөрсдийн мэддэг, биширдэг, хүндэтгэдэг хүмүүстэй адил болохыг хүсдэг гэдгийг тайлбарла. Бид Есүс Христийн тухай сурч, жишээнүүдийг нь дагахыг хичээснээрээ түүнд ойртож, түүнтэй илүү адил болж чаддаг.

Дүгнэлт

Гэрчлэл	Есүс Христийн бодит ба тэнгэрлэг байдлын тухай гэрчлэлээ хуваалц.
Зөвлөмж Болгогдсон Гэрийн Уншлага	Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ 3 Нифай 11-ийг судлахыг зөвлө. Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.

Есүс Христ Нифайчуудад Ивээлүүдийн Тухай Заасан нь

Зорилго

Есүс Христийн Нифайчуудад заасан Ивээлүүд болон бусад үнэнүүд нь Тэнгэрлэг Эцэг болон түүний Хүүтэй илүү адил болоход бидэнд тусалж чадна гэдгийг хүүхдүүдэд заана.

Бэлтгэл

1. 3 Нифай 12 болон 13-ыг залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii-ыг үз).
2. Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго.
3. Шаардлагатай материалууд:
 - а. Хүүхэд бүрт Мормоны Ном.
 - б. Зураг 4-45, Есүс Америк Тивд Сургаалыг Заасан нь (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 316, 62380).

**Хичээл Заах
Зөвлөмж**

Анхаарал Татах
Ажиллагаа

Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.

Хүүхдүүдийг хос хосоор нь хуваа. Хэрэв хүүхдүүдийн тоо сондгойрвол сондгойрсон хүүхдүүдийн хамтрагч бол. Хүүхдүүдээс эхлээд бүх заавруудыг сонсож тэдгээрээ санаж байхыг хичээж байгаад тэдгээрийг өгсөн дарааллаар нь хийхийг хүс.

1. Хамтрагчтайгаа гар бариад бүтэн нэрээ хэл.
2. Босч зогсоод хамтрагчдаа түүний талаар биширч явдаг ямар нэгэн зүйлийг хэл.
3. Дороо нэг эргээд хамтрагчдаа өөрийнхөө талаар таалагддаг нэг зүйлээ хэл.
4. Хамтрагчийнхаа Мормоны Номын дуртай бошиглогчийг мэдэж ав.
5. Суугаад, гараа энгэртээ зөрүүлэн барь.

Хүүхдүүдээс эхлэхийг хүс. Хэрэв хүүхдүүдэд бүх зүйлсийг санахад хэцүү байвал заавруудыг давтаж тэднээр дахин хийлгэ. Үйл ажиллагааг хэд хэдэн удаа давтагдахад хүн болгон тэднээс юу хий гэснийг санаж хийх чадвартай болно гэдгийг тайлбарла. Амьдралынхаа турш Есүс Христийн сургаалуудыг дагахыг сонгосноороо бид Тэнгэрлэг Эцэг болон түүний Хүүтэй илүү адил болохыг аажим аажмаар сурах болно.

Есүс Христ дахин амилсныхаа дараа Америк тивд очсон гэдгийг тайлбарла. Тэр арван хоёр шавь нараа сонгож Иерусалим дахь Уулан Дээрх Номлолдоо зааж байсан тэдгээр зарчмуудаа Нифайчуудад заасан (Матай 5–7-г үз.) Ивээлүүд хэмээн танил болсон эдгээр сургаалууд

бидэнд амьдрахад маань чухал юм. Ивээлүүд гэсэн үг бол аз жаргал буюу адислал гэсэн утгатай.

Судрын Хэсэг

Есүс Америк Тивд Сургаалыг Заасан нь зургийг үзүүлээд 3 Нифай 12 болон 13-аас Есүс Христийн Ивээлүүдийг зааж буй хэсгийг хүүхдүүдэд заа. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii-аас үз.) Аврагч бидэнд тэр болон түүний Эцэгтэй хэрхэн адил болох тухай заасныг онцол.

Ярилцлага ба Тавьж Болох Асуултууд

Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншнаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.

- Есүс Христ Нифайчууд хэнийг сонсож, дуулгавартай дагах ёстой гэж хэлсэн бэ? (3 Нифай 12:1.) Өнөөдөр бид Сүмийн удирдагчдаа сонсож, дуулгавартай дагах нь яагаад чухал вэ?
- Усаар батлуулснаараа бид ямар адислалуудыг хүртдэг вэ? (3 Нифай 12:2.) Хэрэв бид Ариун Сүнсийг бидэнд тусалж байгаасай гэж хүсвэл юу хийх ёстой вэ?
- “Сүнсэндээ ядуу” гэдэг нь юу гэсэн үг вэ? (3 Нифай 12:3.) Юм сурахаар хүн, дээрэлхүү, эсвэл их зантай биш.) Бид Тэнгэрлэг Эцэгтээ юм сурахаар хүн гэдгээ хэрхэн үзүүлж чадах вэ? Гурав дахь шүлэгний “Хэн над дээр ирнэ” гэдэг үгс нь Библийн хэсэг дээр байхгүй ч бидэнд Ивээлүүдийг илүү сайн ойлгоход минь тусалдаг. Бид Аврагч руу очихгүй л юм бол “сүнсэндээ ядуу” байх нь хангалтгүй юм. Энэ нь бусад Ивээлүүдийн тус бүрд хамаатай.

Аврагч биднийг гэм нүглээ наманчлаад, түүн дээр “бяцхан хүүхдийн адил” ирэх ёстой гэж заасан (3 Нифай 9:22). Хүүхэд бүр дээр ажигласан үлгэр жишээ онцлог чанаруудаа хэл. Ангид бишрэлтэй байж, сурахыг хичээн, мөн бусдад сурахад нь туслахын ач холбогдлыг онцлон хэл.

3 Нифай 12:4-ийг унш. Та Сүнсээр тайвшрагдаж байсан үеэсээ хуваалц. Хүүхдүүдийг тайтгарагдаж байсан тохиолдлоосоо хуваалцахыг урь.

- Номхон байх гэдэг нь юу гэсэн үг вэ? (3 Нифай 12:5. Зөөлөн, эелдэг болон биеэ барих чадвартай байх.) Номхон байснаараа бид өөрсдийгөө болон бусдыг хэрхэн адисладаг вэ?
- Зөв шударгын төлөө өлсөж цангах гэдэг нь юу гэсэн утгатай вэ? (Бид хоол, ус хүсдэг шигээ сайныг хүсэх ёстой.) Хэрэв бид зөв шударгын төлөө өлсөж цангаж байвал бидэнд юу амлагдсан бэ? (3 Нифай 12:6.)
- Нигүүлсэнгүй гэдэг нь юу гэсэн үг вэ? (3 Нифай 12:7. Өршөөхөд бэлэн байх, сайхан сэтгэлтэй байх болон хайрлах.) Бид нигүүлсэнгүй байдлаа үзүүлбэл бидэнд юу амлагдах вэ? Та хэн нэгнийг өршөөхийг сонгохдоо болон үүнийг хийснээрээ ямар мэдрэмжтэй байсан тохиолдлоосоо хуваалцаж болно.
- Зүрх сэтгэлдээ цэвэр ариун гэдэг нь юу гэсэн үг вэ? (3 Нифай 12:8. Чин сэтгэлтэй болон үнэнч байх, цэвэр бодол санаа болон зүрхтэй байх, сайн сайхан зүйлд баярлаж, бодол санаа болон үйл хөдлөлдөө муу ёрын буюу бусармаг зүйлсээс хол байх.) Мууг биш, сайн үйл

ажиллагаануудыг сонгохын ямар жишээнүүд байдаг вэ? Сайн мэдээний сургаалуудыг дуулгавартай дагах нь зүх сэтгэлдээ цэвэр ариун байхад бидэнд хэрхэн туслах вэ?

- Энхийг сахигч гэдэг нь юу гэсэн үг вэ? (3 Нифай 12:9.) Энхийг сахигч байснаараа та нар ямар нөхцөл байдлуудыг өөрчилж чадах вэ? Энхийг сахигч байх нь та нарт ямар мэдрэмж төрүүлдэг вэ?
- Аврагч түүний тухай гэрчлэлээс болж хавчигдаж гадуурхагдсан (шоглогдож, дооглуулж, тарчлуулсан) хүмүүст юу амласан бэ? (3 Нифай 12:10–12.) Та нар Аврагчийн төлөө хавчлагыг тэвчсэн хэн нэгнийг мэдэх үү? Та өөрийнхөө буюу өөрийн тань мэдэх хэн нэгнийг шүүмжлүүлж байгаагаа ч үл хайхран зөвийн төлөө зогссон талаар хуваалцаж болно.
- Газрын давс байна гэдэг нь юу гэсэн үг вэ? (3 Нифай 12:13. Баяжуулах үйл ажиллагаа 4- ийг үз.) Та нарын бусдад үзүүлж буй зөв шударга үлгэр дууриал давстай хэрхэн харьцуулагдаж болох вэ?
- Хэрэв асаж байгаа лаа нь хувин, эсвэл савны доор байвал хир сайн гэрэлтүүлэх вэ? (3 Нифай 12:14–16.) Ямар замаар та нар гэрлээ (жишээ) гэрэлтүүлж чадах вэ? Өөр хэн нэгний жишээ нь хэрхэн та нарын амьдрал дахь гэрэл гэгээ болж чадах вэ?
- Зарлигуудыг сахих нь биднийг Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христтэй илүү адил болоход хэрхэн тусалж чадах вэ? (3 Нифай 12:48.)
- Бидэнд бусдыг өршөөх нь хир чухал вэ? (3 Нифай 13:14–15.)
- 3 Нифай 13:16–18-аас бид мацаг барилтын тухай юу сурч болох вэ?
- “Өөрсөддөө газар дэлхий дээр баялгийг бүү хураа. . . харин өөрсөддөө тэнгэрт баялгийг хураа” гэдэг нь юу гэсэн утгатай гэж та нар бодож байна вэ? (3 Нифай 13:19–20.) Бид энэ амьдралаас дараагийн амьдралд очихдоо ямар эд баялгийг авч явж чадах вэ? Бид өөртэйгөө авч явж чадахгүй, бидэнд чухал гэж санагдаж байгаа ямар эд баялгууд байдаг вэ?
- Есүс Христ яагаад бидэнд зарлигуудыг өгдөг вэ? (3 Нифай 12:20.) Энэ долоо хоногт та нарыг Аврагчтай илүү адил байхад туслах Ивээлүүд болон үнэнүүдээс та нар юу сурсан бэ?

Баяжуулах Үйл Ажиллагаа

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно

1. Самбар дээр *Ерөөлтэй еэ* болон *Амлалт* гэсэн гарчгуудыг бич. Тусдаа цааснууд дээр *3 Нифай 12:3*, *3 Нифай 12:4* гэх мэтчилэн шүлэг арав хүртэл бичээд ангийн гишүүдэд тарааж өг. Хүүхдүүдээр өөрсдийнх нь цаасан дээрх шүлгүүдийг уншуулаад Ивээлүүд (шүлэг) бүрт ямар амлалт байгааг хэлүүл. Хариулыг тохирох баганад нь бич. (Ивээлүүд (шүлэг) бүрийн тухай ярихдаа “Христ дээр ирэх”-ийн чухлын онцлон хэл.) Таныг ингэж хийгээд дуусахад самбар дээр дараах жагсаалт бичигдсэн байна:

<u>ИВЭЭГДСЭН</u>	<u>АМЛАЛТ</u>
Есүс Христэд ирэх сүнсэндээ ядуу хүмүүс	Тэнгэрийн хаанчлалыг хүлээн авах болно
Гашуудаж буй хүмүүс	Тайвшрал авах болно
Номхон хүмүүс	Дэлхийг өвлөн авах болно
Зөв шударгын төлөө өлсөж цангагчид	Ариун Сүнсээр дүүргэгдэх болно
Нигүүлсэнгүй хүмүүс	Нигүүлслийг олж авах болно
Зүрх сэтгэлдээ цэвэр ариун байгчид	Бурханыг харах болно
Энхийг сахигчид	Бурханы хүүхдүүд гэж нэрлэгдэх болно
Аврагчийн төлөө хавчигдан гадуурхагдсан хүмүүс	Тэнгэрийн хаанчлалыг хүлээн авах болно

2. Итгэлийн тунхгийн арван гуравдугаарыг ярилцаад, хүүхдүүдэд цээжлэхэд нь тусал.
3. Хүүхдүүдээс Ивээлүүдийн (эдгээр шүлгүүдийн) нэгнийх нь дагуу хэрхэн илүү сайн амьдарч болохыг асуугаад тэдний санаануудыг самбар дээр жагсаа. Хүүхэд бүрийг Ивээлүүдийн нэгийг сонгож энэ долоо хоногт үүн дээрээ ажиллахыг нь урамшуул. Та дээр нь “Энэ долоо хоногт би илүү _____ байна” гэсэн өгүүлбэр бичсэн цааснуудыг өгч болно. Хүүхдүүдээр хоосон зайг бөглүүлээд, гэрт нь өгч явуул.
4. Хүүхдүүдэд жаахан давс харуул. Давс нь олон зуун жилийн өмнөөс хоол амтлахад ашиглагдаж мөн хөгзөрч муудахаас хамгаалж байсан гэдгийг тайлбарла. Давс хоолыг муудахаас хамгаалдгийн адил бид Тэнгэрлэг Эцэг ба Аврагчийн сургаалуудыг дуулгавартай дагаж гэрээнүүдээ сахивал бидний холбоо хэвээр үлддэг. Дараах асуултуудыг хүүхдүүдэд тавь.
 - Бидний Аврагчтай тогтоох холбоо нөлөөлж болох дэлхийн ямар ямар бохир нөлөөллүүд байдаг вэ?
 - Давс бохир зүйлтэй холилдон суларч амтаа алддагийн адил бид амьдралдаа цэвэр бус зүйлсийг (муу бодол, нөлөөлөл, үйлдэл) зөвшөөрвөл бидэнд юу тохиодох вэ?
5. Та энэ хичээлийг мацгийн Ням Гарагт заагаагүй бол давстай, давсгүй эрдэнэшиш зэрэг хоол бэлдээд (хүүхдүүдийн чинь хэн нэг нь харшилтай эсэхийг эцэг эхээс нь лавла) хүүхдүүдэд амсуул. Тодорхой нэг хоолонд давс нь ямар чухал болохыг тайлбарла. Газар дэлхийн давс болохын тулд бид Христтэй адил зан чанаруудыг хөгжүүлж, бусдад үйлчлэх ёстой гэдгийг ойлгоход нь хүүхдүүдэд тусал.

6. Дараах судрыг унш. Хүүхдүүдээр *хий* гэсэн үгийг сонсох бүрт гарыг нь өргүүл.

“Энэ бол миний сайн мэдээ, мөн миний сүмд *хийх* ёстой зүйлүүдээ та нар мэднэ; учир нь миний *хийхийг* та нарын харсан тэр ажлуудыг та нар түүнчлэн *хийх* болно; учир нь миний *хийснийг* та нар харсан, бүр түүнийг та нар *хийх* болно;

“Тиймийн тул, хэрэв та нар эдгээр зүйлийг *хийх* аваас та нар ивээгдэх, учир нь та нар эцсийн өдөр өргөгдөх болно.” (3 Нифай 27:21–22.)

Хэрэв бид Аврагчийн бидэнд хийхийг тушаасан зүйлүүдийг хийвэл, тэр биднийг адислана. Дуулгавартай байдал нь адислалуудыг авчирдаг гэдэг нь мөнхийн хууль юм. Их Эзэн хэлэхдээ бид Бурханаас аливаа адислалыг, адислалд суурилсан хуульд дуулгавартай байснаараа авдаг гэсэн (С ба Г 130:20–21-г үз).

7. Сүмийн арван хоёр дахь Ерөнхийлөгч Спенсэр Б. Кимболлын зургийг үзүүлээд, хүүхдүүдэд түүний хамгийн дуртай уриануудын нэг нь “Үүнийг хий” гэдэг байсныг хэл. Ерөнхийлөгч Кимболл Христийн сургаалуудыг зөвхөн мэдэх нь чухал биш, харин хэрэгжүүлэх нь чухал гэдгийг мэдэж байсан. Ерөнхийлөгч Кимболлын тухай дараах түүхийг яриад “Би Бурханы Хүүхэд” дууг дуул.

“1957 онд Хүүхдийн Хэсгийн Ерөнхий Удирдах Газар . . . Наоми В. Рэндал болон Милдрэд Т. Пэттит нараас . . . хүүхдүүд сайн мэдээнээс суралцсан байх хэрэгцээний тухай дуу бичихийг хүссэн. Наоми В. Рэндал хэлэхдээ: ‘Тэр орой би өвдөг дээрээ сөхөрч суугаад Тэнгэрлэг Эцэг минь зөв үгсийг надад хэлээч хэмээн гуйж чангаар залбирав. Өглөөний хоёр цагийн үед би сэрээд, дууны тухай дахин бодов. Оюун ухаанд минь үгс буун ирэв. . . . Би тэр даруй босч үгсийг надад орж ирснээр нь буулган бичив. 3 бадаг, нэг дахилт удалгүй бүрдэв. Би ажлаа талархалтайгаар шалгаж, үгсээс ирсэн захиасыг зүрх сэтгэлдээ хүлээн аваад, Тэнгэрлэг Эцэгийнхээ өмнө сөхөрч суугаад “Баярлалаа” хэмээн хэлэхээр унтлагын өрөө лүүгээ явсан юм’. . .

“Дахилтын үгс нь эхээрээ ‘Хэзээ нэг өдөр тантай цуг амьдрахын тулд юу мэдэх ёстойг минь заагаач.’ Дуу хэвлэгдэн гарч хэдэн жилийн дараа тэр үед Арван Хоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн байсан Спенсэр Б. Кимболл Хүүхдийн Хэсгийн хүүхдийн найрал дууныхан уг дууг дуулсан чуулганд оролцсон юм. Наоми Рэндал энэ тухай ингэж ярьсан: ‘Гэртээ харих замдаа тэр Хүүхдийн Хэсгийн Ерөнхий Удирдах Газрын гишүүнтэй ярьж дуунд өгсөн өөрийн хайраа илэрхийлээд дахилт дахь нэг үг түүний сэтгэлийг зовоосон гэдгийг дурьдсан юм. Тэр Рэндал эгчийг нэг мөрний “мэдэх ёстойг минь заагаач” гэдгийг “юу *хийхийг* минь заагаач” хэмээн өөрчилж болох эсэх талаар мэдэхийг хүсэв. Би мэдээж түүний саналыг баяртайгаар хүлээн авлаа.

“ ‘Би уг шүлгийг анх бичиж авч байх үед тэр бодлыг яагаад оруулаагүй юм бол гэж гайхаж байлаа. Цаг хугацаа өнгөрсөөр энэ дуу Сүмийн бүх гишүүдэд сургамжтай зүйл болсон бөгөөд сайн мэдээг мэднэ гэдэг нь бүхий л шаардлагатай зүйл биш харин энэ нь өдөр өдрөөр Их Эзэний хүссэнийг хийж биднийг мөнхийн зорилгодоо хүрэхэд туслах зарлигуудыг дагах явдал юм гэдгийг тэдэнд ойлгуулсан учраас би Их Эзэн энэ дууг ийм л байгаасай гэж хүссэн гэдгийг чин

сэтгэлээсээ мэдэрсэн.’ ” (in Karen Lynn Davidson, *Our Latter-day Hymns*, p. 303–4).

Гэрт нь өгч явуулахаар хөзрөн цаасан дээр “Үүнийг одоо хий” гэж хүүхэд бүрээр бичүүл.

8. “Бие Биенээ Хайрлаач” (*Сүмийн Дуулал*, х. 33), эсвэл “Би Бурханы Хүүхэд” (*Сүмийн Дуулал* х. 58) дууг дуулах, эсвэл үгийг нь унш.

Дүгнэлт

Гэрчлэл	Ивээлүүд болон бусад зарлигуудын дагуу амьдарснаар бид адислагдаж, Тэнгэрлэг Эцэгтэйгээ илүү адил болно гэдгийг гэрчил.
Зөвлөмж Болгогдсон Гэрийн Уншлага	Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ 3 Нифай 12: 3–24, 39–48-ыг судлахыг зөвлө. Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.

Есүс Христ Өвчтөнийг Эдгэрүүлж Хүүхдүүдийг Адисласан нь

Зорилго

Есүс Христ бид бүгдэд хайртай гэдгийг заах ба түүнд итгэх итгэлээрээ баяр баясгаланг мэдрэхэд нь хүүхдүүдийг урамшуулна.

Бэлтгэл

- 3 Нифай 17-г залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii-ыг үз).
- Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго.
- Шаардлагатай материалууд:
 - Хүүхэд бүрт Мормоны Ном.
 - Давс
 - Зурагнууд: 4-46, Есүс Нифайчуудыг Эдгээсэн нь (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 317, 62541); 4-47, Есүс Нифайчуудтай Залбирч Байгаа нь (62542); 4-48, Есүс Нифайчуудын Хүүхдүүдийг Адисласан нь.

Хичээл Заах Зөвлөмж

Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.

Анхаарал Татах Ажиллагаа

Хүүхэд бүрт давс амсуулаад, үүний амтыг урьд нь хэзээ ч үзээгүй хэн нэгэнд тэд хэрхэн тайлбарлахыг нь асуу. Тэд амт нь “шорвог” гэж тайлбарлаж болохгүй, учир нь давс хэзээ ч амсаж байгаагүй хүн энэ үгийн утгыг мэдэхгүй гэдгийг та тэдэнд сануулах хэрэгтэй. Та өөртөө тохиолдсон зүйлсийг бусад хүмүүст ойлгуулахын тулд үгээр тайлбарлах нь заримдаа их хэцүү гэдгийг тайлбарла. Нифайчуудад Есүс Христ үзэгдэхэд тэд “Бидний харж бас сонссон шиг тийм агуу их мөн гайхамшигт зүйлүүдийг хэлээр хэлэх аргагүй бас ямар ч хүмүүнээр бичиглэгдсэн байх аргагүй, бас хүмүүн зүрх сэтгэлдээ төсөөлөхийн аргагүй” (3 Нифай 17:17) гэж хэлсэн тийм агуу баяр баясгалантай байсан. Хэрэв хүүхдүүд энэ хичээлийг сонсож байхдаа үйл явдлуудыг оюун ухаандаа зураглавал тэд үгээр тодорхойлж болохгүй тэр үнэнүүдийн заримыг сүнсээр мэдэрч, ойлгож чадах болно гэдгийг тэдэнд хэл.

Судрын Хэсэг

Зургуудыг тохиромжтой үед нь хэрэглэж 3 Нифай 17-гоос Есүс Христ өвчтөнийг эдгэрүүлж, хүүхдүүдийг адислаж байгаа хэсгийг хүүхдүүдэд заа. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii-аас үз.) Аврагчийн хүмүүст өгсөн хайр нь үгээр илэрхийлж боломгүй тийм агуу юм гэдгийг онцол.

Ярилцлага ба
Тавьж Болох
Асуултууд

Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншнаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.

- Өөрийнхөө тэдэнд заасан зүйлсийг ойлгоход нь тэдэнд туслахын тулд хүмүүсийг юу хийх ёстой гэж Есүс Христ хэлсэн бэ? (3 Нифай 17:3.) Эргэцүүлэн бодох гэдэг нь юу гэсэн үг вэ? (Ямар нэг зүйлийн талаар нухацтай бодох.) Бид Сүмийн удирдагчид болон багш нарынхаа заасан зүйлсийн тухай эргэцүүлэн бодож, залбирах нь яагаад чухал вэ?
- Нифайчууд дээр айлчилсныхаа дараа Аврагч хаашаа явна гэж хэлсэн бэ? (3 Нифай 17:4.) Энэ нь Есүс Тэнгэрлэг Эцэгийн бүх хүүхдүүдэд хайртай гэдгийг хэрхэн харуулдаг вэ?
- Аврагчийг явах гэж байгаагаа хэлэхэд хүмүүс яасан бэ? (3 Нифай 17:5.) Тэр тэднийг хайрладаг гэдгээ үзүүлэхээр юу хийсэн бэ? (3 Нифай 17:6–8.)
- Хүмүүсийн эдгэрсний шалтгаан нь юу байсан гэж Есүс Христ хэлсэн бэ? (3 Нифай 17:8.) Гайхамшгууд заримдаа тохиолдохгүй байхын нэг шалтгаан нь юу вэ? (Ифэр 12:12, 18.)
- Есүс Христийг өвчтөнүүдийг эдгээхэд Нифайчууд талархлаа хэрхэн илэрхийлсэн бэ? (3 Нифай 17:10.) Та нар Тэнгэрлэг Эцэг болон Есүст хэзээ талархах ёстой вэ? Хүлээж авсан адислалуудынхаа төлөө талархлыг та нар хэрхэн үзүүлж чадах вэ?
- Есүс Христ өвчтөнүүдийг эдгээснийхээ дараа хүмүүст юу хийхийг тушаасан бэ? (3 Нифай 17:11.) Түүн дээр хүүхдүүдийг авчрахад тэр яасан бэ? (3 Нифай 17:13–15.) Тэнгэрлэг Эцэгтээ хандан залбирсан үгс нь яагаад бичигдээгүй вэ? (3 Нифай 17:16–17.)
- Есүс яагаад уйлсан бэ? (3 Нифай 17:20–21.) Сайн мэдээ та нарт хэрхэн баяр баясгалан авчирсан бэ? Тэр хүүхдүүдэд өгсөн хайраа хэрхэн үзүүлсэн бэ? (3 Нифай 17:21.) Есүс Христ та нарыг гартаа тэвэрч, адислаж, та нарын төлөө Тэнгэрлэг Эцэгт хандан залбирвал та нарт ямар санагдах вэ?
- Аврагч эцэг эхэд нь бяцхан нэгнээ хар гэхэд эцэг эхчүүд нь юу харсан бэ? (3 Нифай 17:23–24.) *Үйлчлэх* гэдэг нь юу гэсэн үг вэ? (Тусламж, эсвэл үйлчлэл үзүүлэх.) Бусдад үйлчлэхээр бид юу хийж болох вэ?

Баяжуулах Үйл
Ажиллагаа

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно

1. Сүмийн арван гурав дахь Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсоны дараах мэдэгдлийг уншиж ярилц:

“Хайрт хүүхдүүд минь, тэнгэрийн элчүүд та нарт бас үйлчлэх болно гэдгийг би та нарт амлаж байна. Та нар тэднийг харахгүй байж болно, гэвч тэд та нарт туслахаар тэнд байж, та нар тэдний байгааг мэдрэх болно. . . .

“Хайрт хүүхдүүд минь, Тэнгэрлэг Эцэг та нарыг энэ цаг үед дэлхий рүү илгээсэн учир нь та нар Түүний хамгийн зоригтой хүүхдүүдийн нэг юм. Тэр өнөөдөр дэлхийд маш их бусармаг явдлууд байх болно, мөн та нарыг итгэлтэй, дуулгавартай байх болно гэдгийг мэдэж байсан” (Conference Report, Apr. 1989, p. 105, or *Ensign*, May. 1989, p. 83).

2. 3 Нифай 17:20–21-ийг хамтдаа унш. Хүүхдүүдээс эдгээр шүлгүүдийн чухал гэж бодож байгаа үг, эсвэл хэсэг үгсийг сонгож авахыг хүсээд, тэднээр сонгосон үгсийнх нь талаар сэтгэгдлийг нь хуваалцуул.
3. Хүүхдүүдээс амьдралдаа хамгийн их аз жаргалтай байсан үеийнхээ тухай бодохыг хүс. Тэдэнд тэдгээр үеийнх нь талаар дараах асуултуудыг тавь:

- Та нар юу хийж байсан бэ?
- Юу та нарыг аз жаргалтай болгосон бэ?
- Бид яагаад Есүсийн зааснаар амьдрахад хамгийн их аз жаргалтай байдаг вэ?
- Та нар яагаад тодорхой нэг найз нөхөд болон гэр бүлийн гишүүдтэйгээ хамт байхад хамгийн их аз жаргалтай байдаг вэ?

Бид жам ёсоороо өөрсдийн хайртай болон биднийг хайрладаг тэдгээр хүмүүстэй хамт байхыг хүсдгийг тайлбарла. Бид зарлигуудыг дуулгавартай дагавал бид Тэнгэрлэг Эцэг, Есүс болон гэр бүлтэйгээ мөнхөд хамт амьдарч чадна. Энэ нь бидний мэдэрч болох хамгийн агуу баяр баясгаланг өгөх болно.

4. Элбэг Дэлбэгийн газар цугласан Нифайн ард түмэн хангалттай бэлтгэгдээгүй байсан учраас Аврагч Тэнгэрлэг Эцэгийн тэдэнд мэдүүлэхийг хүссэн болгоныг нь хэлж чадаагүй. Есүс хүмүүсээс юу хийхийг хүссэн бэ? (Хүүхдүүдээр 3 Нифай 17:3-аас дараах хоосон зайг бөглүүл.)

Тиймийн тул, _____ та нар гэр _____ гэртээ _____ явцгаа _____
 _____ миний _____ хэлсэн _____ зүйлүүдийг _____
 _____ эргэцүүл _____, ойлгохын тулд та нар _____ миний _____
 _____ нэрээр _____, _____ Эцэгээс _____ асуу (3 Нифай 17:3).

Чуулган, ариун ёслолын цуглаан, эсвэл Хүүхдийн Хэсгийн дараа сонссон зүйлээ та нарт ойлгоход туслах ямар зүйлийг та нар хийх ёстой вэ?

Дүгнэлт

Гэрчлэл

Есүс Христ болон Тэнгэрлэг Эцэг бүх хүүхдүүддээ хайртай ба хэрэв бид Есүс Христэд итгэх итгэлтэй байж, зарлигуудыг дуулгавартай дагавал бид тэдэнтэй хамт амьдрахын баяр баясгаланг мэдрэх болно гэдгийг гэрчил.

Зөвлөмж
Болгогдсон

Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ 3 Нифай 17-г судлахыг зөвлө.

Гэрийн Уншлага

Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.

Есүс Христ Нифайчуудад Ариун Ёслол Өгсөн нь

Хичээл
36

Зорилго

Хүүхдүүдийг Есүс Христийг ямагт санаж байхад нь урамшуулах ба ингэснээр түүний Сүнс тэдэнтэй хамт байх болно.

Бэлтгэл

- 3 Нифай 18:1–14-ийг залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii-ыг үз).
 - Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго.
 - Дараах үгсийг цаасан (эсвэл та самбар дээр бичиж болно) дээр бич:
Харанхуй
Сүйрэл
Дуу хоолой
Түүний шархны соривнууд
Тэнгэрийн элчүүд
 - Шаардлагатай материалууд:
 - Хүүхэд бүрт Мормоны Ном.
 - Зурагнууд: 4-43, Христ Нифайчуудад Үзэгдсэн нь (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 315, 62047); 4-46, Есүс Нифайчуудыг Эдгээсэн нь (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 317, 62541); 4-47, Есүс Нифайчуудтай Залбирч Байгаа нь (62542) болон 4-49, Дахин Амилсан Есүс Христ (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 239, 62187).
-

Хичээл Заах

Зөвлөмж

Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.

Анхаарал Татах
Ажиллагаа

Хүүхдүүдээс амьдралынхаа ямар чухал үйл явдлуудыг санаж байгааг нь асуу. Эдгээр үйл явдлуудыг санахад тэдэнд юу тусалж байгааг асуу.

“Бэлтгэл” хэсэгт дурьдагдсан зургууд болон өөрийн бэлдсэн үгсийг нэг нэгээр нь үзүүл. Зураг, үг, эсвэл хэллэг бүр Есүсийн айлчлалын талаар юуг санахад тэдэнд тусалж байгааг хүүхдүүдээс асуу. Энэ хичээлд Есүсийг үргэлж дурсан санаж байхын тулд түүний хийсэн зүйлүүдийг заах болно гэж хэл.

Судрын Хэсэг

3 Нифай 18:1–14-ийг хүүхдүүдэд заа. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii-аас үз.)

Ярилцлага ба
Тавьж Болох
Асуултууд

Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншснаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.

- Есүс Христ төлөөлөгчдөөсөө юу авчрахыг хүссэн бэ? (3 Нифай 18:1.) Есүс талхыг яасан бэ? (3 Нифай 18:3–4.) Тэр дарсыг яасан бэ? (3 Нифай 18:8–9.)
- Залуу эрэгтэйчүүд ариун ёслолыг бэлтгэх буюу адислаж Сүмийн гишүүдэд түгээхээсээ өмнө юутай байх ёстой вэ? (3 Нифай 18:5.) Манай хэсэгт хэн ариун ёслолыг бэлтгэж, түгээж, адисладаг вэ?
- Ариун ёслолын талх биднийг юуг дурсан санахад тусалдаг вэ? (3 Нифай 18:7.) Ариун ёслолын ус биднийг юуг дурсан санахад тусалдаг вэ? (3 Нифай 18:11.)
- Ариун ёслолоос хүртэж байхдаа бид хэнтэй гэрээ хийдэг вэ? (3 Нифай 18:7.)
- Хэрэв бид Есүс Христийг ямагт дурсан санаж байвал тэр бидэнд юу амладаг вэ? (3 Нифай 18:7.) Түүний Сүнсийг өөртэйгөө байлгана гэдэг нь юу гэсэн үг вэ? (Ариун Сүнс биднийг удирдаж, бидэнд тусалдаг.) Аврагчийн Сүнсийг өөртэйгөө байлгаж түүнийг ямагт дурсан санахын тулд бид долоо хоногийн үеэр юу хийж болох вэ?
- Сүмийн гишүүд ариун ёслолыг хүртэхдээ Тэнгэрлэг Эцэгт юу гэрчилдэг вэ? (3 Нифай 18:10.) Түүний зарлигуудыг сахих хүсэлтэй байх гэдэг нь юу гэсэн утгатай вэ? Тэнгэрлэг Эцэг биднээс хүсэлтэйгээр сахихыг хүсдэг ямар ямар зарлигууд байдаг вэ? Та хүүхдүүдээс илүү бүрэн дүүрэн дуулгавартай дагахыг хүсч байгаа нэг зарлигийг дотроо сонгохыг хүсч болно.
- Бид ариун ёслолоос хүртэхдээ ямар гэрээнүүдийг санаж мөн шинэчлэдэг вэ? (3 Нифай 18:11.) Усан баталгаагаараа хийсэн гэрээнүүдийнхээ тухай байн байн бодох нь бидэнд илүү сайхан амьдрахад хэрхэн тусалдаг вэ? (Мозая 18:10.) Ариун ёслолын залбирлуудыг анхааралтай сонсож ирэх долоо хоногт усан баталгааныхаа гэрээнүүдийг сахих арга замуудын талаар бодож үзэхийг хүүхдүүдэд уриал.
- Ариун ёслолыг зохистойгоор хүртэснээрээ бид хэрхэн адислагддаг вэ? (3 Нифай 18:12–14.)

Баяжуулах Үйл Ажиллагаа

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно.

1. Хүүхдүүдээр Моронай 4:3 болон 4:2-оос ариун ёслолын залбирлуудыг уншуул. Хүүхдүүд ариун ёслолыг хүртэхдээ өөрсдийгөө бэлтгэж чадах арга замуудыг санал болгохыг тэднээс хүс. Хүүхдүүдэд тусламж хэрэгтэй бол та дараах санаануудыг ашиглаж болно.
 - Ариун ёслолын дууллыг дуулах.
 - Ариун ёслолын залбирлын үгсийг сонсох.
 - Аврагчийн хайр, зовлон, үхэл, дахин амилалт, сургаал номлолуудын талаар бодох.
 - Тэнгэрлэг Эцэгтэй хийсэн гэрээнүүдийнхээ тухай бодох.

2. Сүнсийг мэдэрсэн тохиолдлоосоо хуваалц. Хүүхдүүдээс хэн нэг нь Сүнсийг мэдэрсэн тохиолдлоосоо хуваалцахыг хүсэж байгаа бол хуваалцахад нь тэднийг урь. Есүс Христ хүүхдүүдийг амьдралдаа түүний Сүнсийг нээн олж, ямагт мэдэрч байгаасай гэж хүсдэг гэдгийг ойлгоход нь тэдэнд тусал. Сүмийн арван гурав дахь Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсоны дараах мэдэгдлийг ярилц. “Бид Их Эзэний үгсийг ихэвчлэн мэдрэмжээрээ сонсдог. Хэрэв бид даруу болоод мэдрэмтгий байвал Их Эзэн биднийг ихэвчлэн мэдрэмжээр маань дамжуулан өдөөнө. Үүнээс болж сүнслэг өдөөлтүүд нь зарим тохиолдолд агуу баяр баясгалан, заримдаа нулимс болон өөрчлөгддөг” (*Эзра Тафт Бенсоны Сургаалууд*, х. 77).
3. Хүүхдүүдэд ариун ёслолын үеэр Аврагчийг дурсан санахад нь туслах ямар нэг зүйлийг тэднийг зурж байх хооронд тэдний мэддэг дуулал, эсвэл Хүүхдийн Хэсгийн дууг аяла. Эдгээр нь Есүс Христ Гетсеманы Цэцэрлэгт, Есүс Христ Нифайчуудтай хамт, өөрсдийнхөө амьдралд талархаж явдаг хүүхдүүдийг адисласан явдал гэх мэт зүйлүүдээс байж болно. Ариун ёслолын үйлчлэлийн үеэр бодол санаагаа Аврагч дээр төвлөрүүлж байхыг урамшуулан дэмж.

Дүгнэлт

Гэрчлэл

Дахин Амилсан Есүс Христийн зургийг үзүүл. Бид Есүсийг дурсан санаж, түүний зарлигуудыг сахивал бид Ариун Сүнсийг өөртэйгөө байлгаж чадна гэсэн гэрчлэлээ хуваалц.

Зөвлөмж
Болгогдсон
Гэрийн Уншлага

Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ 3 Нифай 18:1–14-ийг судлахыг зөвлө.

Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.

Есүс Христ Нифайчуудад Залбирхыг Заасан нь

Зорилго

Хүүхдүүдийг уруу таталтанд оруулахгүйн тулд залбирахыг нь урамшуулна.

Бэлтгэл

1. 3 Нифай 18:15–25, 19, 20:1-ийг залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii- ыг үз).
 2. Нэмэлт уншлага: Алма 13:28–29, Матай 26:41 болон Сургаал ба Гэрээ 31:12, 61:39.
 3. Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго.
 4. Шаардлагатай материалууд:
 - а. Хүүхэд бүрт Мормоны Ном.
 - б. Зурагнууд: 4-47, Есүс Нифайчуудтай Залбирч Байгаа нь (62542); 4-50, Гэр Бүлийн Залбирал (62275).
-

**Хичээл Заах
Зөвлөмж**

Анхаарал Татах
Ажиллагаа

Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.

Гэр бүлийн онцгой залбирлын тухай Ахлагч Рекс Д. Пайнгэрийн дараах түүхээс хуваалц:

“Хэдэн жилийн өмнө нэгэн өглөө би гэр бүлтэйгээ хамт амралтаараа машинаар явж байлаа. Бид нэгэн алдартай цэцэрлэгийг чиглэн эргэхэд бага дөрвөн охины маань сэтгэл маш их хөдөлсөн байлаа. Бидний хөлсөлсөн тэрэг пар пархийн аюулгүйн тойрог дээр зогсоход инээд хөөр, аз жаргалтай яриа хөөрөө ч гэнэт зогсов. Намайг машинаа дахин асаах гэж оролдож байтал машины хөдөлгөөн ихэссэн үе таарч олон машин биднийг гүйцэж түрүүлж байв. Эцэст нь би бидний хийж чадах нэгэн зүйл байсныг ухаарч бид бүгд машинаасаа гарч залбирахаар замаас холдов.

“Бид залбирч дуусаад толгойгоо өндийлгөтөл инээмсгэлэл тодруулсан нэгэн сайхан эр хүүтэйгээ . . . машинаа замын хөдөлгөөний эгнээ дундуур жолоодон бидний хажууд замаас гарч зогсов. Өглөөнөөс авахуулаад үдээс хойшийг хүртэл эдгээр эрчүүд олон сайхан ашиг тустай байдлаар биднийг хэрэгцээт зүйлүүдээр маань хангаж байлаа. Биднийг болоод юмсыг маань . . . цэцэрлэгт аваачив. . . . Тэд чиргүүлтэй машиныг чирч хөлслүүлдэг товчоон дээр солиулахаар аваачив. Тэд гэрийнхэнд маань амттан авчирч намайг хэдэн цагийн дараа ирэх хүртэл тэдэнтэй хамт хүлээж байв.

“Бид тэдгээр хүмүүс үнэхээр бидний залбирлын хариу байсан гэдгийг мэдэрсэн ба түүнийгээ тэдэнд салахдаа талархснаа илэрхийлэхийг хичээн байхдаа хэлсэн юм. Эцэг нь хариулахдаа: ‘Өглөө бүр би Их

Эзэндээ өнөөдөр хэн нэгэнд тусламж хэрэгтэй бол тэдэн рүү намайг удирдан залаач' хэмээн хэлдэг' гэж билээ" (Conference Report, Oct. 1991, p. 54–55, or *Ensign*, Nov. 1991, p.39).

Хүүхдүүдийг хувийн болон гэр бүлийнхээ залбирлаас олж авсан туршлагаасаа хуваалцахыг урь.

Судрын Хэсэг

Зургуудыг тохиромжтой үед нь ашиглан 3 Нифай 18:15–25, 19, 20:1-ээс Есүс Христ Нифайнчуудад зааж байгаа хэсгийг хүүхдүүдэд заа. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii-аас үз.)

Ярилцлага ба Тавьж Болох Асуултууд

Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншнаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.

- Есүс яагаад биднээс байнга залбирч байхыг хүсдэг вэ? (3 Нифай 18:15, 18.)
- Бид хэнд хандан залбирдаг вэ? Бид хэний нэрээр залбирдаг вэ? (3 Нифай 18:19, 19:6–8.)
- Бидэнд юу хамгийн сайн байна түүний төлөө итгэлтэйгээр залбирахад бидэнд ямар амлалт байдаг вэ? (3 Нифай 18:20.) Тэнгэрлэг Эцэг бидэнд юу хамгийн сайн болохыг ямагт мэддэг гэдгийг ойлгоход нь хүүхдүүдэд тусал. Энэ нь заримдаа бидний хүссэнээс өөр байдаг.
- Гэр бүлийн залбирал яагаад чухал вэ? (3 Нифай 18:21.) Та нар гэрийнхэндээ гэр бүлийн байнгын залбиралтай байхад нь хэрхэн тусалж чадах вэ?
- Есүс Христ биднийг Сүмийн гишүүн бус тэдгээр хүмүүсийн төлөө юу хийх ёстой гэж хэлсэн бэ? (3 Нифай 18:22–23.)
- “Дэлхийд туяарч болохын тулд гэрлээ өргөгтүн” гэдэг нь юу гэсэн үг вэ? (3 Нифай 18:24.) Бид бусдад залбирлын ач холбогдлыг ойлгоход нь хэрхэн тусалж чадах вэ?
- Есүс Христийн арван хоёр шавь нар цугларсан Нифайчуудад юу заасан бэ? (3 Нифай 19:6.) Та нар хэзээ сөгдөн сууж залбирдаг вэ? Сөгдөж суух нь Тэнгэрлэг Эцэгт хүндэтгэлийг хэрхэн үзүүлдэг вэ? Бид гэртээ болон ангидаа залбирч байхдаа өөр ямар арга замаар бишрэлтэй байдлаа үзүүлж чадах вэ?
- Шавь нар залбирч байхдаа юуг хамгийн ихээр хүссэн бэ? (3 Нифай 19:9.) Энэ бэлэг нь тэдэнд хэрхэн өгөгдсөн бэ? (3 Нифай 19:13–14.)
- Есүс Христ Тэнгэрлэг Эцэгт залбирч байхдаа юу хэлсэн бэ? (3 Нифай 19:20, 28.) Талархлаа илэрхийлэх нь яагаад залбирлын маань чухал хэсэг гэж та нар бодож байна вэ? Ямар зүйлст та нар талархдаг вэ?
- Бид хэрхэн зогсолтгүйгээр залбирч чадах вэ? (3 Нифай 20:1.) Яагаад бид зүрхэндээ ямагт залбиралтай байх ёстой вэ? (3 Нифай 18:15, 18.) Залбирал нь уруу таталтаас зайлсхийхэд бидэнд хэрхэн тусалдаг вэ?

Баяжуулах Үйл Ажиллагаа

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно.

1. Дараах судрын ишлэлүүдийг цаасан дээр бичиж хүүхэд тус бүрт нь, эсвэл жижиг бүлэг болгоны дунд нь нэгийг өг. Хүүхдүүдээр судруудыг уншуулж, залбирлаар дамжуулан бидэнд ирэх адислалуудын тухай Есүс Христийн заасан зүйлүүдийг эрж олуул. Тэгээд хүүхдүүдээр ангийнханд сурсан зүйлүүдийг нь яриул.
 - 3 Нифай 18:15, 18 (Бид уруу таталтаас зайлсхийх боломжтой байх болно.)
 - 3 Нифай 18:20 (Зөв шударга хүсэл маань шагнагдах болно.)
 - 3 Нифай 18:24 (Бид бусдад үлгэр дууриал байх болно.)
 - 3 Нифай 19:30 ба 27:30 (Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христ бидэнд сэтгэл хангалуун байх болно.)
2. Сүмийн сэтгүүлүүд, эсвэл чуулганы яриануудаас залбирлын тухай түүхүүдийг олж хүүхдүүдтэй хуваалц.
3. Сүмийн арван гурав дахь Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсоны дараах мэдэгдлийг уншиж ярилц:

“Их Эзэнээс нэмэлт адислал авахаар залбирч хичээнгүйлэн гуйх явдал бидэнд их байдаг. Гэвч би заримдаа хүртчихсэн адислалуудынхаа төлөөх баяр, талархалд залбирлынхаа ихэнхийг зориулах хэрэгтэй гэдгийг мэдэрдэг” (God, Family, Country, p. 199).

Хүүхдүүдээс нэг минутанд юунд талархалтай байдаг талаараа аль болох олон зүйл дурдахыг хүс. Тэдний хариултыг самбарт хураангуйлан бич.
4. Алма 13:28-ын “Их Эзэний өмнө өөрсдийгөө даруусган түүний ариун нэрийг дуудаж, та нарын өөрсдийн үүрч чадахаас илүүгээр тэр уруу таталтанд автагдахгүйн тулд үргэлж сэрэмжилж залбираасай, тэгснээр Ариун Сүнсээр удирдуулна” гэсэн хэсгийг ярилцаад хүүхдүүдэд цээжлэхэд нь тусална.
5. Залбирлын үндсэн хэсгүүдийг ярилц:
 - а. Тэнгэрлэг Эцэгтээ ханд . . .
 - б. . . . төлөө түүнд таларх
 - в. Түүнээс . . . гуй
 - г. Есүс Христийн нэрээр, амэн гэж хаа.

Самбар дээр “Би төлөө танд талархаж байна” гэж бич. Хүүхдүүдийг Тэнгэрлэг Эцэгтээ юунд талархдгийг хэлэхийг уриад тэдний санааг самбарт тоймлон бич. “Би . . . танаас гуйж байна” гэдгийг бас үүний адил хий.

Дүгнэлт

Гэрчлэл	Өдөр тутмын залбирлын ач холбогдлын тухай болон хэрэв бид Есүсийн зааснаар залбирвал бид Сатаны нөлөөллөөс хамгаалагдах болно гэсэн гэрчлэлээ хуваалц.
Зөвлөмж Болгогдсон Гэрийн Уншлага	Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ 3 Нифай 13:18–25 болон Алма 13:28–29-г судлахыг зөвлө. Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.

Нифайчуудын Дундах Амар Амгалан Байдал

Хичээл
38

Зорилго

Хүүхэд бүрийг Есүс Христийн сайн мэдээний дагуу амьдарснаар ирэх амар амгалан байдал болон аз жаргалыг эрэлхийлэхэд нь хүчирхэгжүүлнэ.

Бэлтгэл

- 3 Нифай 28:1–16, 23–40 болон 4 Нифайг залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii-ыг үз).
- Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго.
- Шаардлагатай материалууд: Хүүхэд бүрт Мормоны Ном.

Хичээл Заах Зөвлөмж

Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.

Анхаарал Татах
Ажиллагаа

Аврагч гэр бүлийнхэнтэй нь долоо хоногийн турш амьдрах болбол хүүхдүүдээс энэ нь ямар байхыг төсөөлөхийг хүс. Тэднээс тэр долоо хоногт гэр орон нь ямар байх болно гэж тэд бодож байгааг нь асуу. Нэг хүүхдээр 4 Нифай 1:15–16-г уншуул. Эдгээр шүлгүүд нь Америк дахь хүмүүс Есүс Христийг айлчилсны дараа бие биедээ хэрхэн хандаж байсныг дүрсэлдэг гэдгийг тайлбарла. Эдгээр нөхцөл байдлуудын дор амьдрах нь ямар байх талаар ярилцахад нь хүүхдүүдэд тусал.

- Хэрэв хүн бүр зарлигуудыг дуулгавартай дагавал бидний амьдрал хир их өөр байх вэ? (Бидэнд цоож, түлхүүр, цагдаагийн ажилчид зэрэг зүйлс хэрэггүй байх байсан.) Аз жаргалын хамгийн чухал түлхүүрүүдийн нэг бол бидний бусад хүмүүст хандах байдал юм гэдгийг хүүхдүүдэд ойлгоход нь тусал. Есүс Христийн сургаалын дагуу амьдарснаар бид гэр бүл болон найз нөхөддөө илүү найрсаг, хувиа хичээхгүйгээр хандах ба бид илүү их амар амгалан болон аз жаргалыг олох болно.

Судрын Хэсэг

3 Нифай 28:1–16, 23–40 болон 4 Нифайгаас Нифайчуудын шавь нарын тухай болон зарлигуудыг сахиснаараа Нифайчуудын олсон амар амгалан болон аз жаргалын тухай хэсгийг хүүхдүүдэд заа. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii- аас үз.)

Ярилцлага ба
Тавьж Болох
Асуултууд

Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншснаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.

- Есүс Христийн шавь нар түүнээс юу хүссэн бэ? (3 Нифай 28:2, 4–7.)
Гурван шавиа тэр яагаад эцсийг нь хүртэл дэлхий дээр үлдэхийг

зөвшөөрсөн бэ? (3 Нифай 28:6, 9.) Тэдэнд үүнийг хийхийг боломжтой болгохын тулд тэдний биенд ямар өөрчлөлтүүд хийгдсэн бэ? (3 Нифай 28:38–39.)

- Гурван шавь хүмүүст заахдаа хэрхэн хамгаалагдсан бэ? (3 Нифай 28:18–22.) Мормон эдгээр гурван шавийн тухай юу бичсэн бэ? (3 Нифай 28:24–26. Мормон Есүс Христийг төрснөөс хойш 350 оны үед амьдарч байсан гэдгийг анхааруул.)
- Аврагч шавь нараа орхисны дараа тэд юу хийсэн бэ? (3 Нифай 28:18.) Шавь нарын үгсийг сонсоод хүмүүс юу хийсэн бэ? (4 Нифай 1:1–2.) Хичнээн хүмүүс шашинд татагдан орсон бэ? Хүмүүс цаашид Нифайчууд, Лэмэнчүүд гэж хуваагдалгүй, харин нэгдмэл болсон гэдгийг анхааруул.
- *Зөрчил, маргаан* гэж юу гэсэн үг вэ? (4 Нифай 1:2. Хэрэлдэх, эсвэл зөрөлдөх.) Ямар ч зөрчилгүй байх үедээ та нар болон гэр бүлийнхэн тань хэрхэн адислагдаж байсан вэ? Та нар хэрхэн энхийг сахиулагч байж, гэр бүлээ зөрчлөөс зайлсхийхэд тусалж чадах вэ?
- Хүмүүс “тэд өөрсдийн дунд бүх зүйлийг нийтээр эзэмшиж байв” гэдэг нь юу гэсэн үг вэ? (4 Нифай 1:3.) Ийм байдлаар амьдрахын юу нь та нарт таалагдаж байна вэ? Энэ нь яагаад хэцүү байх болно гэж та нар бодож байна вэ?
- Есүс Христийн шавь нар ямар гайхамшгуудыг үйлдсэн бэ? (4 Нифай 1:5.)
- Хүмүүс хэрхэн адислагдсан бэ? (Баяжуулах үйл ажиллагаа 1-ийг үз.)
- Тэр нутагт яагаад зөрчил байгаагүй вэ? (4 Нифай 1:15.) Зүрх сэтгэлд орших “Бурханы хайр” гэдэг нь юу гэсэн үг вэ? Хэзээ та нар амьдралдаа Бурханы хайрыг мэдэрсэн бэ? Бид энэ хайрыг бусадтай хэрхэн хуваалцаж чадах вэ?
- Энэ аз жаргалтай нийгмийн өөрчлөлтөд юу нөлөөлсөн бэ? (4 Нифай 1:23–29.) Хүмүүс шавь нарт хэрхэн хандсан бэ? (4 Нифай 1:30–34.) Бардамнал гэж юу вэ? Бид амьдралдаа бардамналыг хэрхэн давж чадах вэ?
- Эдгээр хүмүүсийн хийсэн шиг “Христийн сайн мэдээний эсрэг санаатайгаар эсэргүүцэх” гэдэг нь юу гэсэн үг вэ? (4 Нифай 1:38.)
- Христийн айлчлалаас хойш 300 жил хүмүүсийн нөхцөл байдал ямар байсан бэ? (4 Нифай 1:45–46.)

Баяжуулах Үйл Ажиллагаа

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно.

1. 4 Нифай 1:2–3, 5, 15–17-ийн эдгээр хэллэгүүдээр үгийн хайчилбар бэлд.

“Хүмүүн бүр нэг нэгэнтэйгээ шударгаар харьцаж байсан.”

“Тэд өөрсдийн дунд бүх зүйлийг нийтээр эзэмшиж байв.”

“Тэд бүх төрлийн гайхамшгуудыг үйлдсэн.”

“Уг нутагт зөрчилдөөн огт байсангүй.”

“Бурханы хайр . . . хүмүүсийн зүрх сэтгэлд оршин байсан.”
 “Тэнд атаар жөтөө байгаагүй.”
 “Тэнд . . . үймээн самуун байгаагүй.”
 “Тэнд . . . худал хэлэх нь байгаагүй.”
 “Тэнд . . . дээрэмчид байгаагүй.”
 “Тэнд . . . алуурчид байгаагүй.”
 “Тэд нэгдмэл Христийн хүүхдүүд байсан.”

Үгийн хайчилбаруудыг саванд хийгээд, хүүхэд бүрээр нэг нэгийг авахуулж үүнийг нь үзүүлүүл. 4 Нифай дахь эдгээр хэллэгүүд нь хүмүүс яагаад амар амгалан болон аз жаргалтай амьдарч байсныг тайлбарласан.

2. Сүмийн арван гурав дахь Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсоны дараах мэдэгдлийг уншиж ярилц:

“Их Эзэн Сургаал ба Гэрээнд биднийг ‘Бардамналаас болгоомжил, үгүй бол та нар эртний Нифайчуудтай адил болно’ хэмээн сэрэмжлүүлсэн байдаг (С ба Г 38:39)” (Conference Report, Apr. 1989, p. 3, or *Ensign*, May. 1989, p. 4). Ерөнхийлөгч Бенсон бидэнд дараах зүйлүүдийг хийснээр амьдралдаа бардам байдлыг даван гарч, даруу, төлөв, дуулгавартай болж чадна хэмээн заасан:

Тэнгэрлэг Эцэгийг хайрлаж, түүнийг амьдралдаа нэгдүгээрт тавьснаар.

Бусад хүмүүс бидний тухай юу гэж бодохоос бус, Тэнгэрлэг Эцэг бидний тухай юу гэж бодох талаар санаа тавьснаар.

Хов жив ярих, эсвэл шүүмжлэхгүй байснаар.

Атаархах, эсвэл байгаа боломжоосоо дээгүүр амьдрахгүй байснаар Гэр бүл дотроо хэрэлдэж, тэмцэлдэхгүй байснаар.

Бусдыг өөрсдийнхөө талаар сайхан сэтгэгдэлтэй байхад нь тусалснаар.

Удирдагчдынхаа зөвлөгөөг хүлээн зөвшөөрснөөр.

Биднийг гомдоосон хүмүүсийг өршөөснөөр.

Хувиа хичээхгүй байснаар.

Бусдад тусалснаар.

Эдгээр мэдээллүүдийг үгийн хайчилбар болгон бэлтгээд уутанд хийж болно. Хүүхдүүд тус тусдаа нэг үгийн хайчилбар сугалж аваад, тэр зарчим нь бидний гэр бүлд байгаа бардам занг үгүй болгоход хэрхэн тусалж чадахыг ярилцаж болно.

3. 4 Нифай 1:15–16-г уншиж, ярилцаад бүгдийг нь буюу хэсгийг нь хүүхдүүдэд цээжлэхэд нь тусал.
4. Амьдралд жинхэнээсээ байдаг зөрчил маргаантай нөхцлүүдийг хүүхдүүдээр жүжигчлэн тоглуул. Хүүхдүүдээр хэрэв тэд Нифайн нийгэмд “зөрчилгүй”-гээр амьдарч байсан бол нөхцөл ямар байх байсныг жүжигчлэн тоглуул. (Зөвлөмж: хоёр хүүхэд хоёулаа дарааллын эхэнд байхыг хүсэх; эгч дүү хоёр хоёулаа нэг тоглоомоор тоглохыг хүсэх гэх мэт.)
5. Ахлагч Марвин Ж. Эштоны дараах мэдэгдлийг уншиж ярилц.

“ ‘Хэн нэг нь Есүс Христэд хөрвүүлэгдсэн гэдгийг та нар хэрхэн хэлж чадах вэ?’ . . . ‘Бидний бусад хүмүүст хандах хандлага маань бидний сүнслэг өсөлт, Христэд ирэх байдлын маань хамгийн сайн, хамгийн

тодоор харуулдаг илэрхийлэгч юм' ” (Conference Report, Apr. 1992, p. 25, or *Ensign*, May. 1992, p. 20).

6. Хүүхдүүдэд итгэлийн тунхгийн арван гурав дугаарыг цээжлэхэд нь тусал. Есүс Христийн Нифайчууд дээр айлчилсны дараа тэдний амьдарч байсан арга замтай энэ нь хэрхэн холбогддог хийгээд бид одоо хэрхэн амьдарч чадахыг ярилц.
7. Их Эзэн бидэнд түүний талаар сурч, түүний үгсийг сонсч, түүний Сүнсний даруу төлөв байдалд алхвал бид түүнээс амар амгаланг олох болно гэж заасан гэдгийг тайлбарла (С ба Г 19:23-ыг үз).

Дүгнэлт

Гэрчлэл	Аврагчийн зааснаар бид даруухнаар амьдарвал амар амгалан болон аз жаргалтай учирч чадна гэсэн гэрчлэлээ хуваалц.
Зөвлөмж Болгогдсон Гэрийн Уншлага	Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ 4 Нифай 1:1–18-ыг судлахыг зөвлө. Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.

Мормон Нифайчуудын Мөхлийг Гэрчилсэн

Хичээл
39

Зорилго

Бидний эргэн тойронд байгаа муу ёрын сүнсний нөлөөллийг үл хайхран Есүс Христийн сургаалд үнэнчээр үлдэх гэсэн хүүхэд бүрийн хүслийг хүчирхэгжүүлнэ.

Бэлтгэл

1. Мормон 1–6-г залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii-ыг үз).
2. Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго.
3. Шаардлагатай материалууд:
 - а. Хүүхэд бүрт Мормоны Ном.
 - б. Анхаарал татах ажиллагаанд үзүүлсний адил Мормоны зургаан бичмэл тодорхойлолт.
 - в. Зурагнууд: 4-1, Мормон Ялтсуудыг Хураангуйлсан нь (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 306, 62520); 4-51, Мормон Нэгэнтээ Агуу Байсан Үндэстэнд Сүүлийн Үгээ Хэлсэн нь (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 319, 62043).

Хичээл Заах

Зөвлөмж

Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.

Анхаарал Татах
Ажиллагаа

Самбарт *Мормон* гэж бич.

- Энэ үгийг сонсоод та нар юу бодож байна вэ?

Хүүхдүүдийг юу бодсон тухай нь ярилцсаны дараа өнөөдөр тэд бошиглогч Мормоны тухай сурах гэж байгааг нь тайлбарла. Зургаан хүүхэд тус бүрт залуу эр Мормоны талаарх дараах тодорхойлолтыг өгч ангийнханд нь уншуул.

Би ойролцоогоор МЭ 321 онд төрсөн.

Намайг арван настай байхад бошиглогч Аммарон надад намайг хорин дөрвөн нас хүрэхэд Нифайн том ялтсуудыг өгөх болно гэж хэлсэн (Мормон 1:2–4).

Би арван нэгэн настай байхдаа аавтайгаа хамт маш олон хүнтэй, том хот болох Зарахэмла руу нүүсэн. Тэр жил дайн дажин эхэлсэн (Мормон 1:6–8).

Намайг арван таван настай байхад Есүс Христ над дээр зочилж би түүний хайр, сайн сайхныг мэдэрсэн (Мормон 1:15).

Намайг арван зургаан настай байхад Нифайн бүх армийг удирдуулахаар томилсон (Мормон 2:1–2).

Ард түмнийхээ бусармаг байдлаас болж би зарлигуудыг сахих болон Тэнгэрлэг Эцэгт итгэхдээ хүчтэй байх хэрэгтэй болсон.

Бид Мормоны амьдралыг судалснаараа бидний эргэн тойронд байгаа муу ёрын сүнсний нөлөөллийг үл хайхран зөв шударгаар амьдрахад ямар их боломж байгааг бид ойлгоно гэдгийг хүүхдүүдэд тайлбарла.

Судрын Хэсэг

Мормон 1–6-гаас Мормоны Нифайн том ялтсуудыг эмхэтгэж байгаа болон Нифайчуудын сүйрлийн талаарх хэсгийг заа. Тохиромжтой үед нь зургуудыг ашигла. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii-аас үз.)

Ярилцлага ба Тавьж Болох Асуултууд

Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншнаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.

- Мормон хэрхэн болон яагаад бичээсүүдийг хадгалахаар сонгогдсон бэ? (Мормон 1:2–4.) Мормоны амьдралд тийм эрт өгсөнтэй адил үүрэг хариуцлагуудыг та нарт өгсөн бол та нар ямар сэтгэгдэлтэй байх байсан гэж та нар бодож байна вэ? Та нар өөрсдийгөө ийм нандин үүрэг хариуцлагад хэрхэн бэлтгэж чадах вэ?
- Тэр үед Нифайчууд болон Лэмэнчүүдийн хооронд юу болж байсан бэ? (Мормон 1:13.) Нифайчууд бусармаг байдлаасаа болж ямар сүнслэг адислалуудаа алдсан бэ?(Мормон 1:13–14) Ариун Сүнс бидэнтэй хамт байхаар амьдрах нь яагаад чухал вэ?
- Яагаад Мормон Нифайчуудад сайн мэдээ заахаас татгалзсан бэ? (Мормон 1:16–17.) Ямар байдлаар энэ бусармаг дэлхийд амьдрахад хэцүү вэ?
- Юу Нифайчуудыг нүглээ наманчилж эхлэхэд хүргэсэн бэ? (Мормон 2:10–11). Та хүүхдүүдэд Хиламан 13:18-аас Сэмүэлийн бошиглолыг сануулж болно.) Хүмүүсийн наманчлалын талаарх Мормоны аз жаргал яагаад удалгүй харуусал болсон бэ? (Мормон 1:12–15.) Бид хэрхэн чин сэтгэлээсээ нүглээ наманчилж чадах вэ?
- Дайны үеэр Мормон Нифайн том ялтсуудыг яасан бэ? (Мормон 2:16–18.) Мормон Нифайн том ялтсуудыг хураангуйлсан буюу нэгтгэсэн бошиглогч байсан учраас Мормоны Ном түүний нэрээр нэрлэгдсэнийг хүүхдүүдэд ойлгоход нь тусал. Мормон Нифайн том ялтсуудыг эмхэтгэж байгаа зургийг үзүүл. Мормон энэ хураангуйллыг хийж, түүний хүү Моронай тодорхой зүйлсийг нэмсэн ба Нифайн жижиг ялтсууд болох алтан ялтсуудыг Иосеф Смит Моронайгаас Кумора толгой дээр авсан.
- Яагаад Нифайчууд тулалдаанд амжилттай байдаг шигээ байгаагүй вэ? (Мормон 2:26–27.) Амьдралдаа “Их Эзэний хүчтэй” байхын тулд бид юу хийж чадах вэ?
- Мормон Нифайчуудад наманчлалын тухай заахад юу болсон бэ? (Мормон 3:2–3.) Яагаад олон хүмүүс Тэнгэрлэг Эцэг болон түүний бошиглогчдыг сонсдоггүй вэ?
- Хүмүүсийн бусармаг байдлаас болж Мормон эцэстээ юу хийсэн бэ? (Мормон 3:11.) Тэдний талаар хир их санаа тавьдгаа үзүүлэхийн тулд

тэр юу хийсэн бэ? (Мормон 3:12.) Тэнгэрлэг Эцэгийн зарлигуудыг сахидаггүй хүмүүсийн төлөө бид яагаад залбирах ёстой вэ?

- Ямар ямар бошиглогчид Нифайчуудын сүйрлийн талаар бошиггосон бэ? (Мормон 1:19, 2:10.) Эдгээр бошиглолуудын биелэлтэнд өөрсдийн бусармаг байдлаас болж хүмүүс ямар гачигдал, зовлон зүдгүүрт унасан бэ? (Мормон 2:8, 20, 4:11, 21, 5:16, 18, 6:7–9.) Та нар энэ гачигдал, зовлон найз нөхөд болон хөршүүдэд чинь тохиолдож байгааг харвал та нар тэдний төлөө юу хийхийг хүсэх вэ? Бид бусдыг Тэнгэрлэг Эцэгийн зарлигуудыг сахиж сурахад нь туслахын тулд юу хийж чадах вэ?(Баяжуулах үйл ажиллагаа 2-г үз.)
- Эдгээр дайн дажинд хичнээн хүмүүс алагдсан бэ? (Мормон 6:10–15. Баяжуулах үйл ажиллагаа 3-г үз.) Мормон ард түмнийхээ мөхлийн талаар ямар мэдрэмжтэй байсан бэ? (Мормон 6:16–22.)

Баяжуулах Үйл Ажиллагаа

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно.

1. Мормон ямар зорилгоор тэмдэглэл хөтөлсөн тухай ярилц (Мормон 3:20–22, 5:14–15). Хүүхэд бүрт наанадаж нэг шүлэг уншиж хариултуудыг олохыг даалга.
 2. Хүүхэд бүрээс нэг зарлиг нэрлэхийг хүс, Зарахемла буюу тэдний хотод хүн бүр зөвхөн тэр нэг зарлигийн дагуу амьдарвал ямар ялгаатай байх байсныг хэлүүл.
 3. Устгагдсан тэр их тооны хүмүүсийн талаар ярилц. Үүнийг хорин дөрвөн хүнээс бусад нь алагдсан 230, 000 хүнтэй хоттой харьцуул.
 4. Өөрийн үүрэгтээ үнэнч байхад нь Мормонд тус болсон агуу их итгэл ба эр зоригийн улмаас бидэнд ирдэг адислалуудын талаар хүүхдүүдтэй давт. Үүнд дараах зүйлийг багтааж болно:
 - Тэр муу ёрын сүнсээр хүрээлэгдэн байхдаа хэрхэн итгэлтэй хэвээр үлдэхийг бидэнд харуулан жишээ болсон.
 - Тэр ард түмнийхээ түүхийг бичсэн.
 - Тэр Нифайчуудын түүхийг эмхэтгэсэн.
 - Тэр өөрийн хүү Моронайдаа бичсэн захиагаараа бидэнд ухаалаг зөвлөгөө болон сургаалуудыг өгсөн.
- Бид эдгээр нандин бичээсүүдийн төлөө талархлаа хэрхэн үзүүлж чадах вэ?

Дүгнэлт

Гэрчлэл	Мормоны Номын тухай болон энэ нь биднийг муу ёрын сүнсний нөлөөллөөр хүрээлэгдэн байхад Есүс Христэд үнэнчээр үлдэхэд маань хэрхэн тусалж чадах тухай гэрчлэлээ ярь.
Зөвлөмж Болгогдсон Гэрийн Уншлага	Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ Мормон 1–7, 13–19-ийг судлахыг зөвлө. Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.

Жарэдчууд Амлагдсан Газар луу Хөтлөгдсөн нь

Зорилго

Хүүхдүүдийг амьдралынхаа туршид Ариун Сүнсний зааврыг эрэлхийлэхэд нь урамшуулна.

Бэлтгэл

1. Ифэр 1:1–4, 33–43, 2, 3, 6:1–13 болон Эхлэл 11:1–9-ийг залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii-ыг үз).
 2. Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго.
 3. Цаасан дээр “Босоод зогс, дороо эргэ, тэгээд чимээгүй суу” гэсэн хэллэгийг бич. Доорхи өөр хэлнүүдийг ашиглан, үлдсэн хүүхдүүд бүгд нэг нэгийг авч болохуйц хангалттай тоогоор хэллэгийг гадаад хэл дээр хий.
Герман: Steh auf, dreh dich um, und sitz still.
Итали: Alzati, girati, siediti, e stai tranquillo.
Дани: Rejs dig op, vend dig omkring, sæt dig stille ned.
Швед: Ställa upp, vänd dig omkring, sätt dig stilla ned.
Франц: Lève-toi, tourne-toi, et assieds-toi tranquillement.
Португал: Levante-se, vire-se, e sente-se silenciosamente!
Испани: Ponte de pie, date una vuelta, y siéntate en silencio.
 4. Шаардлагатай материалууд:
 - а. Хүүхэд бүрт Мормоны Ном.
 - б. Библи.
 - в. Зурагнууд: 4-44, Дэлхийн Газрын Зураг; 4-52, Жэрадын Ах Их Эзэний Хурууг Харсан нь (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 318, 62478); 4-53, Жарэдийн Хөлөг Онгоцнууд; 4-9, Есүс бол Христ (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 240, 62572).
-

**Хичээл Заах
Зөвлөмж**

Анхаарал Татах
Ажиллагаа

Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.

Хүүхэд бүрт өөр өөр хэл дээр бичсэн “Босоод зогс, дороо эргэ, тэгээд чимээгүй суу” хэллэгтэй нэг нэг цаасыг өг. Ангийн гишүүдээс цаасан дээрх заавруудыг дагахыг хүс.

- Яагаад та нар бүгд заавруудыг дагаж чадахгүй байна вэ?

Эхлэл 11:1–9-өөс Бабелийн Цамхгийн тухай түүхийг товч ярь.

- Та нар өөрсдийгөө хүрээлэн байгаа хүмүүсийг ойлгох чадваргүй байвал энэ нь та нарт ямар байх вэ? Өнөөдөр хүүхдүүд Бабелийн Цамхгийн үед амьдарч байсан нэгэн гэр бүлийн тухай сурах болно гэдгийг тайлбарла.

Судрын Хэсэг

Зургуудыг тохиромжтой үед нь ашиглан Ифэр 1–3 болон 6:1–13-аас Жарэдчуудын амлагдсан газар луу хөтлөгдөж байгаа хэсгийг заа. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii-аас үз.)

Ярилцлага ба
Тавьж Болох
Асуултууд

Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншнаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.

- Жарэдчууд гэж хэн байсан бэ? (Ифэр 1:33.) Их Эзэн яагаад тэдний хэлийг бусниулаагүй (өөрчлөх буюу будилуулах) вэ? (Ифэр 1:34–37.)
- Жарэдийн ах Тэнгэрлэг Эцэгээс юу гэж гуйсан бэ? (Ифэр 1:38.)
- Жарэдчууд аялалдаа зориулж ямар бэлтгэлүүдийг хийсэн бэ? (Ифэр 1:41, 2:2–3, 6:4.)
- *Балт зөгий* гэдэг нь юу гэсэн үг вэ? (Ифэр 2:3.)
- Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христ Жарэдчуудыг далай руу хийх аялалд нь хэрхэн хөтөлсөн бэ? (Ифэр 2:4–6.) Бид амьдралдаа тэнгэрлэг удирдамжуудыг хэрхэн хүлээн авч чадах вэ? (Залбирлын хариултуудаар, Ариун Сүнсээр, бошиглогчид болон бусад удирдагчдаар, судруудаар дамжуулан.)
- Яагаад Жарэдчууд сонгогдсон газар луу хөтлөгдсөн бэ? (Ифэр 1:42–43.)
- Их Эзэн яагаад Жарэдийн ахын талаар гонсгор байсан бэ? (Ифэр 2:14.) Их Эзэн Жарэдийн ахыг зэмлэсний дараа тэрээр юу хийсэн бэ? (Ифэр 2:15.) *Зэмлэнэ* гэдэг нь та нарт хийх ёстой зөв зүйл нь юу болохыг мэдүүлэхийн тулд та нарын хийж байгаа зарим буруу зүйлийг хэлнэ гэсэн үг юм гэдгийг тайлбарла.
- Усан онгоцнууд бараг дуусах дөхөж байхад Жарэдийн ахад тусламж хэрэгтэй байсан ямар хоёр асуудал гарч ирсэн бэ? (Ифэр 2:19.) Их Эзэн усан онгоцнуудын гэрэлтүүлгийн асуудлыг шийдэхийн тулд Жарэдийн ахад зааварчилгаа өгөхөөсөө өмнө түүнийг юу хийхийг хүлээж байсан бэ? (Ифэр 2:23, 25, 3:1.) Бид Жарэдийн ахын туршлагаас өөрсдийнхөө асуудлуудыг шийдэх талаар юу сурч болох вэ?
- Өөрийнхөө Есүс Христэд итгэх агуу итгэлийнхээ ачаар Жарэдийн ах усан онгоцнуудыг гэрэлтэй болгохын тулд юу хийсэн бэ? (Ифэр 3:1, 4–5.) Есүс Христ түүнд хэрхэн тусалсан бэ? (Ифэр 3:6.) Бид Есүс Христэд итгэх итгэлээ хэрхэн хөгжүүлж чадах вэ?
- Чулуунууд гэрэлтэж байхад үед Жарэдийн ах юу харсан бэ? (Ифэр 3:6–8.) Жарэдийн ах яагаад Есүс Христийг харах чадвартай байсан бэ? (Ифэр 3:9–15.) Есүс Христийн бие махбодын талаар Жарэдийн ах юу сурсан бэ? (Ифэр 3:6, 15–17.) Жарэдийн ах Есүсийн дэлхий дээр ирэхдээ хүлээн авсан бие махбодтой маш их адилхан харагддаг Есүс Христийн сүнсэн биеийг харсан гэдгийг ойлгоход нь хүүхдүүдэд тусал.
- Жарэдчуудыг далайг гаталж байхад тэдэнд ямар асуудлууд тулгарсан бэ? Их Эзэн тэдэнд хэрхэн тусалсан бэ? Жарэдчууд юу хийсэн бэ? (Ифэр 6:5–9.)
- Жарэдчууд амлагдсан газрын эрэг дээр газардмагцаа юу хийсэн бэ?

(Ифэр 6:12–13.) Ямар адислалуудад та нар талархдаг вэ? Бид Тэнгэрлэг Эцэгтээ адислалуудынхаа төлөө талархаж байгаагаа хэрхэн үзүүлж чадах вэ?

Баяжуулах Үйл Ажиллагаа

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно.

1. Газрын зураг, луужин, гар чийдэн зэрэг хэд хэдэн бодит зүйл, эсвэл зургуудыг үзүүл. Хүүхдүүдээр зүйл тус бүр биднийг хөтлөхөд хэрхэн тусалдгийг ярилцуул. Есүс Христийн зургийг үзүүлээд бид амьдралдаа хэрхэн сүнслэг удирдамжуудыг хүлээн авдгийг ярилц.
2. Итгэлийн тунхгийн дөрөвдүгээрийг давтаад, ярилц. Есүс Христийн зургийг үзүүлээд хүүхдүүдээс яагаад тэдний Их Эзэн Есүс Христэд итгэх итгэл нь сайн мэдээний анхны зарчим гэж бодож байгааг нь асуу. Бид яагаад нүглээ наманчилж, усаар батлуулж, Ариун Сүнсний бэлгийг хүлээн авахаасаа өмнө итгэлтэй байх ёстойг ярилц. Есүс Христэд итгэх итгэл нь бидний үйлдэл болон биеэ авч явах байдлыг хэрхэн сайжруулдаг талаар зарим жишээнүүдийг хүүхдүүдээр өгүүл. Бид түүнд итгэх итгэлээ хөгжүүлэхдээ агуу их болдог хүч чадал нь биднийх болдог хэмээн онцол.
3. Самбар, эсвэл хатуу цаас ашиглан 9 нүдтэй шоо дөрвөлжин хүснэгт хий. Ангийг хоёр бүлэгт хуваагаад, нэг нь Х-г нөгөө нь О-г аваг. Хэрэв та асуулт тавиад тэд зөв хариулбал тэр бүлэг Х, эсвэл О-гоо хаана тавихыг сонгож болно. Нэг эгнээнд гурван Х, эсвэл О-г авах зорилготой байна. Аль нэг асуулт орхигдовол, эсрэг баг тэр асуултанд хариулах боломжтой болно. (Хичээл 18-аас санаа авч болно.) Дараах нь Жарэдчуудын тухай тавьж болох тойм асуултууд юм (та өөр асуултуудыг нэмж болно).

Усан онгоц бүрт хэдэн чулуу байрлуулсан бэ? (Хоёр.)

Жарэд, түүний ах, тэдний гэр бүл болон найз нөхдөд нь далайг гатлахад хир их хугацаа шаардагдсан бэ? (Бараг жил.)

Бусармаг хүмүүсийн барьж байсан өндөр цамхаг ямар нэртэй байсан бэ? (Бабелийн Цамхаг.)

Жарэдийн ах яагаад арван зургаан жижиг чулуу бэлдсэн бэ? (Аялалынхаа гэрлийн эх үүсвэрийг хийхийн тулд.)

Есүс Христ чулуу бүрийг хэрхэн гэрэлтүүлсэн бэ? (Хуруугаараа тэдгээрт хүрч өөрийн хүч чадлаар.)

4. “Би Бурханы Хүүхэд” дууг дуулах, эсвэл үгийг нь унш (*Дуулал*, х. 58).

Дүгнэлт

Гэрчлэл

Хүүхэд болгон амьдралдаа Сүнстэй байхуйц зохистой амьдарвал тэд Ариун Сүнснээс удирдамж хүлээн авч чадна гэсэн гэрчлэлээ хуваалц.

Зөвлөмж
Болгогдсон

Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ Ифэр 3:6–16-г судлахыг зөвлө.

Гэрийн Уншлага

Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.

Жарэдчууд Бошиглогчдыг Эсэргүүцсэн нь

Хичээл
41

Зорилго Хүүхэд бүрт бошиглогчдыг сонсч, дуулгавартай дагахыг сонгосноороо өөрийнхөө амьдралд муу ёрын сүнсийг ялан дийлэхийг хүсэхэд нь тусална.

Бэлтгэл

1. Ифэр 2:10–12, 11:1–5, 12:1–5, 13:13–22, 14:1–2, 21, 15:1–6, 18–34 ба Омни 1:20–21-ийг залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii-ыг үз).
2. Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго.
3. Шаардлагатай материалууд:
 - а. Хүүхэд бүрт Мормоны Ном.
 - б. Зураг 4-54, Ифэр Жарэдчуудын Түүхийг Бичсэн.

**Хичээл Заах
Зөвлөмж**

Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.

Анхаарал Татах
Ажиллагаа

Дараахтай төстэй асуултуудыг тавь:

- Та нар том үлээсэн шаарыг зүүгээр хатгавал юу болох вэ?
- Хэрэв гэрт чинь байгаа ургамлыг гэрийнхэн чинь услахаа больвол юу болох вэ?
- Та нар оройтож унтаад нойроо хангалттай авахгүй байвал юу болох вэ?

Хүүхдүүдэд тэдний сонголт болгон үр дагавартай гэдгийг тайлбарла. Үр дагавар гэдэг нь бидний хийх сонголтуудын үр дүнд юу тохиолдохыг хэлнэ. Тэнгэрлэг Эцэг биднийг сайн сонголт хийхийг хүсдэг учраас судрууд болон бошиглогчид бидэнд сонголтын маань үр дагаварыг заадаг. Энэ хичээл нь Жарэдчууд болон бошиглогч Ифэрийн тухай юм. Ифэр Жарэдчуудад хэрэв тэд нүглээ наманчлахгүй байхыг сонго-вол үүний үр дагаварт бүх хүмүүс устгагдах болно гэдгийг хэлсэн.

Судрын Хэсэг

“Бэлтгэл” хэсэгт жагсаасан судруудаас Жарэдчуудын мөхлийн тухай хэсгийг хүүхдүүдэд заа. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii-аас үз.) Бошиглогчид хүмүүст Есүс Христэд итгэх итгэлтэй байж, нүглээ наманчлахыг заасан боловч тэд бошиглогчдыг эсэргүүцэж, алж байсан учраас бүхэл бүтэн Жарэдчуудын соёл иргэншил мөхсөн гэдгийг анхааруул. Зургийг тохиромжтой үед нь ашигла.

Ярилцлага ба
Тавьж Болох
Асуултууд

Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншнаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.

- Сонголт гэж юу вэ? (Сонгох чадвар.) Тэнгэрлэг Эцэг яагаад бидэнд сонголт өгсөн бэ? Бид сонголтуудыг хийснээрээ өсч, сурах болно гэдгийг ойлгоход нь хүүхдүүдэд тусал. Ямар нэгэн зүйлийг хүчээр хийлгэх нь биднийг түүнтэй адил болохыг сурахад туслахгүй гэдгийг Тэнгэрлэг Эцэг мэддэг.
- Жарэдчууд тэдний мөхлийг бошиглосон бошиглогчдыг яасан бэ? (Ифэр 11:1-5.) Өөрсдийн энэ мөхлийг зайлуулахын тулд Жарэдчууд юу хийж чадсан бэ? Бид үргэлж наманчлаж, нүгэл үйлдсэнээс үүсэх үр дагавараас зайлсхийж чадна гэдгийг тайлбарла.
- Кориантумр гэж хэн бэ? (Ифэр 12:1.) Ифэр гэж хэн бэ? (Ифэр 12:2.) Ифэр Жарэдчуудад юу гэж хэлсэн бэ? (Ифэр 12:3-4.)
- Ифэрийн сургаалын хариуд хүмүүс яасан бэ? (Ифэр 13:13.) Ифэр хаана нуугдсан бэ? (Ифэр 13:14.) Тэр агуйд байхдаа юу хийсэн бэ? Зарим хүмүүс яагаад бошиглогчдыг сонсохоосоо татгалздаг гэж та нар бодож байна вэ?
- Есүс Христ Ифэрийг Кориантумрт юу хэлэхийг тушаасан бэ? (Ифэр 13:20-21.) Кориантумр болон Жарэдчууд Ифэрт ямар хариу өгсөн бэ? (Ифэр 13:22.)
- Хүмүүсийн бусармаг явдал уг нутагт ямар аймшигт зүхэл авчирсан бэ? (Ифэр 14:1-2, 21, 15:2.) Иймэрхүү байдалтай амьдрах нь ямар байна гэж та нар бодож байна вэ?
- Сонголтоо ашиглан зөв сонголтуудыг хийх нь ямар үр дагавартай вэ? Хүүхдүүдээс зөв сонголтууд болон үр дагаваруудын жишээнүүдийг өгөхийг хүс. Буруу сонголт хийхийн үр дагавар юу вэ? Буруу сонголтууд болон тэдгээрийн үр дагаварын жишээнүүдийг өг.
- Кориантумр Шизэд өгсөн захиандаа цэргийн удирдагчаасаа татгалзан юу бичсэн бэ? (Ифэр 15:4.) Шиз юу гэж хариулсан бэ? (Ифэр 15:5.) Кориантумр болон түүний ард түмэн Шизийн ард түмэнд хэрхэн эсэргүүцэл үзүүлсэн бэ? (Ифэр 15:6.)
- Хүмүүс яагаад байлдсаар байсан бэ? (Ифэр 15:18-19.) Жарэдчууд бошиглогч Ифэрийг дуулгавартай дагасан бол юу болох байсан бэ? (Ифэр 13:20.)
- Жарэдчуудын сүүлчийн хоёр байлдагч хэн хэн байсан бэ? (Ифэр 15:29.) Хэн нь амьд үлдсэн бэ? (Ифэр 15:30-32.) Кориантумрыг хэн олсон бэ? (Омнай1:20-21.) Бошиглогч Ифэр Жарэдчуудын тухай бичсэн бичээсээ яасан бэ? (Ифэр 15:33.) Ифэрийн эцсийн гэрчлэл нь юу байсан бэ? (Ифэр 15:34.) Бидний амьдралын хамгийн чухал зорилго юу байх ёстой вэ?
- Хэрэв та нар Ифэр байгаад, ард түмнээ дуулгаваргүйгээсээ болж устгагдахыг нь харвал та нарт ямар мэдрэмж төрөх байсан гэж та нар бодож байна вэ?
- Энэ агуу эмгэнэлт явдлаас зайлсхийхийн тулд Жарэдчууд юу хийж болох байсан бэ? Амьд бошиглогчийг дагахаар сонгох нь өнөөдөр бидэнд хэрхэн тусалж чадах вэ? Өнөөдөр амьд бошиглогчдын ямар сургаалууд байна вэ? Хэрэв бид тэдний зөвлөгөөнүүдийг дагавал ямар адислалууд ирэх вэ?

Та энэ хичээлийн тойм болгон баяжуулах үйл ажиллагаа 3-ыг ашиглаж болно.

Баяжуулах Үйл Ажиллагаа


Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно.

1. Ангийнхаа хүүхдүүдэд зориулан ашиглаж болох Тэргүүн Зөвлөл болон Арван Хоёр Төлөөлөгчийн Чуулгын саяхны чуулганы захиасаас ярьж өг. Хүүхдүүдээс тэд амьд бошиглогчдыг хэрхэн дагаж болхыг нь асуугаад тэдний санаануудыг самбарт жагсаа. Ирэх долоо хоногт бошиглогчдыг дагаж болох нэг аргыг хүүхдүүдээр сонгуул.
2. Хичээлээс өмнө тусдаа цааснууд дээр *дуулгавартай байдал* гэсэн үгийн үсэг бүрийг бичээд ангийн эргэн тойрон нуу. Та хүүхдүүдэд хэдэн үсэг нуусан гэж хэл. Үсэг бүрийг олох тусгай заавруудыг өг. Бүх үсгүүдийг олсны дараа тэдгээрийг шал, эсвэл самбар дээр *дуулгавартай байдал* гэсэн үгний байрлалаар тавь. Тэд хэрхэн бүх үсгүүдийг олох чадвартай байсныг нь асуу. Тэнгэрлэг Эцэг биднийг дуулгавартай байдлыг сонгохыг хүсдэг гэдгийг хүүхдүүдэд заа. Дуулгавартай байдлыг сурах нь дэлхий дээр байгаагийн бидний үндсэн шалтгаануудын нэг юм. Тэнгэрлэг Эцэг биднээс сонголтоо ашиглаж Сүмийн удирдагчдын зөвлөгөөг дуулгавартай дагах явдлыг сонгохыг хүсдэг. Хүүхдүүдээс аз жаргалтай байхын тулд тэдний хийж чадна гэж бодож байгаа хамгийн чухал зүйл нь юу болохыг асуу. *Дуулгавартай байдал* гэж уншигдах үсгүүдийг зааж харуул. Тэнгэрлэг Эцэг биднээр юу хийлгэхийг хүсч байгаагаа судруудад болон Сүмийн удирдагчдаар дамжуулан хэлдэг гэдгийг онцол. Бид сонголтоо дуулгавартай байдал болон түүний юу хэлснийг хийхдээ ашиглавал тэр бидэнд аз жаргалыг олоход туслах болно.
3. Дараах үгийн хайчилбаруудыг хий:
 - Зөв шударга байдал
 - Адислалууд
 - Хөгжил цэцэглэлт
 - Бардамнал
 - Бусармаг байдал
 - Гай зовлон, эсвэл мөхөл
 - Төлөв төвшин байдал
 - Наманчлал

Түүхийн бүхэл хугацаанд Тэнгэрлэг Эцэг хүмүүсийг зөв шударга байх үед нь хөгжил цэцэглэлтээр адисладаг байсан гэдгийг тайлбарла. Харамсалтай нь энэ хөгжил цэцэглэлт нь бардамнал, бусармаг байдал руу, заримдаа бүр бүрэн усгагдал руу хөтөлдөг.

Энэ бол Жарэдчуудад тохиолдсон явдал юм гэж тайлбарла. Эхлээд тэд зөв шударга хүмүүс байсан ба адислагдаж, хөгжин цэцэглэсэн. (Самбарт том тойрог зураад хүүхдүүдээр “Зөв шударга байдал”, “Адислалууд” болон “Хөгжил цэцэглэлт” гэсэн үгийн хайчилбаруудыг тойрог дээр тохирох газар нь тавиул (загварыг хар). Тэгээд Жарэдчууд бардам, бошиглогчдыг эсэргүүцсэн хүмүүс болсон. Хүмүүс бусармаг явдалтай болж улмаар бүхэлдээ устгагдсан. Хүүхдүүдээр “Бардамнал”,

“Бусармаг байдал”, “Гай зовлон, эсвэл мөхөл” гэсэн үгийн хайчилбаруудыг тойрог дээр тохирох газар нь байрлуул. Жарэдчууд устгагдахаасаа өмнө өөрсдийгөө даруусган, нүглээ наманчилсан бол тэд эргээд зөв шударга амьдарч ирэх адислалуудыг эдлэн баясах байсан гэж тайлбарла. (Хүүхдүүдээр “Төлөв төвшин байдал” болон “Наманчлал” гэсэн үгийн хайчилбаруудыг тойрог дээр тохирох газар нь байрлуул.) Энэ тойрог нь үндэстэн болгоны түүхэнд байдгийн адил бидний хувийн амьдралд ч бас үргэлж тохиолдох болно гэдгийг хүүхдүүдэд ойлгоход нь тусал.



4. Хүүхдүүдийн гэр бүлийнхэнтэйгээ хуваалцахаар гэр лүүгээ авч явах түүхийн тойргийг өөрсдөөр нь хийлгүүл. Хүүхдүүд тойргууддаа “бошиглогчдыг сонсох нь”, “эцэг эхдээ дуулгавартай байх”, “өдөр бүр залбирах”, “талархлаа илэрхийлэх”, “бусдад үйлчлэх” гэх зэргийг багтааж үүний өөрийн болгож болно.
5. “Бид Энэ Дэлхийд Түүний Үнэнийг Авчирна” дууг дуулах, эсвэл үгийг нь унш (*Хүүхдийн Дууны Ном*, х. 67).

Дүгнэлт

Гэрчлэл	Бид Тэнгэрлэг Эцэгийн бошиглогчдыг сонсож дагахыг сонговол адислагдаж, муу ёрын сүнсийг ялан дийлж чадна гэж гэрчил.
Зөвлөмж Болгогдсон Гэрийн Уншлага	Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ Ифэр 13:13–22 болон 15:33–34-ийг судлахыг зөвлө. Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.

Моронай болон Түүний Бичээсүүд

Хичээл
42

Зорилго

Мууг биш, сайныг сонгохыг хүсэхэд нь хүүхдүүдэд туслах ба ингэснээр тэд энэрэл болон Христийн цэвэр хайраар адислагдана.

Бэлтгэл

1. Мормон 8:2–6 болон Моронай 1, 7–8-ыг залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii-ыг үз).
 2. Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго.
 3. Шаардлагатай материалууд:
 - а. Хүүхэд бүрт Мормоны Ном.
 - б. Зураг 4-51, Мормон Нэгэнтээ Агуу Байсан Үндэстэнд Сүүлийн Үгээ Хэлсэн нь (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 319, 62043).
-

Хичээл Заах Зөвлөмж

Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.

Анхаарал Татах
Ажиллагаа

Мормон Нэгэнтээ Агуу Байсан Үндэстэнд Сүүлийн Үгээ Хэлсэн нь зургийг үзүүлээд, зурган дээрх хүмүүсийг хэн болохыг хүүхдүүдээс асуу.

Мормон нандин бичээсүүдийн хэсгийг өөрийн хүү Моронайд Лэмэнчүүдээс хамгаалах, мөн Моронайгаар тэмдэглэлийг дуусгуулахын тулд өгсөн гэдгийг тайлбарла. Хүүхдүүдээр Мормон 8:2–5 -аас Моронайн үгсийг уншуул.

Мормон 6-гийн хуудасны доод хэсэг дэх Нифайн сүүлчийн тулалдааны оныг олж Моронай хир удаан ганцаараа байсныг нь ойролцоогоор тодорхойлоход нь хүүхдүүдэд тусал. Тэгээд хүүхдүүдээр Моронай 10-ын сүүлчийн хуудасны доод хэсэгт жагсаасан оноос үүнийгээ хасуул (421-385=36 жил).

Хүүхдүүдээс тэд ер нь хир удаан ганцаараа байсныг нь асуу. Тэднийг 36 жилийн турш ганцаар байх нь ямар байхыг төсөөлөхөд нь тусал.

Моронай алтан ялтсуудыг ирээдүйн үеүүдэд Мормоны Ном болон ирж болохын тулд, мөн бидэнд Есүс Христтэй адил болоход туслахын тулд дуусгахаар олон бэрхшээлүүдийн дунд амьдарч байсан гэж тайлбарла.

Та бас баяжуулах үйл ажиллагаа 1-ийг анхаарал татах ажиллагаа болгон ашиглаж болно.

Судрын Хэсэг

Мормон 8:2–6 болон Моронай 1, 7–8-аас Моронайн цөлд ганцаараа амьдарч байсан болоод аавынхаа үгсийг ялтсууд дээр бичиж байгаа хэсгийг хүүхдүүдэд заа. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii-аас үз.)

Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншнаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.

- Нифайчуудын бичээсийг дуусгахын тулд Моронай өөр нэгэн соёл иргэншлийн товч түүхийг бас нэмэлт болгон бичсэн. Эдгээр хүмүүс хэн байсан бэ? (Моронай 1:1.)
- Моронай Есүс Христийн талаар ямар сэтгэгдэлтэй байсан бэ? (Моронай 1:2–3.) (Та Есүс Христийн тухай гэрчлэлээ ярьж болно.) Есүс Христийн тухай гэрчлэлтэй байх нь бидэнд зөвийг сонгоход хэрхэн тусалж чадах вэ?
- Сайныг хийх талаар Моронай юу бичсэн бэ? (Моронай 7:6–8.) Зөв хандлагатайгаар сайхан сэтгэлийн үйлс хийх нь яагаад чухал вэ? Есүс Христийн Сүмийн гишүүдийн хувьд ямар бэлгүүдийг өгч байхыг бидэнд тушаасан бэ? (Үйлчлэл, хайр, дуулгавартай байдал, аравны нэг, мацгийн өргөл.)
- Биднийг хэрхэн залбирах ёстой талаар Моронай юу бичсэн бэ? (Моронай 7:9.) Бид залбирлуудаа илүү чин сэтгэлийн болгохын тулд юу хийж чадах вэ?
- Бидэнд сайн, мууг ялгахад маань туслах ямар сүнснийг бид бүгдэд өгсөн бэ? (Моронай 7:15–18. Христийн гэрэл нь ямагт хүний дотоод сэтгэл гэгддэг байсныг тайлбарла.) Биднийг усаар батлуулахад Тэнгэрлэг Эцэг бидэнд ямар нэмэлт тусламжийг илгээдэг вэ? (Ариун Сүнсний бэлэг.) Бид энэ мэдлэгийг шийдвэрүүд гаргахдаа хэрхэн ашиглаж чадах вэ? (Баяжуулах үйл ажиллагаа 2-ыг үз.)
- Моронай энэрлийн тухай юу бичсэн бэ? (Моронай 7:45, 47. Баяжуулах үйл ажиллагаа 3 ба 4-ийг үз.) Энэрэлтэй байх нь бидэнд яагаад чухал вэ? (Моронай 10:21.)
- Христийн цэвэр хайртай (энэрэлтэй) болохын тулд бид юу хийж чадах вэ? (Моронай 7:48.) Биднийг Христийн цэвэр хайртай байвал бидэнд ямар адислалууд амлагдсан бэ?
- Жаахан хүүхдүүдийг усаар батлах тухай Моронай юу бичсэн бэ? (Моронай 8:8–10.) Хариуцлага бүхий байна гэдэг нь юу гэсэн үг вэ? (Сайн, мууг таньж мэдэх чадвартай байх болон сонголтууддаа хариуцлага хүлээнэ.) Хэдэн наснаасаа бид үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээх вэ? (Найман наснаасаа. С ба Г 68:25, 27-г үз.)
- Нифайчууд болон Жарэдчууд өөрсдийнхөө амьдралд энэрлийн зарчмыг ашигласан бол тэдний түүх хир өөр байх байсан гэж та нар бодож байна вэ?

Баяжуулах Үйл Ажиллагаа

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно.

1. Энэ үйл ажиллагаанд танд нэг тугалган хавтан болон хадаас хэрэг болно. (Лаазны том тагийг тугалган хавтан болгон хэрэглэж болно. Бүх

хурц ирмэгүүдийг нь наадаг туузаар бүр.) Хүүхдүүдийг ээлж ээлжээр нь хадаас ашиглуулан үсэг, эсвэл дараах: *Би одоо, Моронай . . .* гэсэн үгсийн хоёрыг металл буюу тугалган хавтан дээр зуруул. Металл ялтсууд дээр Бурханы үгийг сийлсэн Мормоны Номны бичээсийг хөтлөгчдөд талархлаа илэрхийл.

2. Хичээлдээ дараах буюу үүнтэй төстэй сонголтуудын жишээнүүдийг ашигла. Хүүхдүүдэд мууг бус, сайныг сонгоход нь тэдэнд туслах Моронай 7:16-г ашиглуул.

Та нарыг найз нөхөдтэйгөө бөмбөг тоглож байхад нэг их сайн тоглож чаддаггүй хүүхэд танай багт орохыг хүслээ. Найз нөхөд чинь та нарт тэр хүүхэд танай багт тогловол та нарыг тоглоомондоо хожигдоно гэж хэлэв. Та нар тэр хүүхдийг өөрсөдтэйгөө тоглож болохгүй гэж хэлэхээр бодож байна. Өөрсдөөсөө “Энэ сонголт нь намайг сайныг хийж, Есүс Христэд итгэхэд урьж байна уу?” гэж асуу.

Та нар хэдхэн л хором үргэлжилсэн ёс суртахуунгүй үйл явдалтай кино үзэж байна. Та нар киног орхиж явахаасаа ичив. Өөрсдөөсөө “Энэ киног үзэх нь нь намайг сайныг хийж, Есүс Христэд итгэхэд урьж байна уу?” гэж асуу.

Та нар дэлгүүрт байна, худалдагч нь алдаа хийж та нарын худалдаж авсан юмнаас зөв хэмжээний мөнгө аваагүй. Та нар тухайн юм нь та нарын төлснөөс илүү үнэтэй гэдгийг мэднэ, гэвч худалдагч алдаа гаргачихлаа. Өөрсдөөсөө “Буруу төлөх нь намайг сайныг хийж, Есүс Христэд итгэхэд урьж байна уу?” гэж асуу.

Бишоп чинь та нарыг өдөр бүр Мормоны Номноос унш гэсэн. Заримдаа судрын үгсийг та нарт ойлгоход хэцүү байдаг. Өөрсдөөсөө “Өдөр бүр судраас унших нь надад сайныг хийхэд тусалж, намайг Христэд итгэхэд урьдаг уу?” гэж асуу.

3. Моронай 7:45 дахь энэрлийн шинж чанаруудыг хүүхдүүд ойлгож чадахын тулд нэр томъёонуудыг нь ашиглан тайлбарла. Та хүүхдүүдээр Моронайн тодорхойлолтуудыг өөрийнхөө тайлбартай тулгуулж болно.

Удаан тэвчдэг: Тэвчээртэй байдаг
 Энэрэнгүй: Харгис, эсвэл муу санаатай биш, хайр бүхий
 Атаархдаггүй: Атаач, жөтөөч биш
 Бардам зан гаргадаггүй: Даруу, бардам биш
 Өөрийнхийг эрэлхийлдэггүй: Хувиа хичээдэггүй
 Уурладаггүй: Уурлахдаа удаан, өршөөхдөө хурдан
 Муу санаагүй: Итгэмтгий, сайн сайхныг эрдэг
 Үнэнд баярладаг: Үнэнч
 Бүхнийг өөртөө үүрдэг: Дуулгавартай байдал
 Бүгдэд итгэдэг: Итгэл дүүрэн
 Бүгдэд найддаг: Өөдрөг, итгэлтэй байх
 Бүгдийг тэсвэрлэдэг: Тэвчээртэй, цөхрөлтгүй

4. Моронайд Христийн цэвэр хайр байсан. Моронайн энэрлийн дараах жишээнүүдийн заримыг нь олоход хүүхдүүдэд тусал, эсвэл та хүүхдүүддээ Моронайн түүхийг хэлэхдээ дараах жишээнүүдийн заримыг ашигла.

Удаан тэвчдэг: Моронай бичээсүүдийг тэвчээртэй хөтөлж бараг гучин зургаан жил гаруй ганцаар амьдарсан (Мормон 8:5).

Энэрэнгүй: Моронай бидний төлөө залбирч, өөрийнхөө ах нарт хайртай байсан (Ифэр 12:36, 38).

Атаархдаггүй: Моронай бидний үеийг харж, бидэнд атаархуу, эсвэл бардам байж болохгүй гэж зөвлөсөн (Мормон 8:35–37).

Бардам зан гаргадаггүй: Моронай бичгийн сул дорой байдлын учир даруу байсан (Ифэр 12:23–25).

Өөрийнхийг эрэлхийлдэггүй: Моронай биднийг Есүс Христийн тухай мэдлэгтэй болгохын тулд хувиа хичээлгүйгээр ажиллаж залбирсан (Мормон 9:36, Ифэр 12:41).

Уурладаггүй: Моронай өөрийн дайснуудыг өршөөж, тэдэнд хэрэг болно хэмээн найдсан юмсыг бичихдээ хичээнгүйлэн ажилласан (Моронай 1:4).

Муу санаагүй: Моронай биднийг сайныг хүлээн авч мууд хүрэхгүй байхыг уриалсан (Моронай 10:30).

Үнэнд баярладаг: Моронай үнэнч байсан (Моронай 10:27).

Бүхнийг өөртөө үүрдэг: Моронай Есүс Христээс татгалзаагүй учраас өөрийн аюулгүй байдлын төлөө ганцаар тэнүүчилсэн (Моронай 1:2–3).

Бүгдэд итгэдэг: Моронай биднийг Есүс Христэд итгэхэд урамшуулдаг (Мормон 9:21). Моронайн итгэл маш агуу байсан тиймээс тэр Христтэй нүүр нүүрээрээ уулзах боломжтой байсан. (Ифэр 12:39).

Бүгдэд найддаг: Моронай итгэл найдвартай байхын ач холбогдлыг ойлгосон (Ифэр 12:32).

Бүгдийг тэсвэрлэдэг: Моронай эцсээ хүртэл итгэлтэй байсан (Моронай 10:34).

5. Моронай үйлчлэлд анх дуудагдахдаа эцгээсээ захиа хүлээн авсан. Захианыхаа нэг хэсэгт Мормон хүүгээ гэсэн өөрийн хайр, хүндэтгэл, санаа тавьж байгаагаа илэрхийлсэн (Моронай 8:2–3-г үз.) Хичээлийг заахаас өмнө анги дахь хүүхэд бүрийн эцэг эх, насанд хүрсэн ойр дотны хүн, эсвэл найз нөхдөөр нь хайр болон хүндэтгэлийн захиа бичүүл. Та Мормоны, хүү Моронайдаа өгсөн хайрыг тайлбарлаж байхдаа эдгээр захиануудыг хүүхдүүдэд өг. Моронай энэ захиагаа үнэлэн дайснуудаасаа зугтааж байхдаа өөртэйгөө авч явж байсан гэдгийг анхааруул. Эцэг эх болон Их Эзэнээ баярлуулах сайн зүйлүүдийг үргэлжлүүлэн хийж байх санамж болгон хүүхдүүдэд эдгээр захиануудаа хадгалахыг зөвлө.

6. Итгэлийн тунхгийн арван гуравдугаарыг давт.

Дүгнэлт

Гэрчлэл

Моронайд талархлаа илэрхийлээд, түүний бичээсүүдийн үнэний тухай гэрчлэлээ хуваалц. Бага багаар бид Христтэй адил болж чадна гэж гэрчил.

Зөвлөмж

Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ Моронай 1, 7:5–19, 43–48-ыг судлахыг зөвлө.

Болгогдсон

Гэрийн Уншлага

Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.

Моронай Есүс Христэд Итгэх Итгэлийг Заасан нь

Хичээл
43

Зорилго

Хүүхэд бүрийг Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлэхийг урамшуул.

Бэлтгэл

- Ифэр 12:6–41 болон Моронай 7:21–28, 33–34-ийг залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii-ыг үз).
 - Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго.
 - Анхаарал татах ажиллагаанд зориулан (Ифэр 12:6-гаас) дараах зургаан үгийн хайчилбарыг бэлд:
Итгэл
бол
найдагдсан
боловч
үзэгдээгүй
зүйлүүд
юм
 - Шаардлагатай материалууд:
 - Хүүхэд бүрт Мормоны Ном.
 - Зурагнууд: 4-9, Есүс бол Христ (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 240, 62572).
-

Хичээл Заах Зөвлөмж

Анхаарал Татах
Ажиллагаа

Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.

Хичээлийн өмнө “Итгэл бол” гэсэн үгийн хайчилбар болон Есүс Христийн зургийг самбар, эсвэл ханан дээр байрлуул. Итгэлийн тодорхойлолтонд зориулсан бусад үгийн хайчилбаруудын тус бүрийг хэд хэдэн хүүхдийн сандлан доор байрлуул.

Хүүхдүүдээр үгийн хайчилбаруудыг олуулаад, тэдгээрийг ангийн урд авчирч, дарааллаар нь байрлуул.

Бүрдүүлсэн судрыг уншаад ярилц (Ифэр 12:6).

- Та нар үзэдээгүй ямар зүйлүүдийг харахыг хүсч байна вэ? Тэдгээр нь байдаг гэдгийг та нар хэрхэн мэддэг вэ?
- Хэдийгээр бид Есүс Христийг өөрсдийнхөө нүдээр хараагүй ч бид түүнийг амьдардаг гэдгийг хэрхэн мэддэг вэ?
- Есүс Христэд итгэлтэй байна гэдэг нь юу гэсэн үг вэ? (Бид Есүс Христийг дуулгавартай дагаж, түүнтэй илүү адил болохоор эрэлхийлэх тийм хүчтэйгээр түүнд итгэх итгэлтэй байх)

- Хэрэв та нар Есүс Христэд итгэлтэй байвал тэрээр та нарт ямар арга замуудаар тусалж чадах вэ? (Тэр та нарт тайвшрал, удирдамж, амар амгалан, хүч, эдгэрэлтийг өгч чадна.)

Мормоны Ном нь Есүс Христэд итгэх итгэлтэй байсныхаа ачаар агуу адислалуудыг хүртэж, гайхамшгуудыг хийсэн олон хүмүүсийн тухай заадаг гэдгийг тайлбарла.

Судрын Хэсэг

Моронай 7:21–28, 33–34 болон Ифэр 12:6–41-ээс Мормон болон Моронайн итгэлийн тухай сургаалуудыг хүүхдүүдэд заа. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii-аас үз.) Мормон болон Моронай нар итгэлээрээ дамжуулан адислагдсан олон хүмүүсийн тухай бичсэн гэдгийг тайлбарла.

Ярилцлага ба Тавьж Болох Асуултууд

Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншснаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.

- Хэрэв бид Есүс Христэд итгэлтэй байх юм бол тэр биднийг юу хүлээн авна гэж хэлсэн бэ? (Моронай 7:33.) (Баяжуулах үйл ажиллагаа 1-ийг үз.)
- Моронай сайн мэдээний гэрчлэлийг хэрхэн хүлээн авах талаар юу заасан бэ? (Ифэр 12:6.) “Итгэлийн тань сорилт”-той байна гэдэг нь юу гэсэн утгатай вэ? (Та нарын итгэл ямар нэгэн байдлаар шалгагдана гэсэн үг.)
- Хүн болгон сул талтай гэдгийг тайлбарла. Есүс Христэд итгэлтэй байх нь ямар арга байдлаар биднийг сул талаа даван туулахад тусалдаг вэ? (Ифэр 12:27.)
- Есүс Христэд итгэх итгэл маань бидэнд ямар ямар зүйлүүдийг хийхэд тусалдаг вэ? (Залбирал, залбирлуудынхаа хариуг авах, нүглээ наманчлах, усаар батлуулах, Ариун Сүнсний өдөөлтийг дагах, бусдад үйлчлэх, уруу таталтын эсрэг зогсох, аравны нэгээ төлөх, сорилтуудтай тулгарах, “Уучлаарай” гэж хэлэх, сүмдээ очих, Мэргэн Ухааны Үгийг дуулгавартай дагах гэх мэт.)
- Тэнгэрлэг Эцэг итгэлтэй хүмүүст залбирлын тухай ямар амлалтыг өгдөг вэ? (Моронай 7:26.) Та нарын залбирал хэрхэн хариулагдаж байсан бэ?

Хүүхдүүдэд Есүс Христийн тухай сэтгэгдлээ илэрхийлэх цаг гаргаж өг. Эдгээр сэтгэгдэл нь тэд түүнд итгэлтэй байгааг үзүүлж байгаа гэдгийг тайлбарла.

Баяжуулах Үйл Ажиллагаа

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно.

1. Тусдаа цааснууд дээр бичсэн дараах хүн тус бүрийн нэрийг хайрцганд хий. Хүүхдүүдээр ээлж ээлжээр нь нэг нэг цаас авахуулаад, тохиромжтой зургийг ашиглан цаасан дээр нэрлэгдсэн хүмүүс Есүс

Христэд итгэх итгэлтэй байсныхаа төлөө хүч чадлаар хэрхэн адислагдаж байсан тухай түүхийг товч яриул.

Алма, Амюлек хоёр шорон нурахад нөлөөлсөн (Алма 14:26–28). Алма, Амюлек хоёр Нурсан Шоронгоос Гарч Ирсэн нь, 4-29 зургийг үзүүл.

Нифай, Лихай хоёр шоронд хоригдож галаар хүрээлэгдсэн (Хиламан 5:44–52). Нифай, Лихай Хоёр Шоронд, 4-41 зургийг үзүүл.

Алма Лэмонай Хааны хонин сүргийг аварсан (Алма 17:29-18:3, 26:12). Аммон Ламонай Хааны Хонин Сүргийг Хамгаалсан нь, 4-30 зургийг үзүүл (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 310, 62535).

Жарэдийн ах Есүс Христийн сүнсэн биеийг харж, уулыг хөдөлгөсөн (Ифэр 3, 12:30). Жарэдын Ах Их Эзэний Хурууг Харсан нь, 4-52 зургийг үзүүл (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 318, 62478).

2000 дайчдын амь нас тулалдаанд хэлтрүүлэгдсэн (Алма 56:44–56). Хоёр Мянган Залуу Дайчид, 4-40 зургийг үзүүл (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 313, 62050).

Нифай гуулин ялтсуудыг авсан (1 Нифай 4:1–31). Нифай Лихай дээр Гуулин Ялтсуудтай Эргэж Ирсэн нь, 4-8 зургийг үзүүл.

Лихай болон түүний гэр бүл амлагдсан газар луу Лиахонагаар удирдагдсан (1 Нифай 16:28–29, 18:23). Лихай болон Түүний Хүмүүс Амласан Газарт Ирсэн нь, 4-20 зургийг үзүүл (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 304, 62045).

Есүс Христ агуу их хүч чадалаар өөрийнхөө шавь нарт үзэгдсэн (Ифэр 12:31). Есүс Америк Тивд Сургаалыг Заасан нь, 4-45 зургийг үзүүл (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 316, 62380).

Абинадай Есүс Христийн тухай гэрчлэлийнхээ төлөө үхэхэд бэлэн байсан (Мозая 17:7–20). Абинадай Ноа Хааны Өмнө, 4-22 зургийг үзүүл (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 308, 62042).

2. Хүүхдүүдтэй Би хэн бэ? тоглоомыг тогло. Тэдэнд дараах түлхүүр үгсийг өгч тэднээр ярьж байгаа хүнээ таалга.

Би Есүс Христэд итгэх итгэлээ ашиглан бүхэл өдөржин, бүхэл шөнөжин залбирсан (Инос).

Итгэлийн улмаас тэнгэрийн элч миний хүү болон Мозаягийн дөрвөн хүүд тэднийг наманчлуулахын тулд үзэгдсэн (Алма).

Би ард түмнээ Есүс Христэд итгэлтэй байж, өөрсдийн эрх чөлөө болон гэр бүлүүдийнхээ төлөө тэмцэхэд нь зоригжуулахаар онцгой далбаа хэрэглэсэн (Ахмад Моронай).

Би итгэлтэй байсан тул гэр бүлээ авч Лихай болон түүний гэр бүлтэй хамт цөл рүү явахыг сонгосон (Ишмэил).

Би гуулин ялтсуудыг авчрахаар Иерусалим руу буцах итгэлтэй байсан (Нифай).

Есүс Христэд итгэх итгэл маань надад түүний хурууг, тэгээд түүний бүхэл оршихуйг харахыг боломжтой болгосон (Жарэдын ах).

Ээжүүдийн маань бидэнд заасан Есүс Христэд итгэх итгэл маань бидний амийг тулалдаанд аварсан (2000 дайчин хөвгүүд).

Есүс Христэд итгэх итгэл маань, мөн түүний сайн мэдээг тунхаглах хүсэл маань надад Лэмонай Хааны хонийг алах гэж байсан дээрмчдийг ялахад тусалсан (Аммон).

Бидний итгэл шоронг нурахад нөлөөлсөн (Алма, Амюлек хоёр).

Итгэлийнхээ улмаас шоронд хоригдож байхдаа бид галаар хүрээлэгдсэн (Нифай, Лихай хоёр).

Есүс Христэд итгэх итгэлтэй байгаагийнхаа улмаас бид үхэл үзэхгүй (Гурван Нифай).

Есүс Христэд итгэх итгэлээрээ дамжуулан бид амлагдсан газар луу Лиахонагаар удирдуулсан (Лихай болон түүний гэр бүл).

3. Есүс Христэд итгэх итгэлээ хүчтэй болгоход бидэнд дараах үйл ажиллагаанууд нь хэрхэн тусалж чадахыг ярилц:

Судраас суралцах: Та нар Есүс Христ болон түүний хийсэн зүйлүүдийн тухай сурч байхдаа түүнийг хайрлах агуу их хайр болон түүнд итгэх итгэлээ хөгжүүлнэ.

Залбирал: Бид Тэнгэрлэг Эцэгээс Есүс Христэд итгэх итгэлийг маань хүчирхэгжүүлэхэд туслахыг хүсч болно.

Есүс Христийн сургаалуудыг дуулгавартай дагах: Түүний зарлигуудад дуулгавартай байх нь аз жаргал, амар амгаланг авчирна.

4. Есүс Христэд итгэх итгэлийг сайн мэдээний анхны зарчим болгон итгэлийн тунхгийн дөрөвдүгээрийг онцлон ярилцаад, цээжил.
5. Итгэл нь мэдэх ба итгэдгээс ирдэг гэж тайлбарла. Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлэхийн тулд бид түүнийг мэдэх ёстой. Хүүхдүүдээр Есүс Христийн тухай мэддэг зүйлс болон эдгээр зүйлс тус бүрийг мэдэх нь Түүнд итгэлтэй байхад тэдэнд хэрхэн тусалдгийг хэлүүл. Тэдгээрийг самбарт бич. Байж болох хариултуудын зарим нь тэр Бурханы Хүү, тэр амьд, тэр бидэнд хайртай, тэр бидний төлөө үхсэн, тэр бидний Аврагч, тэр өршөөнгүй, тэр дэлхийн эд зүйлээс илүү хүч чадалтай, тэр бидэнд юу хамгийн сайн гэдгийг мэддэг, тэр биднийг өөрт нь эргэж очиход туслахыг хүсдэг, тэр болон Тэнгэрлэг Эцэг хоёр Иосеф Смитэд үзэгдсэн гэх зэрэг байж болно.
6. “Их Эзэний зарлигуудыг дуулгавартай дагаснаараа бид итгэлээ хөгжүүлэн бий болгодог” гэсэн үгийн хайчилбарыг бэлдэж самбар, эсвэл ханан дээр тогтоо.

Хүүхдүүдийг зарлигуудыг дуулгавартай дагаж байх үеийнхээ тухай ярихыг урь. Ийм сонголтууд нь Есүс Христэд итгэх итгэлийг үзүүлдэг гэдгийг ойлгоход нь тэдэнд тусал. Хоосон цааснуудыг хана барьж байгаа байдлаар бие биеийнх нь дээр самбар, эсвэл ханан дээр тогтоо (эсвэл самбарт зур). Хүүхдүүдээр ширхэг бүрийг залбирах, судраас судлах, аравны нэгээ төлөх, зөв шударга сонголтуудын үлгэр жишээ байх, эцэг эхдээ дуулгавартай байх, ариун ёслолоос хүртэх, Тэнгэрлэг Эцэгийн зарлигуудыг дуулгавартай дагах зэрэг Есүс Христэд итгэх итгэлээ барихаар тэдний хийх ямар нэг зүйлээр нь хаяглуул.

7. “Гэтэлгэгч Амьдыг Би Мэднэ” дууг дуулах, эсвэл үгийг нь унш (*Хүүхдийн Дууны Ном*, х. 38).

Дүгнэлт

Гэрчлэл	Есүс Христийг бодитойгоор байдаг, мөн түүнд итгэх итгэлээр дамжуулан бид түүнтэй илүү адил болох хүч чадлыг олж чадна гэж гэрчлэлээ хуваалц. Бид сурч, залбирч, түүний зарлигуудыг дуулгавартай дагахад бидний итгэл хүчирхэгжинэ.
Зөвлөмж Болгогдсон Гэрийн Уншлага	Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ Ифэр 12:6–22, 41-ийг судлахыг зөвлө. Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.

Зорилго

Хүүхдүүдийг Мормоны Номын тухай хувийн гэрчлэлээ олж авах болон номоо судалж амьдралынхаа туршид сургаал номлолуудаар нь амьдрахад урамшуулна.

Бэлтгэл

1. Моронай 10 болон Иосеф Смит—Түүх 1:30–35, 59–60-ыг залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii-ыг үз).
 2. Нэмэлт уншлага: Мормон 8:1–4, 16 болон Мормоны Номны эхний хуудас. Тайлбар: Эхний хуудас нь алтан ялтсуудын сүүлчийн хуудаснаас орчуулагдсан (*Сүмийн түүх* 1:71-г үз).
 3. Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго.
 4. *Гэрчлэл* гэсэн үгийн хайчилбар бэлд.
 5. Шаардлагатай материалууд:
 - а. Хүүхэд бүрт Мормоны Ном
 - б. Зурагнууд: 4-2, Моронай Ялтсуудыг Кумора Толгойд Нуусан нь (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 320, 62462); 4-55, Моронай Иосеф Смитийн Өрөөнд Үзэгдсэн нь (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 404, 62492); 4-3, Иосеф Алтан Ялтсуудыг Хүлээн Авсан нь (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 406, 62012) болон 4-56, Ариун Сүм Дээрх Тэнгэрийн Элч Моронай.
-

**Хичээл Заах
Зөвлөмж**

Анхаарал Татах
Ажиллагаа

Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.

Моронай Ялтсуудыг Кумора Толгойд Нуусан нь зургийг үзүүл. Энэ зураг нь Моронайн газар дээрх амьдралын бараг төгсгөл хэсгийг дүрсэлсэн гэдгийг тайлбарла. Хүүхдүүдэд Мормоны Номыг судлах тэдний хичээл ч гэсэн бараг дуусах гэж байгааг хэл.

Моронайн амьдралын тухай дараах зүйлүүдийг товч давт:

Моронай нандин бичээсүүдийг гүйцээсэн. Түүний эцэг Мормон алуулж, хамаатан саднууд нь үхэж, түүнд ямар ч найз нөхөд байгаагүй. Сум, сэлэм, бамбайнууд нь байлдааны талбарт орхигдсон. Газар сайгүй сүйрэл болж байв. Олон жилийн турш Моронай ганцаар амьдарч, Лэмэнчүүдээс нуугдаж, нандин бичээсүүдийг хамгаалж байлаа. Тэр хорин дөрвөн алтан ялтсыг (Ифэрийн ном) хураангуйлсан (нэгтгэсэн) ба аавынхаа түүнд өгсөн ялтсууд дээрх өөрнхөө бичээсийг дуусгасан.

Зураг руу эргэн орж Моронай Кумор толгой дахь чулуун хайрцганд алтан ялтсуудыг хийх гэж байна гэдгийг тайлбарла. Моронай Мормоны Номыг унших бүх хүмүүст онцгой амлалтыг өгсөн. Энэ амлалт нь Моронайн алтан ялтсууд дээр бичсэн сүүлчийн зүйлсийн нэг юм. Энэ нь Мормоны Номын талаарх гэрчлэлтэй болох амлалт юм.

“Гэрчлэл” үгийн хайчилбарыг үзүүл. Хүүхдүүдэд энэ хичээлийн үеэр тэд Мормоны Номын талаарх гэрчлэлтийг олж авахад хийх алхмуудыг нээж илрүүлэх болно гэдгийг хэл (баяжуулах үйл ажиллагаа 1-ийг үз). Тэд бас Моронайн бидэнд өгсөн амлалтын тухай сурах болно.

Судрын Хэсэг

Иосеф Смит—Түүх 1:30–35, 59–60-аас Моронай эцгийнхээ нандин бичээсүүдийг гүйцээх зарлигийг биелүүлж буй хэсэг, Моронай 10- аас түүний итгэлтэй хүмүүст өгсөн амлалт болон салах ёс, газарт бичээсүүдийг нууж байгаа болон 1400 жилийн дараа Иосеф Смитэд түүний үзэгдэж байгаа хэсгүүдийг заа. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii-аас үз.) Зургуудыг тохиромжтой үед нь ашигла.

Ярилцлага ба
Тавьж Болох
Асуултууд

Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншнаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.

- Моронай биднийг юуг санаж байгаасай гэж хүссэн бэ? (Моронай 10:3.)
- Мормоны Номын үнэн эсэхийг мэдэхийн тулд юу хийх ёстой гэж Моронай хэлсэн бэ? (Моронай 10:4.)
- Мормоны Номыг үнэн гэдгийг мэдэхэд хэн бидэнд туслах вэ? (Моронай 10:5.)
- Моронай бидэнд ямар амлалт өгсөн бэ? (Баяжуулах үйл ажиллагаа 4-ийг үз).
- Ариун Сүнс Мормоны Номын үнэн гэдгийг бидэнд гэрчлэх түүний хүч чадлыг бид хэрхэн мэдэж чадах вэ? (Их Эзэн ихэвчлэн бидний мэдрэмжээр хэлж өгдөг гэдгийг тайлбарла. Ариун Сүнс бидэнд зөв сайн зүйл болох амар амгалангийн мэдрэмжийг байнга өгдөг. Энэ нь бидний доторх дулаан мэдрэмж байж болно.)
- Мормоны Номын судалснаар та нар хамгийн чухал ямар зүйлийг сурч чадах вэ? (Есүс бол Христ гэдгийг. [Мормоны Номын эхний хуудсыг үз.]
- Мормоны Ном гарч ирэх тухай Моронай юу хэлсэн бэ? (Моронай 8:16.) Мормоны Ном ямар хүч чадлаар гарч ирсэн вэ?
- Хэн алтан ялтсуудыг хүлээн авч, тэдгээрийг Мормоны Ном болгон орчуулсан бэ?
- Мормоны Номын бошиглогчид болон Бошиглогч Иосеф Смитийн ажил дууссан энэ үед одоо бид Мормоны Номны талаар ямар үүрэг хариуцлагатай вэ? (Үүнийг судалж, үүний тухай гэрчлэлтэй болж, сургаалуудаар нь амьдарч, өөрсдийнхөө гэрчлэлээ бусадтай хуваалцах.)

Баяжуулах Үйл Ажиллагаа

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно.

1. Дараах үгийн хайчилбаруудыг хий: “Унш”, “Сана”, “Эргэцүүлэн бод”, “Залбир”. Хүүхдүүдийг ээлж ээлжээр үгийн хайчилбаруудыг дээш нь эргүүлж Моронайн бидэнд өгсөн гэрчлэлтэй болох алхмуудыг үзэхийг зөвшөөр. Хүүхдүүдийг эдгээр алхмуудыг ашиглан хэрхэн өөрсдийн гэрчлэлийг олж болохыг ярилц:

Мормоны Номын Гэрчлэлийг Олж Авах нь

Унш (Мормоны Номын гэрчлэлийг олж авах анхны алхам нь үүнийг уншиж, судлах явдал гэдгийг тайлбарла).

Сана (Моронай биднийг Есүс Христ хичнээн сайхан сэтгэлтэй, энэрэнгүй гэдгийг санаж, зүрх сэтгэлээ түүнд талархах талархлаар дүүргэх ёстой гэж хэлсэн. Энэ хайр, талархал нь биднийг илчлэлийн сүнсэнд бэлтгэнэ).

Эргэцүүлэн бод (Бид Есүс Христ болон Мормоны Номон дээрх түүний сургаалын тухай сурсан зүйлээ тунгаах буюу зүрх сэтгэл, оюун ухаандаа бодох ёстой.)

Залбир (Бид Мормоны Ном нь үнэн эсэхийг Есүс Христийн нэрээр Тэнгэрлэг Эцэг, Бурханаас асууж чин сэтгэлээсээ залбирах ёстой).

2. Хүүхдүүдэд Сүмийн арван гурав дахь Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсоны дараах мэдэгдлийг уншиж өг:

“Хожмын Үеийн Гэгээнтнүүд яагаад Мормоны Номноос суралцах явдлыг амьдралын зорилго болгох ёстой гэдэг нь гурван агуу том шалтгаантай.

“*Нэгдүгээрт* Мормоны Ном бол манай шашны тулгын чулуу. . . .
Тулгын чулуу гэдэг нь аркан хаалганы гол чулуу юм. Энэ нь бусад бүх чулуунуудыг байранд нь барьж байдаг ба түүнийг хөдөлгөвөл арк нурж унана.

“Мормоны Ном шашны маань тулгын чулуу байх гурван зам бий. Энэ нь бидний Христийн тухай гэрчлэлийн тулгын чулуу юм. Энэ нь бидний сургаалын тулгын чулуу. Энэ нь бидний гэрчлэлийн тулгын чулуу. . . .

“Хоёрдугаар шалтгаан . . . бол энэ нь бидний үед зориулан бичигдсэн. . . .

“Гуравдугаар шалтгаан . . . бол энэ нь бидэнд Бурханд ойртоход тусалдаг. . . .

“Энэ номыг ул суурьтай судалж эхлэх тэр мөчөөс та нарын амьдралд урсан орж эхлэх тийм хүч чадал номонд бий. Та нар уруу таталтын эсрэг зогсох агуу их хүч чадлыг олж авна. Та нар хууран мэхлэлтээс зайлсхийх хүч чадлыг олж авна. Та нар нарийн бөгөөд шулуун зам дээр үлдэх хүч чадлыг олж авнац” (Conference Report, Oct. 1986, 170 p. 4–6, or *Ensign*, Nov. 1986, p. 5–7).

3. Ариун Сүм дээр Тэнгэрийн Элч Моронайн зургийг үзүүл. Бид Илчлэлт 14:6 болон Сургаал ба Гэрээ 133:36-гаас тэнгэрийн элч (Моронай) дэлхийд “мөнхийн сайн мэдээг” эргүүлэн авчрах болно гэдгийг сурдаг гэж тайлбарла. Хүүхдүүдийг манай зарим ариун сүмүүдийн орой дээрх Моронайн алтан хөшөөг олж хараад “Тэгээд би Моронай, Христийг үгүйсгэхгүй” хэмээн Есүс Христийн тухай өөрийн гэрчлэлдээ хэзээ ч шантраагүй Моронайг дурсаж байхыг урь (Моронай 1:3).
4. Хүүхдүүдийг Мормоны Номын амлалт (Моронай 10:4–5), эсвэл итгэлийн тунхгийн наймдугаарыг хэсэгчлэн, эсвэл бүхлээр нь уншиж цээжлэхийг урь.
5. Бид Мормоны Номын гэрчлэлийг олж авснаар бас дараах гэрчлэлүүдийг олж авдаг гэдгийг тайлбарла.
Есүс бол Христ.
Иосеф Смит бол Бурханы бошиглогч.
Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм бол Бурханы үнэний сүм.
6. Хүүхдүүдийг Мормоны Номноос өөрсдийн дуртай хэсгийг хуваалцахыг урь. (Тэд эдгээр хэсгүүдээр жүжигчилсэн тоглолт хийж болно.) Хэсэг тус бүрээс тэд чухал ямар зүйлүүд сурсныг нь асуу.

Дүгнэлт

Гэрчлэл	Моронай 10:3–5 дахь Моронайн амлалтыг үнэн гэдгийг, мөн анги дахь хүүхэд бүр Мормоны Ном бол үнэн гэсэн өөрсдийн гэрчлэлтэй болж чадна хэмээн гэрчил. Хүүхдүүдийг Мормоны Номын гэрчлэлээ хэлэхийг урь.
Зөвлөмж Болгогдсон Гэрийн Уншлага	Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ Моронай 10:1–5-ыг судлахыг зөвлө. Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.

Мормоны Ном бол Есүс Христийн Дахин Амилалтын Гэрч Мөн (Улаан Өндөгний Баяр)

Зорилго

Мормоны Ном бол Есүс Христийн Дахин Амилалтын өөр нэгэн судрын гэрч гэдгийг хүүхдүүдэд заана.

Бэлтгэл

1. Алма 11:40–45, 40 болон 3 Нифай 11:1–17-г залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii-ыг үз).
2. Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго.
3. Шаардлагатай материалууд:
 - а. Хүүхэд бүрт Мормоны Ном.
 - б. Библи.
 - в. Бээлий, эсвэл оймс.
 - г. Зурагнууд: 4-49, Дахин Амилсан Есүс Христ (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 239, 62187); 4-45, Есүс Америк Тивд Сургаалыг Заасан нь (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 316, 62380).

**Хичээл Заах
Зөвлөмж**

Анхаарал Татах
Ажиллагаа

Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.

(Бээлий, эсвэл оймс байхгүй бол та баяжуулах үйл ажиллагаа 2-ыг анхаарал татах ажиллагаа болгон ашиглаж болно.)

Гараа өргөөд, энэ нь бидний биен доторх сүнсийг төлөөлж байгаа гэж хэл. Гараа хөдөлгөж болно. Бээлийг (оймс) өргө, энэ нь бидний биеийг төлөөлж байгаа гэж хэл. Биднийг төрөхөд сүнс, бие хоёр маань түр хугацаагаар нийлж нэгддэг ба сүнс биенд амьдрал өгдөг. Бие дангаараа хөдөлж чадахгүй. Харин яг гарт бээлий өмсөж байгаагийн адил сүнс бие рүү орж тэр нь амьтай болж хөдөлж чаддаг. (Гартаа бээлий өмс.) Бид бүгд сүнс болон биетэй. Биднийг үхэхэд сүнс биеэс салдаг гэдгийг тайлбарла. (Гарнаасаа бээлийг тайл.) Бие сүнсгүйгээр хөдөлж, эсвэл амьдарч чадах уу? Биднийг үхсний дараа сүнс амьдарч, хөдөлсөн хэвээр байх уу? (Загвар болгон гар болон хуруунуудаа хөдөлгө.) Дахин амилалтын үед бие, сүнс хоёр эргэн нэгддэг. (Гартаа бээлийг эргүүлэн өмс.) Дэлхий дээр амьдрах хүн бүр үхлийнхээ дараа дахин амилах болно. Есүс Христ бол бидэнд дахин амилалтыг боломжтой болгож чадах цорын ганц хүн байсан. (Боид Б. Пакерын ярианаас ава. Conference Report, Apr. 1973, p. 79–80, or *Ensign*, May. 1973, p. 51–53).

Гэрч байна гэдэг нь юу гэсэн үг вэ? (Гэрч гэдэг нь үйл явдлын үнэн бодит байдал, эсвэл гэрчлэлүүдийг өгдөг хүн, эсвэл юмыг хэлнэ.) Библи дэх Шинэ Гэрээ нь Есүс Христ дахин амилсан бөгөөд бүх хүмүүст дахин амилалтыг авчирсан гэдгийг гэрчлэх бичмэл гэрч юм. Дахин Амилалтын хоёр дахь бичмэл гэрч нь ямар ном бэ?

Судрын Хэсэг

Алма 11:40–45, 40 болон 3 Нифай 11:1–17-гоос Дахин Амилалтын тухай Мормоны Номын хэсгүүдийг заа. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii-аас үз.) Мормоны Ном бол Есүс Христийн дахин амилалтын бичмэл гэрч юм гэдгийг онцол. Зургуудыг тохиромжтой үед нь ашигла.

Ярилцлага ба
Тавьж Болох
Асуултууд

Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншнаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.

- Есүс Христ хэрхэн нас барсан бэ? (Лук 23:33, 2 Нифай 10:3.) Есүс Христ бидэнд маш их хайртай байсан учраас өмнөх амьдралдаа сайн дураараа бидний Аврагч болсон гэдгийг ойлгоход нь хүүхдүүдэд тусал. Бидний төлөөх Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн тулд тэр нас барахаа мэдэж байсан.
- Есүс Христийг нас барсны дараа гурав дахь хоногт түүнд юу тохиолдсон бэ? (1 Коринт 15:4, Мозая 3:10.) Энэ гурван хоног түүний сүнс хаана байсан бэ? (1 Петр 3:18–19, С ба Г 138:11–12, 18.) Биднийг нас барсны дараа сүнснүүд маань хаачих вэ? (Алма 40:12.)
- Дахин амилалт гэж юу вэ? (Алма 11:43, 40:18.) Анхаарал татах ажиллагаа руу эргэн ороод дахин амилалт гэдэг нь сүнс биетэй дахин нэгдээд, эргэн хэзээ ч биеийг орхихгүй байх болно гэдгийг тайлбарла.
- Иерусалим дахь хүмүүс Есүс Христийг дахин амилсан гэдгийг хэрхэн мэдсэн бэ? (1 Коринт 15:5–7.) Америкт амьдарч байсан Нифайчууд Есүс Христийг дахин амилсан гэдгийг хэрхэн мэдсэн бэ? (3 Нифай 11:8–10.) Нифайчууд Есүс Христийг анх хэзээ харсан ба тэд түүнийг хэн гэж бодсон бэ? (3 Нифай 11:8.) Есүс яагаад Нифайчуудыг түүний гар, хөл дээрх хадаасны ормыг тэмтэрч үзэхийг хүссэн бэ? (3 Нифай 11:14–15.) Та нар дахин амилсан Христийг харсан тэдгээр хүмүүсийн дунд байсан бол ямар сэтгэгдэлтэй байх байсан бэ?
- Та нар Есүс Христийг дахин амилсан гэдгийг хэрхэн мэдэж чадах вэ? (Гэрчлэлийг эрж, мөн олж авснаар.)
- Аврагчийг Нифайчууд дээр айлчлахад түүний дахин амилсан бие юутай адил байсан бэ? (3 Нифай 11:15.)
- Өөр хэн дахин амилах вэ? (1 Коринт 15:20–22, Алма 40:4.) Биднийг дахин амилахад бие махбод маань ямар байх вэ? (Алма 11:43–45, 40:23.) Та бидэнд байгаа аливаа тахир дутуу, сул дорой байдал маань зөвхөн энэ дэлхийн амьдралд л байх болно гэдгийг дурьдаж болно. Бид Дахин Амилалтаар бүрэн бүтэн, төгс төгөлдөр байх болно.
- Хэрхэн Мормоны Ном Есүс Христийн дахин амилалтын судрын гэрч болж байна вэ? Тэнгэрлэг Эцэг биднийг яагаад Ариун Библи, Мормоны Ном хоёрын хоёулангтай нь байхыг хүсдэг вэ? (2 Нифай 29:8.)

- Бидний ихэнх маань Төлөөлөгчид болон Нифайчуудын адил дахин амилсан Есүс Христийг хараагүй учраас бид Дахин Амилалтын тухай мэдлэгийг хэрхэн олж авч чадах вэ? (Судрууд болон Ариун Сүнснээс. [Моронай 10:4–5.]

Баяжуулах Үйл Ажиллагаа

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно.

1. Есүс Христ бид бүгдийг тэр дахин амилсан болон өнөөдөр ч амьдарсаар байгааг мэдээсэй гэж хүсдгийг тайлбарла. Хүүхдүүдээс Есүс яагаад биднийг энэ зүйлийг мэдээсэй хэмээн хүсдэг гэж бодож байгааг нь асуу. Тэдний хариултууд дараахтай төстэй байж болно.

Бид нас барсныхаа дараа үргэлжлүүлэн амьдарч мөн нэг өдөр бидний биес сүнстэйгээ нэгдэнэ гэдгийг мэдсэнээр ирэх амар амгаланг бидэнд өгдөг.

Бид үнэхээр аз жаргалтай байж дараагийн амьдралд Тэнгэрлэг Эцэгтэйгээ хамт амьдарч чадахын тулд зарлигуудыг дуулгавартай дагахад биднийг өдөөдөг.

Бидний хайртай хэн нэгэн нас барахад, тэр нэгэн өдөр дахин амьдрах болно гэсэн мэдлэгээр биднийг тайтгаруулдаг.

2. Самбар дээр сүүлийн үеийн мэдээнүүдийн түүхийг санаанд буулгах нэг үг, эсвэл сэтгүүлийн гарчгийг бич. Тэр түүхэнд татагдсан сонирхлоо тайлбарла. Хүүхдүүдээс дэлхийд зарлагдсан хамгийн агуу мэдээг юу гэж бодож байгааг нь асуу. Хүүхдүүдийн хариултуудыг самбарт жагсаан бич. Хэрэв эдгээр үйл явдлууд нь хэзээ ч тохиолдоогүй бол ямар ялгаа байх байсныг ярилц. Яагаад Есүс Христийг дахин амилсан гэсэн мэдээ нь хэзээ нэгэн цагт болж байсан зүйлүүдээс хамгийн агуу нь вэ? Хэрэв Дахин Амилалт болоогүй бол юу тохиолдох байсан бэ? 2 Нифай 9:19–22-ыг уншиж ярилц.

Дүгнэлт

Гэрчлэл

Мормоны Ном бол Есүс Христийн дахин амилалтын судрын гэрч мөн хэмээн гэрчил. Аврагч бидэнд хайртай учир тэр хүслээрээ хүн тус бүрийн маань төлөө зовж, үхсэн гэдгийг гэрчил. Түүний дахин амилалт бүх хүмүүсийг дахин амьдрах боломжтой болгосон.

Зөвлөмж
Болгогдсон

Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ 3 Нифай 11:8–17-г судлахыг зөвлө.

Гэрийн Уншлага

Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.

Мормоны Ном: Есүс Христийн Өөр Нэгэн Гэрээ (Зул Сарын Баяр)

Хичээл
46

Зорилго Мормоны Ном бол Есүс Христийн хоёр дахь гэрч гэдгийг хүүхдүүдэд заана.

Бэлтгэл

- 1 Нифай 10:4, 11:13, 15, 18, 2 Нифай 25:29, 19:8, Мозая 3:5, Алма 7:10, Хиламан 14:2–5, Исаиа 7:14, Матай 1:21, 2:1–2, 9–10, 20:19, Лук 1:35, 2:8, 10–12 ба Иохан 3:16-г залбиралтайгаар судал. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii-ыг үз).
2. Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго.
3. Шаардлагатай материалууд:
 - а. Хүүхэд бүрт Мормоны Ном.
 - б. Библи.
 - в. Анхаарал татах үйл ажиллагааны үеэр хүүхдүүдэд зүүлгэх нэрийн тэмдэг, эсвэл хүзүүний ороолтууд болон алчуурууд.
 - г. Зурагнууд: 4-9, Есүс бол Христ (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 240, 62572); 4-10, Есүс Мэндэлсэн нь (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 200, 62116); 4-21, Бенжамин Хаан Хүмүүстээ Хандан Үг Хэлсэн нь (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 307; 62298); 4-42, Ламанчуудын Самуэл Хэрмэн Дээр (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 314, 62370); 4-44, Дэлхийн Газрын Зураг; 4-45, Есүс Америк Тивд Сургаалыг Заасан нь (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 316, 62380).

Хичээл Заах Зөвлөмж

Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.

Анхаарал Татах Ажиллагаа Есүс Мэндэлсэн нь зургийг үзүүл. Шинэ Гэрээ нь Есүсийн Иерусалим дахь төрөлтийг тэмдэглэдэг гэдгийг тайлбарла. Мормоны Ном бол Есүс Христийн хоёр дахь бичмэл гэрч ба түүнийг мэндлэхэд Америкт юу болсон тухай өгүүлдэг.

Дөрвөн хүүхдээр, Лихай (М.Э.Ө 600 он), Бэнжамин Хаан (М.Э.Ө 124 он), Алма (М.Э.Ө 83 он), Лэмэны Сэмүэл (М.Э.Ө 6 он) нарын дүрийг авахуул. Дараах ишлэлүүдээс Есүс Христийн төрөлтийн тухай бошиглогч бүрийн бошиглолыг хүүхдүүдээр уншуул: Лихай, 1 Нифай 10:4, Бэнжамин Хаан, Мозая 3:5, Алма, Алма 7:10 болон Лэмэны Сэмүэл, Хиламан 14:2.

Бошиглогч бүрийг таниулахын тулд нэг хүүхдээр бошиглогчийн зургийг бариулж, өөр нэг хүүхдээр судрыг уншуул.

- Есүс Христийг мэндлэхэд Бетлехемд ямар тэмдгүүд өгөгдсөн бэ? (Лук 2:6–14, Матай 2:1-2.) Бетлехем болон Америкт ямар тэмдгүүд үзэгдсэн бэ? (3 Нифай 1:21.) Америкт өөр ямар тэмдгүүд өгөгдсөн бэ? (3 Нифай 1:15, 19.)

Судрын Хэсэг

Зургуудыг тохиромжтой үед нь ашиглаж, Библи болон Мормоны Номноос Есүс Христийн мэндэлсэн тухай болон үүргийнх нь тухай хэсгийг заа. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii-аас үз.) Библи нь Иерусалимд болон үүний ойролцоо бичигдсэн бол Мормоны Ном нь Иерусалимаас олон мянган километрийн зайд орших Америкт бичигдсэн гэдгийг онцол.

Библи болон Мормоны Ном нь хэд хэдэн өөр бошиглогчдоор бичигдсэн гэдгийг тайлбарла. Хэсгүүдийг унших буюу дурьдахдаа хүүхдүүдэд тэдгээр нь Библид тэмдэглэгдснээр Ариун Газрын бошиглогчдоор, эсвэл Америк дахь Мормоны Номны бошиглогчдоор бичигдсэн эсэхийг хэл.

Ярилцлага ба Тавьж Болох Асуултууд

Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншнаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.

- Аврагчийг төрөхөөс 600 жилийн өмнө Бурханы Хүүгийн нэр нь хэн байх болно гэж Нифай хэлсэн бэ? (2 Нифай 25:19.) Нифай, Исаиа нар Аврагчийн эхийн талаар юу бошиглосон бэ? (1 Нифай 11:13, 18, Исаиа 7:14.) Бурханы Хүүгийн эхийн нэр хэн байх болно гэж Алма бошиглосон бэ? (Алма 7:10.)
- Есүсийн эцэг нь хэн бэ? (Лук 1:35. Тэнгэрлэг Эцэг.) Иосеф хэн байсан бэ? (Иосеф Мариагийн нөхөр байсан. Хэдийгээр Тэнгэрлэг Эцэг Есүс Христийн бие болон сүнсний эцэг байсан ч, Иосеф Есүсийн төлөө санаа тавьж, эцэг нь хүүгээ өсгөдгийн адил түүнийг өсгөсөн гэдгийг тайлбарла.) Есүсийг мэндэлхийнх нь яг өмнө тэнгэрийн элч Иосефт хүүхдийг хэн гэж нэрлэхийг хэлсэн бэ? (Матай 1:21.)
- Лэмэны Сэмүэл Есүсийн мэндлэх тухай ямар тэмдгүүдийг өгсөн бэ? (Хиламан 14:2-5.) Иерусалимд ямар тэмдгүүд өгөгдсөн бэ? (Лук 2:8, 10–12, Матай 2:1–2, 9–10.)
- Есүс Христийн төрөлт болон үүргийн талаар хоёр судрын гэрчтэй байх нь бидэнд яагаад чухал вэ? (2 Нифай 29:8.)
- Тэнгэрлэг Эцэг өөрийн Хүү, Есүс Христийг яагаад дэлхий рүү илгээсэн бэ? (2 Нифай 9:21–22, 3 Нифай 27:13–14, Иохан 3:16.)
- Тэнгэрлэг Эцэг биднийг Есүс Христийн төлөөх талархлаа хэрхэн үзүүлэсэй гэж хүсдэг вэ? (Алма 7:23–24.)

Баяжуулах Үйл Ажиллагаа

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно.

1. Хүүхдүүдээр Зул сарын баярт зориулан хэн нэгэнд өгөхөөр үйлчлэлийн онцгой нэг бэлгийг сонгуулж Есүс Христийн жишээг дагуул. Хүүхэд

бүрт өөрсдийнхөө бэлэг болон үйлчлэл өгөхөө хэрхэн төлөвлөх тухайгаа бичихэд нь зориулж харандаа, цаас өг.

2. Хүүхдүүдээс тэдэнд Есүс Христийн мэндэлсэн явдал болон амьдралыг нь сануулдаг гэр бүлийн уламжлалаасаа хуваалцахыг хүс. Жаахан хүүхдүүд ийм уламжлалд тэдний гэр бүлийнхний оролцож байгаа зургийг зурж болно.
3. Есүс бол Христ (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 240, 62572), 4-9 зургийг үзүүл. Хүүхэд болгоноор тэдэнд жилийн турш Есүс Христийн тухай санахад нь тусалдаг Зул Сарын Баярынх нь тухай яриул.
4. Матай 5:16 болон 3 Нифай 12:16, Матай 7:12 болон 3 Нифай 14:12, Матай 5:44 болон 3 Нифай 12:44 гэх зэрэг Библи дэх Аврагчийн сургаалуудын заримыг Мормоны Номынхтой харьцуул.
5. Хичээлийн төгсгөлд хавсаргасан хуанлийг дараах арга замуудын нэг, эсвэл түүнээс илүүгээр ашиглаж болно:

Хүүхэд бүрт энэ хуанлийг будаж мөн гэр бүлийнхэндээ бэлэг болгон гэртээ авч явахад нь зориулж хий. Есүс Христийг дагахаа санаж байхын тулд энэ хуанлийг жилийн турш ашиглаж болно.

Хүүхдүүдэд санаануудыг уншиж өгөөд, тэднээр хийхийг хүсч байгаа заримыг нь сонгуул.

Хуанлийг хийж хэсэг бүрээр нь хайчлан хуваа. Хүүхдүүд сануулга болгон гэртээ авч явахаар эдгээр санаануудаас сонгож болно.

Хуанлийг загвар болгон ашиглаж, хүүхдүүдээр өөрсдийнх нь хуанлийг хийлгэ.

Ангидаа үзүүлэн болгож хуанлийг том цаасан дээр зур.

Дүгнэлт

Гэрчлэл

Есүс Христ бол Бурханы Хүү гэсэн гэрчлэлээ хуваалц. Есүс Христийн амьдрал болон үүргийн гэрчүүд болсон Библи, Мормоны Номтой байгаадаа талархлаа илэрхийл.

Хүүхдүүдэд Аврагчийн тухай болон тэр тэдний хувьд хэн болох талаарх сэтгэгдлээ илэрхийлэх боломжийг өг. Хүүхдүүдийг Зул Сарын Баярын үеэр Есүс Христ болон түүний бидний төлөө хийсэн бүгдийн тухай бодогыг уриал.

Зөвлөмж
Болгогдсон
Гэрийн Уншлага

Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ 1 Нифай 11:12–24 болон 2 Нифай 29:8-ыг судлахыг зөвлө.

Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.

Хайрын Үйлчлэл Үзүүл

НЯМ	ДАВАА	МЯГМАР	ЛХАГВА	ПҮРЭВ	БААСАН	БЯМБА
	Зарим найзуудаа гэр бүлийн үдэш дээр байлга 	 Өвчтөнийг эргэ	Хэн нэгнийг сэтгэлээсээ сонсох 	 Хэн нэгнийг уучлах	Чин сэтгэлийн магтаал хэл 	 Хэн нэгэн рүү утасдаж, урам хайрла
 Номлогчид захиа бич	Сайн дураараа сав суулга угаа 	 Бишопын зөвлөлийг дайл	Бусдад инээмсэглэж бай 	 Хэн нэгэнд захиа илгээ	Хэн нэгний тухай сайн зүйлсийг бод 	 Өвчтэй хэн нэгэнд хоол хүргэж өг
 Хэн нэгнийг Сүмд хүргэж өг	Авьяасаа үзүүл 	 2-ыг хийж 1-ийг нь өг	Тэвэр 	 Жаахан хүүхдэд уншиж өг	Хэн нэгний мэдрэмжийг ойлгохыг хичээ 	 Шинэ найзтай бол
Сүм дээр хэн нэгэнд ая тухтай байх мэдрэмжийг өг 	Гэр бүлийн үдэшт зориулсан амттанаа хуваалц 	Найздаа түүний юу нь чамд таалагддагийг хэл 	Хэн нэгний гуйлтыг биелүүл 	 Хэн нэгэнд анхаарал тавьж байгаагаа мэдрүүл	Хөмсөг зангидсан царай руу инээмсэглэ 	Настай хөршийндөө зочил 
Сүм дээр хүүхдтэйгээ байгаа завгүй ээж нарт тусал 	 "Би чамд хайртай" гэж хэл	Өрөөгөө  хэлүүлэлгүй цэвэрлэ				

Пристийн Зэрэгтнүүд Бидний Амьдралыг Адисладаг (Пристийн Зэрэгтнийг Бэлтгэх Хичээл)

Хичээл
47

Зорилго Энэ хичээл нь 11 настай хүүхдүүдийг пристийн зэргийн адислалууд болон үүрэг хариуцлагыг ойлгоход нь туслахаар хийгдсэн. Энэ хичээлийг анги дахь хүүхдүүдийн эхнийх нь 12 нас хүрэхээс өмнө заах ёстой.

Бэлтгэл

1. Мормоны Номын оршил, эсвэл Иосеф Смит-Түүх 1:29–54, 59, 66–72-оос “Бошиглогч Иосеф Смитийн Гэрчлэл”, Сургаал ба Гэрээ13, тухайн хэсгийн оршлыг хамруулан Сургаал ба Гэрээ 121:34–46-г залбиралтайгаар судал.
2. Тэгээд хичээлээ судалж, судрын хэсгийг хүүхдүүдэд хэрхэн заахаа шийд (“Хичээлээ Бэлтгэх” х. vii, “Судраас Заах” х.viii-ыг үз). Ангийн хүүхдүүдийг оролцуулах болон хичээлийнхээ зорилгод хүрэхэд нь илүү сайн туслах ярилцлагын асуултууд болон баяжуулах үйл ажиллагаануудыг сонго.
3. Шаардлагатай материалууд:
 - а. Хүүхэд бүрт Мормоны Ном.
 - б. Сургаал ба Гэрээ
 - в. Гар чийдэн, гэрлийн шил, дэнлүү зэрэг гэрлийн эх үүсвэрүүд.
 - г. Зураг 4-9, Есүс Бол Христ (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 240, 62572); Усаар Батлагч Иохан Аароны Пристийн Зэргийг Олгосон нь (Ариун Сургаалын Уран Зургийн Цуглуулга 407, 62013) болон Пристийн Зэргийн Ёслол (62341).

**Хичээл Заах
Зөвлөмж**

Анхаарал Татах
Ажиллагаа

Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.

Гэрэл гаргадаг зүйлүүдийг үзүүл.

- Гэрэл гаргахын тулд үүнд юу шаардлагатай вэ? Хэрэв танд гар чийдэн байвал үүнийг зүй ёсоор нь ажиллуулж гэрэл гаргахын тулд танд зай, чийдэн ба унтраалга хэрэгтэй гэж харуул. Чийдэнг сайн холбогч утсанд холбож залгуурт эргэдэн оруулаад цахилгаан хүчний эх үүсвэрт холбодог. Цахилгааныг хүчийг ажиллагаатай болгохын тулд унтраалгаа асаах хэрэгтэй.

Ангийнхаа хөвгүүдийг босч зогсохыг хүс. Эдгээр хөвгүүд пристийн зэргийг хүлээн авах боломжтой бөгөөд энэ нь Бурханы нэрээр үйлдэх хүч чадал болон эрх мэдэл учраас цахилгаанаас ч илүү их хүч чадалтай юм. Энэ хүч чадлаар дамжуулан Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүд усаар батлуулж Сүмийн бусад ёслолуудыг хүлээн авч чадна. Гэвч энэ

хүч чадлыг хүлээн авч Бурханы төлөвлөснөөр ашиглахын тулд хөвгүүн нь зохистой байж зүй ёсоор бэлтгэгдсэн байх ёстой.

Судрын Хэсэг

Зургуудыг тохиромжтой үед нь үзүүлэн “Бошиглогч Иосеф Смитийн Гэрчлэл” буюу Иосеф Смит-Түүх 1:29–54, 59, 66–72-оос Иосеф Смит алтан ялтсуудыг хүлээн авч, Аароны Пристийн Зэрэгт томилон адислагдаж байгаа хэсгийг заа. (Судрын хэсгийг заахад зөвлөсөн аргуудыг “Судраас заах” х.viii-аас үз.) Та Иосефын алтан ялтсуудыг хүлээн авахад хөтөлсөн үйл явдлуудыг ангийнхантайгаа товч давтаж болно.

Ярилцлага ба Тавьж Болох Асуултууд

Хичээл бэлдэж байхдаа дараах асуултууд болон судрын ишлэлийг судал. Хүүхдүүдэд судруудыг ойлгох болон зарчмуудыг амьдралдаа ашиглахад нь илүү тусалж чадна гэж мэдэрч байгаа асуултуудыг хэрэглэ. Анги дахь хүүхдүүдтэй ишлэлүүдийг хамт уншнаар сударт илүү нэвтэрхий болоход нь тусалдаг.

- Иосеф Смит яагаад Анхны Үзэгдлийн дараахан алтан ялтсуудыг орчуулж, пристийн зэргийг хүлээн авч, Сүмийг зохион байгуулж чадаагүй вэ? (Тэр бэлтгэгдээгүй байсан, тэр мэргэн ухаан болон мэдлэгээрээ өсөх хэрэгтэй байсан.)
- Их Эзэний Иосеф Смитээс хийхийг хүссэн анхны үндсэн даалгавар нь юу байсан бэ? (Биднийг Мормоны Номтой байлгахын тулд алтан ялтсуудыг орчуулах.)
- Тэнгэрийн элч Моронай түүнд анх үзэгдэх орой Иосеф юу хийж байсан бэ? (Иосеф Смит—Түүх 1:29–30.) Иосеф алтан ялтсуудыг анх харахаас өмнө Моронай Иосеф Смитэд хэдэн удаа үзэгдсэн бэ? (Иосеф Смит—Түүх 1:30, 44–49, дөрвөн удаа.) Та нар Моронайг яагаад анхны захиасаа гурав дахин давтсан гэж бодож байна вэ?
- Иосеф алтан ялтсуудыг орчуулж эхлэхээсээ өмнө өөр ямар удирдамжуудыг хүлээн авсан бэ? (Иосеф Смит—Түүх 1:53–54.) Энэ удирдамж нь Иосеф Смитийг түүний хийх ёстой байсан бусад агуу их зүйлсийг хийхээр бэлтгэхэд нь түүнд хэрхэн тусалсан бэ? Ирээдүйдээ бэлтгэхийн тулд та нар юу хийж байна вэ?
- Ихэнх Хожмын Үеийн Гэгээнтэн залуу эрэгтэйчүүд арван хоёр насандаа ямар онцгой үүрэг хариуцлага хүлээдэг вэ? (Тэд Аароны Пристийн Зэргийг хүлээн авч, туслагчид томилогдон адислагддаг.)
- Иосеф Смит Аароны Пристийн Зэргийг хэрхэн хүлээн авсан бэ? (Иосеф Смит—Түүх 1:68–70.) Өнөөдөр залуу эрэгтэйчүүд Аароны Пристийн Зэргийг хэрхэн хүлээн авч байна вэ? (Тэр зохистой байдлынхаа талаар ярилцлагад орж, түүнийг томилох эрх мэдэл бүхий эрэгтэй хүнээр толгой дээрээ гар тавиулан томилогдон адислагддаг.)
- Хөвгүүд пристийн зэргийг хүлээн авахдаа өөрсдийгөө хэрхэн бэлтгэх ёстой вэ? Охид пристийн зэргийн адислалыг хүлээн авахдаа өөрсдийгөө хэрхэн бэлтгэх ёстой вэ? (Хөвгүүд, охид адил арга замаар бэлтгэдэг. Тэд залбирч, итгэлтэй байж, эцэг эх болон багш нараасаа сайн мэдээг сурч, зохистой амьдарч, зарлигуудыг дуулгавартай дагаж, бусдад үйлчилж, нэг нэгнийгээ хүндэтгэж мөн үнэнч байдаг.) (Баяжуулах үйл ажиллагаа 4-г үз.)
- Диконууд Сүмд ямар үүрэг хариуцлагатай вэ? (С ба Г 20:59.) Тэд эдгээр үүргээ хэрхэн биелүүлдэг вэ? (Ариун ёслол түгээж, мацгийн

өргөл цуглуулж, ариун ёслолын цуглаан дээр бишопын зарлага болж, сайн үлгэр дуурайл болдог.)

- Ариун ёслолыг түгээсэн анхны хүн хэн бэ? (Есүс Христ.) Яагаад ариун ёслол нь ийм нандин байдаг вэ? (Энэ нь Есүс Христийн бид бүгд, хүн бүрийн төлөө хийсэн золиослолыг төлөөлдөг ёслол юм.)

Ахлагч Жэффри Р. Холандын хэлсэн дараах үгийг унш, эсвэл ангийн гишүүдээр уншуул: “Бид пристийн зэрэгтэй залуу эрэгтэйчүүд та нараас Аврагчийн золиослолын эдгээр бэлэгдлүүдийг зохистой, бишрэлтэйгээр бэлтгэж, адислаж, түгээхийг хүсч байна. Ийм гайхалтай залуу насанд нь өгөгдсөн ямар ер бусын боломж, нандин итгэл вэ! Би Бурханаас та нарт өгөгдөж байгаа магтаалуудаас үүнээс илүүг олж чадахгүй. Бид та нарт хайртай. Хамгийн сайнаараа амьдарч, мөн Их Эзэний Зоог болох ариун ёслолд оролцохдоо хамгийн сайхнаараа харагд” (Conference Report, Oct. 1995 p. 89; or *Ensign*, Nov. 1995, p. 68).

- Бид бүгд пристийн зэргийг хэрхэн хүндэтгэж дэмжиж чадах вэ? (Пристийн зэргийн удирдагчдаас ирсэн дуудлагыг хүлээн авах, бусдад үйлчлэх, Сүмийн удирдагчдын тухай хүндэтгэлтэйгээр ярих, пристийн зэргийг атгагч аав, ах нар, гэр бүлийн гишүүд болон бусдын төлөө залбирч.) (Баяжуулах үйл ажиллагаа 3-г үз.) Та нарын эдгээр зүйлүүдийг хийх нь аав, эсвэл ахад чинь пристийн зэргээ хүндэлж дээдлэхэд нь хэрхэн тусалж чадах вэ? Тэд та нарт пристийн зэрэг хүлээн авахад, эсвэл пристийн зэргийн адислал авахад чинь хэрхэн тусалж чадах вэ?

Баяжуулах Үйл Ажиллагаа

Дараах үйл ажиллагаануудаас нэг юмуу түүнээс илүүг сонгож хичээлдээ тойм, хураангуйлал, эсвэл сорилт маягаар хичээлийнхээ аль ч үед хэрэглэж болно.

1. Пристийн зэргээр дамжин ирэх дараах адислалуудыг тусдаа хөзрүүд, эсвэл цааснууд дээр бич.

Нэр болон адислал хүлээн авах

Усаар батлуулах

Ариун Сүнсний бэлэг хүлээн авах

Өвчтэй байхдаа хүлээн авах адислал

Ариун ёслолоос хүртэх

Номлолд үйлчлэх

Ариун сүмд гэрлэх

Ангийг бүлгүүдэд хуваагаад, бүлэг бүрт хөзрүүдийн нэгийг өг. Бүлэг бүр дэх хүүхдүүдийг хөзөр дээр нь бичигдсэн адислалуудтай холбоотой хувийн, эсвэл гэр бүлийн хуваалцахад тохиромжтой тохиолдлуудаасаа хуваалцахыг урь.

2. Өрөөг аль болох харанхуй болго. Тэгээд хүүхдүүдэд нэгэн хав харанхуй агуйд явж байсан жуулчдын хэсгийн тухай түүхийг ярьж өг. Нэгэн удаа газарч агуй доторх гэрлүүдийг унтраагаад, хэдэн хором

хүлээгээд аль зүгт байгаагаа заахыг хүн бүрээс асуусан. Гэрлүүдийг эргүүлэн асаахад хүн бүр өөр өөр зүгт заасан байлаа.

Ангиа дахин гэрэлтэй болгоод, Ахлагч Робэрт Д. Хэйлсийн хэлсэн дараах мэдэгдлийг хуваалц: “Хэрэв пристийн зэргийн хүч чадал дэлхий дээр байгаагүй бол бидний дайсан хязгаарлалтгүйгээр энд тэндгүй хэрэн хэсч, хаанчлах болно. Биднийг чиглүүлэх, гэгээрүүлэх Ариун Сүнсний бэлэг байхгүй байх байсан, нэг ч бошиглогч Их Эзэний нэрээр ярихгүй, бид нандин, мөнхийн гэрээг хийж чадах ямар ч ариун сүмгүй, адислах, эсвэл усаар батлах, эдгээрүүлэх буюу тайвшруулах эрх мэдэлгүй байх байсан. . . . Гэрэл ч, найдвар ч байхгүй—зөвхөн харанхуй л байх байсан” (Conference Report, 1995 оны 10 сар, х. 40, эсвэл *Ensign*, 1995 оны 11 сар, х. 32).

3. Нэг гэр бүл ааваа пристийн зэргийн дуудлагад дэмжихийн тулд юу хийсэн талаар дараах түүхийг унш, эсвэл ярь:

“Би олон жилийн өмнө Ерөнхий Чуулган дээр Ахлагч Эзра Тафт Бэнсоны зургаан хүүхэдтэй нь нэг дор суусан юм. Тэдний нэгтэй нь би коллежийн байранд хамт амьдардаг байв. Ерөнхийлөгч МакКэй босч дараагийн яригчийг зарлахад миний сонирхол ихэд ихсэж билээ. Миний ойрд уулзаагүй Ахлагч Бэнсон микрофон руу алхахыг би хүндэтгэлтэйгээр харж байлаа. Тэр бол зургаан фүүтээс ч өндөр том хүн байв. Тэр бол мастериин зэрэгтэй, Нэгдсэн Улсын Хөдөө Аж Ахуйн Нарийн Бичгийн Дарга хэмээн дэлхийд нэртэй ба Их Эзэний онцгой гэрч, амирлангуй, итгэлтэй санагддаг эр хүн ба дэлхий даяарх сонсогчдод хандан үг хэлсэн хүмүүсийн нэг юм. Гэнэт нэг гар гарт минь хүрэв. Нэгэн бяцхан охин над руу тонгойж ‘Аавын төлөө залбир’ гэж шаардангуй шивнэв.

“Бага зэрэг гайхаад би бодов, ‘Энэ захиас эгнээ дагуу дамжуулагдаж байгаа бөгөөд би цааш нь дамжуулах ёстой. Би “Ахлагч Бэнсоны төлөө залбир” гэх үү? “Та эцгийнхээ төлөө залбирал хэлэх хэрэгтэй байна” гэх үү?’ Маш яаралтай үйлдэх хэрэгтэйгээ ухааран би доош тонгойж энгийнээр, ‘Аавын төлөө залбир’ гэж шивнэв.

“Би толгойгоо бөхийлгөчихсэн суугаа Бэнсон эгч рүү шивнээ эгнээ дагуу дөхөж байгааг ажиглан харав.

“Тэр өдрөөс хойш би олон удаа—гэрийн патриарх Аавын төлөө залбир гэсэн тэр захиасыг санадаг байв. Түүнийг дүүргийн ерөнхийлөгч, эсвэл гэрийн багшаар үйлчилж байхад нь түүний төлөө залбир. Иргэний бүлгийн гүйцэтгэх нарийн бичиг болоход түүний ажил хэрэг хөгжин, дэвжихэд, түүнийг бага цалин авах шаардлагатай болоход нь түүний төлөө залбир. Түүнийг гэр бүлийн үдэшт зөвлөгөө өгөхөд нь залбир. Жеролд номлолд явж чадах болон Диана дээд сургуульд орж болохын тулд олон цагаар ажилладаг Аавынхаа төлөө залбир. Түүнийг ариун ёслолын цуглаанд ярих, эсвэл Ээжийг дахин сайн болгохоор адислал өгөхөд нь түүний төлөө залбир. Оройд түүнийг гэртээ ядарч, зориг нь мохсон байдалтай ирэхэд нь түүний төлөө залбир. Түүний хийж чадах бүх жижиг болон агуу зүйлст нь Аавынхаа төлөө залбир.

“Олон жил улирсаар, ерөнхий чуулганууд ирж мөн хийгдсээр, Ерөнхийлөгч Бэнсон ярихаар зогсох бүрт би ‘түүний тив даяар таран одсон хүүхдүүд одоо аавынхаа төлөөх залбиралд нэгдэж байгаа’ гэж бодсон.

“Олон жилийн тэртээ эгнээ дагуу дамжсан товч захиас гэр бүлийн хувааж болох чухал захиас юм гэдэгт итгэх болсон. Хэрэв дэлхийн хаа нэгтээ охин нь, эсвэл хүү нь ‘аавын төлөө залбир’ хэмээн шивнэж байвал ямар ч эр амьдралынх нь өдөр тутмын сорилттой учрахдаа ер бусын хүч чадал болон итгэлтэй байж чадна” (Елайн МакКэй “Аавын төлөө залбир” *New Era*, 1975 оны 6 сар, х. 33).

4. Бид сайн мэдээгээр амьдарвал үүрэг хариуцлагуудаа хүлээн авахдаа бэлтгэгдэж мөн пристийн зэргийн адислалуудад сэтгэл хангалуун байх болно. “Миний Сайн Мэдээний Жишгүүд” (*My Achievement Days* booklet [35317], арын хавтсанд)-ийг уншихдаа жишиг бүрийн дараа түр зогсож тухайн жишгээр тэд хэрхэн зохистойгоор амьдарч байгааг нь хүүхдүүдээр бодуул. Жагсаалтыг уншиж дуусаад та тайлбар зураг буюу түлхүүр үгсийг ашиглан хичээлээ давтаж болно.

Миний Сайн Мэдээний Жишгүүд

1. Би өөрийн усан баталгааны гэрээнүүдийг дурсан санаж, Ариун Сүнсийг сонсох болно.
 2. Би Тэнгэрлэг Эцэг, бусад хүмүүс болон өөртэйгөө шударга байх болно.
 3. Би сайн найз нөхдийг эрж, бусдад эелдэг хандана.
 4. Би Тэнгэрлэг Эцэг болон өөртөө хүндэтгэл үзүүлэхийн тулд төлөв даруу хувцаслана.
 5. Би зөвхөн Тэнгэрлэг Эцэгт таалагддаг зүйлсийг уншиж, үзнэ.
 6. Би зөвхөн Тэнгэрлэг Эцэгт таалагддаг хөгжмүүдийг сонсоно.
 7. Би Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийн нэрийг хүндэтгэл бишрэлтэйгээр хэрэглэх болно. Би хараалын юмуу бүдүүлэг үг хэллэг хэрэглэхгүй байх болно.
 8. Би өөрийнхөө бодол санаа, бие махбодоо цэвэр, ариун нандин байлгах болно.
 9. Би өөртөө хортой зүйлсийг хэрэглэхгүй.
 10. Би Хүндэтгэлийн Өдрүүдэд өөрийгөө Тэнгэрлэг Эцэгтэй ойр байгааг мэдрэхэд туслах зүйлсүүдийг хийх болно.
 11. Би зөвийг сонгох болно. Би алдаа гаргавал наманчилж чадна гэдгээ мэддэг.
 12. Би одооноос ариун сүмд орох болон номлолд үйлчлэхийн тулд зохистой байхаар амьдрах болно.
 13. Би Тэнгэрлэг Эцэгийн надад зориулсан төлөвлөгөөг дагана.
5. Сүмийн арван тав дахь Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Гордон Б. Хинклийн хэлсэн дараах үгийг хуваалц: “Энэ сүм бол Ерөнхийлөгчид харьяалагддаггүй. Үүний тэргүүн нь Их Эзэн Есүс Христ ба хүн бүр усан баталгаагаар түүний нэрийг өөртөө авдаг. Бид бүгд энэхүү агуу ажлын нэгэн хэсэг юм. Бид бүгд энд Эцэгтээ ‘хүний үхэшгүй байдал болон мөнхийн амьдралыг бий болгох,’ Түүний ажил, мөн Түүний алдарт нь туслахаар ирсэн (Мосе 1:39). Та нарын ажлын хүрээн дэх үүрэг хариуцлага миний ажлын хүрээн дэх үүрэг хариуцлагын адил

чухал юм. Энэ сүмд жижиг, эсвэл тийм их чухал биш дуудлага гэж үгүй. Бид бүгд үүрэг хариуцлагынхаа дагуу бусдын амьдралыг хөнддөг” (Conference Report, Apr. 1995, p. 94; or *Ensign*, May. 1995, p. 71).

6. “Энд Хайр Яригдах Болно” дууг дуулах, эсвэл үгийг нь унш (*Хүүхдийн Дууны Ном*, х.190).

Дүгнэлт

Гэрчлэл

Пристийн зэрэг нь дахин сэргээгдсэн хийгээд энэ нь Бурханы төлөө үйлдэх эрх мэдэл юм гэсэн гэрчлэлээ хуваалц. Хөвгүүдийг одооноос Аароны Пристийн Зэргийг атгахад зохистой байхыг болон ангийн бүх гишүүдийг пристийн зэргийн бүх адислалыг хүлээн авахын төлөө зохистой амьдрахад нь урамшуул. Хүүхдүүдийг үнэнч шударга байж пристийн зэргийн удирдагчдыг дэмжихийг нь урамшуул.

Зөвлөмж
Болгогдсон
Гэр Бүлийн
Хуваалцах Цаг

Хүүхдүүдийг гэр бүлийнхэнтэйгээ түүх, асуулт, үйл ажиллагаа зэрэг хичээлийн онцгой хэсгүүдийг хуваалцах, эсвэл гэр бүлтэйгээ “Зөвлөмж Болгогдсон Гэрийн Уншлага”-г уншихыг урамшуул.

Зөвлөмж
Болгогдсон
Гэрийн Уншлага

Хүүхдүүдэд энэ хичээлийг давтахын тулд гэртээ Сургаал ба Гэрээ 121:34–46-г судлахыг зөвлө.

Хаалтын залбирал хийх хүүхдийг урь.

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

